



Нээлттэй Нийгэм Форум

Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний индекс - 2005

Улаанбаатар, 2006 он

DDC
330.9'517
M-629

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-48, Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-314857

Вэб: <http://www.forum.mn>

Уг судалгаанд хийсэн дүгнэлт, гаргасан саналууд нь зөвхөн судалгааны багийн дүгнэлт, үзэл бодлыг илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл Нээлттэй Нийгэм Форумын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна.

Тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст номын арын хавтсан дээр бичсэн хямдралтай үнээр борлуулна.

ISBN 99929-0-033-4

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

БҮЛЭГ 1

Б.БАТМӨНХ

Үндэсний Хөгжлийн Хүрээлэнгийн дэд захирал, доктор (Ph.D), (Багийн ахлагч)

Р.БААСАНЖАВ

Үндэсний статистикийн газрын үндэсний тооцоо, аргачлал, судалгааны газрын мэргэжилтэн

Р.ОНГОНЦЭЦЭГ

ҮХХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

БҮЛЭГ 2

Ж.ҮНЭНБАТ

СЭЗДС-ийн профессор

БҮЛЭГ 3

Ц.БАТСҮХ

Эдийн засгийн ухааны доктор, СЭЗДС-ийн Экономикс, эконометриксийн тэнхимийн эрхлэгч (Багийн ахлагч)

Д.ГАНСҮЛД

Эдийн засгийн ухааны бакалавр, МУИС-ийн магистрант, СЭЗДС-ийн Экономикс, эконометриксийн тэнхимийн багш

Б.БАЯРДАВАА

Эдийн засгийн ухааны бакалавр, МУИС-ийн магистрант, СЭЗДС-ийн Экономикс, эконометриксийн тэнхимийн багш

БҮЛЭГ 4

Д.ЖАРГАЛСАЙХАН

Бизнесийн удирдлагын (Санхүүгийн) ухааны МБА, Дэниэлсийн Бизнесийн Сургууль, АНУ-ын Денверийн Их Сургууль (Багийн ахлагч)

Б.ОТГОНТӨГС

Эдийн засгийн ухааны магистр, Их Британий Манчестерийн Их Сургууль, АНУ-ын Колумбийн Их Сургуулийн докторант (Ахлах судлаач)

Ч.ХАШЧУЛУУН

Эдийн засгийн ухааны доктор, Японы Кейо Их Сургууль (Зохицуулагч)

С.ДӨЛБАДРАХ

Эдийн засгийн ухааны магистр, МУИС-ийн ЭЗС

Т.ОЮУНБААТАР

Эдийн засгийн ухааны магистр, МУИС-ийн ЭЗС

Д.БАЯРМАА

Эдийн засгийн ухааны магистр, МУИС-ийн ЭЗС, Японы Софийн Их Сургууль

Б.МӨНХСОЁЛ

Нээлттэй Нийгэм Форумын судалгааны удирдагч

Хянан тохиолдуулсан:

Б.МӨНХСОЁЛ

Ч.ХАШЧУЛУУН

Д.ЖАРГАЛСАЙХАН

ГАРЧИГ

ОРШИЛ 7

**БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭМЖЭЭ: ЗАРДАЛ,
ТАТВАР, АЖ АХУЙН НЭГЖ** 11

1.1 Судалгаа 12

А. Нийт хэрэглээнд улсын
байгууллагуудын хэрэглээний
эзлэх хувь 12

Б. Татаас ба урсгал шилжүүлэг 16

В. Нийт үйлдвэрлэл болон хөрөнгө
оруулалтанд улсын үйлдвэрүүд болон
улсын төсвийн хөрөнгө оруулалтын
эзлэх хувь 20

Г. Татварын дээд хэмжээ, түүнийг
оногдуулах орлогын түвшин 22

1.2 Эдийн засгийн эрх чөлөөний индексийн
төрийн оролцоо, хэмжээг илэрхийлсэн
эхний бүлгийн нэгдсэн индекс 25

1.3 Бүлгийн индекс болон бусад
үзүүлэлтийн хоорондын хамаарал 27

1.4 Олон улсын зэрэгцүүлэлт 28

1.5 Нэгдсэн дүгнэлт санал 33

**БҮЛЭГ 2. ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ:
ЭРҮҮЛ МӨНГӨ ХҮРТЭХ БОЛОМЖ** 35

2.1 Оршил 36

2.2 Эрүүл мөнгө хүртэх боломжийн
судалгааны зорилго 36

А. Сүүлийн 5 оны мөнгөний нийлүүлэлтийн
жилийн дундаж өсөлтөөс хасах нь
сүүлийн 10 оны ДНБ-ий жилийн
дундаж бодит өсөлт 37

Б. Сүүлийн 5 жилийн инфляцийн
стандарт өөрчлөлт 43

В. Өнөөгийн инфляцийн түвшин 46

Г. Дотоодод болон гадаадад гадаад
валютын данс эзэмших эрх 48

2.3 Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний
индексийн 3-р бүлгийн үзүүлэлтийн
(эрүүл мөнгө хүртэх боломж) индекс 51

**БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН
ХУДАЛДААНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ
ИНДЕКСИЙН СУДАЛГАА** 57

3.1 Оршил 58

3.2 Бүлгийн Судалгааны зорилго 60

А. Олон улсын худалдааны татвар 61

А.1. Олон улсын худалдааны
нийт эргэлтэнд олон улсын
худалдааны татварын
орлогын эзлэх хувь 61

А.2. Тарифын дундаж хэмжээ 67

А.3. Тарифын хэмжээний
стандарт хазайлт 71

Б. Худалдааны саад хоригийн
зохицуулалт 73

Б.1. Импортын далд саад хориг 73

Б.2. Импортын зардал 74

В. Худалдааны секторын бодит ба
хүлээгдэж буй хэмжээний харьцаа 75

Г. Валютын хар захын ба албан ханшийн
хоорондын зөрүү 79

Д. Олон улсын хөрөнгийн зах
зээлийн хяналт 81

Д.1. Гадаад дотоодын хөрөнгийн
зах зээлд иргэд харилцан
оролцох боломж 81

Д.2. Тухайн улсын иргэдийн
гадаадын иргэдтэй хамтран
хөрөнгийн зах зээлд
оролцох эрх чөлөө 81

3.3 Монгол Улсын олон улсын худалдааны
эдийн засгийн эрх чөлөөний нэгтгэсэн
индексийн үзүүлэлт 87

3.4 Олон улсын харьцуулалт дүгнэлт 87

3.5 Хавсралтууд 89

БҮЛЭГ 4. МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ЗЭЭЛИЙН САЛБАР, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН БИЗНЕСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС 99

4.1 Товч танилцуулга: Монгол Улсын банкны зээл, хөдөлмөрийн зах зээл болон бизнесийн эдийн засгийн эрх чөлөөний судалгаа.	100
4.2 Судалгааны аргачлал.	100
4.3 Монгол Улсын банкны зээлийн салбар дахь эдийн засгийн эрх чөлөөний судалгаа	101
А. Банкны өмчлөлийн тухай.	102
Б. Өрсөлдөөн: Дотоодын болон гадаадын банкуудын өрсөлдөөн	108
В. Хувийн хэвшилд олгож байгаа зээл	118
Г. Зээлийн хүү сөрөг түвшинд байх.	122
Д. Банкны хүүгийн хяналтын талаар	124
4.4 Монгол Улсын зээлийн зах зээл дэх эдийн засгийн эрх чөлөөний нэгтгэсэн индексийн үзүүлэлт	133
4.5 Олон улсын харьцуулалт	133
4.6 Хэритэдж сан/Уолл Стрит Журналын «Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс»-тэй хийсэн харьцуулалт.	135
4.7 Банкны зээлийн зах зээлийн эдийн засгийн эрх чөлөөний судалгааны дүгнэлт.	138
4.8 Эдийн засгийн эрх чөлөөний индекс - Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт	141
4.9 Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт	147
А. Хөдөлмөрийн хөлсний доод түвшингийн нөлөө.	147
Б. Ажилд авах болон ажлаас халах процесс	148
В. Нэгдсэн хэлэлцээрээр цалин нь тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь	149
Г. Ажилгүйдлийн тэтгэмж.	149
Д. Цэргийн алба	150

4.10 Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын ерөнхий индекс ба түүний олон улсын харьцуулалт.	150
4.11 Эдийн засгийн эрх чөлөөний индекс-бизнесийн зохицуулалт	155
4.12 «Бизнесийн зохицуулалт» бүлгийн индексийн тооцоо	152
4.13 Олон улсын харьцуулалт	156
4.14 Зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалтын эдийн засгийн эрх чөлөөний судалгааны нэгдсэн дүгнэлт.	158

ДҮГНЭЛТ. 160

НОМ ЗҮЙ. 162

ОРШИЛ

“Хувь хүмүүст өөрийн хөрөнгөө хэрхэн зарцуулахыг зааж зохицуулах гэсэн төрийн зүтгэлтэн бол өөртөө огт шаардлагагүй анхаарлыг татахаас гадна нэг хүнд битгий хэл аливаа зөвлөл буюу хуралд ч даалгах боломжгүй эрх мэдэл, хариуцлагыг өөртөө үүрээд зогсохгүй тус эрх мэдлийг ашиглаж чадна гэж эндүүрч байгаа нь бүүр ч аюултай байх болно”

Адам Смит, «Үндэстний баялгийн мөн чанар, учир шалтгааны лавлагаа», 1776

230 жилийн өмнөөс сонгодог эдийн засгийн онолыг үндэслэгч, Их Британи улсын алдартай эдийн засагч Адам Смит хувийн хөрөнгийг төрөөс удирдаж зохицуулах буюу эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах зорилготой аливаа төрийн зөвлөл, байгууллага эсвэл төрийн зүтгэлтний оролдлого эдийн засагт аюул учруулж болзошгүйг анхааруулж билээ. Тэрээр “Үндэстний баялгийн мөн чанар, учир шалтгааны лавлагаа” хэмээх эдүгээ бидний үед ч ач холбогдлоо алдаагүй суут бүтээлдээ “ Хүмүүст эдийн засгийн эрх чөлөөг өг!” гэж уриалаад номынхоо эхнээс эцэс хүртэл “жам ёсны эрх чөлөө”, хэн нэг нь төрийн оролцоогүйгээр юу хүссэнээ хийх эрх чөлөөний зарчмыг өмгөөлсөн байдаг.

Хүн төрөлхтний өнгөрсөн түүхээс үзэхэд эдийн засгийн эрх чөлөө, хөгжил цэцэглэл хоёр хоорондоо нягт холбоотой байжээ. Энэ талаар Жеймс Гвартней, Роберт А.Лаусан, Вольтер И.Влок (1976) нарын хийсэн нарийн судалгаа баталсан ажээ. Эдийн засгийн эрх чөлөө нь илүү материаллаг амьдрал уруу хөтлөөд зогсохгүй, энэ нь хүн бүрийн эдэлбэл зохих хамгийн суурь эрх байдаг. А.Смит “Хүн төрөлхтнийг өөрсдөө үйлдвэрлэж чадах зүйлээ хийхийг, эсвэл өөрсдийн хөрөнгө, үйлдвэрлэлийг хориглох нь хүн төрөлхтний хамгийн нандин эрхийг зөрчсөн хэрэг мөн” гэж бичиж байлаа.

Эдийн засгийн эрх чөлөө бол өөрөө хувь хүний сонголтын эрх чөлөө, хувь хүмүүсийн солилцооны эрх чөлөө, өрсөлдөөний эрх чөлөө, хувь хүн болон түүний эд баялгийн халдашгүй эрх чөлөө гэсэн тулгуур ухагдахуунуудыг агуулдаг.

Эдийн засгийн эрх чөлөөг дээдэлсэн нийгмийн бүтэц ба бодлогууд бол хувь хүмүүсийн эд баялгийг хамгаалж, хүмүүст чөлөөтэй сонголт хийх, эд бараа, баялгийг чөлөөтэй солилцох боломжийг олгож өгдөг. Хуулийг дээдэлсэн эдийн засгийн эрх чөлөө бол шинэ ажлын байруудыг бий болгох хувийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, урамшуулах, хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх болно. Түүний эсрэгээр эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах оролдлогууд эдийн засгийн үйл ажиллагаанд саад тотгор

учруулж, өсөлтийг бууруулж, улмаар ядуурлыг бий болгож байдгийг олон зуун жилийн дэлхийн түүх олон орны жишээн дээр баталсан билээ.

Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний судалгааны ач холбогдол

Өнөөдөр Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас татгалзаж, ардчилал, зах зээлийн эдийн засаг, эдийн засгийн эрх чөлөөг эрхэмлэсэн нийгэм рүү буцалтгүй шилжиж эхлээд 15 жил боллоо. Энэ хугацаанд Монгол Улсын эдийн засгийг нээлттэй болгох, хувийн секторыг хөгжүүлэх, төрийн оролцоог багасгах, зах зээлийн эдийн засагт тулгуурласан төрийн эдийн засгийн зохицуулалтыг бий болгох олон чухал алхам хийгдсэн.

Үүний улмаас Монгол Улсын ихэнх салбарт эдийн засгийн үйл ажиллагаа социализмын үеийн төрийн хэт зохицуулалтаас чөлөөтэй болж, 2005 онд АНУ-ын Херитэдж сангаас гаргадаг дэлхийн 155 орны эдийн засгийн эрх чөлөөний жагсаалтанд 50-р байранд орсон байна. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийг нэр хүнд бүхий судалгааны энэ байгууллага тооцож хэвлэсэн нь чухал бөгөөд гагцхүү Монголын талын өөрсдийн хийсэн тооцоо байхгүй нөхцөлд уг индекс хэр үндэслэлтэй тооцогдсон тухай асуудал үүсч болох юм.

Хэдийгээр энэ бол 15-хан жилийн хугацаанд зах зээлийн эдийн засагт хөгжиж буй улсын хувьд чамлахааргүй үзүүлэлт боловч, өнөөдөр Монгол Улсад олон шатны авилгал, нийтийг хамарсан ядуурал, төрийн оновчтой эдийн засгийн бодлогын дутмаг байдал, эдийн засгийн эрх чөлөөг ил ба далд аргаар боосон олон төрлийн хүнд суртал ажиглагдаж байгаа нь нууц биш ээ. Энэ бол эдийн засгийн хөгжлийг удаашруулж, эдийн засгийн нөөцийн үр ашиггүй хуваарилалт, алдагдлыг бий болгож байгаа гол шалтгаанууд гэж хэлж болно.

Иймээс, Монголын эдийн засгийн эрх чөлөөг судалж түүнийг бодитойгоор хэмжих, улс орны хөгжилд учирч байгаа бэрхшээл, асуудлыг ил тод гаргаж нийтээр хэлэлцэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм. Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн

засгийн харилцаанд шилжилт хийснээс хойшхи энэ хугацаанд хуучин социалист орнуудын хүрээнд хаалттай байсан эдийн засгаа нээлттэй болгож, дэлхийн эдийн засагт нэгдэн орж, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийг бий болгох чиглэлээр багагүй амжилт олсон. Одоо Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний дөрөвний гурвыг хувийн хэвшил бүтээж байна. Энэ өөрчлөлт шинэчлэлтийн нэг салшгүй хэсэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжиж, түүнийг татах бодлого байсан. Энэхүү бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулагч нарт Монгол Улсын бизнесийн орчин, түүнтэй холбоотой хууль эрх зүйн орчин, эрсдлийн талаар мэдээлэл судалгаа зайлшгүй хэрэгцээтэй байгаа юм.

Нээлттэй Нийгэм Форумас Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөг олон улсын хэмжээнд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу тодорхойлох санаачлага гаргаж Фрейзер институтэд хандсанаар түүний дотоодын түнш байгууллага болж ажиллах бололцоо нээгдсэн юм. Энэ нь дараах боломжийг бидний өмнө гаргаж өгч байна.

- Эдийн засгийн эрх чөлөөний байдлаар Монгол улс дэлхийн хамтын нөхөрлөлийн орнуудын хаана явааг үзүүлэлт бүрээр илэрхийлэх
- Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтийг нийтэд ил тод мэдээлэх замаар хэлэлцүүлэг болгох
- Төрийн байгууллагын шийдвэрийг эдийн засгийн эрх чөлөөг хангахад чиглүүлэхэд түлхэц болох

Энэ судалгааг хийснээрээ Монгол Улс ямар чиглэлээр, ямар үзүүлэлтээрээ эдийн засгийн эрх чөлөөг хааж, боогдуулж байгаагаар олж харж, тэр чиглэлээр төрөөс ямар бодлого явуулах шаардлагатайг тодорхойлох боломжтой болно.

Судалгааны аргачлал

Нобелийн шагналт, эдийн засагч М.Фридманы хэлснээр эдийн засгийн эрх чөлөөг хэмжих аргачлал улам бүр боловсронгуй болсоор байна. Онолын энэхүү суурь үзэл санааг үндэслэн дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индексийг олон улсын түвшинд Хэритэйжийн сан болон Фрейзер институт хэвлэн гаргаж байна.

Фрейзер институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний 2004 оны илтгэлээс үзэхэд эдийн засгийн эрх чөлөөг дараахь 5 үндсэн чиглэлээр хэмжиж, ерөнхий индексийг тодорхойлж байна. Үүнд:

- Төрийн байгууллагын хэмжээ
- Хуулийн бүтэц ба өмчлөх эрхийн хамгаалалт
- Эрүүл мөнгө хүртэх боломж
- Олон улсын худалдаанд оролцох эрх чөлөө
- Зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалт

Фрейзер институтын дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн гол 5 салбарын нийт 38 үзүүлэлтийг 60 гаруй орны судалгааны институт оролцон, дэлхийн эдийн засгийн байгууллагуудаас гаргадаг тоон болон чанарын үзүүлэлтүүдийг ашиглан ерөнхий аргачлалаар тооцон гаргадаг.

Индексийн гол зорилго нь судлагдаж буй салбарт эдийн засгийн эрх чөлөөг тоон үзүүлэлтээр гаргахад оршдог ба индексийн утга өндөр байх тусмаа тус салбар илүү чөлөөтэй байна гэж үзнэ.

Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүдийг нормчлохдоо дараахь томъёог ашигладаг. Үүнд:

$$i_F = (V_{max} - V_i) / (V_{max} - V_{min}) * 10$$

Энд: V_i - тухайн улсын үзүүлэлт
 V_{max} - Суурь он болох 1990 оны улс орнуудын хамгийн их утга
 V_{min} - Суурь он болох 1990 оны улс орнуудын хамгийн бага утга

Фрейзер институтийн энэхүү аргачлалаар тухайн үзүүлэлтийн индекс 10 рүү дөхөх тусмаа сайн, 0 рүү дөхөх тусмаа тухайн өгөгдлийн сөрөг утгыг агуулдаг байна.

Нээлттэй Нийгэм Форум нь Дэлхийн Эдийн Засгийн Форумас эрхлэн гаргадаг

Дэлхий Дахины Өрсөлдөх Чадварын тайланд Монгол Улс анх удаа орохоор болсон тул энэ удаад эдийн засгийн эрх чөлөөний хоёрдугаар бүлэг болох *хуулийн бүтэц ба өмчлөх эрхийн хамгаалалтын* индексийг тооцоогүй. Учир нь уг бүлгийн индексийн гол утга энэхүү тайлангаас харагддаг болно.

Бүлэг 1



Засгийн газрын хэмжээ:
Зардал, татвар, аж
ахуйн нэгж

1.1 СУДАЛГАА

Тус бүлэгт Монгол Улс дахь засгийн газрын хэмжээг индексээр хэмжих болно. Энэхүү тооцоо судалгаанд бид Фрейзер институтийн аргачлалыг ашиглаж, дээрх үзүүлэлтүүдээс төрийн оролцоо, хэмжээг илэрхийлсэн эхний хэсэг үзүүлэлтүүдийг тооцож, тэдгээрийг үндэслэн нэгдсэн индексийг тооцож, холбогдох судалгаа, дүгнэлтийг бэлтгэсэн.

Засгийн газрын хэмжээг дараах үзүүлэлтээр хэмжинэ:

- А. Нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь
- В. Дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь
- С. Нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн болон нийт хөрөнгө оруулалтад улсын хөрөнгө оруулалтын эзлэх хувь
- Д. Татварын дээд хувь хэмжээ (хамгийн өндөр татвар ногдуулдаг орлогын түвшин) орно.

Эхний бүлгийн хүрээнд үндсэн гол үзүүлэлтүүд цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж ирсэн хандлагыг харуулж, дүгнэлт хийв. Мөн бид дээрх аргачлалд манай орны нөхцөлд нэмэлт үзүүлэлт оруулах, нэмэлт судалгаа явуулах асуудлыг давхар хөндсөн. Судалгаандаа математик, статистикийн аргууд, тухайлбал, корреляцийн болон зэрэгцүүлэх, задлан шинжлэх, индексийн зэрэг аргуудыг хэрэглэсэн.

А Нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь

Ойлголт, тодорхойлолт

Нийт үндэсний орлогод Засгийн газрын хэрэглээний эзлэх хувийг тодорхойлохын тулд эхлээд үндсэн статистикийн үзүүлэлтүүдийг авч үзэх шаардлагатай. Нийт хэрэглээ нь улсын байгууллагуудын хэрэглээ болон өрх, хүн амын хэрэглээнээс бүрддэг. *World Development Indicators-2002* эмхтгэлд улсын байгууллагын хэрэглээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад зориулсан улсын байгууллагын

бүх төрлийн урсгал зардлыг оруулна гэж тодорхойлсон байдаг.

Манай орны хувьд улсын байгууллагын хэрэглээг олон улсын байгууллагаас тодорхойлсон энэ нийтлэг ойлголт, тодорхойлолттой адилаар тодорхойлон тооцдог. Өрх, хүн амын эцсийн хэрэглээг *World Development Indicators*” эмхтгэлийн аргачлалын тайлбарт өрхүүдийн худалдан авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн өртгөөр тодорхойлогдоно гэжээ. Ингэхдээ өрхүүдийн худалдан авсан авто машин, угаалгын машин, компьютер гэх мэт удаан эдэлгээт барааг оруулдаг. Манай орны статистикийн практикт ч гэсэн өрх, хүн амын хэрэглээг тодорхойлохдоо олон улсын энэ нийтлэг тодорхойлолт, арга зүйг баримталж ирсэн байна.

Мэдээллийн Эх сурвалж

Улсын байгууллагын хэрэглээний талаарх мэдээллийн гол Эх сурвалж нь аль ч улс оронд Засгийн газрын санхүүгийн статистик мэдээлэл байдаг. Манай орны хувьд Сангийн яам хариуцан гаргадаг улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагын талаарх тоо мэдээлэл нь улсын байгууллагын хэрэглээг тооцох суурь мэдээлэл болдог. Энэ нь практикт дээр төсвийн байгууллагуудын худалдан авсан бараа, үйлчилгээний хэмжээ юм.

Нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувь хэмжээг тооцохдоо Үндэсний Статистикийн Газраас (ҮСГ) жил бүр тооцдог ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооноос нийт хэрэглээ, улсын байгууллагуудын хэрэглээг 1990-1995, 2000-2004 оноор, тухайн оны үнээр, сая төгрөгөөр харуулсан дараах тоо мэдээллийг ашиглав.

Хүснэгт 1-д харуулсан үзүүлэлтүүдийг ҮСГ бодит тоогоор нь албан ёсоор нийтэлдэггүй, зөвхөн хэрэглээний нийт дүнд эзлэх хувийн жин байдлаар жил бүрийн статистикийн эмхтгэлд оруулдаг.

Дотоодын нийт бүтээгдэхүүн нь эцсийн ашиглалтын талаасаа дараах томъёогоор илэрхийлэгддэг.

Хүснэгт 1. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, түүний бүрэлдэхүүн хэсгүүд, оны үнээр, сая төгрөг

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
ДНБ эцсийн ашиглалтын дүнгээр	11013.3	590066.4	1111743.6	1243052.3	1329459.8	1549069.4	1976954.1
Нийт хэрэглээ	9628.8	421295.1	913220.0	1052153.7	1194448.6	1278361.0	1509252.6
-Улсын хэрэглээ	3118.2	71397.4	180330.0	210537.9	227446.3	246082.1	312843.0
-Хувийн хэрэглээ	6510.6	348964.4	730006.7	834662.4	957789.8	1024970.5	1187276.6
Хуримтлал, хөрөнгө оруулалт	3379.8	149149.8	321971.1	351594.1	360918.0	498480.0	616570.6
Цэвэр экспорт	-2200.9	-5721.1	-170061.1	-211310.0	-264596.4	-285249.2	230301.8
Статистикийн зөрүү	-548.3	-39812.7	-92857.9	-127410.9	-88673.0	-87900.2	-66073.2

Эх сурвалж: ҮСГ-ын ДНБ-ий тооцоо

Хүснэгт 2. Үйлдвэрлэлийн болон эцсийн хэрэглээний аргаар тооцсон ДНБ-ий зөрүү, сая төгрөг

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
ДНБ эцсийн ашиглалтын дүнгээр	11013.3	590066.4	1111743.6	1243052.3	1329459.8	1549069.4	1976954.1
ДНБ үйлдвэрлэлийн дүнгээр	10465.0	550253.7	1018885.7	1115641.4	1240786.8	1461169.2	1910880.9
Статистикийн зөрүү	-548.3	-39812.7	-92857.9	-127410.9	-88673.0	-87900.2	-66073.2
Зөрүү, хувиар	5.3	7.2	9.1	11.4	7.1	6.0	3.4

Эх сурвалж: ҮСГ-ын ДНБ-ий тооцоо

$$GDP = C + I + X - M;$$

Энд : **GDP** - ДНБ

C - нийт хэрэглээ

I - хуримтлал, хөрөнгө оруулалт

X - экспорт

M - импорт

Эндээс нийт хэрэглээ **C** нь дотроо улсын болон хувийн хэрэглээ гэж ангилагддаг.

ДНБ-ийг тооцдог үйлдвэрлэлийн болон эцсийн хэрэглээний гэсэн 2 аргаар тооцсон үр дүн онолын хувьд адил гарах ёстой боловч практик дээр зөрүүтэй гардаг бөгөөд түүнийг статистикийн зөрүү гэж нэрлэдэг. Манай орны хувьд эцсийн хэрэглээний аргаар тооцсон ДНБ нь үйлдвэрлэлийн аргаар тооцсон хэмжээнээс 1990 оноос хойш 3.4% -11.4% илүү байсныг дараах хүснэгтээс харж болно.

ДНБ-ий тооцооны дээр дурьдсан 2 аргын тооцооноос эцсийн хэрэглээний аргаар тооцсон тооцоог илүү бүрэн хамралттай гэж үзэх үндэслэлтэй. Учир нь үйлдвэрлэлийн аргаар тооцсон тооцоонд далд эдийн засаг

хангалттай тусгагддаггүй, зарим салбаруудын бүтээгдэхүүн бүрэн хамрагддаггүй бол нөгөө талаасаа эцсийн хэрэглээний тооцоонд ашиглагддаг мэдээллүүд үйлдвэрлэлийн аргын тооцооныхоос илүү найдвартай, илүү бүрэн хамралттай байдаг.

Шилжилтийн эдийн засагтай манай орны хувьд одоохондоо далд эдийн засагт бий болсон ДНБ-ий хэмжээ харьцангуй их байгаа бөгөөд зарим судлаачдын тооцоогоор ДНБ-ий 30 хувиас давж байгаа билээ. НҮБ-ын статистикийн хэлтсээс зөвлөмж болгосон аргачлалаар ДНБ-д далд эдийн засгийг хамруулан авч үздэг. 2000 онд Дэлхийн банкнаас явуулсан албан бус секторын судалгааны дүнгээр ДНБ-ий 13 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл өртөг албан бус секторт бий болж байжээ. ҮСГ нь 2000 оноос хойш ДНБ-ий тооцоонд ийм хэмжээний нэмэлт тооцоог жил бүр тусгадаг болсон. Гэвч далд эдийн засгийн хэмжээ өнөөг хүртэл манай орны ДНБ-д бүрэн хэмжээгээр тусгагдаж хараахан чадаагүй байгаа нь манай энэхүү тооцоонд ч бас нөлөө үзүүлж байгааг анхаарах ёстой. Тухайлбал, эдийн засгийн чөлөөт байдлын индексийн эхний хэсэгт

Хүснэгт 3. Нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь болон түүнийг үндэслэн тооцсон оноо

Үзүүлэлтүүд	1990	1995	2000	2001	2002	2003	2004
V_i - нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь	32.4	16.9	19.7	20.0	19.0	19.2	20.7
$V_{max} - V_i$, ($V_{max}=40$, $V_{min}=6$)	7.3	23.1	20.3	20.0	21.0	20.8	19.3
$V_{max} - V_{min}$	34.0	34.0	34.0	34.0	34.0	34.0	34.0
$The\ rate = (V_{max} - V_i) / (V_{max} - V_{min}) \times 10$	2.15	6.79	5.97	5.88	6.18	6.12	5.68

Эх сурвалж: Economic Freedom of the world: 2004 Annual Report, Appendix 1: Explanatory Notes and Data Sources

байгаа ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь, ДНБ-д улсын секторын эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд нь ДНБ-ий хэмжээг далд эдийн засгийн нөлөөгөөр нэмэгдүүлэх буурахад хүргэнэ.

Манай орны хувьд өрх, хүн амын болон улсын байгууллагуудын хэрэглээний талаар ҮСГ-ын албан ёсны тоо баримтаас өөр тоо мэдээлэл үнэндээ байхгүй байна. Гэхдээ *World Development Indicators, 2002, 2004* онуудын эмхтгэлүүдээс харахад энэ хэсэгт хамаарах *General Government final consumption as percentage of GDP* гэсэн үзүүлэлт байна. Энэ нь нийт хэрэглээнд эзлэх улсын хэрэглээ биш, харин ДНБ-д эзлэх улсын хэрэглээ тул бидний тооцоонд хэрэглэх боломжгүй байсан. Нөгөө талаасаа энэ үзүүлэлт уг эмхтгэлд 1990 онд 32 хувь, 2000 онд 19 хувь байгаа нь маш өндөр байна. Гэтэл нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувь ҮСГ-аас жил бүр тооцдог ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцоогоор дээрх онуудад яг ийм хувьтай байв. Уг үзүүлэлтийг дээрх эмхтгэлийг эрхлэн гаргасан байгууллага ҮСГ-ын гаргасан эмхтгэлд байгаа нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувиар нь авсан бололтой байна.

Монгол Улсын индексийн тооцоо

Хүснэгт 1-ийн нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувийг ашиглан Монгол Улсын авах оноог тооцож хүснэгт 3 -т харуулав.

Монгол Улсын харгалзах оноог дээрх аргачлалын дагуу дараах томъёогоор тооцов.

Үүнд:

$$The\ rate = (V_{max} - V_i) / (V_{max} - V_{min}) * 10;$$

Энд:

- V_i - i - оны нийт хэрэглээнд улсын байгууллагын хэрэглээний эзлэх хувь
- V_{max} - хамгийн их утга бөгөөд түүнийг 40 гэж авна.
- V_{min} - хамгийн бага утга бөгөөд түүнийг 6 гэж авдаг.

2003 оны Монгол Улсын оноог тооцсон жишээ харуулбал: 2003 онд нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь 19.2 байсан тул $V_{2003} = 19.2\%$ болно.

Эндээс Монгол Улсын оноо = $[(V_{max} - V_{2003}) / (V_{max} - V_{min})] * 10 = [(40 - 19.2) / (40 - 6)] * 10 = (20.8 / 34) * 10 = 0.612 * 10 = 6.12$ гарав.

Фрейзер институтын аргачлалаар оноо нь 0-10-ын хооронд гардаг бөгөөд нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь өндөр байх тусам авах оноо нь бага болдог. Манай орны 2003 оны тоо мэдээллээр энэ оноо 6.1 гэж гарч байна.


Улсын болон өрх, хүн амын хэрэглээг тооцсон ҮСГ-ын албан ёсны тооцооноос өөр тооцоо одоогоор байхгүй, өөр альтернатив тооцоо хийх боломжгүй байгаа нөхцөлд дээрх оноог тооцсон тоо мэдээлэл нь чанарын хувьд хангалттай гэж үзэх үндэслэлтэй байна.

Судалгааны дүн

Улсын байгууллагуудын хэрэглээ нь хувь хүмүүс, өрхүүд, бизнесийн байгууллагуудын зардлаас илүү хурдтай нэмэгдэх нь төрийн бодлогын шийдвэр хувь хүний сонголтыг орлож, хүмүүсээс сонголт хийх боломжийг хязгаарлаж, эдийн засгийн эрх чөлөө хумигддаг гэж үздэг. Энэ бүлгийн эхний 2 үзүүлэлт нь үүнтэй шууд холбоотой бөгөөд нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь болон ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь өсөх нь эдийн засагт төрийн оролцоо, хэмжээ нэмэгдэж байгааг харуулдаг.

Хүснэгт 3-д харуулсан нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувийг үндэслэн дараахь графикийг байгуулав.

Зураг 1. Нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь



Зураг 1-ээс үзэхэд нийт хэрэглээнд улсын байгууллагын хэрэглээний эзлэх хувь 1990 онд 32.4 хувь байснаа 1995 онд 16.9 хувь болтлоо буурч, харин 2000 оноос хойш тогтмол 19-20 хувь байсаар иржээ. Үүний улмаас энэ үзүүлэлтээр тооцсон индекс 1990 онд 2.2 хувь байснаа 2003 онд 6.1 хувь болж нэмэгдсэн нь харагдаж байна (Хүснэгт 3). 1995 онд нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь ихээхэн бага байсан нь 1991 оноос эхэлсэн “цочир эмчилгээний” үр дүн гэж үзэж болох талтай. Энэ үеэс төсвийн эрс хомсдол эхэлж, төсөвт байгууллагуудын орон тоо, зардлыг ихээхэн хэмжээгээр хорогдуулсан билээ. Нөгөө талаасаа 1995 онд ДНБ 6.3 хувиар өссөн нь улсын байгууллагуудын хэрэглээ бага гарахад нөлөөлжээ.

Манай орны хувьд нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь 1990 оноос хойш ерөнхийдөө буурах хандлагатай байна. Гэхдээ 2000-2003 онд төдийлөн буураагүй үндсэндээ нэг түвшинд байсан бол 2004 онд буцаад 20.7 хувь болж нэмэгдсэн нь хүснэгт 3 –аас харагдаж байгааг анхаарч, цаашид нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувийг бууруулах чиглэлээр тодорхой бодлого баримтлах шаардлагатай байна. Улсын байгууллагуудын хэрэглээ, Засгийн газрын зардлын динамикт шинжилгээ хийж үзье.

Хүснэгт 4. ДНБ ба Засгийн газрын зардлын өсөлт

Он	ДНБ,оны үнээр,сая төгрөг	Улсын байгууллагуудын хэрэглээ, оны үнээр, сая, төгрөг	Нэгдсэн төсвийн урсгал зардал, оны үнээр сая, төгрөг
1995	550253.7	71397.4	101507.6
2000	1018885.7	180330.0	314118.7
2001	1115641.4	210537.9	366700.8
2002	1240786.8	227446.3	413467.1
2003	1461169.2	246082.1	434831.7
2004	1807985.9	312843.0	525878.2
2000/1995,%	185.2	252.6	309.5
2004/2000,%	177.4	173.5	167.4
2004/1995%	328.6	438.2	518.1

Хүснэгт 4-өөс үзэхэд улсын байгууллагуудын хэрэглээ болон улсын нэгдсэн төсвийн урсгал зардал 1995-2000 онд ДНБ-ий өсөлтөөс илүү хурдацтай нэмэгдсэн бол 2000-2004 онд харин ДНБ-ий өсөлтөөс доогуур хурдацтайгаар нэмэгджээ. Засгийн газрын зардал нийгмийн баялгийн өсөлтөөс хурдацтай өсөх нь туйлын зохисгүй үзэгдэл бөгөөд харин энэ байдал сүүлийн жилүүдэд засрах хандлагатай болжээ.

Энэ судалгааны олон улсын зэрэгцүүлэлтийн хэсэгт (Бүлэг 1.7) эдийн засаг дахь төрийн оролцоо, хэмжээг харуулсан дээрх үзүүлэлтийг дэлхийн бусад улс орнуудтай зэрэгцүүлэн авч үзсэн. Эндээс Монгол Улс нийт хэрэглээндээ төрийн байгууллагуудын эзлэх зардлаараа харьцангуй бага зардал гаргадаг. Энэ утгаараа эдийн засаг дахь төрийн

оролцоо их биш улс орны тоонд орсон. Гэтэл практик амьдрал дээр Монголд эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоо их, төрөөс эдийн засгийн эрх чөлөөг боож хаагдуулсан үйл ажиллагааг явуулж байгааг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас (МУХАУТ) явуулсан судалгааны дүн харуулсан (9).

МУХАУТ нь 2004 оны 10 сард “*Бичил болон жижиг бизнесийн үндэсний чуулган*”-ыг зохион байгуулсан бөгөөд түүний өмнө жижиг бизнес эрхлэгчдийн дунд тусгай судалгааг явуулж, бизнесийн орчин нөхцөл, тулгарч буй хүндрэл бэрхшээл, үйлчилж буй хууль тогтоомж, тэдгээрийг сайжруулах талаар бизнес эрхлэгчдийн санал бодлыг судалжээ. Судалгааны дүнгээс үзэхэд бичил болон жижиг бизнес эрхлэхэд ямар нэг саад бэрхшээл тулгарч байна уу гэсэн асуултанд нийт хамрагдсан 584 компани, хувь хүмүүсийн 88.0 хувь нь тийм гэж хариулсны дотор 10,2 хувь нь бизнес дэх төрийн зохицуулалт, оролцоог их гэж үзжээ. Тэдэнд хамгийн түгээмэл тулгардаг бэрхшээлүүдэд татвар, төлбөрийн өндөр хувь хэмжээ, хүнд суртал, хяналтын байцаагчдын дарамт шахалт зэрэг ордог байна.

Монголын эдийн засагт төрийн оролцоо их байгаа нь эдийн засагт улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн монополь тогтсон, эдийн засагт улс төрийн намын оролцоо маш их, авилгал хээл хахууль газар авснаар илэрдэг.

Транспаренси Интернэшнл байгууллагын¹ судалгаагаар 2004 онд Монгол Улс дэлхийн 146 орноос 85-д орж, авилгал ихтэй орны тоонд багтсан.

Нөгөө талаар манай судалгааны баг нь Монголын төрийн эдийн засагт оролцоо оролцоо буруу чиглэлдээ, тухайлбал, оролцоо юмандаа оролцохгүй харин оролцоо ёсгүй зүйлд илүү оролцоод байна гэдэг дүгнэлтийг хийж байгаа юм. Энэ нь юуны түрүүнд төрөөс зах дээл дэх чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополийн ноёрхлыг хязгаарлах талаар

идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй, харин ч улс төр, бизнесийн бүлэглэлүүдэд таатай орчинг бүрдүүлэхэд оролцож байгаагаар илэрч байна гэж бид үзэж байна. Монополийн эсрэг хуулийг олон жилийн өмнө Улсын Их Хурлаас батлан гаргасан боловч тэр нь хэрэгжихгүй байсаар дөнгөж 2005 онд түүний эсрэг тэмцэх тусгайлсан байгууллагыг байгуулсан билээ.

“*Economic Freedom of the World: 2004 Annual Report*” тайланд хууль эрх зүйн орчин, зохицуулалтын бодлогын чанар, үр дүнг хэмжих үнэхээр хүнд байсныг тэмдэглэсэн байв. Эндээс үзэхэд эдийн засаг дахь төрийн оролцоог хэмжихэд ашиглаж байгаа Фрейзер институтын дээрх үзүүлэлтүүд төдийлөн хангалттай биш байгаа юм.

Эдийн засаг дахь төрийн оролцоог илэрхийлэхэд дээрх үзүүлэлтээс гадна манай орны хувьд ДНБ-д төсвийн зардлын эзлэх хувийг ашиглаж болох юм. Манай орны хувьд ДНБ-д эзлэх төсвийн нийт зардал 40 хувиас давдаг бөгөөд бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байдаг онцлогтой.

Б. Татаас ба урсгал шилжүүлэг

Татаас ба урсгал шилжүүлэг бол эдийн засаг дахь Засгийн газрын эзлэх хувь хэмжээг илэрхийлдэг чухал үзүүлэлт юм. Татаас ба шилжүүлэг бол төсвөөр дахин хуваарилагддаг тул тэдгээрийн хэмжээ өндөр байх тусмаа төр үндэсний орлогын их хувийг татвар болон татаасаар дахин хуваарилж байгаа нь тодорхой байх бөгөөд эдийн засагт түүний нөлөө их байна гэсэн үг.

Ойлголт, тодорхойлолт

Олон улсын валютын сангаас гаргасан засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлагад татаас (subsidy) гэж засгийн газраас аж үйлдвэрийн газарт буцаан төлөгдөх нөхцөлгүйгээр өгсөн төлбөрийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Татааст төрийн корпораци болон бусад аж үйлдвэрийн газарт тэдний үйл ажиллагааны алдагдлыг нөхөх зорилгоор шилжүүлсэн шилжүүлэг ордог.

¹ Транспаренси Интернэшнл байгууллага нь дэлхийн 85 гаруй улс оронд өөрийн салбартай авилгалын эсрэг олон улсын томоохон, тэргүүлэх байгууллага бөгөөд түүний идэвхтэй санаачилга, оролцоотойгоор 2003 оны 10 сарын 31 -нд НҮБ-ын Ерөнхий Ассблейгаас Олон улсын авилгалын эсрэг конвенцийг гаргасан. Түүний Монгол дахь салбар 2004 оны 8 сард байгуулагдсан.

Татаасыг засгийн газрын байгууллагаас үйлдвэрийн үйл ажиллагааны түвшин, үйлдвэрлэх, борлуулах, импортлох бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, өртгийг үндэслэн үйлдвэрийн газарт төлж буй урсгал шилжүүлэг гэж үздэг. Шилжүүлэгт эргүүлж төлөх нөхцөлгүйгээр аль нэг хуулийн этгээдээс нөгөөд олгосон хөрөнгө, бараа, үйлчилгээ, хөдөлмөрийг оруулж ойлгодог.

Манай орны хувьд Сангийн яамнаас гаргадаг улсын нэгдсэн төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллаар харуулсан зардлын төрлүүд дотор (*Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2004*, хуудас 114) татаас ба бусад урсгал шилжүүлэг гэсэн зардал байдаг. Үүнд чухам юуг хамруулдгийг судалж үзэхэд 2004 оны байдлаар дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 5. Татаас ба урсгал шилжүүлэг, оны үнээр, сая төгрөг

	2004
Татаас ба урсгал шилжүүлэг	159863.8
Татаас	10317.9
- эрчим хүч, дулааны алдагдал	7081.0
- хотын нийтийн тээвэр	3113.0
- бусад татаас	123.9
Засгийн газар хоорондын шилжүүлэг	30336.1
- орон нутгийн төсөвт өгөх татаас	25609.5
- төсөв хоорондын урсгал шилжүүлэг	4726.6
- төр хариуцах иргэдийн хураамж	4856.6
- нөхөн олговрын шимтгэл	-130.0
Өрх гэрт олгох шилжүүлэг	148524.1
Үүнээс : тэтгэвэр, тэтгэмж	115752.3

Эх сурвалж : Сангийн яамны төсвийн гүйцэтгэлийн мэдээ

Орон нутгийн төсөвт өгөх татаас нь засгийн газраас орон нутгийн төсвийн байгууллагуудыг дэмжихэд чиглэсэн урсгал шилжүүлэг юм. Харин ОУВС-аас гаргасан *Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлага*-д үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээг өртөг борлуулалт, импорт, экспортын түвшинг харгалзан үйлдвэрийн газарт олгосон урсгал шилжүүлгийг татаас гэж үздэг. Үүнээс үзэхэд төвлөрсөн төсвөөс орон нутагт олгодог урсгал шилжүүлгийг татаас гэж нэрлэж, ойлгох нь олон улсын нийтлэг ойлголттой тохирохгүй

байна. Нөгөө талаар Сангийн яамны ангиллаар татаас, урсгал шилжүүлэгт хамруулж ирсэн зардлуудад шүүмжлэлтэй хандаж болох юм. Учир нь төвлөрсөн төсвөөс Засгийн газрын шийдвэрээр улсын зарим байгууллагын үйл ажиллагааны зардлыг хөнгөвчилсөн хөнгөлөлтүүд, алдагдлыг нь улсын төсвөөс хаасан зардлуудыг татаас гэж үзсэн үү аль эсвэл ангилагдаагүй бусад зардалд оруулсан уу гэдэг нь тодорхойгүй эргэлзээтэй байгаа юм.

Мэдээллийн Эх сурвалж

Бид Сангийн яамнаас бэлтгэдэг улсын нэгдсэн төсвийн зарлагад байгаа татаас ба урсгал шилжүүлгийн дүнг 1990-1995, 2000-2004 оноор авч тооцоог хийв. ДНБ-д татаас болон урсгал шилжүүлгийн эзлэх хувийг хүснэгт 6-д харуулав.

ДНБ-ий тооцоонд далд эдийн засгийн хэмжээ дутуу туссан тул түүнийг нэмж оруулбал ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь, ДНБ-д улсын секторын эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд нь буурахад хүрнэ гэж дээр тэмдэглэсэн билээ. Хүснэгт 6-д үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ийг ашигласан. Манай орны хувьд эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ нь үйлдвэрлэлийн аргаар тооцсон хэмжээнээс 3.4% -11.4% илүү байгааг хүснэгт 2-т харуулсан. Иймээс дээрх тооцоонд ДНБ-ийг өөр 2 хувилбараар авч тооцоог хийж болно. Үүнд:

1. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ийг тооцоонд ашиглах,
2. Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан ДНБ-ийг тооцоонд ашиглаж болно.

Хүснэгт 7-д ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувийг дээрх 2 хувилбараар харуулав.

Хүснэгт 7-д далд эдийн засгийн хэмжээг 1995, 2000-2004 онд ДНБ-ий 15 хувиар нэмэгдүүлж тооцоонд оруулав. Хүснэгт 7-оос үзэхэд ДНБ-ий хэмжээ өссөн тул түүнд татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь Хүснэгт 6 -ынхаас буурсан байна. Энэ хувилбараар тооцсон бүлгийн индекс нэмэгдэж гарах болно.

Хүснэгт 6. Дотоодын нийт бүтээгдэхүүнд татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
Татаас ба урсгал шилжүүлэг, оны үнээр, сая төгрөг	2148.0	24348.9	87393.2	95480.9	109928.0	125787.3	157555.5
ДНБ, оны үнээр, сая төгрөг	10465.0	550253.7	1,018,885.7	1,115,641.4	1,240,786.8	1,461,169.2	1910880.9
ДНБ- татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь	20.53	4.43	8.58	8.56	8.86	8.61	8.25

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2003, хуудас 114

Хүснэгт 7. ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь 2 хувилбараар

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ээр	19.5	4.1	7.86	7.68	8.27	8.12	7.97
Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан ДНБ-ээр	19.5	3.8	7.46	7.44	7.70	7.49	7.17

Фрейзер институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний 2004 оны илтгэлд орсон мэдээллийн Эх сурвалж болох Дэлхийн банкнаас гаргадаг *Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд* эмхтгэлийн 1999, 2003 оны хэвлэлтийг үзэхэд нийт зардалд татаас, шилжүүлгийн эзлэх хувь гэсэн үзүүлэлт байна. Гэхдээ энэ нь ДНБ-д биш, төсвийн нийт зардалд харьцуулсан үзүүлэлт учраас манай тооцоонд мэдээллийн Эх сурвалж болгон ашиглах боломжгүй байв.

ҮСГ-ын албан ёсны статистик мэдээллээр төсвийн нийт зардалд татаас, шилжүүлгийн эзлэх хувь 1990 онд 33.1 хувь (нийт зардал 6481.5 сая, татаас ба урсгал шилжүүлэг 2148.0 сая), 2001 онд 19.5 хувь (нийт зардал 489730.5 сая, татаас ба урсгал шилжүүлэг 95480.9 сая) байхад дээрх эмхтгэлд манай орны энэ үзүүлэлт 1990 онд 56 хувь, 2001 онд 46 хувь байгаа нь ихээхэн зөрүүтэй, чухам ямар Эх сурвалж, үндэслэлээр ийм өөр тоо байгаа нь тодорхой бус байв.

Монгол Улсын индексийн тооцоо

Хүснэгт 6-д харуулсан ДНБ-д татаас болон урсгал шилжүүлгийн эзлэх хувийг үндэслэн Монгол Улсын авах оноог Фрейзер институтээс хэвлэн гаргасан *Дэлхийн эдийн засгийн чөлөөт байдлын 2004 оны илтгэл*-ийн Appendix 1, Explanatory Notes and Data Sources

гэсэн хавсралтад харуулсан арга зүй, томъёог ашиглан тооцсоныг Хүснэгт 8 -д харуулав.

Оноог

$$(V_{max}-V_i)/(V_{max}-V_{min}) * 10$$

гэсэн томъёог ашиглан тооцов. Энэ нь нийт хэрэглээнд улсын байгууллагын эзлэх хувиар оноог тооцсонтой адил томъёо юм. Дээрх томъёонд V_i нь i онд ДНБ-д татаас болон урсгал шийлжүүлгийн эзлэх хувь болно. V_{max} нь 1990 оноос хойшхи хамгийн их утга, V_{min} нь суурь 1990 оноос хойшхи хамгийн бага утга болно.

2003 оны Монгол Улсын оноог тооцсон байдлыг доор харуулав. 2003 онд ДНБ-д татаас болон урсгал шилжүүлгийн эзлэх хувь 8.61 байсан тул $V_{2003}=8.61$ болно. Эндээс Монгол Улсыг онооё $= [(V_{max}-V_{2003})/(V_{max}-V_{min})]*10=[(20.5-8.61)/(20.5-4.43)]*10=(11.89/16.07)*10=7.40$ болов.

Энд ДНБ-д татаас шилжүүлгийн эзлэх хамгийн өндөр хувь 1990 онд 20.5 хувь байсан, хамгийн бага хувь 1995 онд 4.4 хувь байсныг тооцоонд max , min утгаар авав.

Хэрэв хүснэгт 7-д харуулсан 2 хувилбараар ДНБ-д эзлэх татаас, урсгал шилжүүлгийг тооцвол дээрх оноо хэрхэн өөрчлөгдөхийг хүснэгт 9-д харуулав.

Дээрх 2 хувилбараар тооцсон оноо хүснэгт 7-д байгаагаас нэмэгдсэн нь ДНБ-ий хэмжээ

Хүснэгт 8. ДНБ -д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувийг үндэслэн тооцсон онооны тооцоо

Үзүүлэлтүүд	1990	1995	2000	2001	2002	2003	2004
V_i - ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь	20.53	4.43	8.58	8.56	8.86	8.61	8.25
$V \max - V_i$, ($V \max = 20.53$,)	0	16.1	11.95	11.97	11.67	11.92	12.28
$V \max - V \min$, ($V \min = 4.43$)	16.1	16.1	16.10	16.10	16.10	16.10	16.10
The rate $= (V \max - V_i) / (V \max - V \min) \times 10$	0	10.0	7.42	7.43	7.25	7.40	7.6

Хүснэгт 9. ДНБ-д эзлэх татаас, урсгал шилжүүлгээр тооцсон оноо

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ээр	0	10	7.5	7.6	7.3	7.4	7.5
Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан ДНБ-ээр	0	10	7.6	7.7	7.5	7.6	7.8

нэмэгдэж, түүнд татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь буурсантай холбоотой.


Судалгааны дүн

Эдийн засагт татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь их байх тусам эдийн засгийн эрх чөлөө хязгаарлагддаг гэж үздэг. ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувийг үндэслэн тооцсон индексийг дээр хүснэгт 8-д харуулсан билээ.

Зураг 2-оос үзэхэд ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь 1990 онд 20.5 байснаа 2004 онд 8.3 хувь болж буурсан байна. Үүнтэй холбоотойгоор индекс суурь оноос өссөн. Үүний зэрэгцээ ДНБ-д эзлэх татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь 2000 оноос хойш үндсэндээ нэг түвшинд төдийлөн буурахгүй байгааг тэмдэглэвэл зохино.

Өмнөх хүснэгт 5-аас харахад татаас, урсгал шилжүүлгийн нийт дүнд 2004 онд татаас (эрчим хүч, дулааны алдагдалд болон хотын нийтийн тээвэрт) дөнгөж 6.5 хувийг, харин 92.8 хувийг нь өрх гэрт олгох шилжүүлэг (тэтгэвэр, тэтгэмж) эзэлж байгаа юм.

Зураг 2. ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь



В. Нийт үйлдвэрлэл болон хөрөнгө оруулалтад улсын үйлдвэрүүд болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь

Мэдээллийн Эх сурвалж

Нийт үйлдвэрлэлтэнд (output) улсын үйлдвэрүүдийн эзлэх хувийг үндэсний статистикийн газрын ДНБ-ий жил бүрийн дэлгэрэнгүй тооцоогоор авав. Харин нийт хөрөнгө оруулалтад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувийг 2004 болон 2005 оны *Монгол Улсын статистикийн эмхтгэл*-ээс авав. Гэхдээ эхний бүлгийн нэгдсэн индексийг тооцоходоо энэ 2 үзүүлэлтийн аль нэгийг нь сонгон авах юм.

ҮСГ-ын тооцоогоор нийт үйлдвэрлэлтэнд улсын үйлдвэрийн газрын эзлэх хувийн жин нь ДНБ-д улсын секторын эзлэх хувьтай адил байв. Харин нийт хөрөнгө оруулалтын хэмжээг харуулсан мэдээлэл нь манай орны хувьд хамралт нь бүрэн бус, ялангуяа хувийн секторын хөрөнгө оруулалт дутуу тооцогдсон байж болох талтай. Учир нь энэ талын мэдээллийг арилжааны банкууд гаргадаггүй бөгөөд ҮСГ нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс өөрийн Эх сурвалжээр хийсэн хөрөнгө оруулалтыг албан ёсны статистикийн мэдээгээр бүрэн гаргуулан авч чадахгүй байгаа билээ. Нөгөө талаар манайд хөрөнгө оруулалтанд хамруулдаг зүйл олон улсын нийтлэг жишгээс нэлээд зөрүүтэй байж магадгүй байна. Учир нь өнөөдрийн хөрөнгө оруулалтын мэдээ тайланг гаргадаг аргачлалаар шинээр барьсан барилга байшин, ашиглалтанд оруулсан үндсэн хөрөнгийг гол төлөв хөрөнгө оруулалтын тооцоонд оруулаад хуучин байшинд худалдан авсан тоног төхөөрөмжийг дутуу тооцдог тал ажиглагддаг.

Харин улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь Сангийн яамнаас улсын төсвийн зарлагын мэдээллээр харьцангуй бодитой тооцогддог үзүүлэлт гэж үзлээ. Ийм учраас нийт хөрөнгө оруулалт нэмэгдвэл улсын секторын хөрөнгө оруулалтын эзлэх хувь доошлох болно. Энэ тохиолдолд нийт хөрөнгө оруулалтад улсын секторын эзлэх хувиар тооцсон Монгол Улсын авах оноонд онцын өөрчлөлт орохгүй. Учир нь одоогоор 12.8-14.5

хувийн хооронд байгаа энэ хувь доошлоход ямар ч тохиолдолд (хүснэгт 8-ын эхний баганыг хар) 15 хувиас доош байхад 10 гэсэн оноо авдаг тул нөлөө үзүүлэхгүй байна.

Монгол Улсын онооны тооцоо

Хүснэгт 10-д нийт үйлдвэрлэлтэнд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувь, нийт хөрөнгө оруулалт, үүнээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, эзлэх хувь, дээрх үзүүлэлтүүдээр Монгол Улсын авах оноог харуулав.

Манай орны хувьд нийт хөрөнгө оруулалтанд улсын секторын хөрөнгө оруулалтын эзлэх хувь 1995, 2000-2004 онуудад 15%-аас доош байгаа тул дээрх онуудад бүгдэд нь 10 оноо авахаар байна.

Харин нийт үйлдвэрлэлтэнд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувь (Хүснэгт 11) 2000-2004 онд 24.0-27.8 хувийн хооронд байгаа тул манай улсын авах оноо дээрх онуудад үндсэндээ 6-7 байна. Энэ үзүүлэлтийг тооцсон мэдээллийг чанарын хувьд хөрөнгө оруулалтынхаас харьцангуй найдвартай гэж үзээд хэсгийн нэгдсэн индексийн тооцоонд нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувийг сонгон авлаа.

Хэрэв ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар болон далд эдийн засгаар нэмэгдүүлж аваад нийт үйлдвэрлэлт түүнтэй пропорционалаар өснө, улсын үйлдвэрүүдийн нийт гаргалт өөрчлөгдөхгүй гэж үзвэл дээрх хувь дараах байдлаар өөрчлөгдөх тооцоо гарч байна.

Хүснэгт 12-д харуулсан тооцоогоор нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувь доошилсон тул түүгээр тооцсон оноо ихэнх онуудад хүснэгт 10-аас нэмэгдсэн.

Судалгааны дүн

Бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэхдээ эдийн засагт хувийн болон улсын сектор ямар байр суурьтай байгаа нь эдийн засгийн эрх чөлөөнд их нөлөөтэй гэж үздэг. Яагаад гэвэл улсын үйлдвэрүүд нь хөрөнгийн эрсдэл хүлээх болон орлого олохдоо хэрэглэгчдээс хамааралгүй нөхцөлд ажилладаг. Улсын үйлдвэрүүд нь чөлөөт өрсөлдөөний бус харин тодорхой хэмжээгээр хамгаалагдсан

Хүснэгт 10. Нийт үйлдвэрлэлт, хөрөнгө оруулалтанд улсын секторын эзлэх хувь, тэдгээрийг үндэслэн тооцсон оноо

	1995	2000	2001	2002	2003	2004
Нийт үйлдвэрлэлтэнд улсын үйлдвэрийн эзлэх хувь	47.4	27.8	25.0	25.5	27.0	24.0
Эзлэх хувьд ноогдох оноо	2.0	6.0	7.0	6.0	6.0	7.0
Нийт хөрөнгө оруулалт, оны үнээр, тэрбум төгрөг	91.5	284.7	309.5	329.3	418.0	406.9
Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	13.2	36.3	40.9	44.2	55.1	59.0
Нийт хөрөнгө оруулалтанд улсын төсвийн Х.О.-ын эзлэх хувь	14.4	12.8	13.2	13.4	13.2	14.5
Эзлэх хувьд ноогдох оноо	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0

Хүснэгт 11. Нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрийн эзлэх хувиар авах оноо

Авах оноо	10	8	7	6	4	2	0
Үзүүлэлтийн утга	15% бага	15-20	20-25	25-30	30-40	40-50	50% дээш

Хүснэгт 12. Хувилбар тооцоо

	1995	2000	2001	2002	2003	2004
Нийт үйлдвэрлэлтэнд улсын үйлдвэрийн эзлэх хувь						
1. Эцсийн ашиглалтын аргаар засварласан	44.2	25.4	22.4	23.8	25.5	23.2
2. Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан	41.2	24.1	21.7	22.2	23.5	20.9
Дээрх хувиар тооцсон оноо						
1. Эцсийн ашиглалтын аргаар засварласан	2.0	6.0	7.0	7.0	7.0	7.0
2. Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан	2.0	7.0	7.0	7.0	7.0	7.0

Хүснэгт 13. Улсын секторын эзлэх хувь, оноо


	1995	2000	2001	2002	2003	2004
Нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувь	47.4	27.8	25.0	25.5	27.0	24.0
Оноо	2.0	6.0	7.0	6.0	6.0	7.0
Нийт хөрөнгө оруулалтанд улсын төсвийн ХО-ын эзлэх хувь	14.4	12.8	13.2	13.4	13.2	14.5
Оноо	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0

зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Иймээс бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд улсын үйлдвэрүүд өндөр хувийн жин эзэлсэн тохиолдолд зах зээлийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болсон чөлөөт өрсөлдөөн хязгаарлагддаг гэж үздэг. Хүснэгт 13-д нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувь, нийт хөрөнгө оруулалтанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь, тэдгээрийг үндэслэн манай орны авах оноог харуулав.

Энд 2 үзүүлэлт байгаа боловч түүний аль нэгнээр нь өөрийн оноог гаргаж болдог тул нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувийг буюу бага оноог нь бүлгийн нэгдсэн индексийн тооцоонд авлаа.

Хүснэгт 14. Дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн эзлэх хувь

	1999	2000	2001	2002	2003	2004
Бүгд	70.3	72.2	75.0	74.5	73.0	76.0
Үүнээс:						
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	96.4	98.0	98.3	98.4	91.1	95.9
Уул уурхай, олборлох АҮ	56.0	56.6	74.9	64.2	61.7	69.0
Боловсруулах АҮ	75.0	78.7	94.9	87.8	86.2	86.4
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл				3.1	3.2	3.2
Барилга	89.1	89.2	89.5	93.1	94.2	94.0
Бөөний болон жижиглэн худалдаа	80.3	88.8	90.0	98.2	99.9	99.9
Зочид буудал, зоогийн газар	84.3	91.7	94.6	100.0	100.0	100.0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	41.1	57.7	58.0	60.1	59.7	62.9
Боловсрол	12.9	11.0	8.2	9.5	11.9	14.5
Эрүүл мэнд	5.5	6.3	6.5	9.0	11.4	12.1

Зураг 3. Нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувь

Энэ үзүүлэлтээр тооцсон оноо 1995 онд 2 гарч байсан бол 2000 оноос тогтмол 6-7 болж дээшилсэн байна.

Манай оронд өмч хувьчлалыг эрчимтэй өрнүүлж, нийт эдийн засагт хувийн хэвшлийн эзлэх хувь нэмэгдсэн нь төрийн байгууллагуудын эдийн засагт эзлэх хэмжээг багасгахад хүргэжээ (Хүснэгт 14).

Г. Татварын дээд хэмжээ, түүнийг оногдуулах орлогын түвшин**Ойлголт, тодорхойлолт**

ОУВС-гаас гаргасан Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлагад тодорхойлсноор татвар нь Засгийн газрын сектороос хүлээн авдаг албан журмын шилжүүлгүүд болно. Энэ нь үйлчилгээ үзүүлсэн зардлын хэмжээтэй харьцуулахуйц хураамжууд юм. Энэ ойлголт тодорхойлолт нь манай орны хувьд мөн адил агуулгатай үйлчилж байна.

Манай орны хувьд татварын шинэ тогтолцоо 1990-ээд оны дунд үеэс бий болжээ. Татварын багц хууль анх 1993 онд батлагдаж 1995 оноос мөрдөгдөх үед аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээ 45 хувь, уг татварыг ногдуулах орлого 1 сая 500 мянган төгрөг байжээ. 1998 онд уг хуульд оруулсан өөрчлөлтөөр татварын дээд хэмжээ хэвээр үлдэж, татвар оногдуулах орлогын түвшин 100 сая төгрөгөөс дээш болжээ. Уг хуулийг 2003 онд дахин өөрчилж, 2004 оноос мөрдөж эхэлсэн шинэ өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээ 100 сая төгрөгөөс дээш орлогоос 30 хувиар тогтоогджээ. Хүн амын орлогын албан татварын дээд хэмжээ, түүнийг тогтоосон орлогын түвшин мөн л өөрчлөгдөж иржээ.

Хүснэгт 15. Өндөр татвар ногдуулдаг хувь болон түүнд хамаарах орлогын түвшинг харгалзан олгох оноо

Татварын Дээд Хувь	Татвар Ноогдуулах Орлогын Түвшин (1982/1984 USS)			
	<\$25,000	\$25,000-\$50,000	\$50,000-\$150,000	>\$150,000
<20%	10	10	10	10
21%-25%	9	9	10	10
26%-30%	8	8	9	9
31%-35%	7	7	8	9
36%-40%	5	6	7	8
41%-45%	4	5	6	7
46%-50%	3	4	5	5
51%-55%	2	3	4	4
56%-60%	1	2	3	3
61%-65%	0	1	2	2
66%-70%	0	0	2	1
>70%	0	0	0	0

Эдгээрийг Хүснэгт 16-д харуулав.

Эдийн засгийн эрх чөлөөний энэ 4 дэх үзүүлэлт дотроо 2 янз байгаа. Манай орны хувьд эхнийх нь аж ахуйн нэгжүүдээс төлөх орлогын татвар, хоёрдахь нь хүн амын орлогын албан татварт хамаарна гэж үзлээ. Гэхдээ хоёр дахь үзүүлэлтэд хүн амын орлогын албан татварын зэрэгцээ Фрейзер институтын аргачлалаар хүн амын орлогоосоо төлдөг бусад хураамжуудыг оруулав. Үүнд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын хураамжуудыг оруулж тооцлоо.

Монгол Улсын индексийн тооцоо

Фрейзер институтээс хэвлэн гаргасан *Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний 2004 оны илтгэлийн Appendix 1, Explanatory Notes and Data Sources* гэсэн хавсралтад харуулсан арга зүйгээр бага орлогод өндөр татвар оногдуулдаг орнуудад бага оноо ноогддог. Энэхүү хавсралтанд өндөр татвар оногдох орлогын түвшинг үндэсний мөнгөн тэмдэгтээс 1982/1984 оны АНУ-ын долларт шилжүүлэхдээ Хүснэгт 15 -д харуулсан ангиллаар оноо олгохоор тусгажээ.

Хүснэгт 15-ыг үндэслэн Монгол Улсын холбогдох оноог хэрхэн тооцсоныг доорхи

жишээгээр харуулав. Тухайлбал, 2003 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээ Монгол Улсад 100 сая төгрөгөөс дээш орлогод 40 хувь байсан. Хүснэгт 15-ын 40%-д харгалзах орлогын түвшин нь АНУ-ын доллароор \$ 50000-\$ 150000-ын бүлэгт оногдох тул эдгээр нүдний уулзвар дээр таарч байгаа 7 гэсэн оноо нь 2003 оны энэ үзүүлэлтээр тооцсон оноо болно.

Үүнтэй нэгэн адилаар 2004 оны хувьд онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээ 30 хувь болсон тул энэхүү хувьд ноогдох мөрөнд АНУ-ын доллароор \$50000-\$150000-ын бүлэгт таарах оноо 9 байгаа юм.

Хүн амын орлогын албан татварын дээд хэмжээг үндэслэн оноог тооцох арга мөн дээрхтэй төстэй. Тухайлбал, 2003 онд хүн амын орлогын албан татварын дээд хэмжээ нь 40 хувь байсан бөгөөд түүнийг 4.8 сая төгрөгөөс давсан орлогоос тооцож байжээ. Үүний зэрэгцээ 1994-1995 онд батлагдсан эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын хуулиар хүн амын орлогоос 10 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд (3%-эрүүл мэнд, 5.5%-гэтгэвэр, 1%-тэтгэмж, 0.5%-ажилгүйдлийн даатгал) төлдөг. Үүнийг Хүснэгт 15-аас харахад 53% ноогдох 4.8 саяас дээш орлого нь АНУ-ын доллароор

Хүснэгт 16. Татварын дээд хэмжээ, түүнийг оногдуулах орлогын түвшин

	1995	2000	2001	2002	2003	2004
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээ, хувиар	45	40	40	40	40	30
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээг оногдуулах орлогын түвшин	1 сая 500 мянгаас дээш	100 саяас дээш	100 саяас дээш	100 саяас дээш	100 саяас дээш	100 саяас дээш
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар авах оноо	4	7	7	7	7	9
Хүн амын орлогын албан татварын дээд хувь	45	40	40	40	40	30
Хүн амын орлогоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх хувь	10	10	10	10	10	10
Хүн амын орлогын албан татварын дээд хувийг оногдуулах орлого, сая төгрөг	64 мянгаас дээш	1 сая 115 мянгаас дээш	1 сая 115 мянгаас дээш	4 сая 800 мянгаас дээш	4 сая 800 мянгаас дээш	4 сая 800 мянгаас дээш
Хүн амын орлогын албан татвараар авах оноо	2	3	3	3	3	5
Онооны дундаж	3	5	5	5	5	7

Эх сурвалж: Монгол Улсын татварын хуулиуд, түүнд орсон өөрчлөлтүүд

тооцвол \$ 25000 доош ангилалд хамаарах тул эдгээр мөрүүдийн огтлолцол дээр байгаа 2 гэсэн оноог авна. Харин 1995 оны хувьд дээрх хувь 55% (45+10), 2004 оны хувьд 40% (30+10) болох тул хүснэгт 15-аас харгалзах оноо нь 1995 онд 2, 2004 онд 5 болно.

Тухайн оны татварын ерөнхий оноог дээрх 2 төрлийн татварын дунджаар тооцож гаргадаг. Тухайлбал, 2003 оны хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээгээр тооцсон оноо 7, харин хүн амын орлогын албан татварын дээд хэмжээгээр тооцсон оноо 2 тул тэдгээрийн дундаж болон 4.5 оноо нь 4 дэх үзүүлэлтийн оноо болно. Фрейзер институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний 2004 оны илтгэлийн хавсралтанд харуулсан улс орнуудын энэ бүлгийн 4 дэх үзүүлэлтийн оноог ийм аргаар тооцсон байсан.

Судалгааны дүн

Бага орлогоос өндөр татвар авах нь түүнээс зайлсхийх сонирхол төрүүлж, хүмүүсийн хөдөлмөрийн үр дүнд нөлөөлдөг тул эдийн засгийн эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлдэг гэж үздэг. Татварын багц хуулиар тогтоосон

татварын дээд хэмжээ, түүнийг оногдуулдаг орлогын түвшинг хүснэгт 16-д харуулав.

Дээрх 2 оноог дундажлан эцсийн энэ 4 дэх үзүүлэлтийн оноог гаргадаг. Бид дундаж оноог хүснэгт 16-д бүлгийн индексийн тооцоонд харуулсан. Хүснэгт 16-аас үзэхэд 1995 онд 3 оноо байсан бол 2004 онд 7 болж 2.3 дахин өссөн нь энэ хугацаанд хүн амын орлогын албан татварын дээд хэмжээ 45 хувиас 30 болтлоо буурч ирсэний үр дүн юм.

1.2 ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКСИЙН ТӨРИЙН ОРОЛЦОО, ХЭМЖЭЭГ ИЛЭРХИЙЛСЭН ЭХНИЙ БҮЛГИЙН НЭГДСЭН ИНДЕКС

Бидэнд нэгэнт 4 гол үзүүлэлтээр өмнө нь тооцсон оноо байгаа тул дээрх Фрейзер институтын аргачлалаар эдгээр 4 онооны арифметик дунджаар бүлгийн дундаж индексийг тооцож гаргасан. (Хүснэгт 17)

Үүнийг 2003 онд хэрхэн тооцсоныг жишээгээр харуулья.

Бүлгийн дундаж оноо= $(6.1+7.4+6.0+5)/4 = 6.1$


Хүснэгт 17-д харуулсан бүлгийн нэгдсэн индексийн тооцоо нь манай орны албан ёсны статистикийн мэдээлэлд тулгуурлан хийсэн тооцоо болно. Харин ДНБ-ий хэмжээг 2 хувилбараар авч үзвэл бүлгийн ерөнхий индекс дараах байдлаар өөрчлөгдөн гарч байна (Хүснэгт 18).

Хүснэгтээс харахад 2 хувилбараар тооцсон бүлгийн нэгдсэн индекс албан ёсны тооцооныхоос 2001-2003 онуудад бага зэрэг нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ 3 дах хувилбар байж болно. Тэр нь нийт хөрөнгө оруулалтанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувиар тооцсон оноог ашигласан хувилбар юм. Бид албан ёсны болон дээрх хувилбаруудын тооцоонд зөвхөн нийт үйлдвэрлэлтэнд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувиас тооцсон оноог ашигласан билээ. Энэ тохиолдолд дээрх хүснэгтийн улсын үйлдвэр ба хөрөнгө оруулалт гэсэн 3 дах үзүүлэлтийн оноонуудыг бүх онд 10 гэж авах тул бүлгийн нэгдсэн индекс улам өсөх болно.

Бүлгийн нэгдсэн индексийг дээр дурьдсан 4 гол үзүүлэлтийн арифметик дунджаар тооцдог аргачлалтай. Бүлгийн нэгдсэн индекс маань 0-10-ын хооронд хэлбэлздэг бөгөөд төрийн байгууллагуудын нийт хэрэглээнд эзлэх хувь, нийт үйлдвэрлэлтэнд улсын үйлдвэрүүдийн эзлэх хувь, татварын дээд хэмжээ бага байх тусам 10 уруу ойрхон индекс гардаг. Үүний эсрэгээр байвал бүлгийн нэгдсэн индекс тэгд ойрхон гардаг.

Эдийн засгийн эрх чөлөөний индексийн Засгийн газрын хэмжээг харуулсан эхний бүлгийн нэгдсэн индексийг 1995 болон 2000-2004 оноор доорх зурагт харуулав.

Зураг 4. Бүлгийн нэгдсэн индекс



Манай орны хувьд эдийн засгийн эрх чөлөөний индексийн Засгийн газрын хэмжээг харуулсан 4 бүлэг гол үзүүлэлт болон бүлгийн нэгдсэн индекс ямар гарсныг дээр хүснэгт 17-д харуулсан билээ.

Зураг 3 болон хүснэгт 17-оос үзэхэд манай орны хувьд Засгийн газрын хэмжээг харуулсан эхний бүлгийн нэгдсэн индекс 1995-2004 онд 5.3 - 6.8-ын хооронд гарсан. Харин 2004 онд уг индекс ихэд дээшилжээ. Энэ нь бидний өмнө нь төсөөлж байснаас сайн, өөрөөр хэлбэл, төрийн байгууллагуудын хэмжээ, оролцоо харьцангуй бага байсан тул нэлээд өндөр индекс гарчээ. Бүлгийн нэгдсэн индекс 1995 онд 5.3 байснаа 2004 онд 6.8 болж, мэдэгдэхүйц өссөн нь манай орны эдийн засагт улсын секторын эзлэх байр суурь аажмаар буурч, харин хувийн хэвшлийн эзлэх хувь нэмэгдэж, татаас, урсгал шилжүүлэг, татварын дээд хэмжээ багассантай холбоотой байна. Эдийн засгийн эрх чөлөө энэ бүлэгт тусгасан үзүүлэлтүүдийн дүнгээр 1995 оноос хойш ерөнхийдөө сайжирч ирсэн байна.

Хэдийгээр манай орны индекс өндөр гарсан боловч цаашдаа үүнээс дээшээ өсөх боломж байна уу? Энэ бүлгийн гол үзүүлэлтээс ямар үзүүлэлт хойш нь татаж байна вэ? гэсэн асуултыг тавьж үзэхэд хүснэгт 17-оос хариулт зарим хэмжээгээр харагдаж байна. Хүн амын орлогын албан татвараар тооцсон оноо бүлгийн нэгдсэн индексийг ихээхэн доош нь татаж байгаа тул энэ чиглэлээр төрөөс ихээхэн анхаарч, татварын хэмжээг багасгавал нэгдсэн индекс өсөх нь тодорхой байна.

Хүснэгт 17. Эдийн засгийн эрх чөлөөний индексийн эхний бүлэг үзүүлэлтээр Монгол Улсын авах оноо

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
1. Бүлгийн нэгдсэн индекс	-	5.5	6.1	6.3	6.1	6.1	6.8
A. Улсын байгууллагын Хэрэглээ	2.2	6.8	6.0	5.9	6.2	6.1	5.7
B. Татаас, урсгал Шилжүүлэг	0.0	10.0	7.4	7.4	7.3	7.4	7.6
C. Улсын үйлдвэр ба Хөрөнгө оруулалт	0.0	2.0	6.0	7.0	6.0	6.0	7.0
D. Татварын дээд хэмжээ		3.0	5.0	5.0	5.0	5.0	7.0
1. Аж ахуйн нэгжийн орлогын татвар	Мэдээлэлгүй	4.0	7.0	7.0	7.0	7.0	9.0
2. Хүн амын орлогын татвар	Мэдээлэлгүй	2.0	3.0	3.0	3.0	3.0	5.0

Хүснэгт 18. Хоёр хувилбараар тооцсон бүлгийн ерөнхий индекс

	1990	1995	2000	2001	2002	2003	2004
1. Бүлгийн нэгдсэн индекс							
1. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ		5.45	6.1	6.4	6.4	6.4	6.8
2. Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан ДНБ		5.45	6.4	6.4	6.4	6.4	6.9
A. Улсын байгууллагын хэрэглээ	2.2	6.8	6.0	5.9	6.2	6.1	5.7
B. Татаас, урсгал шилжүүлэг							
1. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ээр	0	10	7.5	7.6	7.3	7.4	7.5
2. Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан ДНБ-ээр	0	10	7.6	7.7	7.5	7.6	7.8
C. Улсын үйлдвэр ба хөрөнгө оруулалт							
1. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ээр		2	6	7	7	7	7
2. Далд эдийн засгийн хэмжээг нэмж тусгасан ДНБ-ээр		2	7	7	7	7	7
D. Татварын дээд хэмжээ		3	5	5	5	5	7
1. Аж ахуйн нэгжийн орлогын татвар	Мэдээлэлгүй	4.0	7.0	7.0	7.0	7.0	9.0
2. Хүн амын орлогын татвар	Мэдээлэлгүй	1.0	2.0	2.0	2.0	2.0	4.0

Төсвийн байгууллагуудын зардлыг багасгах, улсын төсвийн зардалд үр ашиггүй зардлыг багасгах, улсын хэмжээний нийт үйлдвэрлэлтэд улсын өмчтэй үйлдвэрүүдийн эзлэх хувь хэмжээг багасгах, өөрөөр хэлбэл, өмч хувьчлалыг цаашид үргэлжлүүлэх бодлогыг төрөөс явуулбал эдийн засгийн эрх

чөлөө нэмэгдэх нөхцөл бүрдэх болно. Цаашдаа манай оронд татварын хуулийг шинэчилж, нэг шатлалтай болгож, татварын дээд хэмжээг бууруулбал энэ бүлгийн 4 дэх үзүүлэлтээр тооцох индекс одоогийнхоос улам өсөх болно. 2004 оноос аж ахуйн нэгжийн албан татварын дээд хэмжээг 40 хувиас 30 болгон бууруулснаар

энэ үзүүлэлтээр тооцсон дундаж индекс 2003 онд 5 байснаа 2004 онд 7 болж өссөнийг хүснэгт 16- аас харж болно.

1.3 БҮЛГИЙН ИНДЕКС БОЛОН БУСАД ҮЗҮҮЛЭЛТИЙН ХООРОНДЫН ХАМААРАЛ


Эдийн засгийн эрх чөлөөний индекс, үүний дотор бидний тооцсон төрийн байгууллагын хэмжээ, оролцоог харуулсан хэсгийн индекс нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн бусад үзүүлэлтүүдтэй ямар холбоотой байгааг судлах нь эдийн засгийн дүн шинжилгээ хийх, төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын чанартай шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой юм. Гэхдээ дээр дурьдсан Фрейзер институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн байдлын 2004 оны илтгэлд дурьдсанаар судалгааны үр дүн нь үзүүлэлтүүдийг хэр урт хугацаагаар авснаас ихээхэн шалтгаалдагийг бид энд харгалзан үзэх ёстой.

Бидний тооцоо нь 1990 оноос хойшхи оныг хамарч байгаа тул эдгээрт түр зуурын өөр хүчин зүйл нөлөө үзүүлсэн байж болох талтай. Нөгөө талаар эдийн засгийн эрх чөлөөний ерөнхий индексийг бүрэн тооцсон нөхцөлд энэ хамаарлыг судлах нь илүү зохистой юм. Гэсэн хэдий боловч бид энэ хэсэгт Монгол Улсын хувьд эдийн засгийн чөлөөт байдлын индексийн эхний бүлгийн нэгдсэн индексийг эдийн засаг, нийгмийн бусад үзүүлэлтүүдтэй ямар хамааралтай байгааг судлан үзэхийг хичээв. Энэ хэсгийн индекс маань зөвхөн төрийн эдийн засаг дахь оролцоо, хэмжээг илэрхийлж байгаа тул төрийн оролцоо нь эдийн засаг, нийгмийн бусад үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлж байгааг харуулах болно. Эхлээд төрийн байгууллагын хэмжээ болон эдийн засаг дахь хувийн секторын эзлэх хувь хоорондоо ямар холбоотойг дараах Зураг 5-д харуулав.

Зураг 5-аас харахад ДНБ-д хувийн секторын эзлэх хувь болон төрийн байгууллагуудын хэмжээг илэрхийлсэн үзүүлэлтээр тооцсон бүлгийн индекс хоёр хоорондоо нэлээд хамааралтай нь харагдаж байна. Эдийн засагт хувийн секторын эзлэх хэмжээ өсөх тусам

төрийн байгууллагуудын эзлэх хэмжээ буурч, тэр хэмжээгээр бүлгийн индекс нэмэгдэж байгаа нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, эдийн засаг дахь хувийн сектор өсөх тусам бүлгийн индекс даган өсч, буурахад мөн буурч байна.


Зураг 5. Засгийн газрын хэмжээ болон эдийн засаг дахь хувийн хэвшлийн эзлэх хувь



Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2003

Төрийн байгууллагын хэмжээ болон нэг хүн амд ноогдох орлогын хооронд ямар хамаарал байгааг мөн авч үзэв.

Зураг-6 болон түүний хүснэгтээс харахад худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон нэг хүн амд ноогдох орлого, бүлгийн индексийн аль аль нь 1995 оноос хойш өсөж иржээ. Худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон нэг хүн амд ноогдох орлогын 2003-2004 оны мэдээлэл олдоогүй тул эдгээр оныг судалгаанд хамруулж чадаагүй. Дээр дурьдсан Фрейзер институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний 2004 оны илтгэлд дэлхий нийтээр эдийн засгийн эрх чөлөө нэмэгдэхэд хүн амын орлого өсдөг ерөнхий зүй тогтол байгааг тэмдэглэсэн. Ийм хамаарал манай орны хувьд илэрч байгаа эсэхийг судлах зорилгоор дээрх үзүүлэлтүүдийн хоорондын корреляцийн хамаарлыг тооцов. EXCEL программын tools menu дахь data analysis хэрэгслийг ашиглан корреляцын коэффициентийг тооцоход $R=0.68$ гарч байгаа нь эдгээр үзүүлэлтүүд хоорондоо нэлээд хүчтэй хамааралтайг харуулж байна. Гэхдээ энэ дүгнэлтийг богино хугацааны динамик үзүүлэлт дээр үндэслэн хийсэн тул түүнд бас болгоомжтой хандах нь зүйтэйг дурьдвал зохино.

Зураг 6. Төрийн байгууллагын хэмжээ болон нэг хүнд ногдох орлого

Эх сурвалж: Монголын Хүний хөгжлийн илтгэл, 2003, хуудас-8 болон энэхүү илтгэлд орсон индексийн тооцоо

Эцэст нь тэмдэглэхэд төрийн байгууллагын хэмжээ, оролцоог харуулсан бүлгийн индекс нь эдийн засгийн эрх чөлөөний индексийн нэг бүрэлдэхүүн хэсэг тул уг ерөнхий индексийн адил өргөн агуулгатай биш учраас нэлээд хязгаарлагдмал хүрээнд авч үзлээ.

1.4 ОЛОН УЛСЫН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТ

Манай судалгааны нэг гол зорилт нь Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний байдлыг дэлхийн бусад улс орнуудтай зэрэгцүүлэн судалж, манай орны эзлэх байр суурийг тодорхойлох явдал юм.

Төрийн оролцоо, хэмжээг илэрхийлсэн эхний бүлгийн нэгдсэн индексээр Монгол Улс бусад орнуудтай зэрэгцүүлэхэд ямар түвшинд байгааг дүгнэх зорилгоор Фрейзер институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн байдлын 2004 оны илтгэлийг ашиглав.

Фрейзер институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн байдлын 2004 оны илтгэлд (Exhibit 1.3, page 13-15) дэлхийн 123 орныг 2002 оны байдлаар эдийн засгийн эрх чөлөөний 5 гол бүлгийн индексээр нь эрэмблүүлэн байр эзлүүлсэн байна. Энэхүү зэрэгцүүлэлтийн Засгийн газрын хэмжээг харуулсан эхний бүлгийн индексээр манай индекс 2002 онд 6.0 гарсан бөгөөд ийм

индексстэй Белиз (Belize) улс 60-р байранд оржээ. Үүнээс дүгнэж үзэхэд Монгол Улс Засгийн газрын хэмжээ, оролцоог илэрхийлсэн эхний бүлгийн индексээр 2002 онд Фрейзерийн институтийн зэрэгцүүлэлтэнд оролцсон бол 60-р байр орчимд орохоор байна. 2004 онд манай орны индекс 6.8 болсноос үзэхэд Монгол Улс одоо эхний 60-аас дотогшоо орсон ч байж болохоор байна. Хэритэйжийн сангаас гаргаж, *Wall Street* сэтгүүлд хэвлэгдсэн материалаас үзэхэд Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний ерөнхий индекс 2004 онд 2.90 болж, уг судалгаанд хамрагдсан дэлхийн 155 орноос 63 дугаар байранд, харин 2005 онд 50 дугаар байранд орж урагшилсан байсан.

Зарим улс орны үзүүлэлтүүдтэй Монгол Улсын индексийг зэрэгцүүлэн хүснэгт 19-д харуулав. Хүснэгт 19-өөс үзэхэд нэлээд улс орны бүлгийн индекс тууштай өсөж байхад зарим орных өмнөх онуудаасаа буурсан харагдаж байна. Тэгэхээр бүлгийн индекс бол нэлээд хөдөлгөөнтэй тогтворгүй үзүүлэлт гэдэг нь харагдаж байна.

Хүснэгт 19. Засгийн газрын хэмжээг харуулсан нэгдсэн индекс, сонгосон зарим орноор

Он	1990	1995	2000	2001	2002
Монгол		5.5	6.1	6.3	6.1
Аргентин	6.7	7.7	7.8	7.9	7.7
Австр	5.4	5.7	6.2	6.1	6.2
Бангладеш	7.0	7.7	7.7	8.1	8.1
Бразил	4.2	4.4	5.9	5.9	6.2
Болгар	4.3	4.6	5.1	5.7	6.0
Канад	7.5	7.8	8.1	8.1	7.9
Чили	6.5	7.3	7.1	6.1	6.1
Хятад	3.6	4.0	3.8	3.8	3.1
Чех		5.8	6.7	6.9	6.9
Дани	2.9	3.1	3.6	3.9	3.9
Эстони		5.6	7.1	7.6	7.7
Финлянд	4.2	3.7	4.1	4.5	4.6
Франц	3.5	3.2	2.3	2.8	2.8
Герман	4.9	4.4	4.5	4.2	4.2
Гонг Конг	9.3	9.5	9.2	9.1	9.1
Унгар	2.9	4.7	4.8	5.2	5.7
Израель	3.3	2.8	2.7	2.6	2.6
Польш	2.0	2.6	5.0	5.5	5.6
ОХУ	1.9	4.8	5.3	5.5	5.3
Сингапур	8.2	8.4	8.0	7.8	8.0
Словени	4.1	1.8	2.9	2.5	3.1
Өмнөд Солонгос	6.2	6.8	7.1	7.3	7.4
Япон	6.1	5.0	5.3	5.6	5.6
Латви	7.6	4.1	5.2	5.7	5.8
Литва		4.2	5.6	5.7	5.5
АНУ	6.7	6.9	7.6	7.3	7.4
Их Британи	5.9	5.7	6.2	6.6	6.8

Эх сурвалж: James Gwartney and Robert Lawson Economic Freedom of the World: 2004 Annual Report and author's estimation

Хүснэгтээс харахад энд сонгон авсан 28 орноос 2001-2002 оны байдлаар Аргентин, Гонг Конг, АНУ, Их Британи, Канад, Чех, Эстони, Өмнөд Солонгос, Сингапур, Бангладеш гэсэн 10 орны индекс Монгол Улсынхаас өндөр, бусад орнуудынх манайхаас доогуур байна.

Үүнээс үзэхэд Монгол Улс төрийн байгууллагын хэмжээг илэрхийлсэн эхний бүлэг үзүүлэлтээр гаргасан нэгдсэн индексээр

дундаас доогуур үзүүлэлттэй орны тоонд багтсан байна.

Эдийн засгаа либералчлах, төрийн оролцоог багасгах талаар улс орнуудад 1990-2002 онд янз бүрийн өөрчлөлт гарсан нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Шилжилтийн эдийн засагтай зарим орнууд Засгийн газрын хэмжээг багасгах талаар мэдэгдэхүйц ахиц олжээ. Тухайлбал, Польш улсын Засгийн газрын хэмжээ

Хүснэгт 20. Улсын байгууллагын хэрэглээнд үндэслэсэн оноо, зарим сонгосон орноор

Он	1990	1995	2000	2001	2002
Монгол	2.2	6.8	6.0	5.9	6.2
Аргентин	8.5	8.1	6.9	6.8	6.9
Австр	4.4	4.0	4.2	4.4	4.4
Бангладеш	10.0	10.0	10.0	10.0	10.0
Бразил	4.5	4.5	4.4	4.4	4.5
Болгар	4.9	6.5	5.2	5.8	5.7
Канад	3.3	3.7	4.5	4.5	4.4
Чили	7.8	7.8	7.0	6.9	6.5
Хятад	5.9	6.1	5.5	5.3	5.3
Чех		3.1	4.6	4.5	4.9
Дани	1.7	1.9	1.7	1.4	1.4
Эстони	5.7	3.2	3.7	3.9	4.2
Финлянд	3.3	3.3	3.1	3.0	2.9
Франц	4.8	2.9	1.9	2.9	2.8
Герман	4.4	4.2	4.6	4.6	4.6
Гонг Конг	8.4	8.0	7.6	7.4	7.2
Унгар	7.4	7.6	7.9	7.4	7.2
Израель	2.1	2.2	2.2	1.9	1.6
Польш	7.8	5.5	5.0	4.8	4.8
ОХУ		4.1	4.9	4.6	4.8
Сингапур		5.1	4.4	4.7	4.5
Словени	3.3	5.0	6.1	6.2	5.5
Өмнөд Солонгос	3.0	3.7	5.0	5.3	4.5
Япон	6.5	6.9	5.6	5.3	5.3
Латви		4.2	3.7	3.4	3.7
Литва	7.1	7.0	7.3	7.4	7.4
АНУ	5.7	6.2	6.6	5.6	5.5
Их Британи	4.5	4.4	5.2	5.1	4.9

Эх сурвалж: James Gwartney and Robert Lawson economic Freedom of the World:2004 Annual Report and author's estimation

илэрхийлсэн индекс 1995 онд 2.6 байсан бол 2002 онд 5.6 болж, 3 пунктээр, 1995 онд манайхтай энэ үзүүлэлтээр ойролцоо байсан Эстони улсын индекс 2002 онд 7.7 болж, 2.1 пунктээр нэмэгдсэн байна. Гэтэл энэ хугацаанд Монгол Улсын индекс 5.3-аас 6.0 болж, дөнгөж 0.7 пунктээр дээшилж, өөрчлөлтийн хурдац нь төдийлөн их биш байна.

Нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувиар тооцсон индексээр манай орныг бусад улс орнуудтай зэрэгцүүлэн Хүснэгт 20-д харуулав.

Энэ үзүүлэлтээр Монгол Улс 2002 онд 6.2 гэсэн оноотой гарсан бөгөөд Фрейзер институтын судалгаанд оролцсон 123 орноос

120 нь тоо мэдээлэлтэй байснаас Грек, Румын зэрэг орнууд мөн 6.2 оноотой 58-59 дүгээр байранд байна. Хэрэв Монгол Улс энэ зэрэгцүүлэлтэнд оролцсон бол 2002 оны энэ үзүүлэлтээрээ дээрх байрны нэгэнд орох байжээ.

Хүснэгт 20-иос үзэхэд зэрэгцүүлэлтэнд хамруулсан 28 орноос 2001-2002 оны байдлаар Бангладеш, Хятадын Гонг Конг, Унгар, Чили, Аргентин зэрэг 5 орны индекс манайхаас өндөр, харин бусад орнуудынх манайхаас доогуур байна.

Хүснэгтээс ихээхэн сонирхолтой дүр зураг харагдаж байна. Юуны өмнө Хятадын Гонг Конгоос бусад нь төдийлөн хөгжилтэй бус орнууд энэ

Хүснэгт 21. ДНБ-д эзлэх татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувиар тооцсон индекс, зарим улс орноор

Он	1990	1995	2000	2001	2002
Монгол	0.0	10.0	7.4	7.4	7.3
Аргентин	8.2	7.3	7.2	7.0	7.0
Австр	4.0	3.3	3.6	2.9	2.9
Бангладеш				9.3	9.3
Бразил	7.2	6.5	6.0	6.0	6.0
Болгар	2.7	6.6	5.8	5.5	5.5
Канад	5.9	5.5	6.3	6.4	6.4
Чили	7.3	7.4	6.5	6.5	6.5
Чех	0.0	2.4	2.4	2.0	2.0
Дани	4.0	2.9	4.3	3.7	3.7
Эстони		6.4	6.0	6.2	6.2
Финлянд	5.8	3.9	5.2	4.9	4.9
Франц	3.3	2.5	2.3	3.4	3.4
Герман	5.3	4.3	4.5	2.3	2.3
Гон Конг	9.9	9.8			
Унгар	2.3	3.3	4.7	5.0	5.0
Израель	5.6	5.1	3.9	4.0	4.0
Япон	7.0	6.8			
Латви		5.2	5.8	6.2	6.2
Литва		7.3	6.9	7.2	7.2
Польш	2.7	3.5	4.5	4.3	4.3
Орос	2.0	7.9	6.6	6.3	6.3
Сингапур	9.4	9.6	9.2	8.8	8.8
Словени		1.1	4.0	4.7	4.7
Өмнөд Солонгос	9.3	9.3	9.1	9.1	9.1
АНУ	6.7	6.3	6.7	6.8	6.7
Их Британи	6.1	5.3	5.6	6.3	6.3

Source: James Grawtney and Robert Lawson «Economic Freedom of the World» 2004 Annual Report and author's estimation

хэсэгт өндөр индексгүй гарч, харин нилээд хөгжилтэй орнуудын индекс бага гарсан байна. Энэ нь зарим өндөр хөгжилтэй орнуудад, тухайлбал, Дани (индекс 1.4), Франц (2.6), Израиль (1.8)-д нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувь их байгаагаас тэдгээр орнуудын энэ үзүүлэлтээр тооцсон индекс бага гарахад хүрчээ.

Эндээс дүгнэхэд хөгжилтэй орнуудад төрийн байгууллагын хэрэглээ их байдаг ажээ. Энэ нь дэлхийн II дайнаас хойш хөгжингүй орнуудад Кейнсийн онол ихэд дэлгэрч, төрийн зохицуулалтанд ач холбогдол өгч, төрийн зардал өссөнтэй холбоотой гэж үзэж байна.

Манай орны индекс манайтай адил социалист системд байсан Болгар (2002 онд

5.7), Польш (2002 онд 5.5) зэрэг орныхтой ойролцоо гарсан нь хүснэгт 19-өөс харагдаж байна. Гэтэл зарим орнуудынх нэлээн өндөр, тухайлбал, 2002 онд Бангладеш улсынх 10, Аргентин улсынх-6.9, Чили улсынх-6.9 гарсан бол зарим орнуудынх манайхаас ихээхэн доогуур байна. Тухайлбал, 2002 онд Дани улсынх 1.4, Финланд улсынх 2.9, Австри улсынх 4.4, Канад улсынх 4.4, ХБНГУ-ынх 4.6, Хятад улсынх 5.3 гарчээ.

ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувийг үндэслэн тооцсон индексээр манай орныг бусад улс орнуудтай зэрэгцүүлэн Хүснэгт 21-д харуулав.

Хүснэгт 22. Улсын үйлдвэр болон улсын хөрөнгө оруулалтын эзлэх хувиар тооцсон индекс, зарим орноор

Он	1990	1995	2000	2001	2002
Монгол	0.0	2.0	6.0	7.0	6.0
Аргентин	6.0	8.0	10.0	10.0	10.0
Австр	2.0	2.0	4.0	10.0	10.0
Бангладеш	2.0	4.0	4.0	4.0	4.0
Бразил	6.0	6.0	8.0	10.0	10.0
Болгар	0.0	0.0	2.0	2.0	2.0
Канад	8.0	8.0	10.0	10.0	10.0
Чили	7.0	8.0	10.0	6.0	6.0
Чех		4.0	8.0	8.0	8.0
Дани	6.0	7.0	7.0	10.0	10.0
Эстони		2.0	6.0	10.0	10.0
Финлянд	6.0	6.0	6.0	8.0	8.0
Франц	4.0	4.0	4.0	4.0	4.0
Герман	6.0	6.0	6.0	6.0	6.0
Гон Конг	10.0	10.0	10.0	10.0	10.0
Унгар	0.0	4.0	4.0	6.0	8.0
Израэль	2.0	2.0	2.0	2.0	2.0
Япон	8.0	6.0	6.0	7.0	7.0
Латви	0.0	0.0	4.0	6.0	6.0
Литва	0.0	0.0	6.0	6.0	6.0
Польш	0.0	0.0	6.0	8.0	8.0
ОХУ	0.0	2.0	4.0	4.0	4.0
Сингапур	6.0	8.0	8.0	8.0	8.0
Словени	0.0	0.0	2.0	0.0	2.0
Өмнөд Солонгос	7.0	6.0	7.0	7.0	7.0
АНУ	8.0	8.0	10.0	10.0	10.0
Их Британи	8.0	8.0	8.0	10.0	10.0

Source: James Gwartney and Robert Lawson Economic Freedom of the World: 2004 Annual Report and author's estimation

ДНБ-д татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувийг үндэслэн тооцсон индексээр манай орныг бусад улс орнуудтай 2002 оны үзүүлэлтээр зэрэгцүүлэн үзэхэд энэ үед 7.3 оноотой байсан Монгол Улс зэрэгцүүлэлтэнд хамруулсан 123 орноос 99 орон тоо мэдээлэлтэй байсны дотор 59 -р байранд орсон 7.2 оноотой Литвийн дараа орохоор байна.

Хүснэгт 21-ээс үзэхэд зэрэгцүүлэлтэнд хамруулсан 28 орноос 2001-2002 оны байдлаар

Бангладешийн индекс манайхаас өндөр, харин бусад орных манайхаас бага байна. Ерөнхий байдал нийт хэрэглээнд улсын байгууллагуудын эзлэх хувиар тооцсон индексстэй төстэй, энэ үзүүлэлтээр хөгжиж буй орнуудын индекс өндөр, харин хөгжингүй орнуудынх бага гарчээ. Энд мөн л хөгжилтэй орнуудад эдийн засагт нь төрийн оролцоо, хэмжээ өндөр байгааг дахин нотлон харуулав. Манай орон ДНБ-д эзлэх татаас, урсгал

шилжүүлгийн эзлэх хувь өндөр талдаа орны тоонд орж байна.

Улсын үйлдвэрүүдийн эдийн засагт эзлэх хувь хэмжээгээр манай орныг бусад улс орнуудтай зэрэгцүүлж Хүснэгт 22-г харуулав.

Хүснэгтээс үзэхэд зах зээл хөгжсөн өндөр хөгжилтэй орнуудад улсын үйлдвэр, хөрөнгө оруулалтын эзлэх хувь бага тул өндөр оноотой, харин шилжилтийн эдийн засагтай орнуудад энэ индекс ихэвчлэн доогуур гарсан байна.

Энэ үзүүлэлтээр Фрейзер институтийн зэрэгцүүлэлтэд 2002 оны байдлаар 122 орон тоо мэдээлэлтэй байсны 39-58 дугаар байранд орсон 20 орон Монгол Улсынхтай адил 6.0 оноотой байлаа.

Татварын дээд түвшингээр тооцсон манай орны оноог бусад улс орнуудтай зэрэгцүүлэн үзэхэд 2002 оны байдлаар манай орны оноо 5 байгаа нь уг интситутийн зэрэгцүүлэлтэнд орсон тоо мэдээлэлтэй 105 орны 72-76 дугаар байр эзэлсэн 5 орны (Ирланд, Литва, Польш, Өмнөд Африк г.м.) түвшинд байлаа. Үүнээс үзэхэд манайх татварын дээд түвшин ихтэй талдаа орны тоонд оржээ.

Хүснэгт 23. Засгийн газрын хэмжээг илэрхийлсэн үзүүлэлтээр 2002 онд олон улсын зэрэгцүүлэлтэнд Монгол Улсын эзлэх байр

Үзүүлэлтүүд	Хамрагдсан улс орны тоо, 2002 он	Монголын эзлэх байр
Бүлгийн нэгдсэн индекс	120	60 (6.4)
Улсын байгууллагын хэрэглээ	120	58-59 (6.2)
Татаас, урсгал шилжүүлэг	99	59 (7.3)
Эдийн засаг дахь улсын секторын эзлэх хувь	122	39-58 (7.0)
Татварын дээд хэмжээ	105	72-76 (5.0)

Татварын дээд түвшингээр тооцсон манай орны оноог бусад улс орнуудтай зэрэгцүүлэн Хавсралт 2-г харуулав.

Хүснэгт 23-аас үзэхэд манай орон эдийн засаг дахь улсын секторын эзлэх хувиар бага, энэ чиглэлээр харьцангуй сайн гарсан бол харин татварын дээд хэмжээгээр тооцсон индексээр нэлээн хойгуур байр эзэлжээ.

1.5 НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

- Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийн эхний бүлэг үзүүлэлт, тэдгээрт тулгуурлан гаргасан оноо, тооцсон индексийг харахад Засгийн газрын хэмжээг илэрхийлсэн үзүүлэлтүүд 1990 оноос хойш сайжрах хандлагатай өөрчлөгдөж иржээ. Энэ бүлгийн нэгдсэн индекс 1995 онд 5.3 байснаа 2004 онд 6.8 болж, нэлээд өссөн нь манай орны эдийн засагт улсын секторын эзлэх байр суурь аажмаар буурч, харин хувийн хэвшлийн эзлэх хувь нэмэгдэж, татаас, урсгал шилжүүлэг, татварын дээд хэмжээ багассантай үндсэндээ холбоотой байна.
- Төрийн байгууллагын хэмжээг илэрхийлсэн эхний бүлэг үзүүлэлтээр гаргасан нэгдсэн индексээр Монгол Улс нэлээд дундуур үзүүлэлттэй орны тоонд багтсан байна. 2002 оны байдлаар Монгол Улс Фрейзер институтын судалгаанд хамрагдсан бол дэлхийн 120 гаруй орноос эхний 60 дугаар байранд орхоор байв.
- Эдийн засгийн эрх чөлөөний индексийн эхний хэсэгт хамаарах үзүүлэлтийг тооцоход ашигласан мэдээллийн Эх сурвалжт зарим талаар шүүмжлэлтэй хандаж, хэд хэдэн нэмэлт хувилбараар тооцож болохоор байна. Албан ёсны статистикийн мэдээллийн хамралт, чанарт ч анхаарах зүйл цөөнгүй байна.
- Эхний бүлэг үзүүлэлтээр манай орны оноог цаашид нэмэгдүүлэхийн тулд нэн тэргүүнд татварын дээд хэмжээг багасгах, төсвийн байгууллагуудын зардлыг багасгах, улсын төсвийн зардалд үр ашиггүй зардлыг багасгах, улсын хэмжээний бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт үйлдвэрлэлтэд улсын өмчтэй үйлдвэрүүдийн эзлэх хувь хэмжээг багасгах, өөрөөр хэлбэл, өмч хувьчлалыг цаашид үргэлжлүүлж, эдийн засагт хувийн хэвшлийн эзлэх байр суурийг нэмэгдүүлэх бодлогыг төрөөс үргэлжлүүлэх шаардлагатайг харууллаа.
- Хөгжингүй орнуудад улсын байгууллагын хэрэглээний эзлэх хувь өндөр байгаа ерөнхий хандлага ажиглагдаж байна.

- Хэдийгээр энэхүү бүлэгт тооцсон үзүүлэлтээр Монгол Улсын Засгийн газрын хэмжээ дунд зэргийн түвшинд гарсан боловч практик амьдрал дээр эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоо их, төрөөс эдийн засгийн эрх чөлөөг боож хаагдуулсан үйл ажиллагааг явуулж байгааг Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас явуулсан судалгааны дүн харуулж байна.
- Иймээс эдийн засаг дахь төрийн оролцоог илэрхийлэхэд нэмэлт судалгаа, дүгнэлт шаардлагатай гэж үзлээ. Үүнд нэн тэргүүнд бизнесийн үйл ажиллагаанд саад болж байгаа төрийн байгууллагын хүнд суртал, авилгалтай холбогдсон нэмэлт судалгааг явуулж, үзүүлэлт болгон оруулахыг санал болгож байна.
- Эдийн засаг дахь төрийн оролцоог илэрхийлэхэд манай орны хувьд ДНБ-д төсвийн зардлын эзлэх хувь гэсэн үзүүлэлтийг ашиглаж болох саналыг дэвшүүлж байна.
- Монгол Улс цаашид эхний бүлэг үзүүлэлтээр Фрейзер институтын судалгаанд хамрагдах бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

Бүлэг 2



Эдийн засгийн эрх чөлөө:
Эрүүл мөнгө хүртэх
боломж

2.1 ОРШИЛ

Эдийн засаг нь чөлөөтэй улс хурдан хөгждөг, илүү их хөрөнгө оруулалтыг татаж чаддаг, бүтээмж нь өндөр байдаг. Энэ бол Фрейзер институтээс явуулсан эдийн засгийн эрх чөлөө нь хөрөнгө оруулалт, өсөлт, орлогын түвшинд хэрхэн нөлөөлдгийг 1980-2000 он хүртэлх 20 жилийн үзүүлэлтүүд дээр тулгуурлаж хийсэн судалгааны гол үр дүн.

Мөнгө бол солилцоог түргэтгэх хэрэгсэл. Эрүүл мөнгөгүйгээр худалдаанаас олох ач тусыг хүртэх боломж сул. Нобелийн шагналт Мильтон Фрейдманы олон жилийн өмнө бидэнд сануулсны дагуу, инфляци бол хэт цөөн барааны хойноос хэт их мөнгө хөөцөлдөж байгаагаас шалтгаалсан мөнгөний өөрийнх нь байгалийн шинж чанар юм. Мөнгөний өсөлт өндөр байх нь инфляци руу л хөтөлж аваачдаг. Үүнтэй ижлээр, инфляцийн түвшин нэмэгдэх нь түүнийг илүү хувирамтгай болгох хандлагатай байдаг.

Инфляци өндөр бөгөөд хувирамтгай байх нь харьцангуй үнийг гажуудуулж урт хугацааны хэлцлийн суурь нөхцөл өөрчлөгдөн, хувь хүн, бизнесээс ирээдүйн үйл ажиллагаагаа төлөвлөх ямар ч боломжгүй болгодог. Иймээс эрүүл мөнгө нь өмчлөх эрх ба түүнээс уламжилсан эдийн засгийн эрх чөлөөг хамгаалах зайлшгүй хэрэгсэл мөн.

Инфляци нь санхүүгийн хэрэгсэлд байршуулсан өмчийн үнэлэмжийг бууруулдаг. Засгийн газар төсвийн зардлаа шинээр мөнгө гаргах байдлаар санхүүжүүлдэг нь үнэн хэрэгтээ хувийн өмчид халдаж иргэдийнхээ эдийн засгийн эрх чөлөөг зөрчиж байгаа хэрэг юм.

Фрейзер институтын философийн дагуу, хэн мөнгийг гаргадаг нь чухал бус гагцхүү хувь хүн түүнийг хүртэх боломжтой байх ёстой. Тийм учраас үндэсний мөнгөн тэмдэгтээс гадна бусад нэр хүнд бүхий мөнгө болох гадаад валютыг эзэмшиж ашиглах боломжийг авч үздэг. Хэрэв банкууд нь иргэдэд гадаад валютын харилцах данс, хадгаламжийг нээж өгдөг, нөгөө талаас иргэдээ гадаадын банкинд данстай байхыг зөвшөөрдөг бол энэ нь эрүүл мөнгө хүртэх боломж нэмэгдэж эдийн засгийн эрх чөлөө өргөжиж байгаа нь тэр.

Эдийн засгийн эрх чөлөөний индексийн 3 дахь энэхүү хэсэгт сайн үнэлгээ авахын тулд тухайн улс инфляцийг бага (тогтвортой) байлгах бодлого явуулах, түүнийг хангах тогтолцоотой байх, гадаад валютаар данс эзэмшихийн эсрэг чиглэсэн эрх зүйн зохицуулалтаас татгалзах ёстой.

2.2 ЭРҮҮЛ МӨНГӨ ХҮРТЭХ БОЛОМЖИЙН СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэ бүлгийн зорилго нь Фрейзер институтын аргачлалаар Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийг тогтооход шаардагдах үзүүлэлтийн 3 дахь хэсэг болох *Эрүүл мөнгө хүртэх боломж*-д хамрах дэд үзүүлэлтүүдийг олж цуглуулан холбогдох индексийн төслийг бэлтгэх, индекс ба аргачлалын талаар танилцуулга хийхэд оршсон.

Энэхүү аргачлалыг ашиглан эдийн засгийн үзүүлэлт гадарладаг хэн боловч холбогдох бүлгийн дэд үзүүлэлтүүдийг зохих эх сурвалжаас нь түүж авах, түүнийг индекс болгон гаргах, нэгэнт гаргасан үзүүлэлтийг нягтлан шалгах боломжтой болох юм.

Эрүүл мөнгө хүртэх боломж-ийн хэсэг нь 4 дэд үзүүлэлттэй. Эхний 3 үзүүлэлт (А-С) нь урт хугацааны үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгөний бодлогын (түүнийг эрхэлсэн байгууллагын) үр дүнг хэмжихэд чиглэсэн бол 4 дэх үзүүлэлт (D) нь гадаад валютын дансыг дотоодын болон гадаадын банкинд эзэмшихэд хэр амархан болохыг хэмжих зорилготой.

Эрүүл мөнгө хүртэх боломж-д дараах дэд үзүүлэлтүүд хамаарч байна.

- А. Сүүлийн 5 оны мөнгөний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлтөөс хасах нь сүүлийн 10 оны ДНБ-ий жилийн дундаж бодит өсөлт
- Б. Сүүлийн 5 жилийн инфляцийн стандарт өөрчлөлт
- В. Өнөөгийн инфляцийн түвшин
- Г. Дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрх

А. Сүүлийн 5 оны мөнгөний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлтөөс хасах нь сүүлийн 10 оны ДНБ-ий жилийн дундаж бодит өсөлт

Энэ үзүүлэлтийг тооцохын тулд зарим макро эдийн засгийн ойлголтуудыг энд авч үзье.

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгө бол сонгодог уламжлалын дагуу нийтээр хүлээн зөвшөөрсөн төлбөрийн хэрэгсэл юм.² Эдийн засаг дахь төлбөрийн чадварын байдлыг илэрхийлэх үүрэг бүхий мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлт бол төв банкнаас явуулдаг мөнгөний бодлогын завсрын зорилтыг тодорхойлогч үзүүлэлт, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн судалгааны гол түүхий эд болдог.

Эдийн засгийн онол, статистикийн практикийн нөлөөн дор байнга хувьсан өөрчлөгдөж ирсэн энэ үзүүлэлт санхүүгийн зах зээл дээрхи бүтцийн өөрчлөлтийг тусган хөгжиж иржээ.

Олон улсын практикаас үзвэл, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтийг тухайн зах зээл дээр ямар санхүүгийн хэрэгслүүд ашиглагдаж байгаагаас хамаараад дараах байдлаар тодорхойлж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлт

Дотоод бүтэц

M1 **Банкаас гадуурх бэлэн мөнгө**

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл

Замын чек

Чекээр авч болох бусад хадгаламж

M2 **M1**

Хугацаагүй хадгаламж

Хугацаатай хадгаламж

Валютын хадгаламж

Мөнгөний зах зээлийн хадгаламж

M3 **M2**

Мөнгөний зах зээлийн хамтын

сангийн дансны үлдэгдэл

Хугацаатай репо-буцаан худалдаж

авах гэрээ

M4 **M3**

Хадгаламжийн бонд

Богино хугацаатай засгийн газрын үнэт цаас

Банкны баталгаа

Арилжааны баталгаа

Мөнгөний нийлүүлэлтийн дээрх үзүүлэлтүүдийг M1, M2, M3, M4 гэх мэтээр ангилсан нь тухайн мөнгөний агрегатуудыг төлбөр гүйцэтгэх чадвараар нь эрэмбэлсэн хэрэг юм. Тухайлбал, M1 бол бусад бүх агрегатуудаас илүү төлбөрийн чадвартай, M2 бол M3, M4-өөс илүү төлбөрийн чадвартай гэх мэт.

Мөн дээрх үзүүлэлтүүд дотор доогуур нь зуран ялгаж өгсөн нь Монгол улсад хэрэглэгддэг үзүүлэлт бөгөөд зах зээл дээр ашиглагдаж байгаа санхүүгийн хэрэгслүүдийн байдлаас хамаараад одоогоор M1 ба M2 гэсэн үзүүлэлтийг Монгол Банкнаас олон улсын валютын сангийн аргачлалын дагуу гаргаж байна.

Үүн дотроос M2 гэсэн үзүүлэлт бол мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд болон санхүүгийн зуучлалын түвшинг тогтооход хамгийн өргөн ашиглагддаг үзүүлэлт болоод байна. Өөрөөр хэлбэл мөнгөний нийлүүлэлт гэхэд зөвхөн M2-ыг ойлгодог практик тогтоод уджээ.

Тэгвэл Фрейзер институтээс мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтийг M1-ээр төлөөлүүлэн авч байгаа бөгөөд үүний үндэслэл нь миний өмнө дурьдсанчлан төлбөрийн чадвар нь хамгийн өндөр агрегатыг сонгож тэр нь бүтээгдэхүүний өөрчлөлт, инфляцийн түвшинтэй илүү уялдах ёстой гэсэн үзэл баримтлал, нөгөө талаас индекс тооцсон бусад улсын үзүүлэлттэй зэрэгцүүлэх боломжид оршиж байна.

² The New Palgrave Dictionary of Money and Finance, F-M, p803

Монгол улс, Мөнгөний нийлүүлэлт M1, статистикийн эх сурвалжуудаар

	Монгол Банкны жилийн тайлан (Монгол Банк)		International Financial Statistics (IMF)		World Development Indicators (World Bank)	
	Тэрбум төгрөгөөр	Өсөлтийн хувиар	Тэрбум төгрөгөөр	Өсөлтийн хувиар	Тэрбум төгрөгөөр	Өсөлтийн хувиар
1990	4.8					
1991	7.3	54.0	7.3			
1992	7.6	4.5	7.6	4.5		
1993	18.5	142.8	18.5	142.8		
1994	32.9	77.2	33.0	77.2		
1995	42.6	29.7	42.6	29.7		
1996	64.3	50.8	60.8	42.7		
1997	76.1	18.4	76.1	25.1		
1998	82.6	8.5	82.6	8.5		
1999	114.8	39.0	114.8	39.0		
2000	130.8	13.9	130.8	13.9		
2001	156.2	19.4	156.1	19.4		
2002	187.7	20.2	187.7	20.2		
2003	212.8	13.4				
2004	221.3	4.0				

Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг *World Development Indicators* товхимолд мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтийг M2-оор төлөөлүүлсэн бөгөөд энэ нь Олон улсын валютын сангаас гаргадаг *International Financial Statistics* товхимлын M2 үзүүлэлттэй мөн тохирч байна. Эдгээрийг Фрейзер институтын аргачлалын дагуу тогтоохыг зорьж буй мөнгөний үзүүлэлттэй зэрэгцүүлэх боломжгүй юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Аливаа улсын эдийн засгийн нийт үйл ажиллагааны цар хүрээг харуулдаг хамгийн чухал үзүүлэлтийн нэг нь дотоодын нийт бүтээгдэхүүн юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (цаашид ДНБ гэнэ) нь тодорхой хугацааны турш (тухайлбал, нэг жилийн хугацаанд) тухайн орны нутаг дэвсгэрт үйлдвэрлэж бий болгосон бүх эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт үнэлэмж юм. ДНБ-ийг тооцдог 3 арга бий. Үүнд:

1. Тухайн жилд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээнд ноогдох эцсийн хэрэглээ

нэгтгэж тооцдог аргыг зардлын арга гэж нэрлэдэг. Хүн амын хэрэглээ, төрийн байгууллагын хэрэглээ, хөрөнгө оруулалт, цэвэр экспорт зэрэг нь дээрх эцсийн хэрэглээний үндсэн төрөл бөгөөд ДНБ нь эдийн засаг дахь эцсийн хэрэглээний зах зээлийн үнэлэмжийн нийлбэртэй тэнцүү.

2. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар бүрт бий болсон нэмүү үнэлэмжийг нэгтгэж тооцдог аргыг нэмүү үнэлэмжийн (нэмүү өртөг хэмээн манайд буруу нэрлэдэг³) буюу үйлдвэрлэлийн арга гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл ДНБ нь хөдөө аж ахуйн салбарт бий болсон нэмүү үнэлэмж дээр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт бий болсон нэмүү үнэлэмжийг нэмэх гэх мэтээр тухайн эдийн засагт хэдэн салбар байна тэр бүрт бий болсон нэмүү үнэлэмжийн нийлбэр болж илэрхийлэгддэг.
3. Үйлдвэрлэл, үйлчилгээний процесст оролцогч хүчин зүйлсийн (ажиллах хүч,

³ - Зөвлөхийн байр суурь

капитал) орлогыг нэгтгэн тооцоолдог аргыг орлогын арга гэж нэрлэнэ. Харин энэ аргаар ДНБ-ийг тооцохын тулд хөрөнгийн элэгдэл, шууд бус татварын дүнгээр зохицуулалт хийх шаардлагатай болдог.

Тэгвэл олон улсын байгууллагуудын хамтын оролцоотойгоор 1993 онд гаргасан Үндэсний Тооцооны Системд⁴ дотоодын нийт бүтээгдэхүүнийг түүний хамгийн түгээмэл хэрэглэгддэг зардлын аргаар хэрхэн нарийвчлан тооцохыг тодорхойлсныг авч үзье.

ДНБ-ий зах зээлийн үнэ нь Хүн амын (өрх гэрийн) эцсийн хэрэглээний зардлыг түүний худалдаж авах үнээр тооцсон дээр

- + Төрийн бус байгууллагын эцсийн хэрэглээний цэвэр зардлыг худалдаж авах үнээр тооцон
- + Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардлыг худалдаж авах үнээр тооцон
- + Нийт хуримтлалыг худалдаж авах үнээр тооцон
- + Үнэт зүйлийн цэвэр худалдан авалтыг худалдаж авах үнээр тооцон
- + Борлуулагдаагүй бүтээгдэхүүний өөрчлөлт
- + Экспортыг худалдан авагчийн хилийн үнээр тооцон
- Импортыг хилийн үнэлгээгээр тооцсонтой тэнцүү байна.

Монгол улсын статистикийн эмхэтгэлд⁵ ДНБ-ийг дээрх аргаар тооцож эцсийн хэрэглээний бүтцүүдийн нийт дүнд эзлэх хувийн жинг тооцож гаргасныг толилуулбал:

Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний бүтэц, зардлын аргаар

	1995	2000	2001	2002	2003
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хүн амын хэрэглээ	59.2	65.7	67.1	72.0	73.2
Төрийн ба төрийн бус байгууллагын хэрэглээ	12.3	16.5	17.5	17.8	17.8
Нийт хуримтлал	29.6	33.2	32.4	30.1	28.9
Цэвэр экспорт	-1.1	-15.3	-17.0	-19.9	-19.9

ДНБ-ийг тооцож байгаа арга, түүний нарийвчлал, мэдээллийн үнэн зөв байдал, бүрдэл зэргээс шалтгаалж түүнийг тооцох явцад статистикийн алдаа гарах, ойролцоо тооцоололт шаардах явдал бий.

Сүүдрийн эдийн засгийн (албан бус сектор гэж манайд нэрлэдэг) үйл ажиллагаа зэрэг ойролцоо тооцоололт хийхээс аргагүй зүйлс үүнд хамаарна. Албан ёсоор бүртгэлд ордоггүй боловч нийт эдийн засгийн үйл ажиллагаанд ихээхэн нөлөөтэй энэ салбарын үйл ажиллагааны цар хүрээг тоймлон тооцохыг оролдох явдал чухал юм. Үндэсний статистикийн газраас 2003 онд сүүдрийн эдийн засгийн хэмжээг ДНБ-ий 13.7 хувьтай тэнцүү байхаар тооцоолж ДНБ-ий нэгдсэн тооцоонд оруулсан байна.

Түүнээс гадна ДНБ-ий тооцооны аргачлалд 2000-2002 онд тохиолдсон ган зудын хавсарсан гамшгаас хорогдсон малын тоог онцгойлон авч үзэж Үндэсний тооцооны системийн аргачлалын дагуу холбогдох өөрчлөлтийг оруулжээ. Энэхүү өөрчлөлтийн гол агуулга нь малын хорогдлыг олон жилийн дунджаас хэрхэн хазайж байгаагаар ердийн, тохиолдлын, онцгой хэмээн 3 ангилж, онцгой хорогдлыг ДНБ-ий тооцоонд оруулаагүйд оршиж байна.

Дээрх зохицуулалт, өөрчлөлтийг тусгаснаар ДНБ-ий хэмжээ, өөрчлөлтийг зэрэгцүүлэх үнээр илэрхийлбэл:

⁴ - System of National Accounts 1993, European Commission, IMF, OECD, UN, World Bank, p155

⁵ - Mongolian Statistical Yearbook 2003, p86

Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүн, статистикийн эх сурвалжуудаар 1995 оны зэрэгцүүлэх үнээр

	Монгол улсын статистикийн эмхэтгэл (Үндэсний статистикийн газар)		International Financial Statistics (IMF)		World Development Indicators (Worldbank)	
	Тэрбум төгрөгөөр	Өсөлтийн хувиар	Тэрбум төгрөгөөр	Өсөлтийн хувиар	Тэрбум төгрөгөөр	Өсөлтийн хувиар
1990	635.1	-2.5				
1991	576.4	-9.2		-9.2		
1992	521.6	-9.5		-11.6		
1993	505.9	-3.0				
1994	517.6	2.3				
1995	550.3	6.3				
1996	563.2	2.4	439.3	2.4		
1997	585.7	4.0	457.1	4.0		
1998	606.4	3.5	473.0	3.5		
1999	625.9	3.2				3.2
2000	632.5	1.1				1.1
2001	639.0	1.0				1.0
2002	664.8	4.0				4.0
2003	702.4	5.6				5.6
2004*	776.9	10.6				

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлт олон улсын санхүүгийн байгууллагуудын дээрх гол эх сурвалжид хангалтгүй тусгагджээ. Тухайлбал, ОУВС-аас эрхлэн гаргадаг *International Financial Statistics*-д манай улсын ДНБ-ий үзүүлэлт 5 жилийн хоцролттойгоор нийтлэгдэж байгаа бол, Дэлхийн банкны *World Development Indicators*-ийн Эдийн засгийн хэмжээ гэсэн 1.1 хүснэгтэд Монгол улсын үзүүлэлтийг хамруулсан байна. Энэхүү мэдээллийг жил бүрийн *World Development Indicators* тайлангаас авч болохоос гадна Дэлхийн банкны мэдээллийн сангийн веб хуудас болох <http://devdata.worldbank.org/data-query> хаягаар орж сүүлийн 5 жилийн мэдээллийг авч болно.

Статистикийн эх сурвалжуудын үзүүлэлтийг зэрэгцүүлж үзэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн үзүүлэлтээр гол эх сурвалж болох Үндэсний статистикийн газраас гаргасан үзүүлэлт нь бусад эх сурвалжуудын үзүүлэлттэй тохирох хандлагатай байна.

Түүнчлэн уг тайлангийн Бүтээгдэхүүний өсөлт гэсэн 4.1 хүснэгтэд улсуудын сүүлийн 10 оны ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг харуулсанд Монгол улсыг мөн оруулжээ. Тухайлбал:

Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт

Он	Хувиар
1980-1990	5.4
1990-2000	1.0
1990-2001	1.2
1990-2002	1.5
1990-2003	-1.3

Эх сурвалж: World Development Indicators

Тооцооны аргачлалын хувьд анхаарах ёстой өөр нэг асуудал бол, жилийн дундаж өсөлтийг хэрхэн тооцохтой холбогдож гардаг. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтийн тайланд өсөлтийн дунджийг тооцохдоо нийлмэл аргаар буюу геометрийн дунджаар авсан байна.⁶

* - 2004 оны үзүүлэлт нь УСГ-ын хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр гарсан болно.

⁶ - 2004 World Development Indicators, p363

Эдийн засгийн эрх чөлөөний индексийн тооцоололт, харьцуулалт

Фрейзер институтээс 2004 онд гаргасан Дэлхийн эдийн засгийн чөлөөт байдлын индекстэй харьцуулах боломжтой байлгах, мөн өөрийн орны статистикийн мэдээллийн зэрэгцүүлэх боломжийг харгалзан⁷ 2000-2002 оны индексийг (индекс тооцсон томъёо бүхий файлыг энэхүү тайлангийн хавсралт 1-д тусгасан) тооцож гаргая.

Хэсгийн энэхүү дэд үзүүлэлтийн индексийг тооцохдоо:

- Дотоод үзүүлэлтүүдийн (M1, ДНБ) өсөлтийн хувийг коэффициентэд шилжүүлсэн
- Коэффициентийг ашиглаж сүүлийн 5 жилийн (M1-ийн хувьд), сүүлийн 10 жилийн (ДНБ-ий хувьд) геометрийн дундаж өсөлтийг гаргасан
- M1-ийн 5 жилийн дундаж өсөлтийг гаргасан харгалзах оны үзүүлэлтээс ДНБ-ий 10 жилийн дундаж өсөлтийг гаргасан харгалзах оны үзүүлэлтийг хасаж 2000 оноос хойшхи ДНБ-ий өсөлтөөр засварлагдсан M1-ийн өсөлтийг тооцож гаргасан.
- Фрейзер институтын аргачлалын дагуу

$$(V_{max} - V_i) / (V_{max} - V_{min}) \times 10$$

томъёогоор индексийг тооцсон ба үүнд:

- V_i - ДНБ-ий өсөлтөөр засварлагдсан M1-ийн өсөлт
- V_{max} - 50-тай тэнцүү байхаар аргачлалын дагуу өгөгдсөн
- V_{min} - 0-тэй тэнцүү байхаар аргачлалын дагуу өгөгдсөн

ДНБ-ий өсөлтөөр засварлагдсан сүүлийн 5 жилийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 0 рүү тэмүүлэх тусам үүнийг эдийн засгийн агуулгаар нь мөнгөний өсөлт урт хугацаан дахь бүтээгдэхүүний бодит өсөлттэй ойртож байна гэж ойлгох бөгөөд ингэх тохиолдолд хамгийн дээд буюу 10 гэсэн индекс авна. Харин энэхүү

засварлагдсан мөнгөний өсөлт 50 хувь руу тэмүүлэх тусам мөнгөний өсөлт хэтэрхий өндөр болж хамгийн бага буюу 0 гэсэн индекс авна.

Манай улсын индекс үндсэндээ 5-6.5 хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд 2004 оны үзүүлэлт нилээд сайн буюу 8 гэсэн индекстэй гарсан нь тухайн оны мөнгөний өсөлт хамгийн бага буюу 4 хувь, бүтээгдэхүүний өсөлт хамгийн их буюу 10.6 хувьд хүрч эдгээр нь дундаж өсөлтөд нөлөөлснөөс болжээ.

ДНБ-ий 2004 оны өсөлтөд манай улсаас экспортод гаргадаг гол түүхий эд болох зэс, алтны дэлхийн зах зээлийн үнэ өндөр байсан, мөн цаг агаарын тааламжтай нөхцлөөс үүдсэн малын тоо толгойн өсөлт гарсан, алтны үндсэн ордоос олборлолт хийдэг гадаадын хөрөнгө оруулалттай нэгэн компанийн экспорт огцом өссөн зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн болохыг дурьдах нь зүйтэй.

Энэхүү индексийг шилжилтийн болон хөгжингүй эдийн засагтай зарим улсуудын индекстэй⁸ 2002 оны байдлаар харьцуулж үзвэл:

	Үзүүлэлт	Индекс
ОХУ	33.5	3.3
Украйн	32.3	3.5
Монгол	17.3	6.5
Болгар	16.3	6.7
Чех	13.5	7.3
Унгар	9.8	8.0
Япон	9.1	8.2
Латви	8.1	8.4
Их Британи	7.2	8.6
Солонгос	7.1	8.6
Польш	6.6	8.7
Эстони	6.4	8.7
Литов	6.2	8.8
Чили	5.6	8.9
Гонг конг	5.6	8.9
Канад	5.1	9.0
Бангладеш	4.7	9.1
Хятад	3.7	9.3
Румын	-3.5	9.3
Словак	3.0	9.4
АНУ	1.4	9.7
Сингапур	0.5	9.9

2002 оны олон улсын харьцуулалтаас үзвэл түүвэрт хамрагдсан ихэнхи орнууд Монгол улсаас илүү индекс авсан байгаа нь тэдгээрийн

⁷ - 1990 оноос өмнөх холбогдох үзүүлэлтийг жагсааж болох боловч тэр үед статистикийг ашиглан гаргах индекс нь агуулгын хувьд эдийн засгийн эрх чөлөөтэй ямар ч холбогдолгүй юм.

⁸ - Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайлан 2004

	Мөнгөний нийлүүлэлт М1			Дотоодын нийт бүтээгдэхүүн			ДНБ-ий өсөлтөөр засварлагдсан М1-ийн өсөлт	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
	Тухайн жилийн өсөлт		Сүүлийн 5 жилийн дундаж өсөлт	Тухайн жилийн өсөлт		Сүүлийн 10 жилийн дундаж өсөлт		
	Хувь:	Козф:		Хувь:	Козф:			
1991	54.0	1.540		-9.2	0.908			
1992	4.5	1.045		-9.5	0.905			
1993	142.8	2.428		-3.0	0.970			
1994	77.2	1.772		2.3	1.023			
1995	29.7	1.297	1.551	6.3	1.063			
1996	50.8	1.508	1.545	2.4	1.024			
1997	18.4	1.184	1.584	4.0	1.040			
1998	8.5	1.085	1.348	3.5	1.035			
1999	39.0	1.390	1.284	3.2	1.032			
2000	13.9	1.139	1.251	1.1	1.011	1.000	25.2	5.0
2001	19.4	1.194	1.194	1.0	1.010	1.010	18.4	6.3
2002	20.2	1.202	1.198	4.0	1.040	1.025	17.3	6.5
2003	13.4	1.134	1.208	5.6	1.056	1.033	17.5	6.5
2004	4.0	1.040	1.140	10.6	1.106	1.041	9.9	8.0

ДНБ нь жил бүр өндөр өсөлттэй байсандаа бус харин мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурд нь эдийн засгийн өсөлтийн хурдтай урт хугацаанд нийцэхээр бодлого явуулж үр дүнд хүрсэнтэй холбоотой. Сингапур улсын хувьд энэхүү хоёр үзүүлэлтийн өсөлтийн хурдны зөрүү дөнгөж 0.5 хувь болж 9.9 гэсэн индекс авсан нь бараг төгс нийцсэний үр дүн юм.

Өндөр индекс авсан Словак улсын хувьд мөнгөний өсөлт нь ДНБ-ий өсөлтөөс 3.0 хувиар түрүүлж байгаа бол Румын ДНБ-ий өсөлт мөнгөний өсөлтөөсөө 3.5 хувиар түрүүлж байна. ДНБ-ий өсөлт нь мөнгөнийхөө өсөлтөөс түрүүлсэн Румын улс Словак улсын дараа зэрэглэгдэж байгаа нь мөн л нийцэлтийн түвшингээс шалтгаалж байна.

Нэмэлт судалгаа ба индекс

Энэхүү тайланг бэлтгэх явцад Нээлттэй Нийгэм Форумас өгч байсан зөвлөмжийг үндэслэн мөнгөний нийлүүлэлтийн М2 үзүүлэлтийг ашиглан индексийг тооцож энэхүү тайлангийн хавсралт 2-т тусгасан болно. Ингэхийн шалтгаан нь манай орны

хувьд М2-ын бүрэлдэхүүнд ордог Бараг мөнгө (хугацаатай ба хугацаагүй хадгаламж, гадаад валютын хадгаламж) гэж нэрлэгдэх үзүүлэлт нь мөнгөний нийлүүлэлтэд онцгой байр суурь эзлэх бөгөөд сүүлийн жилүүдэд өссөөр М1 үзүүлэлтээс 4 дахин өндөр болжээ. Тэгвэл Эстони улсад энэ харьцаа эсрэгээр буюу М1 нь Бараг мөнгөнөөсөө 4 дахин их байна. ОХУ-д энэ нь 1:1 гэсэн харьцаатай байгаа бол Болгар, Польш зэрэг улсуудын хувьд Бараг мөнгө нь М1-ээсээ 2 дахин өндөр байна. Харин АНУ-ын хувьд дээрх харьцаа ойролцоогоор манай улсынхтай төстэй байгаа нь гадаад валютын хадгаламж гэх мэт Бараг мөнгөний бүрэлдэхүүнд ордог үзүүлэлтээс бус манайд байдаггүй санхүүгийн зах зээлийн бусад хөгжингүй хэрэгслүүдийн хувийн жингээс шалтгаалжээ.

Хавсралт 2-оос үзэхэд мөнгөний үзүүлэлтийг М2-оор тооцоход манай улсын индекс М1-ээр тооцсоноос үлэмж буурах хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдаж байгаа бол Эстони улсын хувьд энэ нь онцгой нөлөө үзүүлэхгүй буюу М2-оор мөнгөний үзүүлэлтийг тооцсон ч өндөр индекс авахаар байна.

Б. Сүүлийн 5 жилийн инфляцийн стандарт өөрчлөлт

Фрейзер институтын аргачлалын дагуу инфляцийг дотоодын нийт бүтээгдэхүүний дефлятораар төлөөлүүлж авсан байдаг. ДНБ-ий дефлятор нь эдийн засаг дахь үнийн дундаж өсөлтийг харуулдаг.

Тухайн жилийн дотор олон мянган бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр бий болдог учраас ДНБ-ий өсөлт нь тоо хэмжээний өсөлтөөс үү эсвэл түүний үнийн өсөлтөөс болсон уу гэдгийг тооцоолж гаргах нь нэн төвөгтэй. Ийм учраас эдийн засаг дахь тэр олон бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ болон тоо хэмжээний өөрчлөлтийг энгийн индекс шилжүүлэх хэлбэрээр илэрхийлэхэд хүрдэг.

Дундаж үнийг илэрхийлдэг хамгийн түгээмэл индексийн нэг бол Ласпейресийн индекс бөгөөд тухайн жилийн үнийг суурь үнэтэй нь бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээгээр нь жигнэн харьцуулсан арифметик жигнэсэн дундаж үзүүлэлт юм. Онолын хувьд Ласпейресийн индексийг дараах байдлаар илэрхийлнэ.

$$L_p = \sum p_t q_0 / \sum p_0 q_0$$

Гэвч практик дээр ДНБ-ий нэрлэсэн дүнг бодит дүнд харьцуулах маягаар л ДНБ-ий дефлятор буюу эдийн засаг дахь үнийн дундаж өсөлтийг тооцдог. Ингэхийн тулд юуны өмнө ДНБ-ий бүтэц дэх хэрэглээ, хөрөнгө оруулалт, засгийн газрын цэвэр зардал, экспорт, импорт зэргийн үнийн ласпейресийн индексийг олж түүгээр дамжуулан бүтэц бүрийн бодит хэмжээ цаашилбал ДНБ-ий бодит хэмжээг гаргана. ДНБ-ий дефлятор нь ийнхүү шууд бус аргаар тооцогддог учраас ДНБ-ий имплицит (цаад) дефлятор гэж нэрлэх нь бий. Дундаж үнийг илэрхийлдэг өөр нэг түгээмэл индекс болох Паасчийн индексээр үүнийг тооцно.

$$P_p = \sum p_t q_t / \sum p_0 q_t$$

Үүнийг энгийнээр илэрхийлбэл:

$$P = GDP_{nom} / GDP_{real}$$

Монгол улсын статистикийн эмхэтгэлд ДНБ-ий дефляторыг шууд тусгаагүй. Гэвч

ДНБ-ий оны болон зэрэгцүүлэх үнээр гаргасан үзүүлэлтийг ашиглан дараах байдлаар дефляторыг амархан тооцож болно. Үүний гол зарчим нь тухайн жилийн ДНБ-ий нэрлэсэн дүнгийн өсөлтөөс бодит өсөлтийг цэвэрлэх замаар үнийн дундаж өсөлт буюу дефляторыг илэрхийлэх явдал мөн. Ингэхдээ нэгдүгээрт, харьцуулж байгаа хоёр жилийн ДНБ-ий оны үнээрх өсөлтийг зэрэгцүүлэх үнээрх өсөлтөд харьцуулах замаар, хоёрдугаарт, тухайн жилийн ДНБ-ий нэрлэсэн үнийг зэрэгцүүлэх үнэд хуваан дефляторыг гаргаад мөн ийм аргаар гаргаж авсан суурь оны дефляторт харьцуулах замаар тооцно. Аль ч аргаар тооцоолоход дефлятор адилхан гарах бөгөөд үүний гол агуулга нь ДНБ-ий нэрлэсэн дүн бол бодит дүн, үнэ хоёрыг давхар илэрхийлж байдаг, түүнээс бодит дүнг чөлөөлж өгөх юм бол тухайн жилийн үнийн өөрчлөлт буюу дефлятор гарах ёстой гэсэн энгийн санаанд тулгуурлаж байдаг.

Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний дефляторын тооцоололт

	ДНБ, сая төгрөгөөр		ДНБ-ий дефлятор
	Оны үнээр	Зэрэгцүүлэх үнээр	
1995	550,253.7	550,253.7	
1996	646,559.3	563,201.0	14.8
1997	832,635.6	585,719.8	23.8
1998	817,393.4	606,409.8	-5.2
1999	925,345.8	625,910.2	9.7
2000	1,018,885.7	632,521.5	9.0
2001	1,115,641.4	639,013.0	8.4
2002	1,240,786.8	664,868.3	6.9
2003	1,461,169.2	702,421.7	11.5
2004	1,807,985.9	776,902.2	11.9

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл

1995 оны зэрэгцүүлэх үнээр суурь болгосон ДНБ-ий дефляторын дээрх тооцоололтоос үзвэл, 1998 онд эдийн засаг дахь дундаж үнэ буурсан бол сүүлийн 2 жил тус бүр нэг оронтой тооноос хальсан байна.

Гэвч ингэж тооцоолж гаргасан ДНБ-ий дефляторын үзүүлэлт нь дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг *World Development Indicators*-д тусгагдсан

Монгол улсын үзүүлэлтээс зөрж байна. Дэлхийн банкны тооцооны засварыг мэдэхийн аргагүйн дээр угаасаа ДНБ-ий нэрлэсэн дүн, дефляторын утгад тус банкнаас зарим зохицуулалт хийсэн байх магадлалтай гэж ҮСГ-ынхан үзэж байгаа. Төсөөтэй нөхцөл мөн ОУВС-аас эрхлэн гаргадаг олон улсын санхүүгийн статистикийн үзүүлэлтэд ч хамаарна.

Иймд Фрейзер институтын аргачлалын дагуу инфляцийг дотоодын нийт бүтээгдэхүүний дефляторын стандарт өөрчлөлтөөр илэрхийлэхдээ үндэсний статистикийн мэдээлэлд тулгуурласан тооцооллолт болон дэлхийн банкны үзүүлэлтийн аль алиар тооцож үзэх, хоёр Эх сурвалжийн мэдээллийн зөрүүний шалтгааныг тодруулах нь зүйтэй байна.

Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний дефлятор, хувиар

Он	Монгол улсын статистикийн эмхэтгэл	International Financial Statistics (IMF)	World Development Indicators (World Bank)
1999	9.7	9.7	9.7
2000	9.0	8.9	11.6
2001	8.4	8.5	8.8
2002	6.9	5.6	3.7
2003	11.5	5.8	4.7

Инфляцийг ДНБ-ий дефляторын аргаар тооцох нь хэдийгээр онолын хувьд зөв боловч хэрэглээний барааны үнийн индексстэй харьцуулбал ажиглахад илүү төвөгтэй, тооцож байгаа арга нь шууд бус. Гийм учраас манай улсын хувьд макроэдийн засгийн бодлогыг тодорхойлохдоо инфляцийн үзүүлэлтээр хэрэглээний барааны үнийн индексийг авдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Фрейзер институтээс 2004 онд гаргасан Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексстэй харьцуулах боломжтой байлгах, мөн инфляцийг илэрхийлэгч үзүүлэлт болгосон ДНБ-ий дефляторыг зөвлөхөөс тооцоолсон ба дэлхийн банкнаас гаргасан статистик дээр тулгуурлан хэсгийн дэд үзүүлэлтийн 2000-2004 оны индексийг (индекс тооцсон

томъёо бүхий файлыг энэхүү тайлангийн Хавсралт 3-т тусгасан) тооцож гаргая.

Монгол улсын статистикийн эмхэтгэлийн үзүүлэлт хийсэн тооцоогоор			
	ДНБ-ий дефлятор	Сүүлийн 5 жилийн стандарт хэлбэлзэл	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
1996	14.8		
1997	23.8		
1998	-5.2		
1999	9.7		
2000	9.0	10.5	5.8
2001	8.4	10.3	5.9
2002	6.9	6.2	7.5
2003	11.5	1.7	9.3
2004	11.9	2.1	9.2

Дэлхийн банкны World development indicators үзүүлэлтээр			
	ДНБ-ий дефлятор	Сүүлийн 5 жилийн стандарт хэлбэлзэл	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
1996			
1997			
1998			
1999	9.7		
2000	11.6		
2001	8.8		
2002	3.7		
2003	4.7	3.4	8.7
2004			

Юуны өмнө дотоодын үзүүлэлтээс зөрүүтэй байгаа Дэлхийн Банкны *World development indicators*-т тусгасан ДНБ-ий дефлятор нь зөвхөн 1999-2003 он хүртэлх 5 жилийг хамарсан бөгөөд түүнээс үндэслэн стандарт хэлбэлзэл болон хэсгийн дэд үзүүлэлтийн индексийг 2003 оны хувьд л тооцох боломж өгөгдсөн юм.

Хэсгийн дэд үзүүлэлтийн индексийг тооцохдоо:

- ДНБ-ий дефляторыг Монгол улсын статистикийн эмхэтгэлд тусгагдсан ДНБ-ий оны болон зэрэгцүүлэх үнийн үзүүлэлтийг ашиглан 1996-2004 оны хувьд тооцож гаргасан.
- ДНБ-ий дефляторын сүүлийн 5 жилийн стандарт хэлбэлзлийг дараах томъёогоор тооцож гаргасан

$$STDEV = \{[n\sum x^2 - (\sum x)^2] / n(n-1)\}^{1/2}$$

- Ингэж гаргасан стандарт хэлбэлзэл нь сүүлийн 5 жилд ДНБ-ий дефлятор нь дунджаасаа хэрхэн өөрчлөгдсөнийг харуулна.
- Фрейзер институтын аргачлалын дагуу

$$(V_{max} - V_i) / (V_{max} - V_{min}) \times 10$$

томъёогоор индексийг тооцсон ба үүнд:

V_i - ДНБ-ий дефляторын сүүлийн 5 жилийн стандарт хэлбэлзэл

V_{max} - 25-тай тэнцүү байхаар аргачлалын дагуу өгөгдсөн

V_{min} - 0-тэй тэнцүү байхаар аргачлалын дагуу өгөгдсөн

ДНБ-ий дефляторын сүүлийн 5 жилийн стандарт хэлбэлзэл 0 рүү тэмүүлэх тусам үүнийг эдийн засгийн агуулгаар нь инфляцийн тоо хэмжээнээс үл шалтгаалаад тогтвортой гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд хамгийн дээд буюу 10 гэсэн индекс авна. Харин энэхүү стандарт хэлбэлзэл 25 хувь руу тэмүүлэх тусам инфляци тогтворгүй болж хамгийн бага буюу 0 гэсэн индекс авна.

Манай улсын индекс үндсэндээ 5.8-9.3 хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд 2003 оны үзүүлэлт хамгийн сайн буюу 9.3 гэсэн индекстэй гарсан байна. Дэлхийн банкны үзүүлэлтээр ч гэсэн энэхүү индекс 2003 оны хувьд 8.7-д хүрсэн нь мөн л харьцангуй өндөр үзүүлэлт. Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс ингэж өндөр гарсан нь 1999 оноос хойш 2001 оныг оролцуулахгүйгээр ДНБ-ий дефлятор 8.4-11.9 хувийн хооронд л хэлбэлзэж харьцангуй тогтвортой байснаас шалтгаалжээ.

Энэхүү индексийг шилжилтийн болон хөгжингүй эдийн засагтай зарим улсуудын индекстэй⁹ 2002 оны байдлаар харьцуулж үзвэл:

	Үзүүлэлт	Индекс
ОХУ	29.0	0.0
Украин	10.8	5.7
Румын	12.3	5.1
Монгол	6.2	7.5
Болгар	9.6	7.6
Чили	4.1	8.4
Польш	4.0	8.4
Сингапур	3.1	8.8
Гонконг	3.0	8.8
Солонгос	2.8	8.9
Литва	2.7	8.9
Латви	2.5	9.0
Эстони	2.3	9.1
Словак	1.9	9.2
Бангладеш	1.7	9.3
Унгар	1.7	9.3
Канад	1.6	9.4
Чех	1.0	9.6
Хятад	0.8	9.7
Япон	0.7	9.7
АНУ	0.6	9.8
Их Британи	0.5	0.8

Өмнө дурьдсанчлан ДНБ-ий дефляторыг тооцох нь хэрэглээний барааны үнийн индекстэй харьцуулбал ажиглахад илүү төвөгтэй, тооцож байгаа арга нь шууд бус, гарсан дүн нь олон улсын санхүүгийн байгууллагуудаас гаргасан дүнтэй зөрдөг зэрэг нь хэсгийн энэхүү дэд үзүүлэлтийг найдвартай тооцож гаргахад төвөг учруулдаг.

Хэдий тийм боловч статистикийн газраас өгч байгаа мэдээлэл дээр хийсэн тооцооноос үзвэл 1999 оноос хойш дундаж үнийн өсөлт тогтворжих хандлагатай байгаа учраас энэхүү дэд үзүүлэлтээр Монгол улс цаашид өндөр индекс авах бүрэн боломжтой.

⁹ - Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайлан 2004

В. Өнөөгийн инфляцийн түвшин

Инфляцийн түвшинг тодорхойлдог хамгийн түгээмэл арга нь хэрэглээний барааны үнийн индексийн арга юм.

Ласпейресийн стандарт индексийг ашиглан тооцдог энэхүү үзүүлэлт нь дундаж хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар тогтмол байхад үнэ нь дунджаар хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулдаг юм.

Өрх бүрийн, тэр байтугай хүн бүрийн хэрэглээний бүтэц адилгүй. Хүний худалдаж авдаг бараа, үйлчилгээний нэр төрөл тоо томшгүй хийгээд нэр төрөл нь ч, чанар нь ч байнга өөрчлөгдөж байдаг. Ийм нөхцөлд хэрэглээний үнийн өөрчлөлтийг хэрхэн зөв тооцох вэ?

1991 оны 9-р сараас эхэлж Үндэсний статистикийн газраас тооцож ирсэн хэрэглээний барааны үнийн индексийн гол агуулга хэлбэр нь:

- Хүн амыг хэрэглээний бүтцээр нь Улаанбаатар хотын ба аймгийн гэж ангилсан.
- Тодорхой нэр төрлийн бараа, үйлчилгээгээр сагс бүрдүүлэн үнийг нь, үнийн өөрчлөлтийг нь судалж ирсэн.
- Улаанбаатар хотын хэрэглээний сагсыг 1991 оноос 123 нэр төрлийн бараа, үйлчилгээгээр, 1996 оноос 205 нэр төрлийн бараа үйлчилгээгээр, 2001 оноос 239 нэр төрлийн бараа үйлчилгээгээр бүрдүүлэн бүтцийг шинэчилж ирсэн.
- Аймгуудын хэрэглээний сагсыг 1997 оноос 116 нэр төрлийн бараа үйлчилгээгээр, 2001 оноос 139 нэр төрлийн бараа үйлчилгээгээр тооцож ирсэн.
- Хэрэглээний сагсанд орох бараа үйлчилгээний нэр төрлийг олшруулж өөрчлөлт хийхдээ хүн амын хэрэглээний бүтцийг судалсаны үндсэн дээр гүйцэтгэдэг бөгөөд ингэж хийх бүтцийн өөрчлөлт нь ерөнхий индекст нөлөөлөхгүй байхаар тооцож Ласпейресийн хувиргасан индексийг ашигладаг байна.

- Хэрэглээний сагсанд орох бараа үйлчилгээний жинг тогтоохдоо өрхийн орлого зарлагын судалгааг үндэслэдэг.
- Хэрэглээний барааны үнийн ерөнхий индексийг үндсэндээ Улаанбаатар хотын индексээр төлөөлүүлж авдаг.

Хэрэглээний сагсыг бүрдүүлэгч дараах бүлгийн зарим бараа үйлчилгээний үнэ тарифыг ҮСГ-аас тогтмол нийтэд мэдээлж ирсэн. Үүнд:

- Хүнсний барааны (22 нэр төрлийн)
- Хувцас гутлын (15 нэр төрлийн)
- Орон сууц, түлш, цахилгааны (7 нэр төрлийн)
- Гэр ахуйн барааны (7 нэр төрлийн)
- Эм тарианы (2 нэр төрлийн)
- Тээвэр, холбооны үйлчилгээний (5 нэр төрлийн)
- Соёлын бараа үйлчилгээний (2 нэр төрлийн)
- Бусад бараа үйлчилгээний (2 нэр төрлийн)

Хэрэглээний барааны үнийн ерөнхий индексийг тооцож гаргахад чухал ач холбогдолтой мэдээлэл бол бараа үйлчилгээний бүлэг болон нэр төрөл бүрийн нийт хэрэглээний сагсанд эзлэх хувийн жин юм. ҮСГ-аас жилийн турш түүвэрлэлтэд хамрагдсан 11232 өрхийн дундаж үзүүлэлтээр улсын нэг өрхийн орлого зарлагын байдлыг төлөөлүүлэн тогтоож байна.

Тухайлбал 2003 онд манай улсын дундаж нэг өрх сард 131040 төгрөгийн мөнгөн зарлага гаргасны 53056 төгрөг буюу 40.5 хувийг хүнсний зүйлд, 39506 төгрөг буюу 30.1 хувийг хүнсний бус бараанд, 34250 төгрөг буюу 26.1 хувийг үйлчилгээний төлбөрт зарцуулаад зөвхөн 1434 төгрөг буюу 1.1 хувийг хадгаламжид хийж 2794 төгрөг буюу 2.1 хувийг бусад туслахад зориулжээ¹⁰. Дээрх судалгаагаар өрхийн хэрэглээнд хамгийн өндөр жин эзэлсэн хүнсний зүйл нь мах махан бүтээгдэхүүн 9.7 хувь, гурил гурилан бүтээгдэхүүн 9.9 хувь байсан бол хүнсний бус

¹⁰ - Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2003, Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц

бараан дотор бэлэн хувцас 6.7 хувь, гутал 5.5 хувь, үйлчлэгээний дотор сургалтын төлбөр боловсролын зардал 7.1 хувийг тус тус эзэлж байна.

ҮСГ-аас хэрэглээний үнийн индексийг холбогдох аргачлалын дагуу тооцох бөгөөд энэ тухай мэдээллийг www.nso.mn хуудсаас авч болно.

Монгол улс, Хэрэглээний барааны үнийн жилийн өсөлт, хувиар

Он	Монгол улсын статистикийн эмхэтгэл (ҮСГ)	International Financial Statistics (IMF)
1991	52.7	
1992	325.5	263.7
1993	183.0	268.3
1994	66.3	87.5
1995	53.1	60.5
1996	44.6	46.9
1997	20.5	36.5
1998	6.0	9.3
1999	10.0	7.6
2000	8.1	11.6
2001	8.0	6.3
2002	1.6	0.9
2003	4.7	5.1
2004	11.0	

Хүснэгтээс үзэхэд хэрэглээний барааны үнийн өсөлтийг тооцсон ҮСГ болон ОУВС-гийн дүн зөрж байгаа нь ОУВС-гийн өөрийн засвар тооцоололттой холбоотой бөгөөд нэгэнт мэдээллийн үндсэн эх сурвалж нь ҮСГ учраас түүний мэдээллийг ашиглах нь зүйтэй юм.

Фрейзер институтын аргачлалын дагуу өнөөгийн инфляцийг илэрхийлэгч үзүүлэлт болгон хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон. Ингэхдээ Монгол улсын статистикийн эмхэтгэлд нийтлэгдсэн хэрэглээний барааны үнийн ерөнхий индексийн жилийн өсөлтийн үзүүлэлтийг ашиглан хэсгийн дэд үзүүлэлтийн 1991-2004 оны индексийг (индекс тооцсон томъёо бүхий файлыг энэхүү тайлангийн Хавсралт 4-т тусгасан) тооцож гаргая.

	Хэрэглээний барааны үнийн жилийн өсөлт	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
1991	52.7	0.0
1992	325.5	0.0
1993	183.0	0.0
1994	66.3	0.0
1995	53.1	0.0
1996	44.6	1.1
1997	20.5	5.9
1998	6.0	8.8
1999	10.0	8.0
2000	8.1	8.4
2001	8.0	8.4
2002	1.6	9.7
2003	4.7	9.1
2004	11.0	7.8

Хэсгийн дэд үзүүлэлтийн индексийг тооцохдоо:

- Тухайн жилийн хэрэглээний барааны үнийн индексийн өсөлтийг Монгол улсын статистикийн эмхэтгэлээс авсан
- Фрейзер институтын аргачлалын дагуу $(V_{max} - V_i) / (V_{max} - V_{min}) \times 10$ томъёогоор индексийг тооцсон ба үүнд:

V_i - Тухайн жилийн хэрэглээний барааны үнийн индексийн өсөлт

V_{max} - 50-тай тэнцүү байхаар аргачлалын дагуу өгөгдсөн

V_{min} - 0-тэй тэнцүү байхаар аргачлалын дагуу өгөгдсөн

Хэрэглээний барааны үнийн өсөлт 0 рүү тэмүүлэх буюу үнэ өсөхгүй байх тусам үүнийг эдийн засгийн утгаар нь үнийн төгс тогтворжилт гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд хамгийн дээд буюу 10 гэсэн индекс авна. Үнийн өсөлт 50 хувь руу тэмүүлэх тусам хамгийн бага буюу 0 гэсэн индекс авна. Аргачлалын дагуу үнийн өсөлт жилд 50 хувиас дээш гарсан тохиолдолд автоматаар 0 гэсэн индекс өгсөн байгаа.

Ийм ч учраас манай улс 1996 оноос өмнө жилд байнга 50 хувиас дээш үнийн өсөлттэй байсан учраас 0 гэсэн индекс авсан. 1998 оноос эхлэн инфляци нэг оронтой тоонд шилжсэн

учраас тухайн жилүүдийн индекс өндөр гарсан. Индексийн тооцоог хийхдээ инфляци 50 хувиас дээш гарсан нөхцөлд индекс 0-тэй тэнцүү байх нөхцлийг тусгасан логик оператор¹¹ ашигласан.

Сүүлийн жилүүдэд Төв банкнаас явуулдаг мөнгөний бодлого суларч мөнгөний нийлүүлэлт (M2) хэт өссөн (2003 онд 49.6 хувь, 2004 онд 20.5 хувь) учраас энэ нь хэрэглээний барааны үнэнд нөлөөлж түүний жилийн өсөлт 2004 онд 11 хувь, 2005 оны эхний хагас жилийн байдлаар 17.8 хувьд хүрсэн байна. Хэрэглээний үнийн өсөлт ийнхүү нэг оронтой тооноос хальсан явдлыг ҮСГ-аас импортын бензиний үнийн өсөлтөөр тайлбарлахыг оролдож байгаа боловч нэгдүгээрт, нефтийн үнийн өсөлт зөвхөн манай улсад бус дэлхий дахинд тохиолдсон, хоёрдугаарт манай улсаас ч илүү эрчим хүч, нефтийн импортын хэрэглээ өндөртэй орнуудын хувьд ч 2004 он хэрэглээний үнийн өсөлт бага байсан юм. Иймд сүүлийн үеийн хэрэглээний барааны үнийн өсөлтийн шалтгааныг мөнгөний бодлоготой холбон тайлбарлах нь илүү зохимжтой болно.

Хэрэглээний барааны үнийн өсөлтөөр илэрхийлэгдсэн хэсгийн дэд үзүүлэлтийн индексийг шилжилтийн болон хөгжингүй эдийн засагтай зарим улсуудын индекс¹²тэй 2002 оны байдлаар харьцуулж үзвэл:

	Үзүүлэлт	Индекс
Румын	22.5	5.5
ОХУ	15.8	6.8
Болгар	5.8	8.8
Унгар	5.3	8.9
Эстони	3.6	9.3
Бангладеш	3.4	9.3
Словак	3.3	9.3
Гонконг	-3.0	9.4
Солонгос	2.8	9.4
Канад	2.8	9.4
Чили	2.5	9.5
Латви	2.0	9.6

¹¹ - Тайлангийн хавсралт 4-ийн зэрэглэл тооцсон томъёог файлаар харах

¹² - Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайлан 2004

	Үзүүлэлт	Индекс
Польш	1.9	9.6
Чех	1.8	9.6
Монгол	1.6	9.7
Их Британи	1.6	9.7
АНУ	1.6	9.7
Япон	-0.9	9.8
Хятад	-0.8	9.8
Украин	0.8	9.8
Сингапур	-0.4	9.9
Литов	0.3	9.9

Румын, ОХУ-ыг эс тооцвол 2002 он бидний сонгож авсан орнуудын хувьд үнэ харьцангуй тогтвортой жил байсан байна. Өмнө харьцуулсан хэсгийн дэд үзүүлэлтээр харьцангуй сул индекс авч байсан Украин, Монгол зэрэг улсын хувьд ч хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2002 онд бараг өсөөгүй шахам. Тийм ч учраас онцгой сайн индекс^{тэй} гарсан байна.

Г. Дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрх

Мөнгөний хэрэгслийг хаанаас гаргаж буйгаас нь үл хамаараад түүнийг эзэмших эрхтэй байх нь эдийн засгийн эрх чөлөөний чухал үзүүлэлт мөн. Ялангуяа дотоодын инфляци өндөр, тиймээс худалдан авах чадвар нь түргэн унадаг эдийн засагт илүү нэр хүндтэй төлбөрийн хэрэгслийг эзэмших эрэлт их байх нь түгээмэл юм.

Улс төрийн тогтолцоо, макро эдийн засгийн бодлогоос хамаараад улс гүрнүүд өөрийнхөө иргэдэд гадаад валютын данс эзэмших эрхийг олгох талаар ялгаатай байр суурь баримтлах тал бий боловч нэгдүгээрт, улам бүр даяаршиж байгаа санхүүгийн зах зээлийн давуу талыг дотоодын эдийн засагтаа ашиглах үүднээс хоёрдугаарт, валютын данс эзэмших эрхийг хязгаарлах, түүнд хяналт тавих нь улам бүр төвөгтэй бөгөөд үр ашиггүй ажиллагаа болох тул дэлхийн ихэнх улсууд үүнийг чөлөөтэй болгожээ.

Монгол улс бол гадаад валютын харьцангуй чөлөөт дэглэмтэй орон мөн. Худалдаа, төлбөр тооцоо, хөрөнгийн шилжүүлгийн чөлөөт бодлогыг баримталж буйгаас гадна гадаад валютын данс эзэмших эрхийг чөлөөтэй байлгасны илрэл нь сүүлийн 10 гаруй жилийн турш дотоодын банкууд дахь иргэдийн гадаад валютын хадгаламжийн дүн төгрөгийн хадгаламжийн дүнтэй ойролцоо¹³ байгаагаар харагдаж байна.

Манай улс нээлттэй жижиг орон болохын хувьд дотоодын эдийн засаг дахь гадаад валютын гүйлгээний нөлөө асар их. Гадаадад оршин сууж байгаа манай иргэдийн валютын гуйвуулга, гадаадын хөрөнгө оруулалт, албан ёсны зээл тусламж, гадаад худалдааны цар хүрээ нэмэгдэж эдийн засгийн хэмжээ, өсөлтөд шийдвэрлэх байр суурийг эзэлж байна. Хэдийгээр эдийн засгийн хэмжээ жижиг, цөөн хэдэн нэр төрлийн түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнээс хэт хамааралтай боловч валютын ханшны уян хатан тогтолцоо болон гүйлгээний чөлөөт дэглэмийн ачаар аливаа цочир нөлөөллийг сааруулах боломжийг Монгол улс бүрдүүлсэн.

Валютын дэглэмийн бусад асуудлуудыг тусгахын зэрэгцээ улс орнуудын иргэдийн гадаад валютын данс эзэмших эрхийг албан ёсоор тодорхойлсон баримт бичиг нь ОУВС-гаас жил бүр гаргадаг *Валютын зохицуулалт ба валютын хязгаарлалтын тайлан* юм.

Энэхүү тайланд манай улсыг гадаад валютын данстай байхыг зөвшөөрдөг, дансны үлдэгдлээ экспортын орлого болон гадаадаас ирэх мөнгөн гуйвуулгаар өсгөж болдог, дансны үлдэгдлээ ямар ч хязгаарлалтгүйгээр зарцуулах эрхтэй гэж дүгнээд иргэд нь гадаад валютын дансыг дотоодод ба гадаадад эзэмших эрхтэй гэж оруулсан байна.¹⁴

Гадаад валютын гүйлгээтэй холбогдсон асуудлыг бүхэлд нь *Валютын зохицуулалтын хууль*-ийн дагуу журамладаг. Энэхүү тайлангаар хуулийн зохицуулалт хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөхийг зориогүй боловч гадаад валютын данс эзэмших эрхтэй холбогдсон хэрэгжүүлэх, хяналт тавихад төвөгтэй зарим

нэг заалт байгааг анхааралгүй өнгөрсөнгүй. Тухайлбал: Арилжааны банкны эрхлэх валютын гүйлгээ, эрх үүрийг тусгасан уг хуулийн 11 дүгээр зүйлийн 1.3-т байнга болон түр оршин суугчдын нэр дээр гадаад валютын данс нээж гүйлгээ хийх, 2.3-т, харилцагчийн гадаад валютын дансны нууцыг хадгалж, найдвартай байдлыг хангах, 2.4-т, гадаад валютын гүйлгээг харилцагчийн анхны шаардлагаар хийх, хөрөнгийг нь үлдэгдэлд хүү төлөх гэх мэт заалтууд нь нэг талаас данс эзэмших эрхийг банкны байгууллагын талаас баталгаажуулж өгсөн юм шиг боловч бүхэлдээ банкны хууль тогтоомжоор нэгэнт зохицуулагдсан заалтууд байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаад валютын гүйлгээг тусгасан 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт, байнга болон түр оршин суугчид нь валютыг худалдах, худалдан авах, зээлдэх, шилжүүлэх ажиллагааг Монгол Банк болон түүнээс эрх олгосон банкаар дамжуулан гүйцэтгэнэ гэж заасан нь хянах болон хэрэгжүүлэхэд нэн төвөгтэй бөгөөд практик дээр зөрчигдсөн заалт болжээ.

Цаашилбал, мөн зүйлийн 2 дахь хэсэгт, байнга оршин суугч нь орлогоо гадаад валютаар авсан бол эрх бүхий арилжааны банкинд уг орлогоо авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор худалдах буюу хадгалуулна, 3 дахь хэсэгт, бэлэн валютаар гүйлгээ эрхлэгч өдөр тутмын гүйлгээ хийхэд шаардагдахаас бусад гадаад валютыг Монгол Банкнаас тогтоосон журмын дагуу зохих хугацаанд банкинд худалдах буюу хадгалуулна гэж заасан нь бэлэн валютын гүйлгээг илэрхий хязгаарласан шинжтэй байгаагаас гадна энэ зохицуулалтаараа иргэдийг гадаад валютын данс эзэмших эрхтэй гэхээсээ илүү үүрэгтэй болгожээ.

Нөгөө талаас дээрх заалтууд нь иргэдийг гадаад валютаа зөвхөн Монгол Банкнаас эрх олгосон дотоодын арилжааны банкинд худалдах буюу хадгалуулах үүрэгтэй болгоод гадаадын банкинд данс эзэмших эрхийг нээгээгүй буюу хязгаарласан шинжтэй байна. Үүнээс өөрөөр иргэдийн гадаадад валютын данс эзэмшихтэй холбогдсон харилцааг шууд буюу шууд бус замаар зохицуулсан үйл ажиллагаа алга байна.

¹³ - 2004 оны эцэст дотоодын банкууд дахь иргэдийн гадаад валютын хадгаламж 324 тэрбум төгрөгт, төгрөгийн хадгаламж 300 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

¹⁴ - Annual report on Exchange Arrangements and Exchange Restrictions, 2000-2004 issues

Гэвч практик дээр манай иргэд гадаад валютаар дотоодын банкинд ч, гадаадын банкинд ч данс эзэмших үйл ажиллагаа чөлөөтэй бөгөөд гадаадад данс эзэмших эрх нь манай улсын хууль тогтоомжоор гэхээс илүү гадаад улсын хууль тогтоомжоор зохицуулагдаж байна.

Зөвлөх иргэдийн гадаад валютын данс эзэмших эрхийг де юри, хууль тогтоомжийн зохицуулалтаар гэхээс илүү де факто байдлаар нь тодорхойлох нь илүү зохистой гэж үзсэн болно. Ийм ч учраас Монгол улсын иргэд гадаад валютын дансыг дотоодод ба гадаадад эзэмших эрхтэй гэсэн ОУВС-гийн дүгнэлттэй санал нэг байна.

Хэсгийн дэд үзүүлэлтийн индексийг тооцохдоо гадаад валютын дансыг дотоодод болон гадаадад эзэмших эрхтэй бол 10 гэсэн индекс, эрхгүй бол 0 гэсэн индекс, хэрэв гадаад валютын дансыг дотоодод эзэмших эрхтэй, гадаадад эзэмших эрхгүй бол 5 гэсэн индекс аргачлалын дагуу өгөгдөнө.

Нэгэнт Монгол улсын иргэд гадаад валютын дансыг дотоодод эзэмших эрхтэй, мөн гадаадад эзэмших де факто эрхтэй учраас Фрейзэр институтын аргачлалын дагуу хэсгийн дэд үзүүлэлтээр хамгийн өндөр индекс буюу 10 гэсэн индекс авах боломжтой.

Иргэдийн дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрхээр илэрхийлэгдсэн хэсгийн дэд үзүүлэлтийн индексийг шилжилтийн болон хөгжингүй эдийн засагтай зарим улсуудын индекстэй 2002 оны байдлаар харьцуулж дараах хүснэгтэд харуулав.

Сонгож авсан орнуудын ихэнх нь иргэддээ гадаад валютын дансыг дотоодод болон гадаадад эзэмших эдийн засгийн эрх чөлөөг олгосон байна. Жагсаалтын эхэнд бичигдсэн орнууд ч гэсэн иргэддээ гадаад валютын дансыг гадаадад эзэмших эрх олгоогүй гэсэн үг биш бөгөөд гагцхүү тусгай нөхцөл заах, зөвшөөрөл авахыг шаардах зэргээр янз бүрийн хязгаарлалт хийдгээс болж 0 гэсэн индекс авчээ.

Жишээ нь, ОХУ иргэдийнхээ гадаадад данс эзэмших эрхийг Төв Банкнаас зөвшөөрөл авах ёстой гэсэн шаардлагаар хязгаарлаж байсан бол 2004 оноос зөөллөж эдийн засгийн хамтын нийгэмлэг, FATF буюу мөнгө угаах явдлын эсрэг тэмцэх зорилгоор байгуулагдсан

санхүүгийн үйл ажиллагааны тусгай хүчний гишүүн орнуудад арилжааны бус зорилгоор данс нээж болохоор өөрчилсөн байна. Хятад улсын хувьд, иргэдийнхээ гадаад валютын данс эзэмших эрхийг дотоодод ч гадаадад ч зөвшөөрөх боловч тусгай зөвшөөрөл урьдчилан авсан байхыг шаарддаг.

	Дотоодод данс эзэмших эрх	Гадаадад данс эзэмших эрх	Индекс
Бангладеш	0	0	0
Румын	5	0	5
ОХУ	5	0	5
Словак	5	0	5
Польш	5	0	5
Хятад	5	0	5
Украин	5	0	5
Болгар	5	5	10
Унгар	5	5	10
Эстони	5	5	10
Латви	5	5	10
Чех	5	5	10
Монгол	5	5	10
Чили	5	5	10
Гонконг	5	5	10
Канад	5	5	10
Их Британи	5	5	10
Япон	5	5	10
АНУ	5	5	10
Сингапур	5	5	10
Литов	5	5	10

Гэхдээ ямар ч хязгаарлалт хийсэн түүнийг хянах, хэрэгжүүлэх гэдэг нь ямар ч улсын өмнө тавигддаг хамгийн чухал асуудал бөгөөд түүнээс уламжлан уг хязгаарлалтын үр дүн хэмжигддэг билээ.

Монгол улсын хувьд энэхүү дэд үзүүлэлтээр байнга өндөр индекс авахын тулд гадаад валютын талаар явуулж байгаа чөлөөт дэглэмээ баталгаажуулах ингэхийн тулд Валютын зохицуулалтын хуульд нэмэлт оруулж иргэддээ гадаадын банкинд гадаад валютаар данс эзэмших эрхийг албан ёсоор олгох нь зүйтэй байна.

2.3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКСИЙН II БҮЛГИЙН (ЭРҮҮЛ МӨНГӨ ХҮРТЭХ БОЛОМЖ) ҮЗҮҮЛЭЛТИЙН ИНДЕКС

- А. Сүүлийн 5 оны мөнгөний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлтөөс хасах нь сүүлийн 10 оны ДНБ-ий жилийн дундаж бодит өсөлт
- Б. Сүүлийн 5 жилийн инфляцийн стандарт өөрчлөлт
- В. Өнөөгийн инфляцийн түвшин
- Г. Дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрх

Өгөгдсөн аргачлалын дагуу бүлгийн үзүүлэлтийн ерөнхий индексийг тооцохдоо 4 дэд үзүүлэлтүүдийн арифметик дунджаар гаргасан. Монгол улсын иргэдийн *эрүүл мөнгө хүртэх боломж* тогтвортой сайжирч байгаа нь бүлгийн А ба В дэд үзүүлэлтийн индекс дээшилсэн, тухайлбал, сүүлийн 10-аад жилийн турш ДНБ өсч тэр нь сүүлийн 5 жилийн үзүүлэлтэд нөлөөлсөн, 2004 онд ДНБ-ий огцом өсөлт (10.6 хувь) мөнгөний хамгийн бага өсөлт (4 хувь) гарч эдгээр нь дундаж өсөлтөд мөн нөлөөлсөн, сүүлийн жилүүдэд ДНБ-ий дефлятораар илэрхийлэгдсэн инфляци 10 орчим хувьд тогтвортой байгаа зэргээс шалтгаалсан байна.

Хэрэв 2004 онд хэрэглээний барааны үнийн өсөлт бага байсан бол илүү өндөр индекс авах ч боломж байсан байна. Бүлгийн индекс ерөнхийдөө харьцангуй өндөр гарахад нөлөөлсөн өөр нэг чухал дэд үзүүлэлт нь валютын данс эзэмших эрхийг чөлөөтэй байлгасан явдал юм.

Түүнчлэн энэхүү тайлангийн хавсралт 2-т үзүүлсэнчлэн мөнгөний өсөлтийг М2 агрегатаар авсан бол “А” дэд үзүүлэлт М1 агрегатаар тооцсон 8 гэсэн индексээс доошилж 4.6-д хүрэх бөгөөд бүлгийн ерөнхий индекс 7.9 болох байсан.

Бүлгийн үзүүлэлтийн ерөнхий индексийг ашиглан сонгож авсан орнуудыг 2002 оны хувьд жагсааж үзвэл:

	Индекс
ОХУ	3.8
Украйн	6.0
Румын	6.2
Бангладеш	6.9
Польш	7.9
Словак	8.2
Болгар	8.3
Монгол	8.4
Хятад	8.5
Чех	8.9
Унгар	9.1
Чили	9.2
Солонгос	9.2
Эстони	9.3
Латви	9.3
Гонконг	9.3
Литов	9.4
Япон	9.4
Канад	9.5
Их Британи	9.5
Сингапур	9.7
АНУ	9.8

Фрейзер институтын аргачлалын дагуу Эдийн засгийн эрх чөлөөний индексийн *Эрүүл мөнгө хүртэх боломж* гэсэн 3 дугаар бүлгийн ерөнхий индексийг тооцож үзэхэд хэрэв энэхүү төсөлд хамрагдсан бол Монгол улс 2002 оны хувьд 8.4 гэсэн индекс авахаар байгаа нь энэхүү индекст тухайн жилд хамрагдсан 123 орны тэг дундуур буюу 61-62 дугаар байр буюу Коста Рика (8.6), Хятад (8.5), Гаити (8.4) улсуудын дараа, Болгар (8.3), Сири (8.3) Словак (8.2) улсуудын өмнө байр эзлэх байсан байна

	«А» дэд үзүүлэлтийн индекс	«В» дэд үзүүлэлтийн индекс	«С» дэд үзүүлэлтийн индекс	«D» дэд үзүүлэлтийн индекс	«Эрүүл мөнгө хүртэх боломж» үзүүлэлтийн индекс
2000	5.0	5.8	8.4	10.0	7.3
2001	6.3	5.9	8.4	10.0	7.7
2002	6.5	7.5	9.7	10.0	8.4
2003	6.5	9.3	9.1	10.0	8.7
2004	8.0	9.2	7.8	10.0	8.8

Эрүүл мөнгө хүртэх боломж бүлгийн ерөнхий индексийн жагсаалтыг 9.9 индекстэй Панам, Оман улс, 9.8 индекстэй АНУ нар тэргүүлж 1.6 индекстэй Зимбабве, 1.7 индекстэй Бирм, 3.4 индекстэй Конгын Ардчилсан БНУ сүүл мушгисан байна.

Хавсралт 1. Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөр засварлагдсан Мөнгөний нийлүүлэлт М1-ийн өсөлт

	Мөнгөний нийлүүлэлт М1			Дотоодын нийт бүтээгдэхүүн			ДНБ-ий өсөлтөөр засварлагдсан М1-ийн өсөлт	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
	Тухайн жилийн өсөлт		Сүүлийн 5 жилийн дундаж өсөлт	Тухайн жилийн өсөлт		Сүүлийн 10 жилийн дундаж өсөлт		
	Хувь	Козф		Хувь	Козф			
1991	54.0	1.540		-9.2	0.908			
1992	4.5	1.045		-9.5	0.905			
1993	142.8	2.428		-3.0	0.970			
1994	77.2	1.772		2.3	1.023			
1995	29.7	1.297	1.551	6.3	1.063			
1996	50.8	1.508	1.545	2.4	1.024			
1997	18.4	1.184	1.584	4.0	1.040			
1998	8.5	1.085	1.348	3.5	1.035			
1999	39.0	1.390	1.284	3.2	1.032			
2000	13.9	1.139	1.251	1.1	1.011	1.000	25.2	5.0
2001	19.4	1.194	1.194	1.0	1.010	1.010	18.4	6.3
2002	20.2	1.202	1.198	4.0	1.040	1.025	17.3	6.5
2003	13.4	1.134	1.208	5.6	1.056	1.033	17.5	6.5
2004	4.0	1.040	1.140	10.6	1.106	1.041	9.9	8.0

Хавсралт 2. Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөр засварлагдсан Мөнгөний нийлүүлэлт М2-ын өсөлт

	Мөнгөний нийлүүлэлт М2			Дотоодын нийт бүтээгдэхүүн			ДНБ-ий өсөлтөөр засварлагдсан М2-ын өсөлт	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
	Тухайн жилийн өсөлт		Сүүлийн 5 жилийн дундаж өсөлт	Тухайн жилийн өсөлт		Сүүлийн 10 жилийн дундаж өсөлт		
	Хувь	Козф		Хувь	Козф			
1991	76.8	1.768		-9.2	0.908			
1992	31.1	1.311		-9.5	0.905			
1993	228.5	3.285		-3.0	0.970			
1994	79.4	1.794		2.3	1.023			
1995	32.8	1.328	1.785	6.3	1.063			
1996	25.9	1.259	1.668	2.4	1.024			
1997	32.4	1.324	1.671	4.0	1.040			
1998	-1.6	0.984	1.313	3.5	1.035			
1999	31.6	1.316	1.234	3.2	1.032			
2000	17.5	1.175	1.205	1.1	1.011	1.000	20.5	5.9
2001	28.3	1.283	1.209	1.0	1.010	1.010	19.9	6.0
2002	42.0	1.420	1.226	4.0	1.040	1.025	20.2	6.0
2003	49.6	1.496	1.333	5.6	1.056	1.033	30.0	4.0
2004	20.5	1.205	1.310	10.6	1.106	1.041	26.9	4.6

Эх сурвалж: Монгол Банкны жилийн тайлангууд, ҮСГ-ын эмхэтгэлүүд

Эстони улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөр засварлагдсан Мөнгөний нийлүүлэлт М2-ын өсөлт

	Мөнгөний нийлүүлэлт М2		Дотоодын нийт бүтээгдэхүүн			ДНБ-ий өсөлтөөр засварлагдсан М2-ын өсөлт	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс	
	Тухайн жилийн өсөлт		Тухайн жилийн өсөлт		Сүүлийн 10 жилийн дундаж өсөлт			
	Хувь	Көэф	Хувь	Көэф				
1991								
1992	69.6	1.696	-12.4	0.876				
1993	59.0	1.590	-8.5	0.915				
1994	29.0	1.290	-1.8	0.982				
1995	30.0	1.300	0.000	4.2	1.042			
1996	43.3	1.433	1.453	3.9	1.039			
1997	37.6	1.376	1.394	9.8	1.098			
1998	3.9	1.039	1.280	4.6	1.046			
1999	23.5	1.235	1.269	-0.1	0.999			
2000	25.9	1.259	1.261	7.8	1.078			
2001	23.3	1.233	1.223	6.4	1.064	1.012	21.2	5.8
2002	11.3	1.113	1.173	7.2	1.072	1.032	14.0	7.2
2003	10.8	1.108	1.188	5.1	1.051	1.047	14.1	7.2
2004	15.7	1.157	1.172	6.2	1.062	1.055	11.7	7.7

Эх сурвалж: World development indicators, International Financial statistics, Bank of Estonia

Монгол улс, Дотоодын нийт бүтээгдэхүүний дефляторын тооцоололт

	ДНБ, сая төгрөгөөр		ДНБ-ий дефлятор
	Оны үнээр	Зэрэгцүүлэх үнээр	
	1995	550,253.7	
1996	646,559.3	563,201.0	14.8
1997	832,635.6	585,719.8	23.8
1998	817,393.4	606,409.8	-5.2
1999	925,345.8	625,910.2	9.7
2000	1,018,885.7	632,521.5	9.0
2001	1,115,641.4	639,013.0	8.4
2002	1,240,786.8	664,868.3	6.9
2003	1,461,169.2	702,421.7	11.5
2004	1,807,985.9	776,902.2	11.9

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл

Хавсралт 3. Монгол улс, Сүүлийн 5 жилийн инфляцийн стандарт өөрчлөлт

	Монгол улсын статистикийн эмхэтгэлийн үзүүлэлт хийсэн тооцоогоор			Дэлхийн банкны World development indicators үзүүлэлтээр		
	ДНБ-ий дефлятор	Сүүлийн 5 жилийн стандарт хэлбэлзэл	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс	ДНБ-ий дефлятор	Сүүлийн 5 жилийн стандарт хэлбэлзэл	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
1996	14.8					
1997	23.8					
1998	-5.2					
1999	9.7			9.7		
2000	9.0	10.5	5.8	11.6		
2001	8.4	10.3	5.9	8.8		
2002	6.9	6.2	7.5	3.7		
2003	11.5	1.7	9.3	4.7	3.4	8.7
2004	11.9	2.1	9.2			

Хавсралт 4. Монгол улс, Өнөөгийн инфляцийн түвшин

	Хэрэглээний барааны үнийн жилийн өсөлт	Хэсгийн дэд үзүүлэлтийн индекс
1991	52.7	0.0
1992	325.5	0.0
1993	183.0	0.0
1994	66.3	0.0
1995	53.1	0.0
1996	44.6	1.1
1997	20.5	5.9
1998	6.0	8.8
1999	10.0	8.0
2000	8.1	8.4
2001	8.0	8.4
2002	1.6	9.7
2003	4.7	9.1
2004	11.0	7.8

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл

Бүлэг 3



Монгол Улсын Олон
улсын худалдааны эдийн
засгийн эрх чөлөөний
индексийн судалгаа

3.1 ОРШИЛ

Олон улсын худалдаа эрхлэхэд ижил нөхцөл бүрдүүлсэн, төвийг баримталсан аливаа арга хэмжээг худалдааг либералчлах буюу чөлөөтэй болгох үйл явц гэж ойлгох бөгөөд энэ нь тухайн улс орны одоогийн болон ирээдүйн худалдааны түншүүдийн хоорондын бараа эргэлтийг аль болох чөлөөтэй болгоно гэсэн үг юм. Олон улсын худалдааг либералчлах нь эдийн засгийн бодлогод үндсэн өөрчлөлт хийх асуудал бөгөөд эдийн засгийн байдал хүндэрч уналтанд орсон үед урьдын бодлогыг эрс тууштай өөрчлөх, түүнийг үндэсний эдийн засгийн бодлоготой нягт уялдуулахаас урган гардаг. Олон улсын худалдааны төлбөрийн тэнцэл муудах, инфляци их хэмжээгээр нэмэгдэх, худалдааны нөхцөл тааламжгүй болох зэрэг хямрал бий болоход олон улсын худалдааны либералчлал хийх нь олонтоо байдаг.

Эдийн засгийн харьцангуй тааламжтай нөхцөлд ч эдийн засгийн гол, гол салбарт илт доройтол байхгүй нөхцөлд ч либералчлал хийсэн туршлага байдаг. Либералчлалыг амжилттай хэрэгжүүлэхэд эдийн засгийн тогтворжуулалтын бодлогыг зайлшгүй зэрэгцүүлэн явуулж, улс төрийн тогтвортой байдлыг бүрдүүлэх хэрэгтэй. Дэлхийн улс орнууд тус бүрийн нөхцөл байдлаас хамаарч дараах зорилгоор олон улсын худалдааг либералчилж байна. Үүнд:

- Улс төр, үзэл суртлын эрс өөрчлөлт хийх
- Хөрөнгийн Эх сурвалжийг оновчтой зохицуулж, байршуулах, эдийн засгийн өсөлтийг хурдасгах
- Экспортын хэмжээг нэмэгдүүлэх, олон улсын худалдааны төлбөрийн тэнцлийг сайжруулах
- Импортын хэмжээ, барааны үнэд үзүүлэх либералчлалын нөлөөг ашиглан инфляцийг зогсоон, тогтворжуулах
- Бүс нутгийн эдийн засгийн байгууллага юуны түрүүнд олон улсын эдийн засгийн байгууллагад элсэн орох, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх асуудлууд ордог.

Улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлоход тэдгээр улсуудын олон улсын худалдааны эдийн засгийн эрх чөлөөг хэмжих асуудал чухал байр суурийг эзэлдэг. Олон улсын худалдааны эдийн засгийн эрх чөлөө нь тухайн улс олон улсын худалдааг хэр зэрэг либералчилсантай холбогдох ойлголт болно. Сүүлийн жилүүдэд манай улсын олон улсын худалдааг либералчлах үйл явц хэр явагдаж байгааг үнэлж, дүгнэх нь энэ чиглэлийн бодлого үйл ажиллагааны үр дүн ямар байгаа, цаашид хэрхэхийг тодорхойлоход нэн ач холбогдолтой юм.

Олон улсын худалдааны либералчлалыг дараах хоёр арга замаар хийдэг. Үүнд:

- *Засгийн газрын хөндлөнгөөс оролцох хэлбэрийг өөрчлөх.* Жишээ нь: Тарифын бус хязгаарлалт түүний дотор тоон хязгаарлалтаас үнийн механизмд шилжих,
- *Үнийн системд өөрчлөлт оруулах.* Үнийн тогтолцоонд нөлөөлөх замаар импортын тариф, худалдааны бусад татвар, татаасыг өөрчлөх, тарифын бус хязгаарлалтыг багасгах, үндэсний валютын ханшийг өөрчлөх зэрэг бодлогыг хэрэгжүүлдэг.

Олон улсын худалдааны либералчлалыг удаан хугацаагаар мөрдөж байгаа улс орнууд нь

- Улс төрийн байдал тогтвортой
- Ихэвчлэн бага хэмжээний газар нутагтай
- Олон улсын чөлөөт худалдаанаас илүү ашиг олох боломжтой
- Экспортын өсөлт нь бусад орныхоос бараг 2 дахин их
- Валютын ханш удаан хугацаагаар харьцангуй тогтвортой байдаг зэрэг онцлогуудтай байна.

Эдийн засаг, эрх зүйн зохицуулалтын өвөрмөц онцлог бүхий хоёр их гүрний хооронд оршдог, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдсан байдал нь манай орны олон улсын харилцааны онцгой хүчин зүйл билээ. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 5-р зүйлд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн

хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасан нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, даяарчлалын бодлогод түшиглэсэн бодлого үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм.

Шилжилтийн эхний жилүүдэд Монгол улсын улс төр, эдийн засаг, эрх зүйн хүчин зүйлүүд нь олон улсын хамтын нийгэмлэгийн даяарчлалын бодлого, чиг хандлагын дагуу өөрийн бодлогыг тодорхойлох, жижиг орны хувьд олон улсын эрх зүйн баталгаатай хамгаалалтын замыг сонгон авахыг зүй ёсоор шаардаж байв. Ийм хамгаалалттай байх гол арга зам нь Олон Улсын томоохон байгууллагууд, тэдгээрийн ивээл дор байгуулагдан хэрэгжиж буй олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэж орох явдал юм. Чухамхүү энэ зорилгоор Монгол Улс Дэлхийн банк /ДБ/, Олон Улсын Валютын Сан /ОУВС/ зэрэг байгууллагад элсэн орсны зэрэгцээ Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрт /ТХЕХ/ элсэх өргөдлөө 1991 онд ТХЕХ-ийн Ерөнхий захиралд гаргасан юм. Монгол Улсыг ТХЕХ-т элсүүлэх ажлын хэсгийг 1992 оны 1-р сард байгуулж, түүнээс хойш ажлын хэсгийн хуралдааныг 1993, 1994, 1996 онуудад нийт 5 удаа зохион байгуулсан юм. Энэ хугацаанд Дэлхийн Худалдааны Байгууллага /ДХБ/ байгуулагдаж, олон улсын худалдааны зохицуулалтын эрх зүйн асуудлыг хариуцах болсноор Монгол Улс түүнд элсэх болсон. Энэ асуудал 1997 онд шийдэгдсэн билээ.

ДХБ-д нэгдэж орсноор өөрийн орны худалдаа, эдийн засгийг дэлхий нийтийн даяарчлалын шаардлагаар урган гарсан олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу явуулах, ингэснээр олон улсын эрх зүйн хамгаалалтад шилжих, ТХЕХ-ийн үндсэн зарчим болох үндэстний нэн тааламжтай нөхцөл, үндэстний нөхцөл, үл ялгаварлан гадуурхах, ил тод байх, тэгш эрхийн үндсэн дээр олон улсын худалдаанд оролцож, түүний давуу талыг эдлэх өөрийн орны худалдаа, эдийн засгийн бодлогыг дэлхийн жишигт нийцүүлж явуулах эрх зүйн нөхцлийг бүрдүүлэх, татварын бодлого, тариф, тарифын бус арга хэмжээг олон улсын эрх зүйн шаардлагад нийцүүлэн

явуулах, зах зээлийн эдийн засагт эргэлт буцалтгүй шилжих, ингэхийн тулд үндэстний хууль тогтоомжоо олон улсын эрх зүйд аажмаар нийцүүлэх зэрэг олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой болсон юм.

ДХБ-ын үндсэн үйл ажиллагаа нь олон улсын худалдааны эрх зүйн үндсийг тогтоох, худалдааг чөлөөтэй болгох, гадуурхах бодлогыг устгахад дөхөм үзүүлэх, худалдааны саад тотгорыг арилгах, худалдааны хэлэлцээ хийх асуудлыг зохицуулах, холбогдох маргааныг шийдвэрлэх, үндэстний бодлогод хяналт тавих зэрэгт чиглэгддэг. Монгол Улс ДХБ-д элсэхдээ авсан үүрэг амлалтыг хэрэгжүүлэх явцдаа олон улсын худалдааг либералчлах ажлыг тууштай хэрэгжүүлж байна. Монгол Улс Дэлхийн Худалдааны байгууллагад элссэнээр эдийн засаг, худалдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэж байгаа юм. Тухайлбал:

- Олон Улсын Худалдааны харилцаанд нэн таатай нөхцөл болон үндэстний дэглэмийг бусдаас олж авах бололцоо нээгдсэн
- Манай экспортын бараа гадаад орнуудын зах зээлд тарифын илүү хөнгөлөлттэй нөхцлөөр борлогдох бололцоотой болсон
- Шууд хөрөнгө оруулалтыг оруулахад дөхөмтэй болсон
- Худалдааны маргааныг Дэлхийн Худалдааны Байгууллагын маргаан таслах хороогоор шийдвэрлүүлж байх эрх зүйн бололцоо гарч байгаа нь арбитраар маргааныг шийдвэрлүүлэхэд шаардагдах их хэмжээний зардлаас чөлөөлөгдөх зэрэг ач холбогдлуудыг дурьдаж болно.

ДХБ-д элсэхийн зэрэгцээ Олон Улсын бараа худалдах, худалдан авах гэрээний тухай Венийн конвенцид 1997 онд, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцид 1995 онд, Улс болон улсын иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай конвенцид 1996 онд нэгдэн орсон юм.

Ийнхүү олон улсын байгууллага, гэрээ хэлэлцээр, олон улсын конвенциудад нэгдэн

орсон нь манай улсын олон улсын худалдааг либералчлах үйл явцад нэн тустай үйл явдал болсон билээ. 1990 оноос хойш Монгол Улс олон улс орнуудтай худалдааны хэлэлцээр байгуулж, хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих хэлэлцээр, давхар татвараас чөлөөлөх хэлэлцээрт олон улс оронтой гарын үсэг зуржээ.

Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Систем /БТКУС/, Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх конвенциудад гарын үсэг зурсан. Олон Улсын худалдааны горимыг аажмаар либералчилж бизнесийн аль ч нэгж гадаад худалдааны хэлцлийг тусгайлсан зөвшөөрөлгүйгээр хийж хэрэгжүүлэх эрхтэй болжээ. Тооны хязгаарлалтыг экспорт болон импортын хувьд ч тогтоохоо больсон. Экспортын лицензийг зөвхөн түүх дурсгалын болон археологийн олдвор, буу, зэвсэг, цус болон цусан бүтээгдэхүүн, радио идэвхит бодис зэрэг тусгайлсан бараанд, импортын лицензийг зэвсэг, тэсрэх дэлбэрэх бодис гэх мэтийн бараанд шаардах болсон. БТКУС-ийг барааны экспорт, импортын статистикийн мэдээ бүртгэлийг бүрдүүлэх загвар болгон ашиглаж байгаа бөгөөд түүнийг иж бүрэн утгаар нь хэрэглэхээр зорьж байна. Гаалийн үнэлгээний дүрэм нь ТХЕХ-ийн үнэлгээний кодонд тулгуурлах болсон.

Олон Улсын худалдаа нь улс орнуудын хооронд материаллаг үнэт зүйлс болон үйлчилгээ нийлүүлэх техник үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой онолын болон практик мэдлэгийн онцгой салбар бөгөөд Олон улсын худалдааны либералчлал нь Засгийн Газрын шууд оролцоогүй олон улсын худалдааны тогтолцоонд шилжих алхам юм.

3.2 БҮЛГИЙН СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгааны ажилд баримт материал цуглуулах, тоон мэдээлэл боловсруулахтай холбоотой эх сурвалжийн түүврийн арга, индексүүд болон түүврийн тоон үзүүлэлтүүдийг тооцох аргууд, корреляцийн хийгээд регрессийн шинжилгээний арга, харьцуулан дүгнэх аргуудыг ашиглав.

Олон улсын худалдааны эдийн засгийн эрх чөлөөний индекс нь олон улсын солилцоон дахь бодлогын ил ба далд, албан ба албан бус саад тотгорын зэрэг хэр байгааг хэмждэг. Фрейзер институтын аргачлалаар энэ индекс нь таван үндсэн үзүүлэлт, долоон дэд үзүүлэлтийн индексээр тооцогддог. Үзүүлэлтүүдийг авч үзье:

- A. Олон Улсын худалдааны татвар
 - Олон улсын худалдааны эргэлтэнд олон улсын худалдааны татварын орлогын эзлэх хувь
 - Дундаж тарифын хэмжээ
 - Тарифын хэмжээний стандарт хазайлт
- B. Худалдааны саад хоригийн зохицуулалт
 - Импортын далд саад, хориг
 - Импортын зардал
- C. Худалдааны секторын бодит ба хүлээгдэж буй хэмжээний харьцаа
- D. Валютын хар захын ба албан ханшийн хоорондын зөрүү
- E. Олон Улсын хөрөнгийн зах зээлийн хяналт
 - Гадаадын хөрөнгийн зах зээлд дотоодын иргэдийн, дотоодын хөрөнгийн зах зээлд гадаад иргэдийн оролцох боломж
 - Тухайн улсын иргэдийн гадаадын иргэдтэй хамтран хөрөнгийн зах зээлд оролцох эрх чөлөө

Энэ судалгааны ажлын хувьд худалдааны сектор гэсэн ойлголтын дор олон улсын худалдааны нийт эргэлтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг авч үзнэ. Олон улсын худалдааны нийт эргэлт нь тухайн улсын экспорт, импортын нийлбэрээр

тодорхойлогддог үзүүлэлт юм. Хүн ам ихтэй, газар нутаг томтой орнууд дотоодын зах зээлийн цар хүрээний хувьд эдийн засгийн бодит боломж ихтэй байдаг. Энэ нь тухайн улсын хувьд худалдааны сектор бага байх талтай болгодог. Мөн тухайн улсын далайн хилийн урт их байх тусмаа тээврийн зардлыг багасгаж, худалдааны секторын хэмжээг ихэсгэдэг. Дэлхийн нийт эрэлт дэх тухайн улсын харьцангуй хэмжээ нь худалдааны секторт эерэгээр нөлөөлдөг.

Ер нь маш бага тарифтай, хөвөгч ханштай, хөрөнгийн шилжилтэнд ямар нэг хориг саадгүй орон худалдааны сектор ихтэй байх талтай юм. Энэ утгаар нь дээрх үзүүлэлтүүдийг худалдааны нээлттэй байдлын индексийг тооцох гол үзүүлэлтүүд болгон сонгодог.

А. Олон Улсын худалдааны татвар

А.1 Олон улсын худалдааны нийт эргэлтэнд олон улсын худалдааны татварын орлогын эзлэх хувь

Индекс тэй холбоотой тодорхойлолт, хуулийн заалтууд

Аливаа орны хувьд олон улсын худалдааны үйл ажиллагааг тарифын ба тарифын бус аргаар зохицуулдаг. Гаалийн тариф нь барааны системчилсэн жагсаалт бөгөөд энэхүү жагсаалтанд байгаа ихэнх барааг улсын хилээр нэвтрүүлэх нөхцөлд татвар ноогдуулдаг. Гаалийн тариф нь улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, ДХБ-ий өмнө хүлээсэн үүрэг шаардлагыг биелүүлэх, үндэсний үйлдвэрлэгчдийг гадаадын өрсөлдөөнөөс хамгаалах, экспортын барааны бүтцийг оновчтой болгох, орлого дахин хуваарилах гэх мэт үүрэгтэй.

1996 онд батлагдсан Монгол Улсын Гаалийн тарифын тухай хуулийн зорилт нь Гаалийн тарифын тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг тогтоох зарчим, гаалийн үнийг тодорхойлох, гаалийн татвар ноогдуулах, барагдуулахад дагаж мөрдөх журмыг тогтооход чиглэгджээ.

Энэ хуулийн 3-р зүйлд “*гаалийн татвар*” гэж барааг гаалийн хилээр нэвтрүүлэхэд энэ

хууль болон Гаалийн тухай хуулийн дагуу гаалийн байгууллагын хурааж авах албан татварыг, “*гаалийн тариф*” гэж гаалийн татварын хувь, хэмжээг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу эмхэтгэн тогтоосон сүлжээг хэлнэ хэмээн тус, тус заасан байдаг.

Мөн “*гаалийн татварыг гаалийн үнийг үндэслэн тооцно*”, “*гаалийн үнэ гэж гаалийн татвар ноогдуулах, гаалийн статистик мэдээлэл гаргах зорилгоор энэ хуулийн дагуу тодорхойлох үнийг хэлнэ*” гэж заасан байна.

Гаалийн тарифын тухай хуульд гаалийн татварын хувь, хэмжээг дор дурдсан хэлбэрээр тогтоохоор заажээ. Үүнд:

1. Гаалийн үнээс хувиар
2. Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр
3. Дээрх хоёр хэлбэрийг хослуулан

Мөн хуулийн 8-р зүйлд Монгол Улсын Засгийн газар гаалийн татвараас гадна дор дурьдсан нэмэгдэл татвар ноогдуулж болохоор тусгасан байна. Үүнд:

1. Тусгай татвар
2. Демпингийн эсрэг татвар
3. Нөхөн төлөөсийн татвар

Эдгээр нэмэгдэл татварыг дор дурдсан нөхцөл байдал бүрдсэн байвал тогтоодог. Үүнд:

1. Дотоодын үйлдвэрлэгчдэд хохирол учруулсан, учруулж болзошгүй
2. Адилтгах барааны үйлдвэрлэлийг явуулах, өргөтгөхөд саад болох
3. Бусад улсаас Монгол Улсыг ялгаварлан гадуурхаж, эрх ашгийг нь хохироох

Импортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо дор дурьдсан аргыг дарааллын дагуу хэрэглэдэг. Үүнд:

1. Хэлцлийн үнийн арга
2. Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга
3. Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга
4. Ялгавар үнийн арга
5. Нийлбэр үнийн арга
6. Уялдуулан хэрэглэх арга

1993 онд батлагдсан Онцгой албан татварын тухай Монгол Улсын хуулиар

1. Бүх төрлийн согтууруулах ундаа
2. Бүх төрлийн тамхи
3. Автобензин, дизелийн түлш
4. Суудлын автомашин

зэрэгт онцгой албан татвар ноогдуулахаар заасан ба импортын бараанд ноогдох онцгой албан татварыг Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирсэн тухай бүрт гаалийн байгууллага ноогдуулан нэмэгдсэн өртгийн албан татварын хамт өөрийн дансанд оруулна гэж заасан байдаг.

Тариф тогтоосноор дараах сул ба давуу талууд үүсдэг гэж үздэг. Үүнд:

- Дэлхийн хэмжээний худалдааны ашгийг бууруулдаг
- Тарифыг тогтоож байгаа болон энэ улстай харилцаж буй орнуудын худалдааны ашигт байдлыг багасгадаг
- Эдийн засаг болон нийгэмд хор нөлөө болох экспортыг хориглох зорилгоор тариф тогтоох нь ямар ч арга хэмжээ авахгүй байснаас дээр
- Тариф тогтоох нь зарим тохиолдолд худалдааны бусад саад тогтоосноос хохирол багатай байдаг
- Тариф нь нийт нийгмийн хэмжээнд хохирол учруулдаг боловч импортын барааг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд ашигтай байдлыг бий болгодог

Олон улсын худалдааны нийт эргэлтэнд олон улсын худалдааны татварын орлогын эзлэх хувийн индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Тухайн улсын төсвийн орлогын болон олон улсын худалдааны статистик мэдээллээс олон улсын худалдааны орлогын олон улсын худалдааны нийт эргэлтэнд эзлэх хувийг тодорхойлно. Энэ үзүүлэлт нь тооцооны аргачлалын *I* үзүүлэлт болно.

Улсын төсөвт олон улсын худалдаанаас олох орлого ихсэх тусам энэ үзүүлэлтийн индекс буурдаг. Өөрөөр хэлбэл олон улсын худалдааны татварын хувь хэмжээ өндөртэй орон гэдгийг илэрхийлнэ. Олон улсын худалдаандаа ямар ч тусгай татваргүй орны хувьд шууд 10 гарна. Улмаар татварын орлогын хувь 15 хувиас давбал энэ үзүүлэлтийн индекс 0 гардаг.

Манай улсын гадаад худалдааны хувьд нэмэгдсэн өртгийн албан татварыг /НӨАТ/-аас гадна

- гаалийн албан татвар
- онцгой албан татвар
- автобензин, дизелийн түлшний албан татвар

гэсэн гурван төрлийн албан татварыг гаалийн бүрдүүлэлт хийх үед авдаг. Эдгээр татварууд нь тус бүрээ хуулиар зохицуулагддаг.

Монгол Улсын *Гаалийн тарифын тухай хууль* нь 1996 оны 5-р сарын 18-нд, харин *Онцгой албан татварын хууль* нь 1993 оны 1-р сарын 21-нд УИХ-аар батлагдсан. “Онцгой албан татвар”-ын хуулийн зорилт нь импортын болон эх орны үйлдвэрийн зарим бараанд онцгой албан татвар ноогдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Мөн *Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль* нь 1995 оны 6-р сарын 2-нд батлагдсан байна. Энэ хууль нь автобензин, дизелийн түлшинд албан татвар ноогдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Энэ татвар нь гаалийн тарифын тухай хуулийн нэмэгдэл татварын тусгай татварт хамрагдах юм.

Гаалийн албан татвар нь *Импортын барааны гаалийн албан татварын тухай хууль*, *Зарим бараанд ноогдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хууль*, тогтоомжуудаар зохицуулагдан хэрэгждэг. Бид импортын бараанд ноогдуулж буй НӨАТ-ыг авч үзээгүй. Энэ татвар нь олон улсын худалдаатай холбоотой гэхээсээ илүүтэй дотоодын арилжаа солилцооны үйлдэлтэй холбоотой татвар юм. Бид жил бүрийн Статистикийн эмхтгэлийг ашиглан

Хүснэгт 1. Олон улсын худалдааны нийт эргэлтэд олон улсын худалдааны татварын эзлэх хувийн индексийн тооцоо

Он	1995	2000	2001	2002	2003	2004
Онцгой албан татвар, сая төгрөгөөр	8579.7	41011.8	53330	51321.3	58575.3	70230.1
<i>Дотоодын архины</i>	4478.8	15891.7	19506.4	20595.2	19785.5	23230.5
<i>автобензин, дизелийн түлшний</i>	3277.8	13404.9	16626.2	18266.3	21254.1	24808.9
<i>импортын архи, пиво, тамхины</i>	823.1	4470	6183.9	6431.6	6986	7457.6
<i>суудлын автомашины</i>	-	7245.3	7332	6028.2	10549.6	14733.1
Гадаад худалдааны орлого, сая төгрөгөөр	9571.5	22305.9	27018.7	24592.5	32646.7	44719.3
<i>импортын барааны</i>	9571.5	17152.9	26441.3	23767.3	31058.6	40783.3
<i>экспортын барааны</i>	-	5153.1	1027.3	825.2	1588.1	3936
Тусгай зориулалтын орлого, сая төгрөгөөр	3273.2	7117	8892	8595.6	9686.7	10886.1
<i>автобензин, дизелийн түлшний татвар</i>		3680.239	5454.5	4850.3	5703.1	6107.4
<i>Автомээрийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар</i>	3273.2	3436.761	3437.5	3745.3	3983.6	4778.7
Нийт эргэлт, сая доллароор	888.6	1150.3	1159.2	1214.8	1416.9	1864.9
<i>Нийт импорт</i>	415.3	614.5	637.7	690.8	801	1011.6
<i>Нийт экспорт</i>	473.3	535.8	521.5	524	615.9	853.3
Америк долларын ханш, жилийн эцэст	473.62	1097	1102	1125	1168	1209
Америк долларын жилийн дундаж ханш	446.9	1077.7	1098.7	1111.5	1146.5	1187
Нийт эргэлт, сая төгрөгөөр	397115.3	1239678	1273613	1350250	1624476	2213636
Онцгой ба гадаад худалдааны албан татварын орлого, сая төгрөгөөр	13672.4	47426	60842.3	55318.6	71436.5	91718.9
Онцгой, гадаад худалдааны болон тусгай зориулалтын албан татварын орлого, сая төгрөгөөр	13672.4	51106.24	66296.8	60168.9	77139.6	97826.3
<i>Гадаад худалдааны орлогын нийт эргэлтэнд эзлэх хувь</i>	2.4	1.8	2.1	1.8	2.0	2.0
<i>Онцгой ба гадаад худалдааны албан татварын орлогын нийт эргэлтэд эзлэх хувь</i>	3.4	3.8	4.8	4.1	4.4	4.1
<i>Онцгой, гадаад худалдааны болон тусгай зориулалтын албан татварын нийт эргэлтэд эзлэх хувь</i>	3.4	4.1	5.2	4.5	4.7	4.4
Зөвхөн гадаад худалдааны албан татварын хувийн Фрейзерийн индекс	8.4	8.8	8.6	8.8	8.7	8.7
Онцгой болон гадаад худалдааны татварын орлогын Фрейзерийн индекс	7.7	7.4	6.8	7.3	7.1	7.2
Онцгой, гадаад худалдаа, тусгай зориулалтын татварын орлогын Фрейзерийн индекс	7.7	7.3	6.5	7.0	6.8	7.1

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, УСГ, 1989-2004, судалгааны тооцоо

хувь хэмжээний тооцоог хийсэн болно. Гэхдээ гурван ялгаатай байдлаар олон улсын худалдааны орлогын олон улсын худалдааны нийт эргэлтэд эзлэх хувь хэмжээг тооцсон.

Үүнд:

1. Зөвхөн гаалийн албан татвараар
2. Гаалийн албан татвар болон онцгой албан татварын нийлбэрээр

3. Гаалийн албан татвар, онцгой албан татвар болон автобензин, дизелийн түлшний албан татваруудын нийлбэрээр

Дээрх гурван үзүүлэлтээр тооцоо хийхдээ Статистикийн эмхэтгэлд олон улсын худалдааны үзүүлэлтүүд доллараар илэрхийлэгдсэн байдаг тул тэдгээрийг долларын жилийн дундаж ханшаар төгрөгт шилжүүлсэн.

Зураг 1. Олон улсын худалдааны татварын худалдааны нийт эргэлтэд эзлэх хувийн индексийн динамик

Зөвхөн гаалийн татвараар тооцоо хийхдээ Статистикийн эмхтгэлийн *Улсын төсвийн орлого* хэмээх бүлэг үзүүлэлтийн *гадаад худалдааны орлогыг* сонгон авсан бол гаалийн албан татвар болон онцгой албан татвараар тооцоходоо гадаад худалдааны орлого дээр онцгой албан татварын орлогоос дотоодын архины татварын орлогыг хасч, гарсан үзүүлэлтийг нэмж тооцсон. Харин гурван төрлийн татварыг бүгдийг нь авч үзэхдээ өмнөх үзүүлэлт дээр автобензин, дизелийн түлшний тусгай татварыг нэмж тооцоолсон болно. Үзүүлэлтүүдийн утга ямар байгааг Хүснэгт 1-д үзүүлэв. Ийнхүү тооцсон олон улсын худалдааны татварын орлогын олон улсын худалдааны нийт эргэлтэнд эзлэх хувийн тусламжтай Фрейзер институтын аргачлалаар индекс ноогдуулсан болно. Үр дүнг мөн Хүснэгт 1-д харуулав.

Индексийн динамик шинжилгээ, харьцуулалт

Авч үзэж буй индексийг 1991-2004 оны хувьд тооцоолсон болно. Индексийн ерөнхий динамикийг Зураг 1-д харуулав.

Зураг 1-ээс харахад 1991-1996 онуудад олон улсын худалдааны татварын орлогын олон улсын худалдааны нийт эргэлтэд эзлэх хувийн индекс харьцангуй доогуур

гарсан нь энэ үед импортын гаалийн албан татварын хувь хэмжээ өндөр, тухайлбал 15 хувь байсантай холбоотой. 1996 онд индекс буурсан нь автобензин, дизелийн түлшний албан татвар бий болсноос шалтгаалжээ. 1997, 1998 онд импортын барааны гаалийн албан татварыг тэглэсэн тул татварын ачаалал багасч, индексийн утга сайжирсан байна. 1999 оноос импортын барааны гаалийн татварыг тэглэснийг цуцалж, мөн онцгой татварт нилээд өөрчлөлт орсон, банз, дүнз, зүсмэл материалд экспортын гаалийн албан татвар ноогдуулсантай холбоотой дахин индексийн утга буурсан байна. 2001 онд экспортын барааны гаалийн татварыг нэмэгдүүлснээс шалтгаалж, индексийн утга буурч, сүүлийн жилүүдийн хувьд хамгийн бага түвшиндээ хүрчээ.

Одоогоор Монгол Улс нь хүнсний гол нэрийн импортын бараануудын хувьд улирлын шинжтэй 15 хувийн татвартай байдгийг эс тооцвол жигд 5 хувийн татвартай, цөөн тооны барааны хувьд экспортын гаалийн албан татвартай, бусад барааны хувьд нэг хязгаарлалт байдаггүй чөлөөт худалдааны горим бүхий орон юм. Олон Улсын Валютын Сангийн ангиллаар худалдааны хориг саадын хувьд хамгийн бага

1 гэсэн ангилалд байдаг. Импортын тарифын түвшингээрээ Азийн бүсэд нилээд доогуурт нь ордог. 1997 оны 5-р сарын 1-нээс 1999 оны 7-р сарын 1 хүртэлх хугацаанд импортын барааны гаалийн албан татварыг тэглэсэн ба түүнээс хойш 5 хувиар тогтоосон боловч, 2001 оны 1-р сарын 1-нээс 2002 оны 1-р сарын 1-ний хооронд 7 хувь болгон өсгөжээ.

Монгол Улс тухайн үзүүлэлтийн индексээрээ Олон Улсын хэмжээнд ямар байгааг харуулахын тулд дараах жишилтийг хийв.

Хүснэгт 2. Олон улсын худалдааны татварын хувийн индексийн харьцуулалт

Он	1995	2000	2001	2002
Бангладеш	4.3	5.3	5.3	5.3
Болгар	7.9	9.5	9.6	9.6
Канад	9.5	9.8	9.8	9.8
Чех	9.2	9.7	9.8	9.8
Чили	7.7	8.5	8.8	8.8
Хятад	9.2	9.0	9.0	9.0
Эстони	9.9	10	10	10
Гонконг	9.8	9.8	9.8	9.8
Унгар	6.1	9.4	9.4	9.4
Япон	8.9	9.0	9.0	9.0
Латви	9.5	9.8	9.8	9.8
Литва	9.6	9.8	9.8	9.8
ОХУ	7.1	6.9	6.0	6.0
Польш	5.9	9.0	9.4	9.4
Сингапур	9.9	9.9	9.9	9.9
Словак		9.3	9.8	9.8
Өмнөд Солонгос	8.7	8.8	8.8	8.8
Англи	9.6	9.7	9.8	9.8
АНУ	9.2	9.4	9.4	9.4
Монгол Улс /Гурван албан татварын нийлбэрээр/	7.7	7.3	6.5	7.0
Монгол Улс /Зөвхөн гадаад худалдааны албан татварын орлогоор/	8.4	8.8	8.6	8.8

Эх сурвалж: 2004 оны тайлан, зөвлөхүүдийн тооцоо

Зөвхөн гадаад худалдааны албан татвараар тооцсон дүнгээр Монгол Улс Өмнөд Солонгос, Чили улсуудтай нэг ижил индекстэй байна.

Дээрх богино жагсаалтын хувьд Бангладеш, ОХУ-ын индексээс дээгүүр байна¹⁵.

Хүснэгт 3. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтээс тооцсон байдал

Он	2000	2002
Олон улсын худалдааны татвар (төсвийн урсгал орлогод эзлэх хувь)	5.0	8.0
Татварын орлого (ДНБ-д эзлэх хувь)	21.5	23.0
Олон улсын барааны худалдаа (ДНБ-д эзлэх хувь)	93.4	101.5
Татварын орлого (төсвийн урсгал орлогод эзлэх хувь)	75.1	76.4
Экспорт болон импортын дүнд олон улсын худалдааны татварын орлогын эзлэх хувь	1.5	2.4

Энэ тооцооноос харахад Фрейзер институт уг үзүүлэлтийг зөвхөн гаалийн татвараар тооцдог байх гэсэн дүгнэлтэд хүрэхээр байна.

Нэмэлт судалгаа

Монгол Улс ДХБ-д элсэн орохдоо дараах үүрэг амлалт авсан ба эдгээр амлалтуудыг хэрэгжүүлснээр олон улсын худалдааны либералчлалд ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Импортын тарифаас өөр ямар нэгэн шинэ тариф нэвтрүүлэхгүй байх. Энэхүү тохиролцооны дагуу импортын гаалийн татварын ерөнхий түвшин 20 хувь байх юм. Харин АНУ-ын санал болгосон зарим бараанд тухайлбал амьд мал, тэжээвэр шувуу, төрөл бүрийн самар, хиймэл утас, модон материал, мэдээлэл боловсруулах машин зэрэг барааны тарифыг 0-10 хувиар тогтоосон билээ. Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, зах зээлээ хамгаалах үүднээс оёмол, сүлжмэл бараа,

¹⁵ Энэ үзүүлэлтийн утгыг Олон улсын байгууллагуудын статистик мэдээллээс тэр бүр олох боломжгүй юм. Харин Дэлхийн банкны «World Development Indicators»-ийн 4.13-р хүснэгт буюу «Central Government Revenue»-ийн Taxes on International trade (percent of total current revenue) үзүүлэлт, 5.6-р хүснэгт буюу «Tax policies»-ийн Tax revenue (percent of GDP) үзүүлэлт, 6.1-р хүснэгт буюу «Integration with the Global Economy» –ийн Trade in goods (percent of GDP) үзүүлэлт зэргийг ашиглан энэ үзүүлэлтийг олон улсын түвшинд тооцож болох юм. Манай улсын хувьд Дэлхийн банкны «World Development Indicators»-ын 2002, 2004 тайланд гарсан үзүүлэлтийг ашиглан тооцоолол хийсэн үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

нэхий, савхин эдлэл, хивс зэрэг импортын барааны тарифыг 30 хувиар тогтоосон. Тарифыг ялгаварлалтай тогтоож болно. Энэхүү ялгаварлалтай тариф нь дотоодын зах зээлийг хамгаалах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, төлбөрийн тэнцлийг хангах зэрэг худалдааны бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болох ёстой юм. 1997 оны 4-р сарын 18-ны өдрийн 24-р тогтоолоор импортын барааны гаалийн татварыг тэглэсэн нь хэт либералчилсан, 1999 оны 7-р сарын 1-нээс эхлэн импортын бараанд 5 хувийн гаалийн татвар тогтоосон нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх сонирхолд хөтлөгдсөн, худалдаа эдийн засгийн бодлого шингэж чадаагүй алхам юм. Гаалийн тариф нь аливаа улс орны худалдааны бодлогын илрэл болохоос биш, төсвийн орлогыг бүрдүүлэх хэрэгсэл байж таарахгүй гэсэн ДХБ-ын зарчим байдаг.

Дотоодын болон импортын бараанд ялгавартай татвар ноогдуулахгүй байх. Татвар тооцоход хэрэглэж буй арга нь ижил байх ёстой. Худалдааны татварт үйлдвэрлэл, худалдааны бүх шат болон үйлчилгээг бүрэн хамруулах зорилгоор Улсын Их хурлаас нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг 1998 оны 1-р сарын 8-нд баталж, 7-р сарын 1-нээс мөрдөж эхэлсэн. Энэхүү хуулийн дагуу НӨАТ-ыг импортолсон болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний 13 хувиар ноогдуулсан. Худалдааны албан татварын хуулийг халж, НӨАТ-ын хуулийг мөрдөж эхэлснээр үл ялгаварлан гадуурхах зарчим энэ төрлийн татварын хувьд хэрэгжиж байгаа. Харин импортын зарим бараа, ялангуяа архи, спирт, согтууруулах ундаанд ногдож байгаа импортын онцгой албан татварын хувьд импортын татвар нь эх орны үйлдвэрийн ижил төрлийн бараанд ноогдуулж байгаа дотоодын татвараас илүүгүй байх тухай ТХЕХ-ийн үндсэн зарчим биелэгдэхгүй байна.

Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтын хуулиараа гадаадын хөрөнгө оруулагчдад татвараас хөнгөлөх, чөлөөлөх талаар олгож буй хөнгөлөлтүүдийг экспортын татаас гэж үзсэн. ДХБ экспортын татаасыг хориглодог тул манай тал дурдсан хөнгөлөлтүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, тэдгээрийг 2002 оны

12-р сарын 31-ний дотор халах, эсвэл хугацаа болмогц Татаасын хороонд асуудлыг тавьж, хүчингүй болгох хугацааг сунгуулах ёстой. Үүний дагуу Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулинд буй татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай 19, 20 дугаар заалтуудыг хүчингүй болгож, тэдгээрийг орлогын албан татварын хуулинд нэмэлт өөрчлөлт болгон тусгаж, 1998 оны 2-р сарын 1-нээс мөрдөх болсон.

Түүхий ноолуурын экспортын хоригийг 1996 оны 10 дугаар сарын 1 хүртэл байлгаж, түүнээс хойш 30-аас дээшгүй хувийн экспортын татвар ноогдуулна. Энэ татварыг Монгол Улс ДХБ-д элссэн өдрөөс хойш 10 жилийн дотор хална. Хар ба өнгөт төмрийн экспортын лицензийг 1997 оны 1-р сарын 1 гэхэд хүчингүй болгоно. Зарим бараанд ноогдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд 1997 оны 5-р сарын 30-ны өдрийн Монгол Улсын Хуулийн дагуу 1997 оны 7-р сарын 1-нээс эхлэн экспортод гарах ямааны боловсруулаагүй ноолуурын кг тутамд 4000 төгрөгийн гаалийн татвар ноогдуулах болсноор боловсруулаагүй ноолуурын экспортын хоригийг цуцлах тухай ДХБ-ын өмнө авсан үүргээ биелүүлсэн. Хар ба өнгөт төмрийн экспортод лиценз олгодгийг зогсоох талаар ДХБ-ын өмнө хүлээсэн үүргийг уг лицензийг тогтоосон Засгийн Газрын 1996 оны 4-р сарын 19-ний өдрийн 84-р тогтоолыг хүчингүй болгосноор биелүүлсэн.

Гаалийн ажиллагаа, бүрдүүлэлтийг ТХЕХ-1994-ийн 7, 8, 10 дугаар заалтуудад нийцүүлж хийнэ. 1990 оны болон 1996 онд шинэчлэн баталсан Гаалийн тухай Монгол Улсын Хуульд гаалийн хяналт, бүрдүүлэлт, гаалийн шалгалт, гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагч, гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх үүргийг хуульчлан баталж, гаалийн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог хуулиар баталгаажуулсан бөгөөд энэ хууль нь олон улсын жишиг, ДХБ-ын жишигт үндсэндээ нийцсэн. Ер нь гаалийн үйл ажиллагаа, бүрдүүлэлттэй холбоотой асуудлыг олон улсын эрх зүйд нийцүүлэн зохицуулж байгаа дэвшилттэй тал байгаа боловч яам, газраас тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр батлан мөрдөж буй захиргааны зохицуулалтын дүрэм журам нь зарим талаараа хуулинд заагаагүй, худалдаанд оролцогчдын

хувьд “тааламжгүй” хэм хэмжээ тогтоох, ингэснээрээ хүнд суртал, чирэгдэл учруулах, бараа экспортлогч, импортлогчдын хувьд урьдчилж тооцоогүй нэмэгдэл зардал гаргах хандлага байх төлөвтэй байна.

Эдгээр алхмууд нь Монгол Улсын олон улсын худалдааны татварын орлогын олон улсын худалдааны нийт эргэлтэд эзлэх хувийн индексийг сайжруулсан байна.

А.2 Тарифын дундаж хэмжээ

Энэ үзүүлэлт нь гаалийн тарифтай импорт, экспортын бараануудын хувьд ялгаатай татварын хувь хэмжээтэй тохиолдолд дунджаар ямар хэмжээний татвар авдаг болохыг илэрхийлдэг. Уул үзүүлэлтийг гаалийн албан татвар ноогдуулдаг бараануудын хувьд явцууруулан авч үзэж байгаа тул олон улсын худалдааны орлогын олон улсын худалдааны нийт эргэлтэд эзлэх хувиас их утгатай байдаг. Үзүүлэлтийн утга өндөр байхын хэрээр түүний индексийн утга буурдаг. Өөрөөр хэлбэл энэ үзүүлэлтийн утга ихэсвэл эдийн засгийн эрх чөлөөг илүү ихээр алдагдуулж байна гэсэн үг.

Дундаж тарифын хэмжээний индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Тухайн улсын дундаж тарифыг V_i тэмдэглэдэг. Энэ үзүүлэлтийн хувьд $V_{min}=0$, $V_{max}=50$ байдаг. Дэлхийн банкны *World Development Indicators*-д байгаагаар бол дундаж тарифыг хоёр аргаар тооцдог. *Энгийн дундаж тариф* нь тарифтай бүх бүтээгдэхүүний хувьд идэвхтэй үйлчилж буй гаалийн татварын хувь хэмжээнүүдийн арифметик дунджаар тооцогддог. *Жигнэгдсэн дундаж тарифыг* идэвхтэй үйлчилж буй гаалийн татварын хувиудыг тухайн бүтээгдэхүүний нийт гаалийн татвартай бүтээгдэхүүний дүнд эзлэх хувиар жигнэж тодорхойлдог. Энэ үзүүлэлтийг Дэлхийн банк Дэлхийн нэгдмэл худалдааны шийдвэрийн системийг /*World Integrated Trade Solution System-WITSS*/ ашиглан тооцдог. Тарифын мэдээллийг *UNCTAD*-аас авч ашигладаг. *UNCTAD*-ийн *COMTRADE* нэртэй өгөгдлийн сан байдаг. Дэлхийн банкны *World Development Indicators*-ийн 6.6 хүснэгт буюу

“*Tariff barriers*”-ийн мэдээнд манай улсын мэдээлэл одоогоор ороогүй байна.

Манай улсын хувьд дээрх нэр бүхий олон улсын мэдээллийн сан, цувралуудад мэдээлэл нь ороогүй тул анхдагч Эх сурвалжийг ашиглан тухайн үзүүлэлтийг тооцох шаардлагатай.

Дундаж тарифын хэмжээг тооцохдоо экспорт, импортын гаалийн дундаж тарифыг гаалийн албан татвартай олон улсын худалдааны нийт эргэлтэнд тарифтай экспорт, импортын барааны эзлэх хувиар жигнэж дараах дүрмээр тооцсон. Үүнд:

$$\alpha = w_e \cdot \alpha_e + w_m \cdot \alpha_m \quad (1)$$

Энд:

- α - Жилийн дундаж тарифын хэмжээ
- α_e - Экспортын барааны гаалийн дундаж тарифын хэмжээ
- α_m - Импортын барааны гаалийн татварын дундаж тарифын хэмжээ
- w_e - Гаалийн албан татвартай олон улсын худалдаанд тарифтай экспортын барааны эзлэх хувь
- w_m - Гаалийн албан татвартай олон улсын худалдаанд тарифтай импортын барааны эзлэх хувь

Экспортын барааны гаалийн дундаж тарифын хэмжээг тооцохдоо сар бүрээр тооцож жилийн дундаж тарифыг тодорхойлсон. Биет хэмжээнд мөнгөн илэрхийллээр тогтоогдсон зарим татварын хэмжээ доллараар илэрхийлэгдсэн тул долларын ханш өөрчлөгдөх бүрт, төгрөгөөр илэрхийлэгдсэн тохиолдолд ч уг барааны үнэ өөрчлөгдөх бүрт, мөн хуулийн заалт өөрчлөгдөх тохиолдол бүрт татварын хувь хэмжээ өөрчлөгддөг. Эдгээр өөрчлөлтийг нарийн тусгахын тулд сараар тооцоог хийсэн болно.

t -р сарын экспортын барааны дундаж тарифыг

$$\alpha_{et} = \sum_{i=1}^n \gamma_{it} \cdot tax_{it} \quad (2)$$

гэж тооцов.

Энд

- γ_{it} - t -р сарын гаалийн татвартай экспортын барааны дүнд i -р барааны эзлэх хувь

tax_{it} i-р барааны t-р сарын экспортын гаалийн татварын хувь

tax_{it} -г тооцохдоо “Зарим бараанд ноогдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай” хуулийн заалт, өөрчлөлтүүдийг ашиглав.

Жилийн дундаж хувийг тооцохдоо сар бүрийн дундаж хувийг гаалийн татвартай жилийн экспортын дүнд тухайн сарын гаалийн татвартай экспортын эзлэх хувиар жигнэж дундажлав. Үүнд:

$$\alpha_e = \sum_{t=1}^{12} \beta_t \cdot \alpha_{et} \quad (3)$$

Энд: β_t - гаалийн татвартай жилийн экспортын дүнд t-р сарын гаалийн татвартай экспортын эзлэх хувь

Тооцоог хэрхэн гүйцэтгэснийг Хавсралт 3-д харуулав. Хавсралт 3-ыг жил бүрээр хийсэн ба энд зөвхөн 2004 оныг жишээ болгон үзүүлэв. Эдгээр тооцоонд ашигласан мэдээллийг Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газрын мэдээллийн сангаас авч ашигласан болно.

Импортын барааны хувьд жилийн дундаж тарифын хэмжээг тооцохдоо онцгой болон автобензин, дизелийн түлшний албан татвар, гаалийн албан татварын хувь хэмжээг ашиглав. Мөн өргөн хэрэглээний зарим барааны хувьд хэрэглэгддэг улирлын шинжтэй татварын хувь хэмжээний өөрчлөлтийг тусгав. Тооцооллыг Хавсралт 4-д харуулав.

Экспорт, импортын гаалийн дундаж тарифын хэмжээний тусламжтай гаалийн жилийн дундаж тарифыг томъёо (1) –г ашиглан тооцов. Тооцооллыг Хавсралт 5-д харууллаа.

Индексийн динамик шинжилгээ, харьцуулалт

Гаалийн жилийн дундаж тарифын хэмжээний тооцооллоос харахад 1995, 1996 онуудад экспортын татвар харьцангуй өндөр байгаад 1997-98 онуудад буурсан байна. Энэ нь 1995 онд экспортын бараанд гаалийн татваргүй, харин импортын барааны гаалийн татвар

15 хувь байсантай холбоотой юм. Дараа онуудад буурсан нь импортын барааны гаалийн татварыг тэглэснээс үүдэлтэй болно. 1999 оноос дахин өссөн нь импортын барааны гаалийн татварыг дахин сэргээн тогтоосон, мөн онцгой татварын хэмжээг нэмэгдүүлсэн, экспортын гаалийн татвартай барааны нэр төрлийг олшруулсан зэрэг гадаад худалдааны бодлогын арга хэмжээнүүдээс шалтгаалжээ. Энэхүү дүгнэлтийг Хавсралт 3, 4, Хүснэгт 4-ийн харьцуулалтаас харж болно. Сүүлийн жилүүдэд дундаж тарифын хэмжээ харьцангуй тогтворжих хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Олон Улсын хэмжээнд энэ үзүүлэлт нилээд тогтвортой болж байгаа нь харьцуулсан хүснэгтийн тоо баримтаас харагдаж байгаа юм.

Хүснэгт 4. Дундаж тарифын хэмжээ ба Фрейзер институтын индекс

Он	Гадаад худалдааны жигнэсэн дундаж татвар	Фрейзер институтын индекс
1995	12.5	7.5
1996	13.9	7.2
1997	6.5	8.7
1998	3.7	9.3
1999	8.5	8.3
2000	10.4	7.9
2001	11.3	7.7
2002	9.6	8.1
2003	9.7	8.1
2004	9.4	8.1

Гаалийн тарифын дундаж хэмжээг бусад улс орнуудтай харьцуулахад шилжилтийн эдийн засагтай зүүн Европын орнууд болон ОХУ, Өмнөд Солонгос улсуудын түвшинд байна. Энэ байдал нь Бангладеш, Хятад улсуудынхаас илүү, үлдсэн бусад орнуудынхаас доогуур үзүүлэлтэй байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 5. Дундаж тарифын бусад улстай харьцуулсан харьцуулалт

Он	1995	2000	2001	2002
Бангладеш	0.0 (81.2)	5.7 (21.6)	5.7 (21.6)	5.7 (21.6)
Болгар	6.6 (17.2)	7.3 (13.7)	7.2 (13.8)	7.2 (13.8)
Канад	8.0 (10.1)	9.2 (3.9)	9.1 (4.5)	9.1 (4.5)
Чех	8.7 (6.7)	8.7 (6.5)	8.7 (6.5)	8.7 (6.5)
Чили	7.8 (11)	8.2 (9.0)	8.4 (8.0)	8.4 (8.0)
Хятад	2.5 (37.5)	6.7 (16.3)	6.9 (15.3)	6.9 (15.3)
Эстони	10.0 (0.1)	10.0 (0.0)	10.0 (0.1)	10.0 (0.0)
Гонконг	10.0 (0.0)	10.0 (0.0)	10.0 (0.0)	10.0 (0.0)
Унгар	7.8 (11.0)	8.4 (8.2)	8.4 (8.2)	8.4 (8.2)
Япон	8.7 (6.3)	9.1 (4.5)	9.0 (5.1)	9.0 (5.1)
Латви		8.9 (5.6)	9.2 (4.0)	9.2 (4.0)
Литва	9.1 (4.5)	8.9 (5.4)	9.8 (1.1)	9.8 (1.1)
ОХУ	7.7 (11.5)	7.5 (12.6)	7.8 (11.1)	7.8 (11.1)
Польш	6.3 (18.4)	8.0 (10.0)	8.0 (10.0)	8.0 (10.0)
Сингапур	9.9 (0.4)	9.9 (0.4)	10.0 (0.0)	10.0 (0.0)
Словак	8.8 (6.0)	8.8 (6.0)	8.8 (6.0)	8.8 (6.0)
Өмнөд Солонгос	7.7 (11.5)	8.3 (8.7)	8.3 (8.7)	8.3 (8.7)
Англи	8.7 (6.7)	9.5 (2.4)	9.2 (3.9)	9.2 (3.9)
АНУ	8.8 (5.9)	9.2 (4.0)	9.2 (4.0)	9.2 (4.0)
Монгол	7.5 (12.5)	7.9 (10.4)	7.7 (11.3)	8.1 (9.6)

Нэмэлт судалгаа

“Зарим бараанд ноогдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай” хуулийн заалтууд ба өөрчлөлтүүд

Монгол улс гаалиар гарч буй экспортын бараанаас 1996 оны 2-р улирлаас эхлэн зарим нэр төрлийн бараанаас тодорхой зорилгын үүднээс татвар авч эхэлсэн бөгөөд энэ нь Монгол Улсын Их Хурлын 1996 оны 3-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар баталсан *Зарим бараанд ноогдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай* хуулиар тухайн үед зохицуулагдаж байсан. Энэ хуулиар Монгол Улсын хилээр гарч буй дараах төрлийн барааны килограмм тутмаас тогтоосон хэмжээгээр татвар авч байхыг тогтоосон байна. Үүнд:

- Хар төмрийн өөдөс, хаягдлын 1 кг тутмаас - 17 төг
- Ширэмний өөдөс, хаягдлын 1 кг тутмаас - 17 төг
- Хаягдал зам төмрийн 1 кг тутмаас - 25 төг
- Зэсийн өөдөс, хаягдлын 1 кг тутмаас - 350 төг
- Хөнгөн цагааны өөдөс, хаягдлын 1 кг тутмаас - 128 төг

Зарим бараанд ноогдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хууль анх батлагдан гарснаас хойш хэд, хэдэн удаа нэмэлт өөрчлөлтүүд орсон бөгөөд үүний үр дүнд одоогийн байдлаар Монгол Улсын хилээр гарч буй 20 орчим нэр, төрлийн бараанаас тус, тусын тогтоосон хэмжээгээр экспортын гаалийн татвар авч байна. Тухайлбал 1997 оны 5-р сарын 30-ны өдрийн хуралдаанаар оруулсан тус хуулийн нэмэлт өөрчлөлтөөр дараах бараануудаас экспортын гаалийн татвар авч эхэлсэн байна. Үүнд:

- Ямааны боловсруулаагүй ноолуурын 1 кг тутмаас - 4000 төг
- Тэмээний боловсруулаагүй эр ноосны 1 кг тутмаас - 100 төг
- Тэмээний боловсруулаагүй эм ноосны 1 кг тутмаас - 200 төг

Мөн 1999 оны 1-р сарын 8-ны нэмэлт өөрчлөлтөөр бөөрөнхий мод, гуалин, дүнз, зүсмэл материал зэргийн 1 шоо метр тутмаас 150000 төгрөгийн гаалийн татвар авахаар хуульчлан тогтоож өгсөн байна.

2001 оны 5-р сарын 1-нээс Чанаржуулсан, зэвэрдэггүй гангийн өөдөс, хаягдал, Цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй төмөр, чанаржуулаагүй ган, Цутгамал анхдагч хэлбэрт байгаа чанаржуулсан бусад ган, чанаржуулсан бусад гангаар хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн, Өрөмдөлт, цөмлөлт, боловсруулалт хийсэн болон хийгээгүй, эсвэл угсрагдах эд ангиас бүрдэх төмөр, ган хуудсан материалаар хийсэн шон, төмөр, гангаар хийсэн гагнал булан хэлбэрт болон сортын төмөр, Зам төмөр, Зэс, цайрын хайлш /гууль/, Зэс цулдан, туйван болон огтолбор, Боловсруулаагүй хөнгөн цагаан, Хөнгөн цагаан цулдан, туйван болон огтолбор зэрэг бараануудаас экспортын гаалийн татвар авч байхаар хуульчлан тогтоосон байна. Дээрх болон дээрхээс бусад нэмэлт өөрчлөлтүүдээр тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан татварын хувь хэмжээнд өөрчлөлтүүд орж байсан болно. Өнөөгийн байдлаар үйлчилж буй татварын хувь хэмжээ, түүнд гарсан өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс харж болно.

“Импортын барааны гаалийн албан татварын тухай хууль”-ийн заалтууд, өөрчлөлтүүд

Монгол улсын хилээр орж ирж буй бараанаас 1991 оноос импортын гаалийн татвар авч эхэлсэн бөгөөд түүнээс хойшхи Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хуулийн нэмэлт өөрчлөлтүүдээр зарим нэр төрлийн барааг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээг өсгөх, бууруулах асуудлыг зохицуулж байсан. Импортын барааны гаалийн татвар, түүний хувь хэмжээнд гарсан нэмэлт өөрчлөлтийг ерөнхийд нь он дарааллын хувьд авч үзвэл:

- 1991 - 1997.05.01 хүртэл үнийн дүнгийн 15 хувь
- 1997.05.01 - 1999.07.01 хүртэл үнийн дүнгийн 0 хувь
- 1999.07.01 - 2002.01.01 хүртэл үнийн дүнгийн 7 хувь
- 2002.01.01 -ээс хойш үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх татвар авч байна.

Гэвч зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш импортын бүх бараанаас дээрх байдлаар татвар авч байсан гэвэл эндүүрэл болно. Өөрөөр хэлбэл импортын барааны онцлогоос хамааран ялгаатай хувь хэмжээгээр болон хэд, хэдэн хувь хэмжээгээр татвар авах тохиолдол байдаг. Татвар тогтоох байдлаар нь импортын барааг дараах хэд хэдэн бүлэгт ангилан үзэж болно. Үүнд:

- Онцгой албан татварын импортын бараа
- Улирлын чанартай импортын татвараас чөлөөлөгддөг бараа
- Тухайн үеийн шаардлагаас үүдэн татвараас чөлөөлөгддөг бараа
- Бусад

Онцгой албан татварын импортын бараа

Дараах нэр, төрлийн бараанаас онцгой албан татвар авч байна. Үүнд:

- Бүх төрлийн согтууруулах ундаа
 - Хүнсний спирт
 - 40 хүртэл хатуулагтай архи
 - 40 –ээс дээш хатуулагтай архи
 - Бүх төрлийн дарс
 - Шар айраг
- Тамхи
 - Бүх төрлийн янжуур болон бусад тамхи
 - Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи
- Суудлын автомашин
 - Үйлдвэрлэгдэн гарснаас хойш 0 – 3 жил болсон
 - Үйлдвэрлэгдэн гарснаас хойш 3 – 10 жил болсон
 - Үйлдвэрлэгдэн гарснаас хойш 10 –аас дээш жил болсон
- Нефтийн бүтээгдэхүүн
 - Бензин
 - 90 хүртэл октантай
 - 90-ээс дээш октантай
 - Дизелийн түлш

Дээрх төрлийн импортын бүтээгдэхүүнүүдээс нефтийн бүтээгдэхүүн нэлээд онцлогтой байдаг. Тухайлбал ямар хилийн боомтоор оруулж ирсэн бэ? гэдгээс нь хамааруулаад ялгаатай татвар тогтоодог. Мөн энэ төрлийн бүтээгдэхүүнээс гааль дээр

онцгой албан татвар авахын зэрэгцээ Тусгай зориулалтын нэмэлт татвар авдаг байна. Онцгой албан татвар авдаг дээрх бараануудын үнийн дүнгээс хувиар, биет хэмжээнээс нь мөнгөн илэрхийллээр /ам.доллараар/ татвар авдаг нь энэ төрлийн татварын нэг онцлог болдог. Учир нь тухайн барааны борлуулалтаас олох ашиг, үнэ өөрчлөгдөөгүй үед ам.долларын ханш өөрчлөгдөхөд төлж буй татварын дарамт өөрчлөгдөж байдаг.

Улирлын чанартай импортын татвараас чөлөөлөгддөг бараа. Эдийн засгийн онцлог байдалтай уялдуулан дотоодын үйлдвэрлэл эрчимждэг тодорхой үеүдэд гадны өрсөлдөөнөөс дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор, мөн ард иргэдийн хэрэглээний зардлыг хямд байлгах зорилгоор зарим нэр төрлийн бараануудыг тодорхой хугацаанд импортын татвараас чөлөөлдөг. Үүнд:

- Төмс, хүнсний ногоо
- Гурил

Импортолон оруулж ирж буй дээрх хоёр төрлийн бүтээгдэхүүнийг өнөөдрийн байдлаар тухайн оны 8-р сарын 1 –ээс дараа оны 4-р сарын 1 хүртэл хугацаанд 15 хувийн гаалийн татвар авч байхаар хуульд заажээ.

Тухайн үеийн шаардлагаас үүдэн татвараас чөлөөлөгддөг бараа. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа болон бусад шалтгаантай холбогдуулан зарим нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг импортын татвараас чөлөөлөх явдал нэлээд байдаг. Тухайлбал, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай холбогдуулан Мянганы зам барихтай холбоотой бүх төрлийн барааг импортын татвараас чөлөөлөх хууль гаргаж байсан.

Импортын болон онцгой албан татварын хувь хэмжээ, түүнд гарсан өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос харж болно.

Ийнхүү ялгаатай хувь хэмжээний татвартай, улирлын болон бусад хөнгөлөлт чөлөөлөлттэй нөхцөлд дундаж тарифын хэмжээг тооцох нь ихээхэн хүндрэлтэй юм.

Монгол Улс ДХБ-ын гишүүн орнуудтай хийсэн тарифын хэлэлцээрээр 260 гаруй нэр төрлийн барааны гаалийн тарифыг хөндөж, ноогдуулах тарифын хувь хэмжээг 0, 5, 10, 15, 20, 25, 30, 35, 40, 50, 75 гэсэн ялгавартай байхаар тогтоосон бөгөөд тарифын ерөнхий түвшин 20 хувиас хэтрэхгүй байх ёстой.

Гэвч бодит амьдрал дээр барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон татварын хэмжээнүүдийн хувьд гаалийн үнийн дүнд хувиар тогтоосон байдлаар илэрхийлэхэд хаягдал хар төмөр, хаягдал зэс, хуучин ашиглагдсан дэр мод, зүсмэл хусан банз, цэвэр банз, Палкан мод зэрэгт тогтоосон татвар нь тухайн сарын олон улсын худалдааны онцлог, валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан 90-2000 хувийн татвартай байна. Энэ нь ДХБ-ын өмнө хүлээсэн татварын ялгавартай хувийн дээд хязгаарын 75 хувиас хэтрүүлж татвар тогтоож байна гэсэн үг юм.

Дундаж тарифыг тооцохдоо хуульд заагдсан хэмжээгээр татвар тогтоосон нөхцөлд үнийн дүнгийн хэдэн хувийг эзэлж байгаагаар авч үзсэн. Бодит байдалд хуульд заагдсан хэмжээгээр татвар төлөгдөхгүй, хөнгөлөлт, чөлөөлөлтөөс шалтгаалан энэ хэмжээнээс бага байдаг. Тиймээс дундаж тарифыг төлөгдсөн татвараар тооцвол үзүүлэлтийн индексийн утга өсөх магадлалтай юм.

А.3. Тарифын хэмжээний стандарт хазайлт

Энэ үзүүлэлт нь гадаад худалдааны тариф нь жигд, эсвэл жигд бус байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрвээ тариф нь ялгаварлалгүй жигд байдаг бол стандарт хазайлт нь тэг болж Фрейзер институтын индекс 10 гэсэн утгаа авдаг. Энэ нь эдийн засгийн сонгодог онолын эдийн засгийн субъектүүдийн тэгш оролцоог хангах, мөн ДХБ-ын худалдаанд оролцогч субъектүүдийг үл ялгаварлах зарчимтай нийцэж байгаа юм. Гадаад худалдааны тариф нь ялгаварлал ихтэй бол энэ индексийн утга буурдаг. Гадаад худалдааны тарифын стандарт хазайлт өсөөд 25 хувьд болон түүнээс дээш болбол индексийн утга тэг болно.

Тухайн улсын дундаж тарифын хэмжээний стандарт хазайлтыг I_i тэмдэглэдэг. Энэ

үзүүлэлтийн хувьд $V_{min}=0$, $V_{max}=25$ байдаг. Тарифын хэмжээний стандарт хазайлтыг энгийн дундаж тарифтай харьцуулсан тарифын хэмжээний дундаж дисперсээр хэмждэг. Дэлхийн банкны *World Development Indicators*-ийн 6.6 хүснэгт буюу *Tariff barriers*-д энэ мэдээлэл байдаг. Манай улс энэ мэдээлэлд одоогоор хамрагдаагүй байгаа болно.

Тарифын хэмжээний стандарт хазайлтыг тооцохдоо экспорт, импортын барааны хувьд тус бүрт нь тооцож, тэдгээрийн гадаад худалдааны тарифтай бараанд эзлэх хувиар жигнэж дундаж стандарт хазайлтыг олсон. Үүний тулд дараах томъёог ашигласан. Үүнд:

$$s_{\alpha} = w_e \cdot s_{\alpha_e} + w_m \cdot s_{\alpha_m} \quad (4)$$

Энд: s_{α} - Жилийн жигнэгдсэн дундаж тарифын стандарт хазайлт

s_{α_e} - Экспортын барааны гаалийн тарифын стандарт хазайлт

s_{α_m} - Импортын барааны гаалийн тарифын стандарт хазайлт

Экспортын барааны гаалийн тарифын сар бүрийн стандарт хазайлтыг тооцохдоо

$$s_{\alpha_{et}} = \sqrt{\sum_{i=1}^n \gamma_{it} \cdot (tax_{it} - \alpha_{et})^2} \quad (5)$$

дүрмийг ашигласан.

Энд: $s_{\alpha_{et}}$ - t-р сарын экспортын барааны гаалийн тарифын стандарт хазайлт

Сар бүрийн стандарт хазайлтын тусламжтай, жилийн стандарт хазайлтыг

$$s_{\alpha_e} = \sum_{t=1}^{12} \beta_t \cdot s_{\alpha_{et}} \quad (6)$$

гэж тооцов.

Энд: β_t - гаалийн татвартай жилийн экспортын дүнд t-р сарын гаалийн татвартай экспортын эзлэх хувь

Харин импортын барааны гаалийн тарифын стандарт хазайлтын хувьд онцгой албан татвартай бараанууд болон автобензин,

дизелийн түлш, улирлын шинжтэй өөрчлөлттэй бараануудыг тусад нь салган авч үзэж, бусад бараануудыг нэг бүлэглэн, төсөвт төлөгдсөн бодит татварт тулгуурлан дээрх томъёонуудын тусламжтай тооцоог хийв.

Индексийн динамик шинжилгээ, харьцуулалт

Өмнөх дүрмээр 1995-2004 оны гаалийн тарифын стандарт хазайлтыг тооцсон үр дүнг Хавсралт 5-д харуулав. Хавсралтаас харахад 1995-1996 онуудад стандарт хазайлт харьцангуй багатай байсан бол сүүлийн жилүүдэд нилээд өсөх хандлагатай болсон байна. Энэ нь эхний жилүүдэд экспортын бараанд гаалийн татвар ноогдуулдаггүй байсан хийгээд онцгой албан татварын хэмжээ харьцангуй бага байсантай холбоотой. Харин сүүлийн жилүүдэд гаалийн татвартай экспортын барааны тоо, хэмжээ өссөнөөс гадна онцгой албан татварын хувь хэмжээ, нэгжид ноогдох мөнгөн илэрхийллийн хэмжээ ихэссэнтэй холбоотой дээрх үр дүн гарчээ. Мөнгөн илэрхийллээр ноогдуулсан экспортын зарим барааны хийгээд онцгой татвар нь гаалийн үнэд эзлэх хувьд шилжүүлэхэд хэтэрхий өндөр байгаа тал ажиглагдаж байна. Цаашид бодлого боловсруулагчид гаалийн татварын хувь хэмжээг жигд болгох тал дээр анхаарах шаардлагатай юм.

Хүснэгт 6. Тарифын стандарт хазайлт ба Фрейзер институтын индекс

Он	Гадаад худалдааны татварын жигнэсэн дундаж хазайлт	Фрейзер институтын индекс
1995	4.5	8.2
1996	5.4	7.9
1997	7.3	7.1
1998	8.7	6.5
1999	10.2	5.9
2000	8.2	6.7
2001	15.0	4.0
2002	13.3	4.7
2003	10.6	5.8
2004	9.9	6.0

Хүснэгт 7. Стандарт хазайлтын бусад улсуудтай харьцуулсан харьцуулалт

Он	1995	2000	2001	2002
Бангладеш	0.0 (26.1)	4.6 (13.6)	4.6 (13.6)	4.6 (13.6)
Болгар	4.7 (13.3)	6.8 (8.1)	5.5 (11.3)	5.5 (11.3)
Канад	0.3 (24.2)	7.3 (6.7)	7.3 (6.7)	7.3 (6.7)
Чех	7.4 (6.4)	6.3 (9.3)	6.3 (9.3)	6.3 (9.3)
Чили	10.0 (0.0)	10.0 (0.0)	10.0 (0.0)	10.0 (0.0)
Хятад	0.0 (28.0)	5.7 (10.7)	6.0 (10.0)	6.0 (10.0)
Эстони	9.5 (1.2)	9.5 (1.2)	9.5 (1.2)	9.5 (1.2)
Гонконг	10.0 (0.0)	10.0 (0.0)	10.0 (0.0)	10.0 (0.0)
Унгар	6.1 (9.7)	4.1 (14.7)	4.1 (14.7)	4.1 (14.7)
Япон	6.6 (8.4)	7.2 (7.0)	7.0 (7.5)	7.0 (7.5)
Латви		6.3 (9.2)	7.0 (7.4)	7.0 (7.4)
Литва	6.4 (9.0)	6.8 (8.0)	6.8 (8.0)	6.8 (8.0)
ОХУ	5.0 (12.4)	6.6 (8.5)	7.8 (5.4)	7.8 (5.4)
Польш	6.9 (7.8)	6.1 (9.8)	6.1 (9.8)	6.1 (9.8)
Сингапур	8.9 (2.7)	10.0 (0.0)	10.0 (0.0)	10.0 (0.0)
Өмнөд Солонгос	7.4 (6.6)	7.6 (5.9)	7.6 (5.9)	7.6 (5.9)
Англи	7.6 (5.9)	8.2 (4.4)	8.0 (4.9)	8.0 (4.9)
АНУ	7.2 (7.0)	5.7 (10.7)	5.6 (11.1)	5.6 (11.1)
Монгол	8.2 (4.5)	6.7 (8.2)	4.0 (15.0)	4.7 (13.3)

Олон улсын худалдааны гаалийн тарифын стандарт хазайлтыг бусад улс орнуудтай харьцуулан үзэхэд эхний жилүүдэд бусад улс орнуудтай жишиг байсан бол сүүлийн жилүүдэд энэ хэмжээ ихэсч индекс нь эрс буурсан тал ажиглагдаж байна. Манай улстай харьцуулахад стандарт хазайлт нь Унгар, АНУ зэрэг орнууд ойролцоо байгаа бол Гонконг, Сингапур, Чили зэрэг орнууд жигд тарифтай байна. Үүнийг Хүснэгт 7-оос харж болох юм.

Манай улсын хувьд экспортын зарим бараанд тогтоосон гаалийн татвар, онцгой албан татварууд нь ихэвчлэн бодит хэмжээнд мөнгөн илэрхийллээр тогтоогдсон, тэрхүү мөнгөн илэрхийлэл нь ихэвчлэн доллараар авагдахаар заагдсан нь гаалийн тарифын хувь хэмжээ хэт хэлбэлзэлтэй болоход нөлөөлж байна.

Б. Худалдааны саад хоригийн зохицуулалт

Энэ үзүүлэлт нь дотроо

- Импортын далд саад хориг
- Импортын зардал

гэсэн хоёр дэд үзүүлэлттэй.

Б.1 Импортын далд саад хориг

Энэ үзүүлэлт нь гадаад худалдаанд хуулийн бус далд зохицуулалт, тухайлбал гаалийн байгууллагын хувьд авилгал, хээл хахуулийн асуудал, элдэв шахалт дарамт хэр байгааг илэрхийлдэг. Эдгээр саад хоригууд байснаараа хувь хүмүүсийн үйл хөдлөлд сөргөөр нөлөөлж, гадаад худалдааны эрх чөлөөг хязгаарладаг хэмээн үздэг.

Импортын далд саад хоригийн индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Дэлхийн эдийн засгийн форумын *The Global Competitiveness Report 2005-2006* түүвэрт манай улс хамрагдсан тул энэ үзүүлэлтийн индексийг тооцох боломжтой болсон юм.

Худалдааны далд саад хоригийн зохицуулалтын индекс нь *The Global Competitiveness Report 2005-2006*-ийн Хүснэгт 8.02-ын индексээр илэрхийлэгддэг тул энэ үзүүлэлтийн хувьд ямар оноо авсныг тодруулья. 2004 оны байдлаар Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан нийт 117 орноос 84-р байр эзэлж, 2.9 гэсэн индекс оногдсон байна. Дэлхийн эдийн засгийн форумын аргачлалаар улс бүрт 1-ээс 7 гэсэн индекс ноогдуулдаг ба индексийн утга өсөхөд тухайн үзүүлэлтийн чанар сайжирдаг. Энэ индексийн утгыг Фрейзер Институтын аргачлалд байж болох боломжит хамгийн их утгаар нь хөрвүүлбэл 5.9 гэсэн индекс ноогдохоор байна.

Энэ нь бизнес эрхлэгчдийн дунд явуулсан санал асуулгаар манай улсын хувьд гаалийн далд саад хориг маш их байдгийг илэрхийлж байна. Бид судалгаандаа манай улсын хувьд 2004 оноос өмнө энэ байдал үүнээс дээргүй байсан гэсэн үндэслэлээр өмнөх жилүүдийн индексийн утгыг бага зэрэг бууруулан тооцов.

Нэмэлт судалгаа

Манай улсын хувьд өмнө нь Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдаггүй байсан тул урьд жилүүдийн индексийг хөөж тооцох боломжгүй юм. Учир нь Дэлхийн эдийн засгийн форумын индекс нь түүвэр судалгааны үндсэн дээр тодорхойлогддог тул судалгааг он ухрааж авах бололцоогүй. Харин индексийн талаар баримжаа авах нэг боломж нь тухайн үед үйлчилж байсан гаалийн албан зохицуулалтуудтай харьцуулж болох юм. Албан зохицуулалт хэр их байна түүнийг дагаад мөн далд зохицуулалт их байх магадлалтай. Эдийн засаг дахь зохицуулалт, эрх чөлөө хоёр урвуу хамааралтай байдаг билээ.

Б.2 Импортын зардал

Энэ үзүүлэлт нь гаалийн байгууллагын хүнд суртал, түүнтэй холбоотой үүсч буй алдагдсан боломжийн өртөг хэр их байдгийг илэрхийлдэг. Гаалийн байгууллагын хүнд суртал ихэссэнээрээ худалдаанд оролцогч талуудын хувьд ил ба далд зардал ихэсдэг нь гадаад худалдааны эрх чөлөөг хязгаарладаг хэмээн үздэг.

Импортын далд саад хоригийн индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Импортын зардлын индекс нь *The Global Competitiveness Report 2005-2006*-ийн Хүснэгт 8.01-ийн индексээр илэрхийлэгддэг тул энэ үзүүлэлтийн хувьд ямар оноо авсныг тодруулья. 2004 оны байдлаар Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан нийт 117 орноос 116-р байр эзэлж, 2.0 гэсэн индекс оногдсон байна. Дэлхийн эдийн засгийн форумын аргачлалаар улс бүрт 1-ээс 7 гэсэн индекс ноогдуулдаг ба индексийн утга өсөхөд тухайн үзүүлэлтийн чанар сайжирдаг. Энэ индексийн утгыг Фрейзер Институтын аргачлалд байж болох боломжит хамгийн их утгаар нь хөрвүүлбэл 5.0 гэсэн индекс ноогдохоор байна.

Энэ нь бизнес эрхлэгчдийн дунд явуулсан санал асуулгаар манай улсын хувьд гаалийн хүнд суртал асар их байдгийг илэрхийлж байна. Бид судалгаандаа манай улсын хувьд 2004 оноос өмнө энэ байдал үүнээс дээргүй байсан гэсэн үндэслэлээр өмнөх жилүүдийн индексийн утгыг бага зэрэг бууруулан тооцов.

Нэмэлт судалгаа

Манай улсын хувьд гаалийн хүнд суртал бусад улсуудтай харьцуулахад маш их байдгийг энэ судалгааны үр дүн харуулж байна. Өнөөгийн гаалийн нөхцөл байдал, түүнийг тойрсон хээл, хахуулийн хэрэг явдал үүнийг мөн давхар нотолж байна.

2004 оны байдлаар дээрх хоёр үзүүлэлтийн индексийн арифметик дунджаар *Импортын саад хоригийн зохицуулалт* үзүүлэлтийн хувьд 5.45 гэсэн индекс ноогдохоор байна. Энэ нь

манай улсын хувьд импортын далд саад хориг, гаалийн хүнд суртал маш их байгааг илэрхийлж байна.

В. Худалдааны секторын бодит ба хүлээгдэж буй хэмжээний харьцаа

Хүлээгдэж буй худалдааны секторын хэмжээг тооцохдоо улс орнуудын *хүн ам, газар нутаг, түүний онцлогууд /тухайлбал далай тэнгистэй хиллэдэг эсэх, хиллэдэг бол түүний эргийн шугамын урт гэх мэт/, үйлдвэрлэлийн хөгжил болон боломж, цаг хугацааны хүчин зүйлийг* харгалзан үнэлдэг.

Хэрвээ худалдааны секторын бодит хэмжээ нь хүлээгдэж буй хэмжээнээсээ их бол тухайн улсын хувьд худалдааны элдэв саад хориг, хязгаарлалтууд бага, гадаад худалдаа солилцооны хувьд өөрийн орны боломж нөхцлийг бүрэн дүүрэн ашиглаж байгааг илэрхийлнэ. Харин эсрэг тохиолдолд худалдааны саад хориг, хязгаарлалт ихтэй учраас бодит боломжийг ашиглаж чадахгүй байна гэсэн утгатай. Иймээс энэ үзүүлэлтийг гадаад худалдааны эрх чөлөөг илэрхийлэх бололцоотой хэмээн үздэг.

Тухайн улсын олон улсын худалдааны нийт эргэлтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жингийн бодит утгын хүлээгдэж буй утгаасаа хазайх хазайлтыг тодорхойлох асуудал олон улсын худалдаанд оролцох эрх чөлөөний индексийн нэгэн үзүүлэлт болдог. Худалдааны секторын бодит утга ба хүлээгдэж буй утга ялгаатай байх, хүн ам ба газар нутаг болон газар зүйн байрлал ялгаатай байх нь дэлхийн улс орнуудын хувьд туйлын нөхцөл бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн ялгаатай байдлаас шалтгаалан олон улсын худалдааны нийт эргэлт их эсвэл бага байх боломжтой юм.

Худалдааны секторын бодит утгын хүлээгдэж буй утгаасаа хазайх хазайлтын түвшинг тооцох регрессийн загварыг үнэлэх үндсэн аргачлалыг товчхон авч үзье.

Фрейзер институт Олон Улсын худалдааны секторын хүлээгдэж буй хэмжээг үнэлэхдээ

- хөдөлмөрийн насны хүн ам
- газар нутгийн хэмжээ
- далайн эргийн урт

- далайд гарцтай эсэх
- шугаман трендийг илэрхийлэх хувьсагч
- дэлхийн нийт эрэлтэд улс бүрийн эзлэх хэмжээ

гэсэн зургаан тайлбарлагч хувьсагчаас хамааруулдаг. Энэхүү эконометрикийн загварыг тэгшитгэл хэлбэрээр бичвэл дараах хэлбэртэй байна.

$$\ln(TRSHARE)_{it} = \beta_0 + \beta_1 \cdot \ln(WPOP)_{it} + \beta_2 \cdot \ln(SIZE)_{it} + \beta_3 \cdot LOCK + \beta_4 \cdot TREND + \beta_5 \cdot COAST_{it} + \beta_6 \cdot DADS_{it} + \varepsilon_{it} \quad (7)$$

Энд:

- $TRSHARE_{it}$ - i -р улсын t -р жилийн гадаад худалдааны нийт эргэлтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин
- $WPOP_{it}$ - i -р улсын t -р жилийн 15-64 насны хүн ам /хөдөлмөрийн насны хүн ам/
- $SIZE_{it}$ - i -р улсын t -р жилийн газар нутгийн хэмжээ /квадрат км/
- $COAST_{it}$ - i -р улсын t -р жилийн далайн эргийн урт
- $LOCK_i$ - далайд гарцтай эсэхийг тэмдэглэсэн дамми хувьсагч /Энэ хувьсагч нь хэрэв тухайн улс далайд гарцгүй бол “1” гэсэн утга авна, бусад тохиолдолд “0” гэсэн утга авна./
- $TREND_i$ - шугаман трендийг харуулж буй хувьсагч
- $DADS_{it}$ - i -р улсын t -р жилийн зайгаар зохицуулагдсан эрэлтийн хэмжээ /дэлхийн нийт эрэлтэд улс бүрийн эзлэх хувийн жин/
- ε_{it} - i -р улсын t -р жилийн гадаад худалдааны саад хоригуудтай холбоотой шок

Тухайн улсын хувьд хүн амын тоо их, түүний дотор хөдөлмөрийн насны хүн ихтэй бол эдийн засгийн дотоод нөөц сайтай болохыг илэрхийлэх тул дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ их байх бөгөөд энэ нь гадаад худалдааны секторын хэмжээнд сөрөг нөлөөтэй гэж үздэг ба эконометрикийн загварын хувьд B_2 коэффициент сөрөг утгатай байдаг.

Газар нутгийн хэмжээ томтой байх нь тухайн улсын хувьд дотооддоо эдийн засгийн нөөц бололцоо мөн ихтэй гэдгээс дотоодын үйлдвэрлэл ихтэй байх тул гадаад секторын хэмжээ харьцангуй бага байх болно гэсэн үндэслэлээр $B_2 < 0$ байна гэж үздэг.

Далай, тэнгистэй тухайн улс хиллэдэг бөгөөд түүний эргийн урт их байх тусмаа гадаад секторын өргөжилттэй эерэг нөлөөтэй. Учир нь далайн тээвэр хамгийн бага зардалтай байдаг. Энэ нь худалдаалагдаж буй барааны үнэ хямд байх нөхцлийг бүрдүүлнэ. Иймээс гадаад худалдаанд эерэг нөлөөтэй байх ба $B_5 > 0$ байна. Харин далайд гарцтай эсэхийг илэрхийлсэн дамми хувьсагч нь зөвхөн их газраар хүрээлэгдсэн, далай тэнгисээс алслагдсан орнуудын гадаад худалдааны онцлогийг илэрхийлдэг.

Цаг хугацааны шугаман трендийг илэрхийлсэн хувьсагч нь гадаад худалдаанд эерэг нөлөөтэй. Учир нь дэлхийн хүн амын тоо жил ирэх тусам өсч байгаа, нөгөө талаас шинжлэх ухаан технологийн дэвшил хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж байгаагаас шалтгаалан дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүн, мөн дэлхийн гадаад худалдааны нийт эргэлт ихэсч байгаа билээ. Иймээс $B_4 > 0$ байна.

Тухайн улс дэлхийн эрэлтийн гол төв бол гадаад худалдаа их байх хандлагатай. Дэлхийн эрэлтийн гол төвүүд нь Зүүн Европ, Хойд Америкт байна гэсэн дүгнэлтийг судлаач нар хийжээ. Тиймээс тухайн улс дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувийг үйлдвэрлэж байна вэ гэдгээр эрэлтийн төв болж буй эсэхийг тодорхойлж болох юм. Фрейзер институтын эрх чөлөөний индексийн зохиогч нар энэ үзүүлэлтийг *зайгаар зохицуулагдсан эрэлтийн хэмжээ* /*distance adjusted demand scalar*/ гэсэн тусгай үзүүлэлтээр илэрхийлсэн. Уул үзүүлэлтийн дор *худалдааны тэнцүү чанарын индексээр* /*Power purchasing parity*/ илэрхийлэгдсэн дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнд тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувийг авч үзсэн. Энэ үзүүлэлтийн коэффициент нь $B_6 > 0$ байна¹⁶.

Дээрх эконометрикийн загварын параметр-үүдийг холимог өгөгдөл /*panel data*/ ашиглан үнэлдэг. Гадаад худалдааны секторын хүлээгдэж буй хэмжээтэй харьцуулсан гадаад худалдааны бодит хэмжээний хувийг

$$V_i = \left(\frac{\text{Бодит хэмжээ} - \text{Хүлээгдэж буй хэмжээ}}{\text{Хүлээгдэж буй хэмжээ}} \right) \cdot 100 \quad (8)$$

гэж тооцдог.

Худалдааны секторын бодит ба хүлээгдэж буй хэмжээний хоорондын зөрүүний индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Хавсралтад харуулсан судалгааны дүнг танилцуулахад дараах дүн гарч байна: Манай улсын хувьд худалдааны секторын хэмжээний индекс 1999-2003 онуудад 7.1-ээс 7.8-ын хооронд хэлбэлзэж байна. Энэ нь Монгол Улсын гадаад худалдааны секторын бодит утга хүлээгдэж буй хэмжээтэй харьцуулахад 56.3-67 хувь давуу байна гэсэн үг. Үүний учир нь манай улс хэдийгээр газар нутгийн хэмжээ харьцангуй том боловч, хүн ам цөөтэй, далайд гарцгүй, үйлдвэрлэлийн боломж багатай зэргээс дотоодын үйлдвэрлэл бага харин гадаад худалдааны сектор ихтэй зэргээр тайлбарлагдана. Нөгөө талаас гадаад худалдааны секторын бодит хэмжээ их байгаа нь манай улс гадаад худалдааны хувьд харьцангуй хориг саад багатай улс болохыг илэрхийлж байна.

¹⁶ - Чарлес Скиптон/Charles Skipton/, Роберт Лавсон/Robert Lawson/нарын «Estimating the Size of the Trade Sector: An Explanation of the Methodology Used to Construct Actual and Expected Trade Sector Size for Component 4-C of the Economic Freedom of the World Index» аргачлалаас харж болно.

Хүснэгт 8. Гадаад худалдааны хүлээгдэж буй хэмжээний индекс

Улсууд	1999	2000	2001	2002	2003
1 Албани	0.5	1.4	1.4	1.4	1.2
2 Алжир	3.0	4.3	3.5	3.7	3.9
3 Ангол	4.8	3.7	2.9	2.9	2.6
4 Аргентин	2.0	2.1	1.9	6.2	5.8
5 Армян	1.9	2.1	1.8	2.0	2.3
6 Австри	4.2	4.8	4.9	4.6	4.4
7 Азербайжан	2.8	3.3	3.2	4.3	5.5
8 Бангладеш	1.2	1.4	1.8	1.2	1.3
9 Беларус	7.7	9.3	8.6	7.8	8.1
10 Бельги	10.0	10.0	10.0	10.0	10.0
11 Белайз	3.3	3.3	3.0	2.8	2.8
12 Бенин	0.8	0.6	0.5	0.3	0.3
13 Болив	0.7	0.7	0.7	0.9	0.9
14 Босни Герцеговин	3.8	4.0	3.5	3.6	3.3
15 Ботсвани	3.5	3.5	2.8	2.1	1.8
16 Бразил	2.6	2.6	3.7	3.9	4.1
17 Болгар	5.7	7.5	7.5	6.7	6.8
18 Буркино Фасо	4.2	3.7	3.2	2.6	3.0
19 Бурунд	3.4	4.8	2.6	3.6	2.5
20 Камбож	5.9	8.1	8.4	9.0	9.6
21 Камирун	1.9	2.8	3.0	2.4	1.9
22 Кап Верд	1.0	1.5	1.7	1.9	6.5
23 Төв Африк	2.2	2.9	2.5	2.5	7.9
24 Чад	0.9	1.6	2.6	3.3	3.1
25 Чили	1.9	2.5	3.3	2.8	3.1
26 Хятад	4.8	6.1	5.8	6.8	8.7
27 Колумб	1.1	1.6	1.7	1.5	1.7
28 Коморос	4.1	3.6	3.6	3.3	2.2
29 Конг	8.3	7.4	8.1	8.0	7.7
30 Коста Рика	4.6	4.2	3.4	3.6	3.9
31 Котэ Д Айворэ	4.5	4.4	4.4	5.1	5.0
32 Кротия	4.0	4.5	4.7	4.3	4.4
33 Чех	6.5	7.9	7.9	6.9	6.9
34 Дани	2.3	3.0	2.9	2.8	2.5
35 БН Доминикан Улс	5.7	5.6	4.2	4.0	5.8
36 Эквадор	2.4	3.5	2.4	2.0	1.7
37 Египет, Арабын Улс	1.8	1.7	1.7	1.5	2.3
38 Эль Сальвадор	2.0	2.6	2.3	2.2	2.4
39 Эритри	4.5	4.9	4.6	4.9	6.0
40 Эстони	7.0	8.8	8.0	6.7	6.8
41 Этиоп	2.1	2.2	2.1	2.7	3.1
42 Фижи	1.4	1.8	1.6	1.3	0.8
43 Финлянд	2.5	3.2	2.6	2.3	2.1

Улсууд	1999	2000	2001	2002	2003
44 Франц	2.7	3.3	3.0	2.7	2.3
45 Габон	2.7	1.7	3.7	3.4	3.7
46 Гамби	3.5	3.9	4.0	4.0	2.4
47 Гүрж	1.9	2.3	2.2	2.6	3.2
48 Герман	4.2	5.1	5.1	4.8	4.7
49 Гана	5.7	9.1	8.2	6.7	6.3
50 Грек	1.3	1.7	1.2	0.6	0.5
51 Гватемал	1.2	1.4	1.1	0.8	0.7
52 Гэн	1.3	1.6	1.8	1.5	0.9
53 Гэнуя Бисау	1.6	2.7	3.2	2.4	1.9
54 Гондурас	5.5	5.4	4.8	4.5	4.4
55 Гонконг, Хятад	2.8	3.4	3.1	3.3	4.1
56 Исланд	0.7	0.7	0.9	0.6	0.4
57 Энэтхэг	1.6	2.1	1.8	2.3	2.2
58 Индонези	3.1	4.4	4.3	3.0	2.2
59 Иран, Исламын БНУ	2.2	2.2	1.5	3.0	2.4
60 Израиль	2.8	3.1	2.5	2.7	2.5
61 Итали	2.0	2.6	2.4	2.1	1.7
62 Ямаик	3.6	3.9	3.5	3.3	3.7
63 Япон	3.0	3.4	3.2	3.4	3.6
64 Йордан	5.8	6.1	6.0	5.9	6.0
65 Казахстан	5.2	7.3	5.8	5.7	5.6
66 Киргиз	4.7	3.8	2.4	3.0	2.7
67 Лаос	3.2	1.9	1.6	0.9	0.6
68 Лесодо	4.7	4.7	5.5	6.0	5.5
69 Литва	5.2	5.7	6.4	6.8	6.7
70 Люксембург	3.2	3.7	3.7	3.2	2.8
71 Македон	2.0	2.8	2.0	1.8	1.4
72 Мадагскар	2.7	3.9	3.0	0.6	2.1
73 Малави	3.1	2.5	2.7	2.7	2.6
74 Малайз	3.6	3.8	3.3	3.1	2.9
75 Мавритани	2.9	3.4	3.5	3.8	4.0
76 Мауритус	7.8	7.3	7.1	6.0	5.7
77 Мексик	4.2	4.1	3.2	2.9	3.2
78 Молдав	4.2	4.3	4.1	4.2	4.8
79 Монгол	7.1	7.8	7.4	7.5	7.3
80 Марокко	4.2	4.7	4.5	4.6	4.3
81 Мозамбик	2.0	2.3	2.8	3.2	3.2
82 Намиби	4.7	4.1	3.9	3.8	3.0
83 Непал	2.0	2.3	2.0	1.2	1.1
84 Нигер	0.3	0.8	0.5	0.3	0.4
85 Нигери	6.4	7.8	6.0	6.4	7.4
86 Норвег	1.7	1.9	1.7	1.2	1.2

Хүснэгт 8. Гадаад худалдааны хүлээгдэж буй хэмжээний индекс (үргэлжлэл)

Улсууд	1999	2000	2001	2002	2003
87 Пакистан	1.5	1.7	2.0	2.0	2.4
88 Панам	5.8	6.0	5.6	4.8	4.2
89 Прагвай	1.6	1.1	0.9	2.5	2.8
90 Перу	0.3	0.4	0.3	0.3	0.4
91 Филиппин	7.1	7.5	6.5	6.1	6.1
92 Польш	3.3	4.0	3.5	3.3	1.9
93 Румын	3.5	4.5	4.7	4.7	4.0
94 ОХУ	4.9	4.6	3.5	3.2	2.4
95 Рванда	2.7	3.3	3.6	3.2	3.9
96 Саудын Араб	3.0	4.0	3.4	3.4	3.9
97 Снигал	3.5	3.4	3.4	3.2	3.1
98 Серб Монтенегро	2.4	4.4	3.5	2.7	2.9
99 Сыр Лён	8.2	9.6	10.0	9.7	10.0
100 Словак	5.2	5.6	5.4	5.1	5.3
101 Словени	0.8	1.1	1.0	0.7	0.5
102 Соломоны арлууд	1.2	1.7	1.2	1.0	0.9
103 Сомаль	8.3	8.8	8.0	8.0	5.7
104 Өмнөд Африк	4.0	3.4	3.5	2.2	3.6
105 Испани	4.3	3.4	3.1	2.9	2.9
106 Шри Ланк	3.1	3.4	3.3	3.4	3.1
107 Судан	2.3	4.2	3.4	3.3	3.6
108 Швейцарь	6.5	7.1	7.9	7.5	6.6
109 Швед	4.0	4.5	4.3	3.8	3.6
110 Сир Арабын БНУ	3.7	3.7	3.9	4.3	3.9
111 Тажикстан	7.9	10.0	8.2	8.3	7.9
112 Танзани	1.7	1.3	1.6	1.6	2.1
113 Тайланд	2.7	3.7	3.6	3.3	3.3
114 Того	2.5	3.6	3.6	3.7	3.4
115 Тринада Тобоко	3.0	3.5	3.0	2.8	2.3
116 Тунис	5.1	5.4	5.9	5.3	4.8
117 Турк	3.0	3.6	4.6	3.9	3.6
118 Уганда	0.4	0.1	0.3	0.4	0.4
119 Украин	3.3	4.3	3.4	3.1	2.7
120 Их Британи	2.7	3.0	2.8	2.4	2.1
121 АНУ	3.6	4.0	3.3	3.0	2.8
122 Уругвай	2.9	3.3	2.9	3.4	4.3
123 Узбекистан	0.6	1.5	2.4	2.6	3.3
124 Вэнесуэль	1.0	1.6	1.0	1.6	1.5

Индексийн динамик шинжилгээ, харьцуулалт

Монгол Улсын онцлог

Фрейзер институтын уг индексийн тооцоонд ашиглагдаж буй худалдааны секторын хүлээгдэж буй утгыг тодорхойлж байгаа регрессийн загварын тайлбарлагч хувьсагчдаас тухайн улсын газар нутгийн хэмжээ нь оновчтой бус сонгогдсон байж болзошгүй юм. Учир нь дан ганц хугацааны цувааны өгөгдөл ашиглан үнэлгээ хийвэл тогтмол утгатай байх газар нутгийн хэмжээ үнэлгээнд ямар ч нөлөөгүй юм.

Мөн далайтай хиллэдэг хилийн шугамын урт тэг тохиолдолд их газартай хиллэдэг гээд дамми хувьсагч оруулсан нь уул хоёр үзүүлэлт хоорондоо хамааралтай болж, регрессийн үнэлгээний хувьд мультиколлинеар нөхцөл үүсч магадгүй юм.

Хүлээгдэж буй утгыг тодорхойлж буй регрессийн тайлбарлагч үзүүлэлтээр тухайн улс ямар улсуудтай хиллэдэг, хүн амын нягтрал, дэд бүтцийн хөгжил, тухайн улсын хөгжлийн түвшин зэрэг тоон ба чанарын үзүүлэлтийг нэмж тооцвол илүү зүйтэй юм. Учир нь тухайн улсын олон улсын худалдаанд тус улстай хиллэдэг орнуудын эдийн засаг, улс төрийн байдал маш чухал нөлөөтэй байх нь дамжиггүй. Тухайлбал манай улсын хувьд хоёр их гүрний дунд оршдог, олон улсын худалдааны ихэнх асуудал энэ хоёр гүрэнтэй зайлшгүй холбогддог онцлогтой. Хүн ам сийрэг суурьшилтай, дэд бүтцийн хөгжил сул байдал нь дотоодын үйлдвэрлэх хүчний хөгжилд сөрөг нөлөө үзүүлж, хэрэглээ, худалдааны эдийн засгийн зонхилох бүтэцтэй байгаа нь энэ индексийн утга өндөр гарахад нөлөөлж байж болзошгүй юм.

Регрессийн үнэлгээний хувьд түүвэрт хамрагдалт бага зэрэг ялгаатай, зарим тоон үзүүлэлтийг өөр үзүүлэлтээр төлөөлүүлж авсан тул Фрейзер институтын тооцоололтой зөрж магадгүй гэсэн эргэлзээ байж болох юм. Бид 2002 оны хувьд өөрсдийн тооцсон индексийн тооцоог Фрейзер институтын индекстэй хэр хамааралтай байгааг корреляцийн шинжилгээний тусламжтай тодорхойлоход нилээд хүчтэй хамааралтай байгаа нь тогтоогдсон болно.

Г. Валютын хар захын ба албан ханшийн хоорондын зөрүү

Валютын ханшийн хөвөгч ба хатуу ханшийн гэсэн хоёр тогтолцоо байдаг. Хөвөгч ханшийн тогтолцоотой орны хувьд тухайн улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан гадаад валютын ханш өөрчлөгдөж байдаг. Энэ тогтолцооны сул тал нь гадаад худалдаа эрхлэгч нар болон гадаад валюттай харьцаж буй хүмүүс валютын ханшийн эрсдэлд орох магадлалтай байдаг.

Харин хатуу ханшийн тогтолцоотой орны хувьд тухайн улсын Төв банк эсвэл Валютын хороо нь өөрийн мөнгөн тэмдэгтийн бусад гадаад орнуудын валютуудтай харьцах ханшийг тогтоодог. Энэ тохиолдолд валютын ханшийн эрсдэл үгүй болох боловч, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан дотоодын зах зээлд валютын эрэлт, нийлүүлэлт өөрчлөгдсний улмаас валютын албан бус зах үүсдэг. Валютын хөвөгч ханштай тохиолдолд бодит ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан олон улсын худалдааны хэмжээ өөрчлөгдөж байдаг. Харин хатуу ханшийн тогтолцоо үүнийг мэдэрдэггүй. Мөн хатуу ханшийн тогтолцоотой үед төр иргэдийн сонголтод хөндлөнгөөс оролцож байдаг. Хөвөгч ханштай орны хувьд олон улсын худалдаа илүү чөлөөтэй байдаг гэсэн үндэслэлээр энэ үзүүлэлтийг худалдааны нээлттэй байдлыг илэрхийлдэг гэж үздэг.

1993 оны 5-р сарын 27-ноос валютын хөвөгч ханшийн тогтолцоонд шилжсэнээр Монгол Банк валютын захын ханшийг нэгдсэн нэг тогтолцоонд шилжүүлэхийг зорьсон боловч өнөөг хүртэл дотоодын зах зээл дээр валютын параллель гурван ханш тогтож байна.

Хар захын ханшийг валютын гудамжны худалдаачид тодорхойлдог бөгөөд дамлан худалдах сонирхлын үүднээс валютын худалдаж авах, худалдах ханшийг тогтоодог юм. Хар захын ханш нь валютын эрэлт, нийлүүлэлтэд мэдрэмжтэй бөгөөд хэлбэлзэл ихтэй байдаг.

Банк хоорондын захын ханшийг Монгол Банкнаас гадаад төлбөр тооцооны эрх авсан арилжааны банкууд тодорхойлдог бөгөөд валют худалдан авах ханшийг тогтоохдоо Монгол Банкны албан ханшийг суурь болгон

ашиглаж байна. Худалдах ханшийг хар захын ханшийн түвшинд хүргэх хандлагатай. Банк хоорондын захын худалдан авах, худалдах ханш нь Монгол Банкнаас тогтоосон ханшийн зөрүүнд захирагддаг тул ханшийн хэлбэлзэл бага, харьцангуй тогтвортой байдаг.

Монгол Банкны ханш нь Монгол Банкны валютын бодлого, нөөцийн удирдлагын газар арилжааны банкуудын өдрийн валютын арилжааны мэдээг үндэслэн *Midpoint* аргачлалаар тогтоодог ханш юм.

Валютын албан ба хар захын ханшийн зөрүүний индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Энд V_i -ээр валютын хар захын буюу дамын валютын наймааны ханшийн албан ханшаас давж буй хувийг авна. $V_{min}=0$, $V_{max}=50$ байх ба хэрвээ хар захын ханш байдаггүй бол энэ үзүүлэлтийн индекс 10 гэсэн утгаа авна. Хар захын ба албан ханш гэсэн хоёр ханш үйлчилдэг бол энэ индексийн утга буурна. Хар захын ханшийн албан ханшаас давж буй хувь нь 50 ба түүнээс дээш бол энэ индекс шууд тэг утгатай болно.

Энд V_i үзүүлэлтийг


$$V_i = \left(\frac{\text{Хар захын ханш} - \text{Төв банкны ханш}}{\text{Төв банкны ханш}} \right) \cdot 100\%$$

гэж тооцсон.

Хүснэгт 9. Валютын ханшийн мэдээ

Он	Хар захын ханш	Банк хоорондын захын ханш	Монгол Банкны ханш
1995	473.6	472.0	471.0
1996	693.0	691.5	693.5
1997	815.0	813.6	813.2
1998	917.0	912.5	902.0
1999	1072.8	1070.5	1070.4
2000	1099.0	1097.4	1097.0
2001	1102.1	1101.0	1101.3
2002	1126.3	1124.5	1124.1
2003	1171.0	1170.6	1170.3
2004	1216.6	1215.5	1211.8

Эх сурвалж: Монгол Банкны Валютын бодлого, нөөцийн удирдлагын газар, Жилийн эцсийн ханш

Зураг 2. Валютын албан ба хар захын ханш

Америк долларын дээрх гурван ханшийн мэдээг Монгол Банкнаас авсан болно. Мэдээллээс гурван параллель ханшийн хувьд зарчмын зөрүү бараг байхгүй болсон харагдаж байна.

Индексийн динамик шинжилгээ, харьцуулалт

1998 онд хоёр ханшийн зөрүү 2 орчим хувийн зөрүүтэй байсныг эс тооцвол бусад онуудад бараг зөрүүгүй байсан байна. Иймээс энэ үзүүлэлтийн индекс нь хамгийн дээд буюу 10 утгаа ихэвчлэн авчээ.

Хүснэгт 10. Валютын албан болон хар захын ханшийн зөрүү

Он	Хар захын ханшийн албан ханшаас зөрсөн хувь	Фрейзер институтын индекс
1995	0.56	9.9
1996	-0.07	10.0
1997	0.23	10.0
1998	1.66	9.7
1999	0.22	10.0
2000	0.18	10.0
2001	0.07	10.0
2002	0.20	10.0
2003	0.06	10.0
2004	0.40	9.9

Үүнээс манай улсын валютын тогтолцоо нь чөлөөт хөвөгч ханшийн тогтолцоотой байна гэсэн дүгнэлтийг хийж болох юм. Бусад түүвэрлэгдсэн орнуудын хувьд дээрхтэй ижил үр дүнтэй байгаа юм.

Манай улсын хувьд албан болон хар захын валютын ханшийн зөрүү бага байгаа нь валютын эрэлттэй дагаж нийлүүлэлт түргэн хийгддэг, валют орж ирэх боломж нээлттэй, валютын нөөц харьцангуй сайтай, валютын албан ханшийг өдөр бүр шинэчлэн тогтоодог зэрэгтэй холбоотой юм.

Валютын ханшийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн дагуу тогтоох, банк хоорондын валютын захын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Банк 2002 оны 6-р сарын 24-ний өдрөөс арилжааны ханшийг зарлаж эхлэсэн. Валютын худалдан авах ба худалдах ханшийн зөрүүг Монгол Банкнаас зарласан банк хоорондын захын дундаж ханшаас (Midpoint rate) нэмэх, хасах 1 төгрөгтэй тэнцүү байхаар тогтоожээ.

Д. Олон улсын хөрөнгийн зах зээлийн хяналт

Энэ үзүүлэлт нь дотроо

- Гадаадын хөрөнгийн зах зээлд дотоодын иргэдийн, дотоодын зах зээлд гадаад иргэдийн оролцох боломж
- Тухайн улсын иргэдийн гадаадын иргэдтэй хамтран хөрөнгийн зах зээлд оролцох эрх чөлөө гэсэн хоёр дэд үзүүлэлттэй.

Нэг дэх үзүүлэлтийг Дэлхийн Эдийн Засгийн Форумын *Global Competitiveness Report*-ын 9.08 болон 9.09 үзүүлэлтээр тооцдог ба харин хоёр дахь дэд үзүүлэлтийн мэдээг Олон Улсын валютын сангийн *Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions* цувралаас авдаг.

Д.1 Гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлд иргэд харилцан оролцох боломж

Гадаадын иргэдийн манай улсад хийсэн, дотоодын иргэдийн гадаад орнуудад хийсэн шууд хөрөнгө оруулалт нь тухайн улсын олон улсын худалдаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Эдгээр үйл хөдлөлд ямар нэг хориг саад тавьсан байдал нь дам утгаар олон улсын худалдааг хязгаарлаж, эрх чөлөөг боогдуулдаг.

Хөрөнгийн зах зээлд иргэдийн харилцан оролцох боломжийн индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Дэлхийн эдийн засгийн форумын *The Global Competitiveness Report 2005-2006* тайланд тусгагдснаар гадаадын, дотоодын хөрөнгийн зах зээлд иргэдийн харилцан оролцох боломж гэсэн үзүүлэлтээр

- Хүснэгт 8.07-ын индексээр илэрхийлэгддэг үзүүлэлт болох *Гадаадын хөрөнгийн зах зээлд дотоодын иргэдийн оролцох боломж*-ийн хувьд 2004 оны байдлаар түүвэрт хамрагдсан 117 орноос 111-р байр эзэлж, 3.4 гэсэн оноо авсан байна. Үүнийг Фрейзер Институтын аргачлалд хөрвүүлбэл 6.4 гэсэн индекс ноогдохоор байна.

- Хүснэгт 8.08-ын индексээр илэрхийлэгдэх үзүүлэлт болох *Дотоодын хөрөнгийн зах зээлд гадаадын иргэдийн оролцох боломж*-ийн хувьд 2004 оны байдлаар 117 орноос 102-р байр эзэлж, 3.3 гэсэн оноо авсан байна. Үүнийг Фрейзер Институтын аргачлалд хөрвүүлбэл 6.3 гэсэн индекс ноогдохоор байна.

2004 оны байдлаар *Гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлд иргэдийн харилцан оролцох боломж* үзүүлэлтийн хувьд дээрх хоёр индексийг нэгтгэвэл 6.35 гэсэн индекс ноогдохоор байна. Энэ нь манай улсын хувьд гадаад болон дотоодын хөрөнгийн зах зээлд иргэдийн оролцох боломж нь багатай болохыг харуулж байна.

Энэ үзүүлэлтийн хувьд бусад улсуудтай харьцуулахад харьцангуй муу гарч байгаа нь манай улсад хөрөнгийн зах зээл хөгжөөгүй, иргэд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг сайн ойлгож мэдээгүйтэй холбоотой. Нөгөө талаас манай эдийн засаг хэт жижиг тул гадаадын иргэд манай хөрөнгийн зах зээлийг тэр бүр сонирхохгүй байх талтай юм.

Д.2 Тухайн улсын иргэдийн гадаадын иргэдтэй хамтран хөрөнгийн зах зээлд оролцох эрх чөлөө

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр өмнө хэрэглэж байсан эдийн засгийн нэр томъёо, хэллэгүүд бүхлээрээ өөрчлөгдсөн билээ. Энэ ч утгаараа зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд удаагүй байгаа манай улсын хувьд зах зээлийн эдийн засгийн зарим нэр томъёо хараахан хэвшээгүй байгаа гэдгийг бид хүлээн зөвшөөрөх нь зүйн хэрэг юм. Иймээс хөрөнгийн хяналтын индексийг илэрхийлдэг үзүүлэлтүүдийг эдийн засгийн утга агуулга талаас нь товчхон тайлбарлах шаардлагатай юм.

Фрейзер Институтын аргачлалд тодорхойлсноор хөрөнгийн хяналтын индекс нь дараах 13 үзүүлэлтээр илэрхийлэгддэг. Эхлээд эдгээр 13 үзүүлэлтийг англи хувилбараар хүснэгтэд танилцуулаад дараа нь Олон Улсын Валютын Сангийн тодорхойлсноор тайлбарыг хийе.

Хүснэгт 11. Хөрөнгийн зах зээлийн хяналтын үзүүлэлтүүд

Д/Д	Үзүүлэлтүүд
1	Repatriation requirements
2	Restrictions on use of funds
3	Controls on capital transactions
4	Controls on capital and money market instruments
5	Controls on derivatives and other instruments
6	Controls on credit operations
7	Controls on direct investment
8	Controls on liquidation of direct investment
9	Controls on real estate transactions
10	Controls on personal capital transactions
11	Provisions specific to commercial banks and other credit institutions
12	Provisions specific to institutional investors
13	Other controls imposed by securities laws

Эх сурвалж: «Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions» 2003

Үзүүлэлт тус бүрийн тайлбарыг авч үзье.

1. *Эргэх холбоо байгаа эсэх:* Нэг талаас экспортлогчдын гол үүрэг нь экспортын орлогыг эх орондоо буцаан авчрах явдал байдаг. Энэ төрлийн хязгаарлалт байгаа эсэх нь тухайн улсын иргэн ба гадаад улсын иргэн хөрөнгө эзэмших эрх чөлөөнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байдаг.
2. *Хөрөнгийн хэрэглээтэй холбоотой хязгаарлалтууд:* Энд өмнө нь банкны дансанд хадгалсан мөнгөн орлогыг ашиглахад учирч байгаа хязгаарлалтуудыг авч үздэг.
3. *Хөрөнгө эзэмшихтэй холбоотой хязгаарлалтууд:* Хөрөнгө эзэмших гэсэн ойлголт нь маш өргөн хүрээг хамардаг бөгөөд ерөнхийдөө хөрөнгийн дотогшоо болон гадагшаа чиглэсэн урсгалуудад нөлөөлж байгаа зохицуулалтуудыг цогц хэлбэрээр авч үздэг. Иймээс хөрөнгө эзэмшихтэй холбоотой хяналтууд нь саад хоригууд, мэдэгдэл болон зөвшөөрөл урьдаас шаардах, хоёр болон нийлмэл валютын ханш, ялгаварлалтай

татварууд, болон гадаадад тухайн улсын иргэд хөрөнгө эзэмших болон гадаадын иргэд тухайн улсад хөрөнгө эзэмших эсвэл, үйл ажиллагааны гүйцэтгэл эсвэл шилжүүлгүүдийг зохицуулах үндэслэл бүхий зээлийн хүүгийн торгууль эсвэл нөөцийн шаардлагууд зэргийг багтаадаг.

4. *Хөрөнгийн болон мөнгөний зах зээлийн хязгаарлалтууд:* Энэ ойлголт нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

a. *Хөрөнгийн зах зээлийн үнэт цаас:* Энд хувьцаа ба үнэт цаас, бондууд ба 1 жилээс дээш хугацаатай үнэт цаасуудыг авч үзнэ.

b. *Мөнгөний зах зээлийн арга хэрэгслүүд:* Энд 1 жилийн хугацаатай эсвэл 1 жилээс бага хугацаатай хэрэглэгдэх үнэт цаасыг авч үзэх ба богино хугацааны арга хэрэгслүүд тухайлбал, хадгаламжийн дэвтэр болон валютын тооцооны баримтууд зэрэг багтдаг.

c. *Хамтарсан хөрөнгө оруулалтын үнэт цаас:* Энд хамтарсан хөрөнгө оруулалттай байгууллагын хувьцааны сертификат болон бүртгэл багтах бөгөөд эсвэл хөрөнгө оруулагчийн сонирхлыг илэрхийлэх бусад баталгааг авч үзнэ. Тухайлбал, хамтын хөрөнгө гэх мэт.

5. *Уламжлагдсан болон бусад арга хэрэгслүүд дэх хязгаарлалтууд:* Энд эзэмших эрхийн бичиг, санхүүгийн сонголтууд, хоёрдогч зах зээл дээрх аливаа үйл ажиллагаа, форвард үйл ажиллагаанууд, бондууд болон бусад өрийн үнэт цаасны арилжаа зэргийг багтаан ойлгоно.

6. *Зээлийн үйл ажиллагаатай холбоотой хязгаарлалтууд:* Энд дараах хоёр төрлийн зээлийн үйл ажиллагааг авч үздэг. Үүнд:

a. *Арилжааны зээл:* Олон улсын худалдааны үйл ажиллагаа болон олон улсын хэмжээнд үзүүлж буй үйлчилгээтэй шууд холбогдож буй үйл ажиллагааг хамарч буй зээл юм.

b. *Санхүүгийн зээл:* Энд арилжааны зээлээс бусад тухайн улсын иргэдийн хүлээн зөвшөөрсөн зээлийн үйл ажиллагааг авч үзнэ.

7. *Шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтууд:* Энд урт хугацааны эдийн засгийн харилцааг бий болгох зорилго бүхий тухайн улсын иргэдийн гадаадад хийх болон гадаадын иргэдийн тухайн улсад хийх хөрөнгө оруулалтуудыг ойлгоно. Эдгээр хөрөнгө оруулалтууд гол нь бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх зорилготой байдаг бөгөөд ялангуяа үйлдвэрлэлийн менежмент дэх хөрөнгө оруулагчийн оролцоог хүлээн зөвшөөрдөг хөрөнгө оруулалтууд юм.
8. *Шууд хөрөнгө оруулалтын өр төлөлттэй холбоотой хязгаарлалтууд:* Энэхүү ойлголтын доор үндсэн хөрөнгийн шилжүүлгийг авч үзэх бөгөөд мөн анхны хөрөнгө, хөрөнгийн орлого болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг багтаан ойлгоно.
9. *Үндсэн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой хязгаарлалтууд:* Энд шууд хөрөнгө оруулалтад хамаарахгүй үндсэн хөрөнгийг эзэмших асуудлыг авч үзнэ. Тухайлбал, хувийн хэрэглээндээ зориулж үндсэн хөрөнгийг хуримтлуулах эсвэл цэвэр санхүүгийн шинж чанар бүхий хөрөнгө оруулалт орно.
10. *Хувийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой хязгаарлалтууд:* Энэ ойлголт нь төлөвлөгдсөн хувь хүмүүсийн орлого болон хувь хүмүүст зориулсан шилжүүлгүүдийг хамардаг. Нэг талаас хүүний төлбөр хэлбэрээр орж ирэх найдвар бүхий эзэмшигчийн орлого болох өмчтэй холбоотой үйл ажиллагааг багтаадаг.
11. *Арилжааны банкууд болон бусад зээлийн байгууллагуудын тусгай хэлэлцээрүүд:* Энд эдгээр байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой онцгой зохицуулалтуудыг авч үздэг. Тухайлбал, мөнгөний, зөвлөх эрхтэй ба гадаад валютын хяналтууд. Гэхдээ энэ категорт багтаж байгаа үзүүлэлтүүд нь заавал хөрөнгийн урсгалын хяналтыг илэрхийлэх албагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.
12. *Институциональ шинж чанар бүхий хөрөнгө оруулагчдын тусгай хэлэлцээрүүд:*

Энэхүү үзүүлэлт нь даатгалын компаниуд болон тэтгэвэрийн сангуудын үйл ажиллагаан дахь хяналтын асуудалд чиглэдэг.

13. *Үнэт цаасны хуулиар зохицуулагдах бусад хязгаарлалтууд:* Энд хуульд заасан хөрөнгийн шилжүүлгүүдийн нэмэлт зохицуулалтуудыг авч үздэг. Тухайлбал, дотоодын үнэт цаасны зах зээлд гадаадын үнэт цаас арилжаалагдах үйл явцад хяналт тавих.

Хөрөнгийн зах зээлийн хяналтын индексийн тооцоолол, динамик шинжилгээ, харьцуулалт

Энэ индексийг мэдээллийн олдцын боломжит байдлаас шалтгаалан 2002 ба 2003 оны өгөгдлийг ашиглан тооцлоо.

Тооцох аргачлалын хувьд Олон Улсын Валютын сангаас жил бүр гаргадаг *Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions* тайлангийн хөрөнгийн хяналтын индексийг илэрхийлэх 13 үзүүлэлтэд үндэслэдэг. Тухайн улсын эдийн засагт эдгээр 13 үзүүлэлт хэрхэн тодорхойлогдож байгаагаас хамааран “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн хариултуудыг Олон Улсын Валютын сангаас гаргадаг дээрх тайланд тусгасан байгаа бөгөөд хөрөнгийн хяналтын индексийг тооцохдоо “Тийм” гэсэн харилтуудын тоог доорх томъёонд орлуулах замаар тооцно.

$$KCI_t = \frac{13 - N_t}{13} \cdot 10$$

Энд: KCI_t - t -р оны хөрөнгийн хяналтын индекс

N_t - t -р оны “Тийм” гэсэн хариултын тоо

Хэрэв дээрх 13 үзүүлэлтүүдийн хариултууд бүгд “Тийм” гэсэн хариулттай бол хөрөнгийн хяналтын индекс нь 0 гэсэн доод хязгаарын утгаа авна. Эсрэг тохиолдолд бүгд “Үгүй” гэсэн хариулттай бол хөрөнгийн хяналтын индекс 10 гэсэн дээд хязгаарын утгаа авна.

Индексийн тооцооллыг хийхийн тулд *Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions* тайлангийн 2002 ба 2003 оны хэвлэлүүдээс дээрх 13 үзүүлэлт Монгол Улсын

эдийн засгийн практикт хэрхэн тодорхойлогдож байгаа байдлыг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа. /Хүснэгт 12/

Хүснэгт 12. Хөрөнгийн зах зээлийн хяналт

Д/Д	Үзүүлэлтүүд	2002	2003
1	Эргэх холбоо байгаа эсэх	Үгүй	Үгүй
2	Хөрөнгийн хэрэглээтэй холбоотой хязгаарлалтууд	Үгүй	Үгүй
3	Хөрөнгө эзэмшихтэй холбоотой хязгаарлалтууд	Тийм	Тийм
4	Хөрөнгийн болон мөнгөний зах зээлийн хязгаарлалтууд	Тийм	Тийм
5	Уламжлагдсан болон бусад арга хэрэгслүүд дэх хязгаарлалтууд	Тийм	Тийм
6	Зээлийн үйл ажиллагаатай холбоотой хязгаарлалтууд	Тийм	Тийм
7	Шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтууд	Үгүй	Үгүй
8	Шууд хөрөнгө оруулалтын өр төлөлттэй холбоотой хязгаарлалтууд	Үгүй	Үгүй
9	Үл хөдлөх хөрөнгийн эзэмшилтэй холбоотой хязгаарлалтууд	Тийм	Тийм
10	Хувийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой хязгаарлалтууд	Тийм	Тийм
11	Арилжааны банкууд болон бусад зээлийн байгууллагуудын тусгай хэлэлцээрүүд	Тийм	Тийм
12	Институциональ шинж чанар бүхий хөрөнгө оруулагчдын тусгай хэлэлцээрүүд	Үгүй	Үгүй
13	Үнэт цаасны хуулиар зохицуулагдах бусад хязгаарлалтууд	Тийм	Тийм

Эх сурвалж: «Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions» 2002, 2003

Хүснэгт 12-оос харвал 2002 ба 2003 оны хувьд хөрөнгийн хяналтын индексийг илэрхийлэх 13 үзүүлэлтийн “Тийм” эсвэл “Үгүй” хариултууд өөрчлөгдөөгүй байна. Иймээс энэ 2 оны хувьд хөрөнгийн хяналтын индексийн утга өөрчлөгдөхгүй болох нь тодорхой юм. 2002 болон 2003 оны байдлаар хөрөнгийн хяналтын индексийг илэрхийлэгч 13 үзүүлэлтүүдийн хувьд 8 нь ямар нэгэн зохицуулалт ба хязгаарлалттай гэсэн үр дүн гарч байгаа бөгөөд өөрөөр хэлбэл, 8 нь “Тийм” гэсэн хариулт байгаа гэсэн үг юм. Үүнд үндэслэн хөрөнгийн хяналтын индексийг тооцвол дараах үр дүн гарна.

$$KCI_{2002} = KCI_{2003} = \frac{13-8}{13} \cdot 10 = 3.846$$

Хөрөнгийн хяналтын индексийн тооцогдсон утгаас харвал Монгол Улсын хувьд хөрөнгө эзэмшихтэй холбоотой эдийн засгийн эрх чөлөө ерөнхийдөө хязгаарлагдмал байна гэсэн дүгнэлтийг хийж болно. Хөрөнгийн хяналтын индексийг илэрхийлэгч 13 үзүүлэлтийн хариултуудын хувьд эргэх холбоо байгаа эсэх, хөрөнгийн хэрэглээтэй холбоотой хязгаарлалтууд, шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтууд, шууд хөрөнгө оруулалтын өр төлөлттэй холбоотой хязгаарлалтууд болон институциональ шинж чанар бүхий хөрөнгө оруулагчдын тусгай хэлэлцээрүүд гэсэн 5 үзүүлэлт дээр ямар нэгэн хуулийн зохицуулалт болон хязгаарлалт байхгүй гэсэн үр дүн гарч байна. Бусад 8 үзүүлэлтийн хувьд ямар нэгэн хуулийн зохицуулалт болон хязгаарлалт байдаг гэсэн үр дүнд хүрч байна.

Дээрх тооцсон үр дүнгээ дэлхийн улс орнуудтай харьцуулсан үр дүнг дараах хүснэгтэд харууллаа. /Хүснэгт 13/

Хүснэгт 13. Олон улсын харьцуулалт

Д/Д	Улсууд	2002
1	Бангладеш	0.8
2	Болгар	1.5
3	Канад	8.5
4	Чех	6.2
5	Чили	5.4
6	Хятад	0.8
7	Эстони	6.2
8	Гонконг	8.5
9	Унгар	8.5
10	Япон	7.7
11	Латви	6.9
12	Литва	6.9
13	ОХУ	2.3
14	Польш	2.3
15	Сингапур	6.2
16	Словак	6.2
17	Өмнөд Солонгос	1.5
18	Англи	8.5
19	АНУ	6.9
20	Монгол	3.8

Эх сурвалж: Economic Freedom of the World: Annual Report 2004

Хүснэгт 13-аас харвал 2002 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн хяналтын индексийн утга шилжилтийн эдийн засагтай орнууд болох Словак /6.2/ ба Латвиас /6.9/ тус тус доогуур байна. Мөн Ази тивийн улс орнууд болох Бангладеш /0.8/, Өмнөд Солонгос /1.5/, Хятад /0.8/ зэрэг улсуудаас өндөр, харин Япон /7.7/ ба Гонконгтой /8.5/ харьцуулахад доогуур байна.

Монгол Улсын онцлог

Олон Улсын Валютын Сангаас санал болгосон хөрөнгийн хяналтын индексийг илэрхийлэгч 13 үзүүлэлтийн хувьд Монгол Улсын 2003 оны байдлаарх “Тийм”, “Үгүй” гэсэн хариултаудыг дэлгэрүүлэн авч үзсэн үр дүнг Хүснэгт 14-д харууллаа.

Хүснэгт 14-өөс харвал дээрх 13 үзүүлэлтүүдийн хувьд “Тийм” эсвэл “Үгүй” гэж хариулагдах эсэх нь Монгол Улсын санхүүгийн зах зээлтэй холбоотой хууль тогтоомжуудын өөрчлөлтөөс хамаарах болж байна. Ер нь хөрөнгийн хяналтын индексийн хувьд манай улсын дараах 4 гол хуультай шууд холбогдож байна¹⁷. Үүнд:

1. Үнэт цаасны тухай хууль
2. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
3. Банкны тухай хууль
4. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хууль

Нэг талаас эдгээр 4 гол хуульд дорвитой өөрчлөлт оруулж байж хөрөнгийн хяналтын индексийн утгыг сайжруулах буюу Монгол Улсын иргэдийн гадаадын иргэдтэй хамтран хөрөнгийн зах зээлд оролцох эрх чөлөөг нэмэгдүүлэх боломжтой юм.

Энэ 4 хуулиас эхний 2 хуулийн нэмэлт, өөрчлөлт хөрөнгийн хяналтын индексийн утганд хэрхэн нөлөөлж болох талаар товчхон авч үзье.

Үнэт цаасны тухай хууль: Энэхүү хуулийг 1994 оны 10-р сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан бөгөөд түүнээс хойш энэ хуульд зөвхөн нэг удаа

өөрчлөлт оруулсан бөгөөд 2002 оны 7-р сарын 4-ний өдрийн Монгол Улсын Их Хурлаар баталсан энэхүү өөрчлөлтөөс дүн шинжилгээ хийж үзвэл хөрөнгийн хяналтын индексийн утгад нөлөөлөхүйц өөрчлөлт ороогүй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль: Энэхүү хуулийг 1993 оны 5-р сарын 10-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан бөгөөд түүнээс хойш энэ хуульд 2 удаа өөрчлөлт орсон байна. Эхний нэмэлт, өөрчлөлтийг 2001 оны 11-р сарын 30-ны өдөр, хоёрдох нэмэлт, өөрчлөлтийг 2002 оны 1-р сарын 03-ны өдөр тус тус Монгол Улсын Их Хурлаар баталжээ. Энэхүү өөрчлөлтүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл эхний өөрчлөлтийн хувьд хөрөнгийн хяналтын индексийн утганд нөлөөлөхөөр нэмэлт, өөрчлөлт байгаагүй бөгөөд харин хоёр дахь өөрчлөлт нь нэлээд өргөн хүрээний нэмэлт, өөрчлөлт болсон байна. Хоёр дахь өөрчлөлтийн хувьд тодорхой зүйл, хэсэг, заалтыг нэмэх, өөрчлөн найруулах болон зарим зүйл, хэсэг, заалтыг хассан байна. Тухайлбал, энэ нэмэлт, өөрчлөлтийн дүнд тогтвортой байдлын гэрээг 19, 20-р зүйлд бүхлээрээ нэмж тусгаж өгсөн ба мөн 18-р зүйлийн 2 дахь хэсэг болох “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбар, хөрөнгө оруулалтын гэрээ хэрэгжүүлэгчид үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Гаалийн тарифын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Онцгой албан татварын хууль, Газрын тухай хуулиар зохицуулна” гэдгийг нэмж оруулж өгсөн хөрөнгийн хяналтын индексийн утга сайжрах үндэслэл болж өгөх нь дамжиггүй юм. Мөн аж ахуй нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 7-р зүйлийн 5, 6, 7, 8-р хэсгүүдэд гадаадын хөрөнгө оруулалт ямар салбарт хийгдсэнээс хамаарах орлогын албан татвараас чөлөөлөх нөхцлийг ялгаатай тусгаж өгсөн байна. Тухайлбал, аж ахуй нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 2001 оны 11-р сарын 9-ний өдрийн өөрчлөлтөөр 7-р зүйлийн 6-г нэмж өгснөөр гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах нэгэн нөхцөл болж өгөөд зогсохгүй бидний тооцож буй хөрөнгийн хяналтын индексийн утга сайжирч гарахад нөлөөлжээ.

¹⁷ Мөн өөр бусад дагалдах хууль, тогтоомжууд байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, Аж ахуй нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Гаалийн тарифын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль гэх мэт

Хүснэгт 14. Хөрөнгийн хяналтын индексийн утга

Д/Д	Үзүүлэлтүүд	2003	2003
1	Эргэх холбоо байгаа эсэх	Ямар нэгэн хуулийн зохицуулалт болон хязгаарлалт байхгүй.	Үгүй
2	Хөрөнгийн хэрэглээтэй холбоотой хязгаарлалтууд	Ямар нэгэн хуулийн зохицуулалт болон хязгаарлалт байхгүй.	Үгүй
3	Хөрөнгө эзэмшихтэй холбоотой хязгаарлалтууд	Тийм.	Тийм
4	Хөрөнгийн болон мөнгөний зах зээлийн хязгаарлалтууд	Гадаадын иргэд хувьцаа болон бусад үнэт цаасыг дотоодын хөрөнгийн зах зээл дээр худалдах эсвэл гаргахыг хориглодог. Мөн бонд болон бусад төрлийн өрийн бичгүүдийг худалдаж авахын тулд Монголын Хөрөнгийн биржэд бүртгүүлсэн байх шаардлагатай. Цаашилбал, мөнгөний зах зээлийн арга хэрэгслүүдийг гадаадын иргэд зах зээл дээр гаргаж тавихыг хориглодог. Мөн хамтарсан хөрөнгө оруулалтын үнэт цаасыг худалдах эсвэл эргэлтэнд оруулахыг хориглодог.	Тийм
5	Уламжлагдсан болон бусад арга хэрэгслүүд дэх хязгаарлалтууд	Үүсмэл болон бусад арга хэрэгслүүдийг гадаадын иргэд зах зээл дээр гаргахыг хориглодог.	Тийм
6	Зээлийн үйл ажиллагаатай холбоотой хязгаарлалтууд	Монгол Улсын иргэд гадаадын иргэдээс эсвэл гадаадын иргэд Монгол Улсын иргэдээс арилжааны ба санхүүгийн зээл авахад Монгол Банк болон Санхүү Эдийн Засгийн Яаманд бүртгүүлэх шаардлагатай.	Тийм
7	Шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтууд	Монгол Улс уруу чиглэсэн хөрөнгө оруулалтын хувьд хувийн корпораци хийж байгаа тохиолдолд урамшуулдаг бөгөөд ялангуяа экспортыг чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих, шинэ технологийг ашиглах, болон байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой төслүүдэд төрөл бүрийн хөнгөлөлтүүдийг үзүүлдэг. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль нь гадаадын пүүсүүдийг үндэсний шинж чанартай болгохгүй байх болон гадаадын хөрөнгө оруулагчид өөрийн хөрөнгийг байршуулах эрхтэй байх баталгааг хангаж өгдөг.	Үгүй
8	Шууд хөрөнгө оруулалтын өр төлөлттэй холбоотой хязгаарлалтууд	Ямар нэгэн хуулийн зохицуулалт болон хязгаарлалт байхгүй.	Үгүй
9	Үл хөдлөх хөрөнгийн эзэмшилтэй холбоотой хязгаарлалтууд	Монгол Улсын иргэд гадаадаас үл хөдлөх хөрөнгө худалдаж авах болон гадаадын иргэд Монгол Улсаас үл хөдлөх хөрөнгө худалдаж авахад тус тус «Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар»-т бүртгүүлэх шаардлагатай.	Тийм
10	Хувийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой хязгаарлалтууд	Монгол Улсын иргэд гадаадаас зээл авах болон гадаадын иргэд дотоодоос зээл авахад Монгол Банк болон Санхүү Эдийн Засгийн Яаманд бүртгүүлэх шаардлагатай. Мөн үүний зэрэгцээгээр Монгол Улсын иргэд гадаадын иргэдэд бэлэг, хандив, өв залгамжлал болон уламжлагдан ирсэн эртний өв хөрөнгийг шилжүүлэхэд зохих захиргааны удирдах байгууллагад бүртгүүлэх ёстой.	Тийм
11	Арилжааны банкууд болон бусад зээлийн байгууллагуудын тусгай хэлэлцээрүүд	Монгол Улсын иргэд гадаадаас зээл авахад Монгол Банкнд бүртгүүлэх ёстой. Мөн гадаадаас санхүүгийн тусламж авахад Монгол Банк зөвшөөрөл олгодог. Банкууд гадаадын иргэдэд арилжааны болон санхүүгийн зээл олгоход гадаадын валютын нэмэлт зөвшөөрөл авсан байх шаардлагатай.	Тийм
12	Институциональ шинж чанар бүхий хөрөнгө оруулагчдын тусгай хэлэлцээрүүд	Ямар нэгэн хуулийн зохицуулалт болон хязгаарлалт байхгүй.	Үгүй
13	Үнэт цаасны хуулиар зохицуулагдах бусад хязгаарлалтууд	Үнэт цаасны тухай хуульд зааснаар үнэт цаасуудыг зөвхөн Засгийн газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлөөр аймаг, нийслэлийн засаг дарга болон Монгол Улсын хуулийн этгээд болох компаниуд гаргах эрхтэй байдаг. Мөн үнэт цаасуудыг зээлдүүлэхийг хориглодог. Үүнээс гадна Үнэт Цаасны тухайн хуульд заасан өөр бусад хязгаарлалт болох заалтууд байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу.	Тийм

Хүснэгт 15. Олон Улсын худалдааны эрх чөлөөний индекс

Он	А үзүүлэлт			В үзүүлэлт			С үзүүлэлт	D үзүүлэлт	Е үзүүлэлт			Гадаад худалдааны эрх чөлөөний индекс	
	A.i	A.ii	A.iii	A	B.i	B.ii			B	E.i	E.ii		E
1995	7.7	7.5	8.2	7.8	n/a	n/a	n/a	n/a	9.9	n/a	3.0	3.0	6.9
1996	7.1	7.2	7.9	7.4	n/a	n/a	n/a	n/a	10.0	n/a	3.0	3.0	6.8
1997	8.3	8.7	7.1	8.0	n/a	n/a	n/a	n/a	10.0	n/a	3.0	3.0	7.0
1998	8.3	9.3	6.5	8.0	n/a	n/a	n/a	n/a	9.7	n/a	3.0	3.0	6.9
1999	8.1	8.3	5.9	7.4	n/a	n/a	n/a	7.1	10.0	n/a	3.0	3.0	6.9
2000	7.3	7.9	6.7	7.3	n/a	n/a	n/a	7.8	10.0	n/a	3.0	3.0	7.0
2001	6.5	7.7	4.0	6.1	n/a	n/a	n/a	7.4	10.0	n/a	3.0	3.0	6.6
2002	7.0	8.1	4.7	6.6	n/a	n/a	n/a	7.5	10.0	n/a	3.8	3.8	7.0
2003	6.8	8.1	5.8	6.9	n/a	n/a	n/a	7.3	10.0	n/a	3.8	3.8	7.0
2004	7.1	8.1	6	7.1	5.9	5	5.45	7.3	9.9	6.35	3.8	5.08	6.97

3.3 МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ НЭГТГЭСЭН ИНДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өмнө тооцсон индексүүдээ нэгтгэн Монгол Улсын олон улсын худалдааны эрх чөлөөний индексийг тодорхойлжээ. Зарим индексийн утга эхний жилүүдэд тооцогдоогүй тул түүний утгыг хасч, бусад үзүүлэлтийн индексийн арифметик дунджаар нэгдсэн индексийг тооцов. Мөн E үзүүлэлтийн хоёрдугаар дэд үзүүлэлтийн хувьд зөвхөн 2002, 2003 онуудад индексийг тооцсон. Нэгдсэн тооцооллын хувьд 2002 оноос өмнө хөрөнгийн зах зээлийн хяналт илүү хаалттай байсан тул индексийг 3 орчим, харин 2004 оны хувьд 2003 оныхоос нэг их өөрчлөгдөөгүй гэж таамаглав. В үзүүлэлт бүхэлдээ, E үзүүлэлтийн нэгдүгээр дэд үзүүлэлт 2004 оны байдлаар тооцогдсон болно. Эдгээр үзүүлэлтийн утгыг бусад онуудад оруулж тооцоогүй. (Хүснэгт 15)

3.4 ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ, ДҮГНЭЛТ

Нэгдсэн индексийг ашиглан манай улс Олон улсын худалдааны эдийн засгийн эрх чөлөөний хувьд Фрейзер институтын түүвэрт хөддүгээр байр эзлэх боломжтой байгааг тодорхойлжээ.

2002 оны байдлаар Монгол Улс Олон улсын худалдааны эдийн засгийн эрх чөлөөний

индексээрээ Бангладеш, Болгар, Япон, ОХУ зэрэг улсуудаас арай дээгүүр, бусад улсаас доогуур байна. Нэгдсэн индекс 7 байгаа нь Фрейзер институтын түүврийн хувьд 59-65 дугаар байрыг эзэлж, Кувейт(64), Малта(60), Намиб(62), Польш(59), Норвеги(63) улсуудтай зэрэгцэхээр байна.

Гэхдээ энэ дүгнэлт нь эцсийн найдвартай дүгнэлт биш юм. Учир нь олон улсын худалдааны эрх чөлөөний индексийн хоёр үзүүлэлт нь хараахан бүрэн тооцогдоогүй байгаа тул индексийн утга үүнээс буурч болох юм.

Бид олон улсын худалдааны эрх чөлөөний индексийн A, C, D, E үзүүлэлтүүдийг 1995-2004 оны байдлаар тооцов. Эдгээр үзүүлэлтийн арифметик дунджаар олон улсын худалдааны эдийн засгийн эрх чөлөөний индексийг тооцож дараах дүгнэлтэд хүрлээ. (Хүснэгт 16).

2002 оны байдлаар Монгол Улс Олон улсын худалдааны эдийн засгийн эрх чөлөөний индексээрээ Бангладеш, Болгар, Япон, ОХУ зэрэг улсуудаас арай дээгүүр, бусад улсаас доогуур байна. Нэгдсэн индекс 7 байгаа нь Фрейзер институтын түүврийн хувьд 59-65 дугаар байрыг эзэлж, Кувейт(64), Малта(60), Намиб(62), Польш(59), Норвеги(63) улсуудтай зэрэгцэхээр байна.

Хүснэгт 16. Олон улсын харьцуулалт

Д/Д	Улсууд	2002
1	Бангладеш	5.9
2	Болгар	6.8
3	Канад	8.0
4	Чех	8.3
5	Чили	8.4
6	Хятад	7.5
7	Эстони	8.7
8	Гонконг	9.7
9	Унгар	8.3
10	Япон	6.5
11	Латви	7.6
12	Литва	7.8
13	ОХУ	6.9
14	Польш	7.0
15	Сингапур	9.5
16	Словак	8.7
17	Өмнөд Солонгос	7.2
18	Англи	8.3
19	АНУ	7.8
20	Монгол	7.0

А бүлэг үзүүлэлт буюу Олон Улсын худалдааны татварын индекс -ийн хувьд манай улс 1997, 1998 онуудад харьцангуй өндөр буюу 8.0 гарсан нь энэ онуудад импортын барааны гаалийн татварыг тэглэсэнтэй холбоотой байна. Харин сүүлийн жилүүдэд импортын барааны гаалийн татварыг буцааж сэргээсэн хийгээд экспортын нилээд олон нэр төрлийн

бараануудын хувьд гаалийн татвартай болгосон төдийгүй татварыг нь өндөр тогтоосон, мөн татварын хэмжээний мөнгөн илэрхийллүүдийг 1999, 2001, 2004 онуудад ихэсгэсэн нь индекс буурахад нөлөөлжээ.

С үзүүлэлт буюу худалдааны секторын хэмжээний индексийн хувьд 1999-2003 онуудад 7.1-ээс 7.8-ын хооронд хэлбэлзэж байна. Энэ нь Монгол Улсын гадаад худалдааны секторын хэмжээний бодит утга хүлээгдэж буй утгатайгаа харьцуулахад 56.3-67 хувь давуу байсан гэсэн үг. Үүний учир нь манай улс хэдийгээр газар нутгийн хэмжээ харьцангуй том боловч, хүн ам цөөтэй, далайд гарцгүй, үйлдвэрлэлийн боломж багатай зэргээс дотоодын үйлдвэрлэл бага харин гадаад худалдааны сектор ихтэй зэргээр тайлбарлагдана. Нөгөө талаас гадаад худалдааны секторын бодит хэмжээ их байгаа нь манай улс гадаад худалдааны хувьд харьцангуй хориг саад багатай улс болохыг илэрхийлж байна.

Д үзүүлэлт буюу Валютын хар захын ба албан ханшийн зөрүүний индексийн хувьд 1998 онд хоёр ханшийн зөрүү 2 орчим хувийн зөрүүтэй байсныг эс тооцвол бусад онуудад бараг зөрүүгүй болсон байна. Иймээс энэ үзүүлэлтийн индекс нь хамгийн дээд буюу 10 утгаа ихэвчлэн авчээ.

Е үзүүлэлт буюу Хөрөнгийн зах зээлийн хяналтын индексийн хувьд 2002 оны байдлаар шилжилтийн эдийн засагтай орнууд болох Словак /6.2/ ба Латвиас /6.9/ тус, тус доогуур байна. Мөн Ази тивийн улс орнууд болох Бангладеш /0.8/, Өмнөд Солонгос /1.5/, Хятад /0.8/ зэрэг улсуудаас өндөр, харин Япон /7.7/ ба Гонконгтой /8.5/ харьцуулахад доогуур байна.

3.5. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Экспортын барааны гаалийн татвар түүнд гарсан өөрчлөлтүүд

Д/д	Код	Нэр	Тайм авч эхэлсэн огноо	Хэмжих нэгж	Тайм-ийн хэмжээ	Өөрчлөгдсөн тайм		Өөрчлөгдсөн тайм	
						Хэмжээ	Огноо	Хэмжээ	Огноо
1	72.04	Хар төмөрлөгийн өөдөс, хаягдал, дахин хайлуулах төмөр буюу гангийн өөдсийн цутгамал	1996.3.29	Кг	17	140	2001.05.01	350	2004.05.14
2	7204.10.00	Ширэмний өөдөс, хаягдал	1996.3.29	кг	17	140	2001.05.01	350	2004.05.14
3	7204.21.00	Чанаржуулсан, зэвэрдэггүй гангийн өөдөс, хаягдал	2001.05.01	кг	140			350	2004.05.14
4	7204.29.10	Хаягдал зам төмөр	1996.3.29	кг	25	140	2001.05.01	350	2004.05.14
5	72.06	Цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй төмөр, чанаржуулаагүй ган	2001.05.01	кг	140			350	2004.05.14
6	72.24	Цутгамал анхдагч хэлбэрт байгаа чанаржуулсан бусад ган, чанаржуулсан бусад гангаар хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн	2001.05.01	кг	140			350	2004.05.14
7	73.01	Өрөмдөлт, цөмлөлт, боловсруулалт хийсэн болон хийгээгүй, эсвэл угсрагдах эд ангиас бүрдэх төмөр, ган хуудсан материалаар хийсэн шон, төмөр, гангаар хийсэн гагнамал булан хэлбэрт болон сортын төмөр	2001.05.01	кг	140			350	2004.05.14
8	7302.10.00	Зам төмөр	2001.05.01	кг	140			350	2004.05.14
9	7403.21.00	Зэс, цайрын хайлш /гууль/	2001.05.01	кг	128				
10	74.04	Зэсийн өөдөс, хаягдал, гууль	1996.3.29	кг	350	140	2001.05.01		
11	74.07	Зэс цулдан, туйван болон огтолбор	2001.05.01	кг	1500				
12	76.01	Боловсруулаагүй хөнгөн цагаан	2001.05.01	кг	450				
13	76.02	Хөнгөн цагааны өөдөс, хаягдал	1996.3.29	кг	128	140	2001.05.01		
14	76.04	Хөнгөн цагаан цулдан, туйван болон огтолбор	2001.05.01	кг	350				
15	5102.11.20	Ямааны боловсруулаагүй ноолуур	1997.07.01	кг	4000				
16	5102.19.12	Тэмээний боловсруулаагүй ноолуур/эм/	1997.07.01	кг	200				
17	5102.19.11	Тэмээний боловсруулаагүй ноолуур/эр/	1997.07.01	кг	100				
18	44.01 44.03	Бөөрөнхий мод, гуалин	1999.02.15	м3	150000				
19	44.03 44.06	Дүнз	1999.02.15	м3	150000				
20	44.07 44.09	Зүсмэл материал	1999.02.15	м3	150000				

Хавсралт 2. Онцгой албан татвар болон Импортын барааны татвар, түүнд гарсан зарим нэмэлт өөрчлөлтүүд

Д/д	Нэр	Тат авч эхэлсэн огноо			Өөрчлөгдсөн тах			Өөрчлөгдсөн тах			Өөрчлөгдсөн тах		
		Хэмжих нэгж	Тах-ийн хэмжээ	Огноо	Хэмжээ	Огноо	Хэмжээ	Огноо	Хэмжээ	Огноо	Хэмжээ	Огноо	
1	Согтууруулах ундаа	Хүнсний спирт	литр	7\$									
			Архи 40 хүртэл	литр	5\$								
			Архи 40-с дээш	литр	6\$								
			Дарс	литр	0.5\$			0.75\$	2001.1				
			Пиво	литр	0.5\$	1999.7	0	2000.2	0.2\$	2001.1			
2	Тамхи	Янжуур	100ш	0.2\$									
			Дүнс	кг	0.1\$			0.3\$	2001.1				
							0.15\$	2001.1					
3	Нефтийн бүтээгдэхүүн	Бензин 90 хүртэл октантай	тн	4, 10, 31\$	1997.5.1	11, 17, 38\$	1998.3.1						
			Бензин 90-с дээш октантай	тн	5, 14, 36\$	1997.5.1	12, 21, 43\$	1998.3.1					
			Дизелийн түлш	тн	8, 12, 41\$	1997.5.1	15, 19, 48\$	1998.3.1					
					500, 1000, 1500\$	2000.1.15							
4	Суудлын а.машин	0-2 жил /1-3 жил/	ш	1000, 2000, 3000\$	2000.1.15								
			2-4 жил /3-10 жил/	ш	2000, 4000, 6000\$	2000.1.15							
			4-с дээш жил /10-с дээш/	ш	2000, 4000, 6000\$	2000.1.15							
5	Хүнсний бүтээгдэхүүн	Төмс, хүнсний ногоо	үнийн дүн	15%	0 хувь	1997.5.1	09.01-04.01- ний хооронд 15 хувь	1998.9.1	09.01-04.01- ний хооронд 15 хувь	1999.7.1	08.01-04.01- ний хооронд 15 хувь	2001.1.1	
			Гурил	үнийн дүн	15%	0 хувь	1997.5.1	09.01-04.01- ний хооронд 15 хувь	1998.9.1	09.01-04.01- ний хооронд 15 хувь	1999.7.1	08.01-04.01- ний хооронд 15 хувь	2001.1.1
6	80 хувь буюу түүнээс дээш хэмжээний алкогольн хатуулагтай этилийн хувиргаагүй спирт: Ямарваа бусад хатуулагтай этилийн хувиргасан ба бусад спирт		үнийн дүн	15%	хүчингүй	1999							
				үнийн дүн	15 хувь	хүчингүй	1999						
7	Этилийн спирт, алкогольн хэмжээ нь 80 хувиас бага, шинжийг нь өөрчлөөгүй алкогольн хатуулагтай согтууруулах ундаа, ликёр болон спиртийн бусад төрлийн ундаа		үнийн дүн	15 хувь	хүчингүй	1999							
				үнийн дүн	15 хувь	хүчингүй	1999						
8	20 хувиас доош спирт агуулсан ундаанд татвар ноогдуулахгүй		үнийн дүн	хүчингүй	1999								
9	Дээр онцгойлон заасан бусад бараа		үнийн дүн	15 хувь	0 хувь	1997.5.1			7 хувь	1999.7.1	5	2002.1.1	

Хавсралт 3. Экспортын гаалийн татварын дундаж хувь, стандарт хазайлтын тооцоо, 2004 оны байдлаар

Огноо	Код	Барааны нэр	Х. нэгж	Тоо, хэмжээ	Үнийн дүн /ам.дол/	Н.үнэ /ам.дол/	Н.үнэ /төг/	Үнийн дүн /төг/	Барааны татварын түвшин	Экспортод барааны эзлэх %	Сарын болон жилийн дундаж татвар	Сарын экспортын жилийн экспортод эзлэх хувь	Сарын стандарт хазайлт
2004.01	7204.21.00	Зэвэрдэггүй гангын өөдөс, хаягдал	кг	10180	2239.60	0.22	257.4	2620667.9	54.38	0.0115			
	7204.49.00	Хаягдал хар төмөр.	кг	1922983	165514.75	0.09	100.7	193677084.7	139.00	0.8522			
	7204.50.00	Хаягдал лааз	кг	163100	23527.00	0.14	168.8	27530119.1	82.94	0.1211			
	7602.00.00	Хөнгөн цагааны өөдөс ба хаягдал	кг	6000	2940.00	0.49	573.4	3440241.0	24.42	0.0151			
	Сарын дүн							227268112.7	129.5		4.03	23.9	
2004.02	4407.99.00	Шүдэн углуургаар холбосон бэлдэц мод	м3	4.94	2058.84	416.77	488945.3	2415389.9	30.68	0.0154			
	7204.21.00	Хаягдал хар төмөр	кг	36020	4706.00	0.13	153.3	5520985.1	91.34	0.0352			
	7204.29.10	Хаягдал зам төмөр	кг	267675	48181.50	0.18	211.2	56525572.2	11.84	0.3599			
	7204.49.00	Хаягдал хар төмөр.	кг	718722	74405.08	0.10	121.5	87290551.8	115.27	0.5558			
	Сарын дүн							157055272.5	72.0		2.08	48.8	
2004.03	4403.99.00	Гуалин мод /холтослож, дөрвөлжилсөн/	м3	35.98	5396.56	149.99	176633.1	6355258.9	84.92	0.0060			
	4407.99.00	Шүдэн углуургаар холбосон бэлдэц мод	м3	3.29	1372.70	417.23	491355.7	1616560.2	30.53	0.0015			
	5102.19.12	Тэмээний эм ноос	кг	1000	1100.00	1.10	1295.4	1295415.0	15.44	0.0012			
	7204.29.10	Хаягдал зам төмөр	кг	568840	124273.20	0.22	257.3	146350334.0	54.42	0.1371			
	7204.29.90	Хаягдал төмөр	кг	115900	19743.00	0.17	200.6	23250344.0	69.79	0.0218			
	7204.49.00	Хаягдал хар төмөр	кг	4525590	728294.14	0.16	189.5	857675594.0	73.87	0.8035			
	7602.00.00	Хөнгөн цагааны өөдөс ба хаягдал	кг	6100	2869.00	0.47	553.9	3378677.9	25.28	0.0032			
	Сарын дүн							1067361428.8	69.0		18.93	7.8	
2004.04	5102.11.10	Ямааны самнасан угаагаагүй ноолуур	кг	33130	522732.98	15.78	18507.9	613165785.5	21.61	0.3303			
	7204.21.00	Хаягдал нерж	кг	4000	800.00	0.20	234.6	938400.0	59.68	0.0005			
	7204.29.10	Хаягдал зам төмөр	кг	419716	96992.22	0.23	271.1	113771874.1	9.22	0.0613			
	7204.49.00	Хаягдал хар төмөр	кг	7224221	895259.40	0.12	145.4	1050139276.2	96.31	0.5657			
	7204.50.00	Хаягдал лааз	кг	19000	6020.00	0.32	371.7	7061460.0	37.67	0.0038			
	7404.00.10	Зэс хаягдал	кг	800	1200.00	1.50	1759.5	1407600.0	85.25	0.0008			
	7602.00.00	Хөнгөн цагааны өөдөс ба хаягдал	кг	8000	3920.00	0.49	574.8	4598160.0	24.36	0.0025			
	7604.29.00	Хөнгөн цагаан цулдан туйван	кг	5520	3668.00	0.66	779.5	4302564.0	44.90	0.0023			
	Сарын дүн							1856381119.8	62.6		32.93	37.1	

Огноо	Код	Барааны нэр	Х. нэгж	Тоо, хэмжээ	Үнийн дүн /ам.долл/	Нүнэ /ам.долл/	Нүнэ /төг/	Үнийн дүн /төг/	Барааны татварын түвшин	Экспортод барааны эзлэх %	Сарын болон жилийн дундаж татвар	Сарын экспортын жилийн экспортод эзлэх хувь	Сарын стандарт хазайлт
2004.05	5102.19.11	Тэмээний эр ноос /угаагагуй/	кг	12000	6800.00	0.57	659.0	7907720.0	15.18	0.0154			
	7204.29.10	Хаягдал зам төмөр	кг	370000	98320.62	0.27	309.0	114337049.0	8.09	0.2233			
	7204.29.90	Зам төмрийн жижиг эд анги	кг	100000	24157.40	0.24	280.9	28092640.5	49.84	0.0549			
	7204.49.00	Хаягдал хар төмөр	кг	838497	162259.08	0.19	225.0	188691084.1	62.21	0.3685			
	7404.00.10	Хаягдал зэс	кг	1000	1000.00	1.00	1162.9	1162900.0	128.99	0.0023			
	Сарын дүн							512057094.0			28.0	9.08	23.9
2004.06	4406.90.00	Хуучин ашиглагдсан дэр мод	м3	480	2761.00	5.75	6712.4	3221949.0	2234.67	0.0067			
	4407.10.90	Шүдэн углуургаар холбосон бэлдэц мод /Цонхны хүрээ модны бэлдэц /	м3	1.11	498.00	448.65	523550.5	581141.1	28.65	0.0012			
	7204.29.10	Хаягдал зам төмөр.	кг	92000	12880.00	0.14	163.4	15030316.0	15.30	0.0313			
	7204.49.00	Хаягдал хар төмөр	кг	122480	46006.50	0.38	438.3	53687285.2	31.94	0.1118			
	7204.50.00	Хаягдал лааз	кг	1000	350.00	0.35	408.4	408432.5	34.28	0.0009			
	7602.00.00	Хөнгөн цагааны хаягдал ба өөдөс	кг	100	49.00	0.49	571.8	57180.6	24.48	0.0001			
	Сарын дүн							480119790.5			19.1	8.52	181.5
2004.07	4406.90.00	Хуучин ашиглагдсан дэр мод	м3	480	2725.72	5.68	6716.9	3224090.6	2233.19	0.0056			
	4407.99.00	Шүдэн углуургаар холбосон бэлдэц мод	м3	3.8	1583.91	416.82	493029.5	1873512.1	30.42	0.0033			
	5102.19.12	Тэмээний эм ноос	кг	14500.7	34351.61	2.37	2802.1	40632458.4	7.14	0.0706			
	7204.49.00	Хаягдал харт төмөр	кг	1453323	165113.43	0.11	134.4	195302769.5	104.18	0.3391			
	7302.10.00	Хуучин зам төмөр	кг	67826	6782.60	0.10	118.3	8022730.6	295.90	0.0139			
	7404.00.10	Зэсийн хаягдал	кг	3000	4500.00	1.50	1774.3	5322780.0	84.54	0.0092			
	7602.00.00	Хөнгөн цагааны хаягдал ба өөдөс	кг	500	225.00	0.45	532.3	266139.0	26.30	0.0005			
	7604.29.00	Хөнгөн цагаан босоо тавиур	кг	90	37.31	0.41	490.4	44131.8	71.38	0.0001			
	Сарын дүн							575899696.1			53.4	10.22	168.7
2004.08	4406.90.00	Хуучин ашиглагдсан дэр мод	м3	384	2154.88	5.61	6686.7	2567711.9	2243.24	0.0187			
	4407.10.10	Зүсмэл хусан банз	м3	0.7	24.50	35.00	41705.3	29193.7	359.67	0.0002			
	4407.99.00	Шүдэн углуургаар холбосон бэлдэц мод	м3	6.91	2903.80	420.23	500739.5	3460110.0	29.96	0.0253			

Огноо	Код	Барааны нэр	Х. нэрж	Тоо, хэмжээ	Үнийн дүн /ам.дол/	Н.үнэ /ам.дол/	Н.үнэ /Тег/	Үнийн дүн /Тег/	Барааны татварын түвшин	Экспортод барааны эзлэх %	Сарын болон жилийн дундаж татвар	Сарын экспортын жилийн экспортод эзлэх хувь	Сарын стандарт хазайлт
	7204.49.00	Хаягдал хар төмөр		290300	44685.00	0.15	183.4	53245752.3	76.33	0.3888			
	7302.10.00	Хуучин зам төмөр	кг	61500	7075.94	0.12	137.1	8431548.6	255.29	0.0616			
		Сарын дүн						136965114.5			88.3	2.43	298.2
2004.09	4406.90.00	Хуучин ашиглагдсан дэр мод	м3	288	1608.00	5.58	6694.0	1927879.4	2240.80	0.0163			
	7204.29.10	Хуучин зам төмөр	кг	193050	21136.11	0.11	131.3	25340716.4	19.05	0.2148			
	7204.49.00	Хаягдал хар төмөр	кг	110000	32185.32	0.29	350.8	38587945.7	39.91	0.3270			
	7602.00.00	Хөнгөн цагааны хаягдал ба өөдөс	кг	600	294.00	0.49	587.5	352485.4	23.83	0.0030			
		Сарын дүн						117998606.7			53.8	2.09	280.1
2004.10	4403.20.00	Гуалин мод /бм урттай/	м3	68.74	2740.66	39.87	48020.2	3300905.7	312.37	0.0105			
	7204.29.10	Хуучин зам төмөр	кг	188743	21619.30	0.11	138.0	26038717.3	18.12	0.0828			
	7204.29.90	Хаягдал хар төмөр	кг	296650	15563.00	0.05	63.2	18744388.5	221.56	0.0596			
	7204.49.00	хар төмөрлөгийн хаягдал ба өөдөс	кг	2027383	216119.30	0.11	128.4	260298407.3	109.04	0.8277			
	7204.50.00	Хаягдал лааз	кг	12000	4200.00	0.35	421.5	5058564.0	33.21	0.0161			
	7602.00.00	Хаягдал хөнгөн цагаан	кг	800	880.00	1.10	1324.9	1059889.6	10.57	0.0034			
		Сарын дүн						314500872.4			108.8	5.58	44.7
2004.11	4403.20.00	Гуалин мод /бм урттай/	м3	368.67	14397.36	39.05	47260.9	17423685.1	317.39	0.1645			
	4407.99.00	Цонхны хүрээ мод /шүдэн углуургаар холбосон бэлдэц мод/	м3	10.74	5481.89	510.42	617707.9	6634183.3	24.28	0.0626			
	7204.29.10	Хуучин зам төмөр	кг	76739	9624.90	0.13	151.8	11648054.0	16.47	0.1099			
	7204.49.00	Хаягдал хар төмөр	кг	384530	49880.88	0.13	157.0	60365841.0	89.18	0.5698			
	7302.10.00	Зам төмөр /хуучин/	кг	128000	5760.00	0.05	54.5	6970752.0	642.69	0.0658			
	7404.00.10	Зэсийн хаягдал	кг	3000	2400.00	0.80	968.2	2904480.0	154.93	0.0274			
		Сарын дүн						105946995.3			152.9	1.88	160.1
2004.12	4403.99.00	Дүнзэн мод / бэлдсэн тайрдас/	м3	16.14	17640.00	1092.94	1324388.0	21375622.8	11.33	0.2486			
	4407.10.10	Цэвэр банз	м3	27	2160.00	80.00	96941.6	2617423.2	154.73	0.0304			
	4407.10.90	Палкан мод	м3	150.48	12038.40	80.00	96941.6	14587772.0	154.73	0.1697			
	7204.29.10	Хуучин зам төмөр	кг	57918	6702.80	0.12	140.2	8122252.0	17.83	0.0945			
	7204.49.00	Хаягдал хар төмөр	кг	569590	32236.05	0.06	68.6	39062678.3	204.14	0.4543			
	7204.50.00	Хаягдал лааз	кг	500	175.00	0.35	424.1	212059.8	33.01	0.0025			
		Сарын дүн						85977807.98			128.3	1.53	85.6
		Жилийн дүн						5637531911.31			64.7	1.00	70.8

Хавсралт 4. Импортын барааны гаалийн дундаж тарифын хэмжээний тооцоо

Он	Онцгой тах-н орлого /сая.төг/				Тусгай зориулалтын орлого /сая.төг/				Импортрийн дүн /мян. Ам.дол/				Нийт импор- тийн дүн /мян.ам.дол/
	Бензин, түлш	Архи, пиво, тамхи	СА.машин	Бензин, түлш	Өөрөө явагчийн тах	Нийт	Бензин, түлш	Архи, пиво, тамхи	СА.машин	Төмс, хүнсний ногоо	Гурил	Бусад	
1995	3277.8	823.1	1904.6	1368.6	3273.2	54244.4	2887	31351.1	834.4	8898.4	317084.8	415300	
1996	3867.4	1476.4	2666.4	1916.1	4582.5	56253.4	2908.7	16295	1722.3	27196.8	346523.8	450900	
1997	7023	3107.5	2813.7	2022.0	4835.7	57939.0	6967.2	10868.7	2111.3	18118.6	372295.2	468300	
1998	9522.4	3819.4	2258.7	3712.7	2668.0	57794.3	10344.2	29135.2	2090.9	10590.5	393344.9	503300	
1999	8819.4	3698.6	3054	3975.4	2856.7	59635.9	5887.4	17056	1261.9	6099.8	422859.0	512800	
2000	13404.9	4470	7245.3	4141.2	2975.8	7117	95999.7	10636.3	30901.2	2037.3	16932.4	484993.1	641500
2001	16626.2	6183.9	7332	5454.5	3437.5	8892	117904.5	8789.3	5424.2	2587.1	17567.8	485427.1	637700
2002	18266.3	6431.6	6028.2	4850.3	3745.3	8595.6	102088.4	10082.7	5752.4	4450.3	16111.7	552314.5	690800
2003	21254.1	6986	10549.6	5703.1	3983.6	9686.7	128438.4	11773.7	38467.9	5424.2	12643.8	604252.0	801000
2004	24808.9	7357.6	14733.1	6107.4	4778.7	10886.1	195087.2	10993.4	47849.7	5752.4	17854.4	734062.9	1011600

Он	Бараануудын жилийн дундаж тах /Импортрийн тах-н орлогын импортод эзлэх хувь/				Бараануудын импортрийн нийт импортод эзлэх хувь				Импортрийн дундаж тах/ жилээр/	Стандарт хазайлт				
	Бензин, түлш	Архи, пиво, тамхи	СА. машин	Төмс, хүнсний ногоо	Гурил	Бусад	Бензин, түлш	Архи, пиво, тамхи			СА. машин	Төмс, хүнсний ногоо	Гурил	Бусад
1995	9.6	28.5	0.0	15.0	15.0	15.0	0.1	0.007	0.075	0.002	0.021	0.764	13.3	4.8
1996	11.6	50.8	0.0	15.0	15.0	15.0	0.1	0.006	0.036	0.004	0.060	0.769	14.3	5.0
1997	17.0	44.6	4.8	3.8	3.6	3.9	0.1	0.015	0.023	0.005	0.039	0.795	6.1	7.0
1998	22.9	36.9	7.8	3.0	3.8	0.0	0.1	0.021	0.058	0.004	0.021	0.782	3.9	9.1
1999	21.5	62.8	17.9	7.7	8.3	3.5	0.1	0.011	0.033	0.002	0.012	0.825	6.8	9.1
2000	18.3	42.0	23.4	10.6	11.0	7.0	0.1	0.017	0.048	0.003	0.026	0.756	10.2	7.4
2001	18.7	70.4	135.2	10.6	11.0	7.0	0.2	0.014	0.009	0.004	0.028	0.761	11.3	14.9
2002	22.6	63.8	104.8	9.6	9.9	5.0	0.1	0.015	0.008	0.006	0.023	0.800	9.4	13.3
2003	21.0	59.3	27.4	9.6	9.9	5.0	0.2	0.015	0.048	0.007	0.016	0.754	9.5	10.2
2004	15.8	66.9	30.8	9.6	9.9	5.0	0.2	0.011	0.047	0.006	0.018	0.726	9.1	9.6

Хавсралт 5. Гаалийн тарифын жилийн дундаж хэмжээ, стандарт хазйлтын тооцоо

Он	Гадаад худалдааны дундаж татвар, хувиар		Гаалийн татвартай гадаад худалдаа, сая доллараар		Нийт эргэлтэд эзлэх хувь		Гадаад худалдааны татварын стандарт хазйлт				
	Экспортын жилийн дундаж татвар	Импортын жилийн дундаж татвар	Экспорт	Импорт	Нийт	Импорт	Экспортын жилийн дундаж татварын стандарт хазйлт	Импортын жилийн дундаж татварын стандарт хазйлт			
1995	0.00	13.25	25.6	415.3	440.9	0.06	0.94	12.5	0	4.81	4.5
1996	9.01	14.27	35.9	450.9	486.8	0.07	0.93	13.9	9.39	5.03	5.4
1997	9.55	6.13	53.4	468.3	521.7	0.10	0.90	6.5	10.76	6.96	7.3
1998	1.62	3.93	42.5	503.3	545.8	0.08	0.92	3.7	4.61	9.07	8.7
1999	41.69	6.82	25.6	512.8	538.4	0.05	0.95	8.5	32.02	9.13	10.2
2000	15.62	10.18	28.5	614.5	643.0	0.04	0.96	10.4	24.94	7.43	8.2
2001	20.84	11.26	4.4	637.7	642.1	0.01	0.99	11.3	22.27	14.93	15.0
2002	73.55	9.44	1.6	690.8	692.4	0.00	1.00	9.6	24.30	13.29	13.3
2003	22.60	9.55	12.1	801.0	813.1	0.01	0.99	9.7	35.68	10.18	10.6
2004	64.69	9.10	4.8	1011.6	1016.4	0.00	1.00	9.4	70.82	9.59	9.9

Хавсралт: Хүлээгдэж буй худалдааны секторын хэмжээний эконометрикийн судалгаа

Өмнө өгүүлсэн регрессийн тэгшитгэлийн хувьсагчдаас ганц *DADS* хувьсагчийг мэдээллийн дутагдлаас шалтгаалан тухайн орнуудын худалдааны тэнцүү чанарын индексээр илэрхийлэгдсэн Үндэсний Нийт Орлогоор төлөөлүүлэн авсан. Бусад хувьсагчид нь загварт авагдсан үзүүлэлтүүд болно. Бид эконометрик загварын регрессийн тэгшитгэлийн параметруудийг үнэлж, худалдааны секторын хүлээгдэж буй хэмжээг тооцоходоо худалдааны секторын бодит хэмжээ, хөдөлмөрийн насны хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, Үндэсний нийт бүтээгдэхүүний мэдээг Дэлхийн банкны

- www.devdata.worldbank.org/hnpstats/query/default.html,
- www.worldbank.org/data/wditext/section5.htm

хаягаас, далайн эргийн уртын талаарх мэдээллийг

- www.geographer.pwp.blueyonder.co.uk/development.htm
- www.library.cornell.edu/olinuris/ref/maps/refsas.htm
- www.geography.about.com/library/maps/blindex.htm

хаягаас авч, нийт 124 орны 1999-2003 оны 5 жилийн холимог өгөгдлийг ашигласан. Фрейзер институт нийт 123 орны 1980-2002 оны жилийн мэдээллийг ашиглан үнэлсэн байсан. Мэдээллээ Дэлхийн банкны 2003 *World Development Indicators CD-ROM*, CIA-ийн *World Factbook*-аас авдаг байна.

Бидний түүврийн хэмжээ болоод түүвэрт багтсан орнууд Фрейзер институтынхаас бага зэрэг ялгаатай. Ийнхүү ялгаатай байгаа нь зөвхөн мэдээллийн олдцоос шалтгаалсан гэдгийг тэмдэглэе. Гэхдээ үнэлгээний ерөнхий аргачлалын хувьд Фрейзерийнхтэй ижил юм. Анхны үнэлгээний дараа регрессийн үлдэгдэл санамсаргүй хэмжигдэхүүний утга нилээд хазайлттай, энэ нь жил бүр давтагдаж буй орнуудын хувьд тусгай дамми хувьсагч оруулж, үнэлгээний хувьд үүсч болзошгүй

хетероскедастикийн асуудлыг шийдсэн. Үүний үр дүнд регрессийн загварын найдвартай байдал нилээд сайжирсан.

Дараах хүснэгтэд бидний түүвэрт Фрейзер институтынхаас ялгаатай нэмж орсон орнуудын жагсаалт, Фрейзер институтынхаас түүвэрт оролцоогүй орнуудын жагсаалтыг оруулав.

Хүснэгт 1. Ялгаатай түүвэрлэгдсэн орнуудын жагсаалт

Д.д	Фрейзер институтийн түүврээс үнэлгээнд оролцоогүй орны жагсаалт	Бидний нэмж авсан орнуудын жагсаалт
1	Австри	Ангол
2	Бахамас	Армян
3	Бахрян	Азербайжан
4	Барбадос	Беларус
5	Канад	Босни Герцеговин
6	Конг	Буркино Фасо
7	Кипр	Кампож
8	Гуяна	Капе Верде
9	Хайти	Коморос
10	Унгар	Эритри
11	Ирланд	Этиоп
12	Кени	Гамбия
13	Кувейт	Гүрж
14	Латви	Казахстан
15	Мали	Киргиз
16	Мальт	Лаос
17	Мянмар	Лесодо
18	Нидерланд	Македон
19	Шинэ Зеланд	Мавритан
20	Никрагуа	Молдав
21	Оман	Монгол
22	Португал	Мозамбек
23	Сингапур	Саудын Араб
24	Өмнөд Солонгос	Серб Монтенегро
25	Швейцарь	Соломоны арлууд
26	Тайван	Сомали
27	Арабын Нэгдсэн Улс	Судан
28	Замб	Тажикстан
29	Зимбабве	Узбекстан

Худалдааны секторын хүлээгдэж буй утгын үнэлгээний үр дүнг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Олон Улсын худалдааны секторын хүлээгдэж буй утгын үнэлгээ

Dependent Variable: LOG(TRSHARE)				
Method: Least Squares				
Included observations: 620				
Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	6.474106	0.185954	34.81567	0.0000
LOG(WPOP)	-0.142259	0.009740	-14.60597	0.0000
LOG(SIZE)	-0.025478	0.005844	-4.359373	0.0000
LOCK	0.099875	0.032268	3.095154	0.0021
TREND	0.019076	0.008589	2.220991	0.0267
COAST	8.49E-06	1.92E-06	4.425539	0.0000
LOG(GNI1)	0.029947	0.012451	2.405175	0.0165
HONG	1.188680	0.140339	8.470044	0.0000
ANGOL	0.844850	0.136846	6.173712	0.0000
ARGEN	-0.741884	0.137392	-5.399769	0.0000
BURUND	-1.095929	0.138951	-7.887153	0.0000
CENTAF	-0.967478	0.138757	-6.972478	0.0000
JAPAN	-1.145898	0.144148	-7.949460	0.0000
MALAYS	1.027812	0.141616	7.257716	0.0000
RWANDA	-0.921407	0.138137	-6.670219	0.0000
SUDAN	-0.716677	0.137469	-5.213386	0.0000
COMOROS	-0.991410	0.139728	-7.095285	0.0000
BRAZIL	-0.551177	0.138864	-3.969183	0.0001
FASO	-0.808441	0.138123	-5.853032	0.0000
LUXEM	0.897406	0.151438	5.925884	0.0000
SOUTHAF	0.756160	0.137961	5.480953	0.0000
SPIAN	0.644804	0.137825	4.678429	0.0000
THAILAND	0.799823	0.137088	5.834376	0.0000
UKRIAN	0.676437	0.136738	4.946938	0.0000
US	-0.705015	0.142313	-4.953979	0.0000
URUG	-0.711481	0.136448	-5.214304	0.0000
R-squared	0.668806	Mean dependent var	4.278531	
Adjusted R-squared	0.654867	S.D. dependent var	0.513446	
S.E. of regression	0.301639	Akaike info criterion	0.481862	
Sum squared resid	54.04591	Schwarz criterion	0.667625	
Log likelihood	-123.3774	F-statistic	47.98040	
Durbin-Watson stat	1.814805	Prob(F-statistic)	0.000000	

Дээрх үнэлгээний үлдэгдэл санамсаргүй хэмжигдэхүүний утга, үнэлэгдсэн эндоген хувьсагчийн утга буюу олон улсын худалдааны секторын хүлээгдэж буй утгын тусламжтай Фрейзер институтын индексийг тооцоход дараах байдлаар илэрхийлэгдэж байна. Хүснэгт 2-т тухайн улсуудтай холбоотой гажилтыг арилгах зорилгоор оруулсан дамми хувьсагчдыг тэр улсын нь нэрээр нэрлэв. Тухайлбал HONG гэсэн хувьсагч нь Гонконгийн онцлогийг илэрхийлсэн дамми хувьсагч болно.

Бүлэг 4



Монгол Улсын банкны
зээлийн салбар,
хөдөлмөрийн зах зээл
болон бизнесийн эдийн
засгийн эрх чөлөөний
индекс

4.1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА: МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ЗЭЭЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН БИЗНЕСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ СУДАЛГАА

Уг судалгааны ажил нь Нээлттэй Нийгэм Форумын санаачлага, удирдлагын дор хийгдсэн бөгөөд судалгааны гол зорилго нь Монгол Улсын банкны зээлийн салбар дахь эдийн засгийн эрх чөлөөний байдлыг судалж, дэлхийд алдаршсан Фрейзер институтын эдийн засгийн эрх чөлөөний индексийн аргачлалыг үндэслэн тус салбарын эдийн засгийн эрх чөлөөг хэмжиж, тоон үзүүлэлтээр илэрхийлж тайлбарлах, олон улсын түвшинд харьцуулалт хийхэд оршино.

Судалгааны хүрээнд Монгол Улсын банкны зээл, хөдөлмөрийн зах зээл болон бизнесийн эдийн засгийн эрх чөлөөг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартын дагуу судалсан. Эдгээр зах зээлүүд өнөөгийн Монгол улсын эдийн засгийн хөгжилд хамгийн их нөлөөтэй салбар, зах зээлүүд мөн гэж хэлж болно. Эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйлс бол хөдөлмөр ба капитал байдаг бол, тэдгээрийг эдийн засгийн эргэлтэд оруулах дүрмийг нь бизнесийн зохицуулалтын бодлогоор тогтоодог. Тэгэхээр энэ судалгаа бол эдийн засгийн гол хүчин зүйлсийн зах зээл, Эх сурвалжүүд Монгол Улсад хэрхэн чөлөөтэй ажиллаж байгаа, хувийн хэвшлийн бизнесийн үйл ажиллагаа хэрхэн чөлөөтэй байгааг хамарсан.

Судалгааны баг эдийн засгийн эрх чөлөөний индексийг зээлийн салбарт, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, бизнесийн зохицуулалтыг Фрейзер институтын аргачлалаар тооцохоос гадна, Монгол Улсад зээлийн хүү өндөр байгаа шалтгаанууд, зээлийн тогтолцооны гажигтай болон дутагдалтай талуудыг гүнзгийруулэн судлах, Фрейзерийн индексийн аргачлалыг Монголын өнөөгийн байдалд нийцүүлэн боловсронгуй болгох, тус индексээр илэрхийлэх боломжгүй Монголын зах зээлийн онцлогийг тусгах нэмэлт судалгаа хийх зэрэг зорилготой ажилласан.

Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, олон жилийн туршид боловсруулагдаж ирсэн Фрейзерийн эдийн засгийн эрх чөлөөний индексийг Монгол Улсад тооцож жил болгон гаргах нь Монгол Улсын эдийн засгийн

либералчлалын явц, эдийн засгийн эрх чөлөөний байдлыг бодитойгоор харуулах, оновчтой төрийн бодлого боловсруулахад онол практикийн өндөр ач холбогдолтой байх болно.

Судалгааны тайлан дараах бүтэцтэй байгаа юм: 1, 2, 3-р хэсэг нь тус судалгааны товч танилцуулга, судалгааны зорилго, судалгааны аргачлал, 5-9-р хэсэг банкны зээлийн салбарын, 10-13-р хэсэг хөдөлмөрийн зах зээлийн, 14-16-р хэсэг бизнесийн зохицуулалтын судалгаа, 17-р хэсэг дүгнэлтийг агуулсан байгаа.

4.2. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгааны баг Монголын эдийн засгийн эрх чөлөөг хэмжихдээ Фрейзер Институтын аргачлалыг ашиглан эрх чөлөөний индексийн 5-р гол хэсэг болох “Бизнес, Хөдөлмөр, Зээлийн” хэсгүүдийн эдийн засгийн эрх чөлөөний индексийг 1995, 2000-2004 оноор 0-ээс 10 хүртэлх түвшнээр, тус бүрийг 5 дэд үзүүлэлтээр тооцож гаргасан. Үүнд банкны зээлийн салбарт:

- Банкны өмчлөл
- Өрсөлдөөн
- Хувийн хэвшилд олгосон зээл
- Зээлийн хүү сөрөг түвшинд байх
- Банкны хүүгийн хяналт,

Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг хэмжихэд:

- Хөдөлмөрийн хөлсний доод түвшингийн нөлөө
- Ажилд авах болон ажлаас халах процесс
- Цалин нь төвлөрсөн хамтын хэлэлцээрээр тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь
- Ажилгүйдлийн тэтгэмж
- Цэргийн алба,

Бизнесийн үйл ажиллагаа хэр зэрэг эрх чөлөөтэй байгааг дараах таван үзүүлэлтээр:

- Үнийн хяналт
- Төрийн зохицуулалт ба шинэ бизнес
- Хэлэлцээр хийхэд зарцуулж буй хугацаа
- Шинээр бизнес эрхлэх
- Нэмэлт төлбөр

Зах зээл болгон дахь эдийн засгийн эрх чөлөөг хэмжиж, эцэст нь нэгдсэн дүгнэлтийг хийсэн.

Индексийн утга 0 рүү ойртох тусам эрх чөлөө байхгүй, 10 руу ойртох тусам өндөр эрх чөлөөтэй байгааг харуулдаг. 5 үзүүлэлтийн индексийг тус бүрд нь тооцсоны эцэст арифметик дунжийг нь тооцоолон зээлийн зах зээл дэх эдийн засгийн эрх чөлөөний нэгдсэн индексийг гаргасан.

Судалгааны зорилгын дагуу, зээлийн зах зээлийн 5 үзүүлэлт болгоны индексээр болон нэгдсэн индексээр Монгол улс зарим шилжилтийн болон өндөр хөгжилтэй, хөгжиж буй орнуудтай харьцуулахад ямар түвшинд байгааг харуулсан.

Ийнхүү Фрейзер Институтын аргачлалаар Монгол улсад эдгээр зах зээл дээрх эрх чөлөө ямар түвшинд байгааг харуулсны дараа тус аргачлал, индексээр илэрхийлэх боломжгүй, онцлогуудыг тусгасан нэмэлт судалгааг хоёрдогч Эх сурвалжт тулгуурлан, нэмэлт үзүүлэлтүүдийг оруулан дахин тооцох, ажиглалт, статистикийн харьцуулалт, дүгнэлт, шинжилгээ, төв болон арилжааны банкуудын ажилтнуудтай уулзалт, ярилцлага хийх зэрэг аргуудыг ашиглан хийсэн.

Нэмэлт судалгаагаар¹⁸ бид зээлийн зах зээл дээрх эрх чөлөөний индексийг илүү тод харуулж чадах хүчин зүйлсийг санал болгон дэвшүүлсэн бөгөөд санал болгож байгаа эдгээр үзүүлэлтүүдийг уг зах зээлийн бүх онцлогийг харуулсан бүрэн үзүүлэлтүүд гэж үзэхгүй байна. Гэхдээ энэ чиглэлээр хийгдэх судалгаанд суурь болох гол үзүүлэлтүүдийг оруулж өгсөн нь ирээдүйд хийгдэх судалгааг сайжруулж, баяжуулж өгч байгаагаараа ач холбогдолтой юм.

4.3 МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ЗЭЭЛИЙН САЛБАР ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ СУДАЛГАА

Зах зээлийн эдийн засаг руу шилжилт эхэлснээс хойш Монгол Улсад арилжааны банкны салбар

¹⁸ - Нэмэлт хүчин зүйлсийг оруулан тооцсон индексийн утгууд Фрейзер Институтын аргачлалаар тооцсон индексийн утгуудаас доогуур гарч байна. Үүний гол шалтгаан нь хэмжилт, аргачлалд оршихоос илүү Монгол Улсад хувийн хэвшил, зээлийн зах зээл хөгжиж эхлээд удаагүй байгаатай холбоотой юм.

идэвхтэй хөгжиж, банкны зээл, хадгаламжийн зах зээлүүд ихээхэн өргөжиж ирсэн бөгөөд өнөөдөр 17 арилжааны банк тус салбарт өрсөлдөж байна. Монгол Улсад хөрөнгийн зах зээлийн бусад салбарууд сул хөгжсөн учир банкны зээл нь хувийн хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагааны санхүүжилтийн гол Эх сурвалж болсон байна. Банкны зээл ийнхүү улсын хөгжилд нөлөө ихтэй салбар болсны улмаас тус салбарын үйл ажиллагаа нээлттэй, шударга өрсөлдөөн давамгайлсан байх тусмаа улсын эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх нь гарцаагүй байгаа юм.

Тус судалгааны гол зорилго нь банкны зээлийн салбар дахь өрсөлдөөн, өмчлөл, хүүгийн бүтэц, банкны хүүгийн төрийн хяналтын байдлыг судалж, Фрейзер Институтын аргачлалыг үндэслэн тус салбар дахь эдийн засгийн эрх чөлөөний түвшинг тооцож тусгай индексээр илэрхийлэхэд оршиж байгаа юм. Фрейзер Институтын банкны зээлийн салбар дахь эдийн засгийн эрх чөлөөний индексийг *банкны өмчлөл, гадаад ба дотоодын банкуудын хоорондох өрсөлдөөн, хувийн хэвшилд олгосон зээлийн хувь, зээлийн хүү сөрөг түвшинд байгаа эсэх, банкны хүүгийн төрийн хяналт* зэрэг 5 дэд үзүүлэлтээр тооцдог. Тус индексийн үзүүлэлт нь 0-10 хооронд байдаг бөгөөд 10-тай тэнцүү байвал тус үзүүлэлт эдийн засгийн маш их чөлөөтэй байдлыг харуулж, 0-тэй тэнцүү байвал огт эрх чөлөөгүй байдлыг илэрхийлж байна.

Судалгааны дүнгээс харахад, сүүлийн жилүүдэд Монголд идэвхтэй явагдсан банкны хувьчлалын үр дүнд банкны зээлийн салбар дахь Фрейзерийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн үзүүлэлт нь 2000 онд 5.5 —тай тэнцүү байсан бол 2004 онд 6.9 хүртэл өсч сайжирсан байна. Эдийн засгийн эрх чөлөөний индекс сүүлийн жилүүдэд ийнхүү сайжран гарч байгаа шалтгаан гэвэл Монгол дахь хувийн, түүний дотор гадаадын банкуудын нийт банкны системд эзлэх хувь нь сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч, улсын болон төрийн оролцоотой банкуудын нийт жин нь их багассан байна. Монголын төр, засгийн газрын зүгээс арилжааны банкуудын хадгаламж зээлийн хүүг тодорхой түвшинд тогтоох, барих талаар тусгай хууль, дүрэм журам гаргаж байгаагүй, хүү зах зээлийн хүчээр зохицуулагдаж ирсэн гэж хэлж болно.

Гэвч бодит амьдралд банкны хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү их, зээлийн хүү тогтвортой өндөр байгаа, зээл их хэмжээгээр нэг жилээс дээш хугацаагаар олдохгүй байгаагийн цаана эдийн засгийн эрх чөлөө, түүний дотор зээлийн эрх чөлөө боогдмол байна гэж үзэж болно. Монгол Улсад олгогдож байгаа нийт зээлийн дөнгөж 20-иос илүү хувь нь 1 жилээс дээш хугацаатай зээл байгаа явдал, зээлийн хүү дунджаар 30%, дээд тал нь жилийн 48% хүрч байгаа нь хувийн хөрөнгө оруулалтыг ихээхэн хязгаарлаж, эдийн засгийн өсөлтөд маш сөрөг нөлөө үзүүлж байна. 2000–2004 онуудад банкны өмчлөлийн хүрээнд бий болсон нааштай өөрчлөлтүүд буюу хувийн банкуудын эрчимтэй өсөлт болон төрийн банкуудын хувьчлал нь хувийн хэвшилд олгох зээл, хүүгийн хяналтын байдалд эерэг нөлөө үзүүлээгүй байна. Гадаадын хөрөнгө орсон банкны тоо өссөн мэт харагдаж байгаа боловч орчин үеийн технологи, ноу-хау гадаадын хөрөнгийг дагаж банкны салбарт орж ирэхгүй байна, гадаадын том банкууд Монголын зах зээлд орж ирээгүй хэвээр л байна.

Тийм учраас судалгааны баг Фрейзер Институтын аргачлалаар тооцоо хийхээс гадна Монгол Улсын банкны салбарын онцлогийг тусгах, дээрх асуудлыг илүү гүнзгийрүүлэн судлах үүднээс нэмэлт судалгаа хийж, тус тайланд оруулсан болно.

Зээлийн эдийн засгийн эрх чөлөөний байдал Монгол Улсын хөгжилд маш өндөр ач холбогдолтой байгааг тэмдэглэх нь зүйтэй. Өнөөдөр Монгол Улсад хөрөнгийн зах зээл сул хөгжсөний улмаас хувийн хөрөнгө оруулалт, нийт эдийн засгийн байдал банкны зээл, банкны салбарын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай болсон байна. Гэтэл өнөөгийн нөхцөлд Монгол Улсад олгогдож байгаа нийт зээлийн 27% нь л 1 жилээс дээш хугацаатай зээл байгаа явдал, зээлийн хүү жилийн 48% хүрч байгаа нь хувийн хөрөнгө оруулалтыг ихээхэн хязгаарлаж, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.

Судалгааны баг банкны зээлийн зах зээлийн эдийн засгийн эрх чөлөөг хэмжихдээ дэлхийн хүн амын 91% нь амьдардаг 123 орныг хамарсан, жил тутам гаргадаг Фрейзер институтын эдийн засгийн эрх чөлөөний индексийн аргачлалыг

ашигласан болно. Тус индекс улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөний байдлыг 38 үзүүлэлтээр хэмждэг.

Судалгааны хэсэг 5 дэд индексийн хэсгээс бүрдэж байгаа бөгөөд үүнд Фрейзерийн индексийг банкны өмчлөл, банкны өрсөлдөөн, хувийн секторт олгож буй зээл, зээлийн хүү сөрөг байгаа эсэх, зээлийн хүү зах зээлээр тодорхойлогдож буй эсэхийн судалгааны дэд хэсгүүд орсон. Дэд хэсгийн судалгааны хэсэг болгон өөрөө дараах бүтэцтэй байгаа:

- Тухайн дэд индексийн үзүүлэлтийн тодорхойлолт болон Монгол Улс дахь тухайн салбарын түүх,
- Монгол Улс дахь Фрейзерийн индексийн үзүүлэлтийн тооцоо, харьцуулалт
- Монгол Улсын онцлогийг харуулсан тус салбар болон сэдэвт хамаарах нэмэлт судалгаа, тайлбарын хэсгээс бүрдсэн болно.

4.3.А. Банкны өмчлөлийн тухай

Тодорхойлолт

Монгол Улс зах зээлд шилжиж эхэлсэн 1991 онд анх хоёр шатлалтай банкны тогтолцоо үүсэж эхэлсэн бөгөөд тэр үеэс эхлэн төв болон хувийн банкуудыг зааглан тодорхойлсон.

1996 оны 9-р сарын 3-нд баталсан Монгол Улсын Банкны тухай хууль-д *аж ахуйн банкныг дараах байгууллага “Хувь нийлүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн дүрмийн сантай, хувь нийлүүлэгчид нь оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо зэрэг санхүүгийн зуучлалын ажил үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг Монгол Банкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээд”* гэж тодорхойлсон.

Банкны өмчлөлийг авч үзэхдээ тус хуулийн 4-р зүйлд банкны дүрмийн сан, түүний эзэмшигчдийн тухай: *“4 дүгээр зүйл. Банкны төрөл. Банк нь дүрмийн сангийн өмчлөлөөр төрийн, хувийн болон холимог... байж болно”* гэсэн заалтыг үндэс болгодог.

Иймээс Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкуудыг дүрмийн сангийн өмчлөлөөс

шалтгаалан 3 төрлийн өмчийн хэлбэрийн гэж үзнэ:

1. *Төрийн* (дүрмийн сангийн өмчлөгч нь төр)
2. *Хувийн* (дүрмийн сангийн өмчлөгч нь дотоодын ба гадаадын хувийн хувь нийлүүлэгчид)
3. *Холимог* (дүрмийн сангийн өмчлөгч нар нь төр ба хувийн хувь нийлүүлэгчид аль аль нь байгаа нөхцөлд)
4. Хуулинд заагаагүй боловч хувийн өмчлөгч нь дотоодын болон гадаадын байж болох учраас банкны мөн улсын харьяалаар нь *дотоодын* ба *гадаадын* гэж 2 ангилж болно.

Нэгэнт банкны өмчлөлийн хэлбэрийг түүний дүрмийн сангийн өмчлөл нь тодорхойлж байгаа учраас дүрмийн сангийн өөрчлөлттэй холбоотой зүйлсийг тус хуулиар дараах байдлаар зохицуулдаг.

27 дугаар зүйл. Банкны өөрийн хөрөнгө

2. *Дүрмийн сан нь банкны гишүүдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 1 тэрбум төгрөг байна. Дүрмийн сангийн хэмжээг улсын эдийн засгийн байдал, мөнгөний ханш уналт, тухайн банкны төлбөрийн чадвар, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монгол Банк нэмэгдүүлэн тогтоож болно.*
9. *Банкны хувь нийлүүлэгч дүрмийн санд оруулсан хөрөнгөө Монгол Банкны зөвшөөрлөөр худалдах, өв залгамжлах, бэлэглэх, гэрээслэхээс өөрөөр буцааж авахыг хориглоно. Хувь нийлүүлэгч нь дүрмийн санд оруулсан хөрөнгөө худалдах, өв залгамжлуулах, бэлэглэх, гэрээслүүлэхээр байгуулсан гэрээ нь хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон бол Монгол Банк зохих зөвшөөрлийг олгохгүй байх эрхтэй. Дүрмийн санд оруулсан хөрөнгийг худалдсанаас гишүүдийн бүтцэд орсон өөрчлөлт нь банкны тухай хууль тогтоомжид харшилж байвал Монгол Банк зохих зөвшөөрлийг олгохгүй байх эрхтэй. Хууль тогтоомж зөрчиж дүрмийн санг бүрдүүлсэн нь шүүхийн шийдвэрээр*

нотлогдсон бол гэмт үйлдлийн улмаас учирсан хохирлыг дүрмийн санд оруулсан хөрөнгөөр барагдуулах, Монгол Банкнаас эрх хүлээн авах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд банкны алдагдлыг дүрмийн сангаас хаах нь үүнд тус тус хамаарахгүй.

11. Банкны дүрмийн сангийн бүтэц, гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах бүрд Монгол Банкнд мэдэгдэж зөвшөөрөл авна. Дүрмийн санг нэмэгдүүлэх, хорогдуулах шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журмыг Монгол Банк тогтооно.”

Ийнхүү банкны дүрмийн сан болон түүний өмчлөлийг өөрчлөхтэй холбоотой бүх алхмуудыг энэ хууль болон холбогдох Монгол Банкны журмаар зохицуулна гэж тодорхойлсон байгаа.

Фрейзер Институтын аргачлалаарх тооцоолол (1995, 2000-2004)

Фрейзерийн индексийг банкны өмчлөлийн хүрээнд тооцоход хувийн банкин дахь хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь нь голч үзүүлэлт болдог.

Фрейзерийн индексийн банкны өмчлөлийн (хадгаламжийн хувийн) индексийг дараахи үзүүлэлтээр тооцно. Хэрэв хувийн банкин дахь хадгаламжийн хувь нийт хадгаламжийн дотор

- i. 95%-100% байвал, индексийн үзүүлэлт 10,
- ii. 75-95% бол индексийн үзүүлэлт 8,
- iii. 40-75% бол индексийн үзүүлэлт 5,
- iv. 10-40% бол 2 ба түүнээс доош тохиолдолд 0-той тэнцүү байна.

Тэгэхээр үүнийг тооцохын тулд Монгол Улсын банкны өнөөгийн байдлыг авч үзье. 2004 оны байдлаар Монгол Улсад 17 банк бүртгүүлсэн байсан бөгөөд эдгээр 17 арилжааны банкаас

1. төрийн өмчит 1,
2. төрийн өмчийн оролцоотой 2,
3. хувийн 14 банкууд байв.
 - a. гадаадын хөрөнгө оруулалттай хувийн 4,
 - b. бусад хувийн (БХ) 10 банк байна.

Банкны нэрээр нь Хүснэгт 4.3.1.1-ээс үзэхэд: (Хүснэгт 4.3.1.1.)

Хүснэгт 4.3.1.1. 2004 оны байдлаар Монгол Улсын банкны өмчлөлийн бүтэц

Банк	Өмчлөл
Хадгаламжийн Банк	төрийн өмчит (100% төрийн)
Капитал Банк	төрийн өмчийн оролцоотой (8.8% төрийн)
Улаанбаатар Хотын Банк	төрийн өмчийн оролцоотой (20.0% төрийн)
Менатеп Банк	(гадаадын хөрөнгө оруулалттай) хувийн (100% гадаадын)
Хөдөө Аж Ахуйн Банк	(гадаадын хөрөнгө оруулалттай) хувийн (60.0% гадаадын)
Худалдаа Хөгжлийн Банк	(гадаадын хөрөнгө оруулалттай) хувийн (76.0% гадаадын)
Чингис Хаан Банк	(гадаадын хөрөнгө оруулалттай) хувийн (100% гадаадын)
Монгол Шуудан Банк	хувийн (100% дотоодын)
Голомт Банк	хувийн (100% дотоодын)
Эрэл Банк	хувийн (100% дотоодын)
Тээвэр Хөгжлийн Банк	хувийн (100% дотоодын)
Кредит Банк	хувийн (100% дотоодын)
Анод Банк	хувийн (100% дотоодын)
Зоос Банк	хувийн (100% дотоодын)
Интер Банк	хувийн (100% дотоодын)
Капитрон Банк	хувийн (100% дотоодын)
Хас Банк	хувийн (100% дотоодын)

Эх сурвалж: А. Хулан, «Банкны салбар дахь гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

Хүснэгт 4.3.1.2. Монголын хувийн болон төрийн банкууд дахь хадгаламжийн хувь (банкуудаар)

(Дүн мянган төгрөгөөр)

Банкууд	Хадгаламж 06/30/2000	Нийт хадгаламжид эзлэх хувь 6/30/2000	Нийт хадгаламжид эзлэх хувь		
			Хадгаламж 6/30/2004	6/30/2004	Өсөлт (%)
Нийт хадгаламж	74,263,698.50		444,962,699.46		499.17%
Хадгаламжийн Банк (ТӨ*)	33,008,598.08	44.45%	35,887,569.16	8.07%	8.72%
Хөдөө Аж Ахуйн Банк (Г)	2,451,988.00	3.30%	80,790,130.58	18.16%	3194.88%
Менатеп (Г)		0.00%	0.00	0.00%	
Чингис Хаан Банк (Г)		0.00%	0.00	0.00%	
Худалдаа Хөгжлийн Банк (Г)	16,715,918.36	22.51%	37,933,713.79	8.53%	126.93%
Шинэчлэл / Капитал Банк (ТӨО)	507,893.27	0.68%	6,672,269.13	1.50%	1213.71%
Улаанбаатар Хотын Банк (ТӨО)	126,737.85	0.17%	6,325,285.78	1.42%	4890.84%
Монгол Шуудан Банк (Х)	2,088,535.28	2.81%	31,555,430.74	7.09%	1410.89%
Голомт Банк (Х)	13,695,931.80	18.44%	78,766,106.92	17.70%	475.11%
Эрэл (Х)	365,407.76	0.49%	1,147,033.39	0.26%	213.91%
Тээвэр Хөгжлийн Банк (Х)	904,665.14	1.22%	4,266,323.41	0.96%	371.59%
Кредит Банк (Х-Х)	410,950.54	0.55%	2,828,268.56	0.64%	588.23%
Анод Банк (Х)	3,172,003.87	4.27%	103,995,793.42	23.37%	3178.55%
Зоос Банк (Х)	815,068.56	1.10%	21,077,092.87	4.74%	2485.93%
Интер Банк (Х)			1,574,049.03	0.35%	
Капитрон Банк (Х)			21,145,010.84	4.75%	
Хас Банк (Х)			10,998,621.85	2.47%	

Эх сурвалж: А. Хулан, «Банкны салбар дахь гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

* ТӨ- төрийн өмчийн, Г- гадаадын, Х- хувийн, ТӨО- төрийн өмчийн оролцоотой

Хүснэгт 4.3.1.3. Монголын банк дахь хадгаламжийн бүтэц

(Дүн мянган төгрөгөөр)

	Хадгаламж 06/30/2000	Нийт хадгаламжид эзлэх хувь 6/30/2000	Нийт хадгаламжид		
			Хадгаламж 6/30/2004	эзлэх хувь 6/30/2004	Өсөлт (%)
Нийт хадгаламж	74,263,698.50		444,962,699.46		499.17%
Төрийн өмчит	35,460,586.08	47.75%	35,887,569.16	8.07%	-31.22%
Төрийн өмчийн оролцоотой	19,439,084.76	26.18%	12,997,554.91	2.92%	377.30%
Хувийн (түүний дотор)	19,364,027.70	26.08%	396,077,575.39	89.01%	1945.43%
Гадаадын хөрөнгө оруулалттай			118,723,844.37	26.68%	

Эх сурвалж: А. Хулан, «Банкны салбар дахь гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

Хүснэгт 4.3.1.4 Банкны өмчлөлийн Фрейзерийн индекс Монгол Улсад 2000-2004

	1995	2000	2001	2002	2003	2004
Нийт хадгаламж (сая төгрөг)	-	92686.1	134606.9	218359.6	363497.9	516488.3
Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкууд дахь хадгаламж (сая төгрөг)	-	64781.1	78860.2	112626.2	44491.6	49300.6
Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкууд дахь хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь (хувиар)	-	69.89%	58.59%	51.58%	12.24%	9.55%
Фрейзерийн индексийн тоо	2	2	5	5	8	8

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоо

Банкны өмчлөлийн үзүүлэлтийг Фрейзерийн индексэд нийт хадгаламжийн улсын, хувийн банкин дахь хувиар тооцдог тул Монгол Улсын банкны систем дэхь хадгаламжийн бүтцийг банкуудаар авч үзье. 2000 болон 2004 оны байдлыг харахад (хүснэгт 4.3.1.2), нийт хадгаламжийн хэмжээ бараг 5 дахин өссөн байхад ХААН Банк, Капитрон, УБ Банк, Кредит, Анод ба Зоос банкууд дахь хадгаламжийн өсөлт дунджаас илүү өндөр байна (Хүснэгт 4.3.1.2.).

Фрейзерийн индексийг тооцож үзэхэд 2000 онд Монгол Улсын үзүүлэлт дараах байдалтай байв. Төрийн болон төрийн оролцоотой банкуудад нийт 74 тэрбум төгрөгийн хадгаламжийн 73% хадгалагдаж байсан бол 2004 оны 6-р сарын байдлаар энэ үзүүлэлт нийт хадгаламжийн 444 тэрбум төгрөгийн

48 тэрбум буюу 10.9% орчим хүртэл буурчээ (Хүснэгт 4.3.1.3).

Он оны эцсийн байдлаар тооцож үзэхэд, 2000-2004 онд төрийн өмчийн болон төрийн оролцоотой банкууд дахь хадгаламж нийт хадгаламжид дараах хувийг эзэлж байсан байна.

1995 оны тооны өгөгдлийн олдоц хангалтгүй учраас 1995 оны байдлыг шууд тооцох боломжгүй боловч, банкуудын хувьчлал зөвхөн 2000 оноос хойш идэвхтэй явагдсан, түүнээс өмнө төрийн өмчийн банкууд давамгайлсан байдалтай байсныг харгалзаж 1995 оны эдийн засгийн эрх чөлөөний байдал 2000 оны байдлаас нь зарчмын хувьд ялгаагүй байсан гэж хэлж болно. Тийм учраас 1995 оны Фрейзерийн индексийг 2-той тэнцүү байсан гэсэн таамаглалыг дэвшүүлж байна.

Үр дүн: Фрейзерийн индексийн үзүүлэлт Монгол Улсад 2000 онд 2 байсан бол 2004 оны байдлаар 8 хүртэл сайжирсан гэж үзэж болно. Дараах хүснэгтэд Фрейзерийн Институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн 2004 оны илтгэлээс бусад орнуудын хувьд гарсан үзүүлэлттэй харьцуулан харуулав.

Хүснэгт 4.3.1.5. Олон улсын харьцуулсан дүн

Улс	2002
Канад	10
Гонконг	10
Эстони	10
Латви	10
Сингапур	10
Словак	10
Их Британи	10
АНУ	10
Болгар	8
Чех	8
Чили	8
Унгар	8
Литва	8
Польш	8
Монгол	8
Япон	5
Орос	5
Өмнөд Солонгос	5
Бангладеш	2
Хятад	0

Эх сурвалж: Economic Freedom of the World. 2004 Annual Report

Нэмэлт судалгаа ба индекс: Монголын онцлог байдал

Цэвэр өмчийн хэлбэрээр 2000 онд гадаадын хөрөнгө оруулалттай банк байгаагүй байхад 2004 оны байдлаар хамгийн их активтай 5 банкны 3 нь гадаадын хөрөнгөтэй банкууд болсон байна. 2004 оны 6-р сарын байдлаар эдгээр гадаадын хөрөнгө орсон банкууд нийт банкуудын өөрийн хөрөнгийн 141 тэрбум төгрөгийн дотор 48.92%-ийг эзэлж, нийт дүрмийн сангийн 110 орчим тэрбум төгрөгийн 45%-ийг эзэлсэн байна¹⁹. ОХУ-ын Чингис Хаан банк дангаараа

¹⁹ - А.Хулан, «Банкны салбар дахь гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

нийт банкуудын өөрийн хөрөнгийн 27% эзэлж байгаа, дүрмийн сангаар нь мөн л Чингис Хаан банк нийт банкуудын дүрмийн сангийн 33.2%-ийг бүрдүүлж байна. Цэвэр тоон үзүүлэлтийн талаас харахад гадаадын өмчлөлтэй банкууд нийт банкны системд чухал байр суурийг эзэлсэн байна (Хүснэгт 4.3.1.6).

2000 онтой харьцуулахад, 4 жилийн дотор Монгол Улсын банкны салбарт томоохон өөрчлөлтүүд бий болсон байна: хувийн банкууд илт давамгайлдаг болсон бөгөөд төрийн болон төрийн оролцоотой банкуудын хувь нь активаар үзэхэд илт буурчээ. Энэ бол хувийн банкуудын эрчимтэй өсөлт болон хувьчлалын үр дүн мөн бөгөөд дүндээ банкны салбар дахь төрийн оролцоо багасч байгаагийн нэг илрэл байж болох юм.

Доод хүснэгтэд банкны өмчлөлийн бүтцийг активаар харуулахад, хувийн болон гадаадын банкуудын активын хувь 2000 оноос илт өссөн нь харагдаж байгаа юм.

Гадаадын хөрөнгө орсон банкуудын дотор 2000 оноос хойш актив нь 13 дахин их өссөн ХААН Банк анхаарлыг татаж байна (Хүснэгт 4.3.1.7).

Энэ өөрчлөлтийн гол шалтгаан нь сүүлийн үед төрийн өмчийн банкуудын хувьчлал идэвхтэй явагдсантай холбоотой. Хувьчлалын эцсийн зорилго нь тухайн банкны үйл ажиллагаа сайжирч, нийт бөгөөд гадаадын өмчлөгчтэй болсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт тухайн банкинд нэмэгдэж, банкны өөрийн хөрөнгө, түүний гаргаж байгаа зээлийн хэмжээ нэмэгдэж, нийтдээ үйл ажиллагаа сайжирч, нийт эдийн засагт үзүүлэх нөлөө нь эерэг байх ёстой. Гэхдээ хувьчлагдсан банкуудын дүрмийн сан, хадгаламж, зээл, өөрийн хөрөнгийн өсөлт нь хувийн банкуудын өсөлттэй харьцуулахад хоорондоо их ялгаатай байна.

Ялангуяа ХХБ бол 1990-онуудад Монголын эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэдэг тэргүүний банкуудын нэг байсан. Гэтэл түүний хувьчлал явагдсан 2000-2004 онуудад түүний хадгаламжийн, өөрийн хөрөнгийн, дүрмийн сангийн өсөлтүүд бүгд банкны салбарын дунджаас илт доогуур болж, Монголын банкны систем дахь тэргүүлэх байр сууриа алдаж байна.

Хүснэгт 4.3.1.6

Банкууд	Актив (мянган төг) 06/30/2004	Нийт активт эзлэх хувь 06/30/2004	2000 оны 6-р сарын байдалтай харьцуулсан активын өсөлт (%)
Нийт актив	977,531,679.35		383.63%
Худалдаа Хөгжлийн Банк (Г)	182,044,375.99	18.62%	97.76%
Голомт Банк (Х)	152,855,603.92	15.64%	439.75%
Анод Банк (Х)	133,891,207.90	13.70%	2023.81%
Хөдөө Аж Ахуйн Банк (Г)	119,938,196.23	12.27%	1372.74%
Чингис Хаан Банк (Г)	74,242,156.77	7.59%	
Хадгаламжийн Банк (ТӨ)	61,907,877.48	6.33%	49.74%
Монгол Шуудан Банк (Х)	59,994,485.22	6.14%	569.92%
Зоос Банк (Х)	44,975,435.88	4.60%	1794.63%
Капитрон Банк (Х)	30,467,890.06	3.12%	
Хас Банк (Х)	22,495,365.88	2.30%	
Улаанбаатар Хотын Банк (ТӨО)	20,766,269.51	2.12%	210.66%
Менатеп (Г)	16,220,699.35	1.66%	
Интербанк (Х)	15,383,629.40	1.57%	
Шинэчлэл / Капитал Банк (ТӨО)	14,758,538.97	1.51%	728.58%
Кредит Банк (Х)	10,872,163.53	1.11%	567.94%
Тээвэр Хөгжлийн Банк (Х)	10,029,848.01	1.03%	382.75%
Эрэл (Х)	6,687,935.27	0.68%	171.94%

ТӨ - төрийн өмчит

ТӨО - төрийн өмчийн оролцоотой

Г - гадаадын хөрөнгөтэй

Х - хувийн

Эх сурвалж: А. Хулан, «Банкны салбар дах гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

Хүснэгт 4.3.1.7.

	Нийт активт эзлэх хувь 6/30/2000	Нийт активт	
		эхлэх хувь 6/30/2004	Өсөлт (%)
Нийт актив			383.63%
Төрийн өмчит	24.48%	6.33%	25.09%
Төрийн өмчийн оролцоотой	54.16%	3.63%	-67.55%
Хувийн	21.35%	90.03%	1939.04%
Гадаадын хөрөнгө оруулалттай		40.15%	
Бусад	21.35%	49.89%	1029.81%

Эх сурвалж: А. Хулан, «Банкны салбар дах гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

ХХБ 2000 онд Монголд нийт олгосон зээлийн үлдэгдэлийн 40%-ийг эзэлж байсан бол 2004 онд түүний хувь нь 14.27% хүртэл буурч²⁰, нэрлэсэн дүнгээр 4 жилийн хугацаанд дөнгөж 227% өсч, нийт банкны салбарын 4

жилийн өсөлтийн дундаж 828%-ийн өсөлтөөс ихээхэн доогуур өсөлтийн үзүүлэлттэй байна. Түүний нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэдийгээр 2000 онд 34% байснаа 2004 онд 16% болж буурсан ч нийт банкны систем дэх чанаргүй зээлийн 2004 оны дундаж 8%-ийн үзүүлэлтээс 2 дахин өндөр, адилхан гадаадын компанид хувьчлагдсан ХААН банкны 3.51%-иас 4 дахин өндөр байна (ХААН банк 2000 оны

²⁰ - Статистикийн эх сурвалж: А.Хулан, «Банкны салбар дах гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

чанаргүй зээлийн 78%-ийг 2004 онд 3.51% хүртэл буулгаж чадсан байна).

ХХБ 2000 оноос 2004 он хүртэлх хугацаанд өөрийн хөрөнгөө ердөө л 40.13% нэмэгдүүлсэн байхад гадаадын хөрөнгө оруулалтгүй бусад Монголын хувийн банкууд дунджаар 557%-иар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн байна. Мөн энэ хугацаанд Монголын хувийн банкууд дүрмийн сангаа дунджаар 525%-иар нэмэгдүүлсэн байхад Худалдаа Хөгжлийн банк дөнгөж 166%-ийн өсөлттэй, хадгаламжийн үлдэгдэл нь мөн хугацаанд дөнгөж 126%-ийн өсөлттэй байна (нийт банкны салбарт энэ үзүүлэлт бол 499% байгаа юм). Харьцуулахад, төрийн өмчид үлдсэн Хадгаламжийн банк ижил хугацаанд дүрмийн сангаа 300%-иар, өөрийн хөрөнгөө 195%-иар өсгөсөн байна.

Үүнээс үзэхэд, ХХБ хувьчлагдаж гадаадын хөрөнгийг Монгол Улсын банкны систем руу идэвхтэй татаж оруулах, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж нийт эдийн засаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувьчлалын анхны зорилгууд нь маш хангалтгүй биелэгдэж, өсөлт нь төрийн болон дотоодын банкуудаас эрс хоцорч байна.

Харин ХААН банкны 1999-2000 оны санхүүгийн байдал маш хүнд байсан мөртлөө 2004 онд гэхэд өөрийн хөрөнгөө 13 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж хадгаламжийн үлдэгдлээ мөн хугацаанд 3194%-иар өсгөж, энэ үзүүлэлтээр улсад тэргүүлж байна.

ХААН банк, ХХБ хоёр банкны хувьчлал нь яагаад ийнхүү маш зөрүүтэй үр дүнд хүргэсэн бэ гэвэл ХААН банкны хувьд зөвхөн өмчлөгчийг солих төдийгүй (харин ч Японд худалдахаас өмнө төрийн өмчид үлдэж байсан), гадаадын менежерүүдийг үйл ажиллагаанд идэвхтэй татан оруулж, цогцоор нь банкны менежментийн арга барил, бүтэц, үйл ажиллагааны стратегийг шинэчлэж чадсанд оршино гэж хэлж болох байх, харин ХХБ-ийн хувьд хувьчлал нь нэр төдий явагдаж, үйл ажиллагаа нь хуучин хэвээр үлдэж, олон улсын туршлага, боловсон хүчин, хөрөнгө оруулалтыг жинхэнээр татаж оруулж ирж чадаагүй нь ХААН банкны хувьчлалаас ялгаатай байгаагаас харагдаж байна.

4.3.Б. Өрсөлдөөн: Дотоодын болон гадаадын банкуудын өрсөлдөөн

А.Тодорхойлолт

Зах зээлийн эдийн засгийн гол зарчим нь эдийн засагт үйл ажиллагаа явуулж байгаа субъектуудын сонголт, шийдвэрүүд нь (эдийн засгийн онолд тэдгээрийг агентууд гэж нэрлэдэг бөгөөд түүнд аж ахуйн нэгжүүд, байгууллага, хувь хүмүүсийг оруулдаг) чөлөөтэй байх байдал юм. Зах зээлийн эдийн засагт эдгээр агентууд тэгэхлээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчийн төлөө хоорондоо өрсөлдөх болдог.

Энэ өрсөлдөөн нь хэр зэрэг чөлөөтэй байгаа нь нийт эдийн засгийн чөлөөт байдлыг илэрхийлэх нэг том үзүүлэлт. Эдийн засгийн субъектууд өөрсдөө сонгосон салбартаа орж, үйл ажиллагаа явуулж хоорондоо чөлөөтэй өрсөлдөх эдийн засгийн, эрх зүйн болон бусад нөхцөл байдал хангагдсан байвал тухайн эдийн засаг дахь өрсөлдөөн нь чөлөөтэй, мөн эдийн засаг нь өөрөө чөлөөтэй байна гэсэн үг.

Өрсөлдөөн чөлөөтэй, зах зээлийн зарчмаар зөв шударга явагдвал үнэ ханш, зардал зөв тодорхойлогдож, хүчин зүйлс зөв хуваарилагдан, эдийн засгийн үр ашигтай байдал хангагддаг гэж эдийн засгийн онолд үздэг.

Энэ хэсгийн гол зорилго нь Монгол Улсад дотоодын болон гадаадын банкуудын хоорондох өрсөлдөөнийг тодорхойлоход оршино.

Гадаадын банк гэсэн ойлголтыг

- i) гадаадын банкны салбар, гадаадын банкны хөрөнгө оруулалттай эсвэл,
- ii) гадаадын хөрөнгө оруулалттай банк гэж хоёр янзаар тодорхойлж болно.

Гадаадын хөрөнгө оруулалттай гэж үзэхдээ:

1. "... гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмших нийт хувьцааны хэмжээ нь аж ахуйн нэгжийн удирдлагын хяналтыг тухайн гадаадын хөрөнгө оруулагчид өгч байх үед гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдлээ гэж үздэг. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг санхүүгийн бусад хөрөнгө оруулалтаас ялгаж байгаа гол зүйл бол удирдлагын цар хүрээ юм" гэсэн тодорхойлолт,
2. Монгол Улсын "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль"-ийн III бүлэг, XI зүйлийн 1-д заасан "Монгол Улсын

Хүснэгт 4.3.2.1

	Гадаадын банкны зөвшөөрлийн татгалзлын түвшин (Татгалзал/Хүсэлт) (Foreign Bank Licence Denial Rate (Denials/Applications))		
Банкны секторын нийт хөрөнгөнд гадаадын банкны хөрөнгийн эзлэх хувь	0%	0%-49%	50%-100%
(Foreign bank assets as a share of total banking sector assets)	80%-100%	10	8
	40%-79%	9	7
	0%-39%	8	6
			3

Эх сурвалж: Economic Freedom of the World: 2004 Annual Report

хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, өөрийн хөрөнгийн 25-аас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэнэ” гэсэн заалтуудыг суурь болгон авч үзнэ.

Фрейзер Институтын индексийн тооцоолол (1995, 2000-2004)

Фрейзерийн индексээр дотоод, гадаад банкуудын хоорондох өрсөлдөөнийг үзэхдээ тухайн улс гадаадын банкны үйл ажиллагаа явуулах хүсэлтийг бүгдийг нь эсвэл дийлэнхийг зөвшөөрч, мөн хэрвээ банкны секторын нийт хөрөнгөнд гадаадын банкуудын хөрөнгийн эзлэх хувь өндөр байх тусам тухайн улс доорх хүснэгтэнд үзүүлснээр Фрейзерийн индексэд өндөр үнэлгээтэй болно. (Хүснэгт 4.3.2.1)

Ийнхүү, Фрейзер Институтын аргачлалд дараах хоёр үндсэн үзүүлэлт хэрэгтэй болдог:

1. Банкны секторын нийт хөрөнгөнд гадаадын банкны хөрөнгийн эзлэх хувь
2. Гадаадын банкны зөвшөөрлийн татгалзлын түвшин (Татгалзал/Хүсэлт)

1. Банкны секторын нийт хөрөнгөнд гадаадын банкны хөрөнгийн эзлэх хувь

Гадаадын банк гэсэн ойлголтыг гадаадын хөрөнгө оруулалттай банк мөн гадаадын банкны салбар гэсэн 2 төрлийн тодорхойлолттой авч үзье.

Монгол Улс 1991 онд банкны хоёр шатлалт системд шилжсэнээс хойш анх удаа 1992 онд ОХУ-ын хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ Банк байгуулагджээ. Уг банк хоёр жил үйл ажиллагаа явуулаад 1994 онд татан буугдсан

байна. Үүний дараагаар хоёрдахь гадаадын хөрөнгө оруулалттай банк 1996 онд Малайз Улсын хөрөнгө оруулалтаар ММ Инвест Банк нэртэйгээр байгуулагдаж 1999 онд мөн татан буугдсан. Эдгээр банкууд нь их хэмжээний найдваргүй зээл олгон, төлбөрийн чадваргүй болсны улмаас дампуурсан.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад 17 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс гадаадын хөрөнгө оруулалттай 4 арилжааны банк байгаагийн хоёр нь 100 хувийн гадаад хөрөнгө оруулалттай (Чингис Хаан, Менатеп банкны салбар), үлдсэн хоёр нь (Худалдаа Хөгжлийн, Хөдөө Аж Ахуйн-ХААН) дотоод, гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай банкуудыг тус бүрт нь авч үзвэл дараах байдалтай байна:

Худалдаа Хөгжлийн Банк. Анх Монгол Улсын Засгийн Газрын 1990 оны 71-р тогтоолыг үндэслэн Улсын Банкны Ерөнхий Хорооны /хуучин нэрээр/ даргын баталсан 1991 оны 3/19 тоот тушаалын дагуу тэнцэл тусгаарлан байгуулагдаж 1991 оны 1-р сарын 1-ний өдрөөс арилжааны банкны үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Анх байгуулсан зорилго нь банкны 2 шатлалт тогтолцоог бий болгох, бэхжүүлэх, өмнө байсан нэг банкны үүргийг задлан арилжааны банкуудаар гүйцэтгүүлэх, үүнээс гадаад төлбөр тооцоо, харилцах үйл ажиллагааг тусгайлан гүйцэтгүүлэх явдал байсан. Ийм ч учраас гадаад пассивын 70-80% төвлөрүүлсэн, хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны далайцаар манай улсын хамгийн том арилжааны банк болсон. 1997-2000 онуудад банкны секторын нийт активын 31.3-43.1%, нийт гадаад активын

Хүснэгт 4.3.2.2. ХХБ-ны гол үзүүлэлтүүд 2002 оны 5-р сарын байдлаар

Он	Зээл			Депозит			Актив		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2002.05	48.2	29	I	25.9	16.1	III	122.5	32.4	I

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Хүснэгт 4.3.2.3. ХХБ-ны гол үзүүлэлтүүд 2005 оны 2-р сарын байдлаар

Он	Зээл			Хадгаламж			Харилцах		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	90.6	14.7	III	83.1	43.5	I	44	8	V

Он	Актив			Гадаад актив			Ашиг		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	213.1	18.7	I	66.2	33.4	I	1.6	124.5	I

	Татвар /тэрбум/
2000	7.03
2002	3.2
2003	0.372
2004	2.01

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

62.5-79 хувь, нийт гадаад Эх сурвалжийн 51.5-75.8%, нийт зээлийн 27-39.3 %-ийг дангаар эзэмшиж байсан нь үүний баталгаа юм.

Тус банк 2002 оны 5-р сар хүртэл төрийн өмчид тулгуурласан /нийт дүрмийн сангийн 76%-ийг МУ-ын Засгийн Газар, 24%-ийг банкны ажиллагсад болон бусад хувь нийлүүлэгчид/ банк байсан.

2002 оны 5-р сард төрийн мэдлийн 76%-ийг олон улсын тендерт ялсан Швейцарийн *Banco Commerciale Lugano* АНУ-ын *Gerald Metals, Inc*-ийн хамтарсан *Globull Investment and Development* компанид 12.23 сая ам.доллараар хувьчилсан.

2004 оны 12-р сард *Олон Улсын Санхүүгийн Корпораци /IFC/*, *Азийн Хөгжлийн Банк /ADB/*-наас хөрөнгө оруулалт хийснээр одоо нийт дүрмийн сангийн 61.51 хувийг *Globull Investment and Development* компани, 9.08 хувийг *Азийн Хөгжлийн Банк*, 9.08 хувийг *Олон Улсын Санхүүгийн Корпораци*, 20.32 хувийг банкны ажиллагсад болон бусад хувь нийлүүлэгчид эзэмшиж байна.

Хувьчлал явагдсан 2002 оны 5-р сарын байдлаар банкны гол үзүүлэлтүүдийн хэмжээ, нийт банкны секторын хэмжээнд эзлэх хувь, эзэлж байсан байдал, улсын төсөвт төлсөн татварын хэмжээ дараах байдалтай байжээ. (Хүснэгт 4.3.2.2)

Тэгвэл 2005 оны 2-р сарын байдлаар гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. (Хүснэгт 4.3.2.3)

Бэлэн бус төлбөр тооцооны *VISA* болон *American Express* карт, иргэд хоорондын олон улсын мөнгөн гуйвуулгын *MoneyGram* болон *SWIFT* үйлчилгээ, харилцагчдын гар утсанд дансны мэдээлэл хүргэх *Mobile Phone Banking*, БНХАУ-ын юаны гуйвуулгын үйлчилгээ зэрэг дэвшилтэд үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Одоо уг банк, нийт активынхаа хэмжээгээр дэлхийд 25 дугаарт ордог Нидерландын *Ай Эн Жи* (ING) банктай менежмент зөвлөгөө болон техникийн тал дээр хамтран ажиллах гэрээг 2003 онд хийж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 4.3.2.4. ХААН банкны гол үзүүлэлтүүд 1999 оны 12-р сарын байдлаар

Он	Зээл		Депозит		Актив	
	Хэмжээ / тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Хэмжээ / тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Хэмжээ / тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь
1999.12	0.913	2.8	2.76	4.2	6.96	3.8

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Хүснэгт 4.3.2.5. ХААН банкны гол үзүүлэлтүүд 2005 оны 2-р сарын байдлаар

Он	Зээл			Хадгаламж			Харилцах		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	88.78	14.4	IV	113.35	20.7	II	11.14	5.8	VI

Он	Актив			Гадаад актив			Ашиг		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	160.97	14.1	III	2.7	1.1	X	0.613	46.4	III

Он	Татвар /тэрбум/
2002	1.32
2003	1.40
2004	1.61

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Хөдөө Аж Ахуйн - ХААН Банк. 1991 оны 1-р сараас 100%-ийн улсын хөрөнгө оруулалтаар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Хөдөөгийн ард иргэдэд банк, санхүүгийн үйлчилгээг үзүүлэх, хүргэх гол зорилготой байгуулагдсан банк юм.

1990-ээд онуудад үлэмж хэмжээний чанаргүй зээл (нийт зээлийн 57.7-100%) хэд хэдэн банкуудад хуримтлагдсны нэг нь ХААН банк байсан. Их хэмжээний алдагдал хүлээж, төлбөрийн чадваргүйгээс нэр хүнд нь унаж дампууралд тулж очоод байсан уг банкиг МУ-ын Засгийн Газар, Монгол Банк, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Банкны эрх хүлээн авагчдаас Олон улсын банк, санхүүгийн менежер, АНУ-ын иргэн, ноён Ж.Питер Морроу 2000 оны 8-р сарын 11-нд хүлээн авсан (Хүснэгт4.3.2.4).

Монголын хөдөө орон нутагт санхүүгийн найдвартай үйлчилгээг сэргээх, санхүүгийн

хувьд ашигтай, тогтвортой үйл ажиллагаа явуулах зэрэг зорилтуудыг тодорхойлон, амжилттай хэрэгжүүлснээр уг банкны үйл ажиллагаа тэлэн, манай улсын 3 том арилжааны банкны нэг болсон байна (Хүснэгт4.3.2.5).

Бэлэн бус төлбөр тооцооны *VISA* карт, иргэд хоорондын олон улсын мөнгөн гуйвуулгын *Western Union* болон *SWIFT* үйлчилгээ зэрэг дэвшилтэд үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна.

2002 онд Япон Улсын *HS Securities, Inc* 6.8 сая ам доллараар хувьчилж авсан. 2003 оны 3-р сараас Удирдах зөвлөл нь Япон Улсын *HS Securities, Inc*-ийн 2, Монгол Улсын *Таван Богд ХХК*-ийн 1, АНУ-ын *Development Alternatives Inc*-ийн 1 хүнээс бүрдэж, АНУ-ын менежментийн багийн гэрээг сунган ажиллаж байна. 2004 оны байдлаар 60 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай байна.

Чингис Хаан Банк. ОХУ-ын *Миллениум Секьюритиз* компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай. 2003 онд ББСБ-аас арилжааны банк болсон.

2001оны 5-р сарын 18-нд гадаадын хөрөнгө оруулалттай *Чингис Хаан* банк үүсгэн байгуулагчид банк байгуулах зөвшөөрлийг Монгол Банкнаас олгосон боловч 2001 оны 7-р сарын 16-нд зөвшөөрлийг хүчингүй болгосон. 2001 оны 7-р сарын 25-нд *Чингис Хаан* ББСБ

Хүснэгт 4.3.2.6. Чингис Хаан банкны гол үзүүлэлтүүд 2005 оны 2-р сарын байдлаар

Он	Зээл			Хадгаламж			Харилцах		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	40.77	6.6	VI	0	0	XVII	0.1	0.00005	XVII

Он	Актив			Гадаад актив			Ашиг		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	72.96	6.4	VI	30.52	15.4	III	0.104	7.9	VII

Он	Татвар /тэрбум/
2003	0.149
2004	0.585

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

байгуулах зөвшөөрөл олгосон (Монгол Банкны жилийн тайлан 2001 он). Банкны зөвшөөрөл эхэлж олгоод дараа нь цуцалсны гол шалтгаан нь уг банкны дүрмийн санг бүрдүүлсэн хөрөнгө, мөнгийг Оросын мафийнх байж болзошгүй гэсэн мэдээллийг Тагнуулын Төв Газраас гаргасан явдал гэж үздэг. Уг банкиг үүсгэн байгуулагч ОХУ-ын иргэн ноён н.Громов нь Красноярскийн хөнгөн цагааны магнат бөгөөд, олигархи бүлэглэлийн гишүүн юм (Хүснэгт 4.3.2.6).

Чингис Хаан банк зөвхөн их хэмжээний зээл олгох буюу өөрийн хөрөнгийг байршуулах зорилгоор орж ирсэн гэж үздэг. Дотоодоос Эх сурвалж татах, жижиг зээл олгох, хадгаламжийн урамшуулал зэрэг банк санхүүгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй, томоохон төсөл, хувьчлалыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Менатеп Санкт-Петербург Банкны салбар. 2001 оны 10-р сарын 20-нд Монгол Банкнаас ОХУ-ын Менатеп СПб банкинд Монгол Улсад салбар байгуулах зөвшөөрлийг олгосноор анх үүсэн байгуулагдсан. 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай (Хүснэгт 4.3.2.7).

Менатеп банкны салбар нь зөвхөн өөрийн улсын компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд үйлчлэх зорилгоор орж ирсэн учраас дотоодын банкуудтай төдийлөн өрсөлдөөнгүй байна.

Хүснэгт 4.3.2.7. Менатеп СПб банкны салбарын гол үзүүлэлтүүд 2005 оны 2-р сарын байдлаар

Он	Зээл			Хадгаламж			Харилцах		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	1.81	0.3	XVII	0	0	XVI	5.2	2.7	IX

Он	Актив			Гадаад актив			Ашиг		
	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр	Хэмжээ /тэрбум/	Банк.сек-т эзлэх хувь	Байр
2005.02	8.24	0.7	XVI	0.058	0.03	XVII	-1.86	-142.5	XVII

Он	Татвар /тэрбум/
2003	0.185
2004	0.0112

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Хүснэгт 4.3.2.8 Гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын нийт хөрөнгийн эзлэх хувь

	Гадаадын хөрөнгө оруулалттай банкууд	ГХО-тай банкуудын нийт хөрөнгө /мян.төг/	Банкны секторын нийт хөрөнгө /мян.төг/	ГХО-тай банкуудын хөрөнгийн банкны секторын нийт хөрөнгөнд эзлэх хувь
1995	-	0	-	
2000	-	0	225,728,498.0	0.00
2001	Менатеп СПб салбар	4,477,856.7	332,731,663.1	1.3
2002	Менатеп СПб салбар, ХХБ, ХААН банк	189,755,060.0	493,059,139.1	38.5
2003	Менатеп СПб салбар, ХХБ, ХААН банк, Чингис Хаан банк	364,137,112.3	826,101,827.8	44.1
2004	Менатеп СПб салбар, ХХБ, ХААН банк, Чингис Хаан банк	440,326,431.3	1,108,845,928.5	39.7

Эх сурвалж: Монгол Банкны танилцуулга-2004 он, Судалгааны багийн тооцоо

Тооцоолол

Оны дарааллаар авч үзэхэд 1995 онд манай улсад гадаадын хөрөнгө оруулалттай банк байхгүй байсан байна. Түүнээс хойш 1996-1999 онуудад ММ Инвест банк ажиллаж байгаад 2001 онд Менатеп СПб банкны салбар байгуулагдсан бол 2002 онд ХХБанк, ХААН банк, 2003 онд Чингис Хаан банкууд байгуулагдан ажиллаж байна.

Банкны секторын нийт хөрөнгөнд гадаадын банкны хөрөнгийн эзлэх хувь гэсэн үзүүлэлтийг гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын нийт активын банкны секторын нийт активт эзлэх хувиар тооцно.

2. Гадаадын банкны зөвшөөрлийн татгалзлын түвшин (Татгалзал/Хүсэлт)

Манай улсад банк байгуулах албан ёсны хүсэлтийг сонгож авсан онуудад хичнээнйг гадаадын хөрөнгө оруулагчдаас ирүүлснийг тодорхойлох боломж одоогоор байхгүй байна (Монгол Банкнаас албан ёсоор ийм статистик мэдээлэл тооцдоггүй).

Гэхдээ өмнөх хэсгүүдэд тодорхойлсон мэдээллүүдээ нэгтгэвэл 1991 оноос хойш манай улсад гадаадын хөрөнгө оруулалттай 6 банк албан ёсоор зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулсан байна.

Гадаадын хөрөнгө оруулагчийн хүсэлтэнд албан ёсоор татгалзсан, хүчингүй болгосон 1 тохиолдол (Чингис Хаан банкны анхны хүсэлтийг буцаасан), Менатеп СПб Салбар банк болон Чингис Хаан банкуудад үйл

ажиллагааны хязгаарлагдмал зөвшөөрөл өгсөн зэрэг нь тэдгээрийн үйл ажиллагааг хязгаарлан, анх гаргасан хүсэлтэнд тодорхой хэмжээгээр татгалзсан гэж үзэж болно.

Уг хоёр дүгнэлтээ нэгтгэвэл татгалзлын түвшин **16.7 хувь** байна гэж гарна. Гэхдээ энд 1991-2004 оны хоорондох мэдээллүүдийг нэгтгэсэн учраас энэ үр дүн эдгээр онуудын хувьд уг үзүүлэлтийг ерөнхийд нь төлөөлж байна.

Үр дүн

Дээрх хоёр үзүүлэлтээ нэгтгэн, Фрейзер Институтын аргачлалын дагуу тооцвол доорх үр дүн гарч байна.

Хүснэгт 4.3.2.9. Үр дүн

	ГХО-тай (гад.банкны төлөөлөл, салбар) банкуудын хөрөнгийн банкны секторын нийт хөрөнгөнд эзлэх хувь	Гадаадын банкны зөвшөөр-лын татгалз-лын түвшин (Татгалзал/ Хүсэлт)	Индексийн утга, (гад. банкны төлөөлөл, салбар)
1995	-		
2000	-		
2001	1.3 (1.3)	16.7	6 (6)
2002	38.5 (28.3)	16.7	6 (6)
2003	44.1 (26.5)	16.7	7 (6)
2004	39.7 (19.9)	16.7	7 (6)

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоо

Фрейзер Институтын аргачлалын дагуу 2001-2002 онуудад (0%-39%) интервалд, 2003-2004 онуудад (40%-79%) интервалд оршиж байна. Манай улсын хувьд бүх хүсэлтийг зөвшөөрсөн гэж үзэх боломжгүй, ямар ч шалтгаантай байсан татгалзсан тохиолдол байгаа болохоор зөвшөөрлийн түвшний үзүүлэлтээр сүүлийн хоёр интервалд байх нь гарцаагүй. Өнөөгийн бодит байдалд хоёр дахь буюу (0%-49%) гэсэн татгалзлын интервал тохирно. Иймээс 2001-2002 онуудад **6**, 2003-2004 онуудад **7** гэсэн үр дүн гарсан нь бодитой байх магадлалтай.

Гадаадын банкныг гадаадын банкны салбар, гадаадын банкны хөрөнгө оруулалттай гэж тодорхойлсон үед гадаадын банкны хөрөнгийн эзлэх хувь (0%-39%) гэсэн интервалд оршиж байгаа учраас **6** гэсэн тогтмол үр дүн гарч байна.

Харьцуулалт

Тооцсон үр дүнгээ бусад улсуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 4.3.2.10

Улсууд	2001	2002
Бангладеш	5.9	5.9
Хятад	2.3	2.3
Чех	4.9	10.0
Словак	5.3	5.3
Унгар	6.9	6.9
Болгар	5.2	9.0
Польш	6.7	9.0
Латви	5.1	5.1
Литва	5.2	7.0
Эстони	6.6	6.6
ОХУ	4.3	6.0
Сингапур	4.6	4.6
Гонконг	7.3	8.0
Япон	4.2	8.0
Өмнөд Солонгос	3.2	8.0
Канад	5.1	8.0
АНУ	7.6	8.0
Их Британи	7.4	7.4
Чили	6.0	6.0
Монгол	6.0	6.0

Эх сурвалж: Economic Freedom of the World: Annual Report 2004

Дээрх улсуудыг нэг бүс нутгийн хөрш улсууд, ижил нөхцөл байдлаас шилжилт хийж байгаа улсууд, өндөр хөгжилтэй улсууд гэсэн үндсэн гурван бүлэг болгож ангилж, бүс нутгийн хөрш улсуудтай харьцуулахад Монголын үзүүлэлт БНХАУ, Бангладешээс илүү, ОХУ-тай адилхан, Япон, Өмнөд Солонгос Улсуудаас бага дунд нь байна.

Ижилхэн шилжилт хийж буй улсуудтай харьцуулахад сүүлийн үед Монгол Улсын үзүүлэлт Словак, Латви улсуудаас өндөр, харин харьцуулалтад сонгогдсон өндөр хөгжилтэй улсуудаас бага байна.

Нэмэлт судалгаа ба индекс: Монголын онцлог байдал

Манай улсын банкны секторт өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай банкуудаас Менатеп банкны салбар 100 хувь гадаадын банкны төлөөлөл, Худалдаа Хөгжлийн Банк тодорхой хэмжээгээр²¹ Швейцарийн Лугано банкны төлөөлөл болж байна. ХААН, Чингис Хаан банкуудын цаад хөрөнгө оруулагчид банк бус компаниуд байгаа. Чингис хаан банк хадгаламж авдаггүй, мөн ХХБ-ны үйл ажиллагааны өсөлт бусад төрийн болон хувийн банкуудаас ихээхэн хоцорч байгааг харгалзвал,

1. Дотоодын арилжааны банкууд гадаадын банкуудтай бус гадаадын хөрөнгөтэй өрсөлдөж байна гэж үзэж болно.
2. Манай улсад гадаадын банкууд салбараа байгуулан идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа байдал нийтдээ харьцангуй сул бөгөөд олон улсын хэмжээнд ажилладаг, дэлхийн хаана ч салбараа нээдэг томоохон банкууд тухайлбал, HSBC, City Bank зэрэг банкууд манай улсад орж ирээгүй байна.

Тийм учраас нийт банкны салбар дахь гадаад, дотоодын банкны өрсөлдөөн бодит байдлаар хэрэгжиж, банкны олон улсын менежментийн арга барил, мэдлэг, технологи орж ирэх байдал төдийлөн хангалтгүй байна гэж хэлж болно.

Үүнээс үндэслэн манай улсад яагаад гадаадын томоохон банкууд салбараа нээхгүй, зөвхөн гадаадын хөрөнгө байршаад байна вэ? гэсэн асуулт гарч ирнэ.

²¹ - Лугано банк АНУ-ын «Gerald Metals, Inc» -тай хамтран ХХБ-ны 61.51 хувийг эзэмшдэг.

Үүнд дараах хэд хэдэн шалтгаанууд байна гэж үзсэн:

1. Шилжилтийн жижиг эдийн засаг, зах зээлийн хэмжээ бага

- i. Зах зээлийн хэмжээ багатай.** Тухайн зах зээл том байх нь өсөх өргөжилтийн үр өгөөжтэй буюу нэгжийн зардлыг бууруулж чадах нэг нөхцөл байдаг учраас гадаадын хөрөнгө оруулагч том дотоодын зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүнийхээ үнийг бууруулж, үр ашигтайгаар өрсөлдөх боломжтой байдаг. Гэтэл манай улс хүн ам харьцангуй цөөн, бага орлоготой, буурай хөгжилтэй байгаа нь дээрх нөхцлийг хангаж чадахгүй байгааг илтгэнэ.
- ii. Эдийн засгийн бүтцийн гажуудал.** Өнөө хүртэл төрийн оролцоо, үйл ажиллагаа эдийн засагт байсаар, хувьчлал дуусаагүй байна. Төрийн мэдлийн томоохон үйлдвэр, уурхай, аж ахуйн нэгжүүд байгаа нь банкны секторт шударга бус өрсөлдөөн, хээл хахууль, монополь байдлыг бий болгох нэг эх сурвалж болж байна. Тухайлбал, төрийн томоохон байгууллагуудын харилцах, хадгаламжийг өөр дээрээ байрлуулах, төрийн мөнгийг үнэгүй шахуу ашиглах Төрийн сангийн тогтолцоо бий болсон тул нийт Монголын хөрөнгийн хэмжээ бага байгаагийн дээр хамгийн том аж ахуйн нэгж, байгууллагын данс нь хувийн банкуудад очихгүй байна.
- iii. Нягтралын нөлөө.** Дотоодын зах зээлд компаниудын нягтрал их байх нь гадаадын хөрөнгө оруулалтыг илүү их татдаг. Нягтралын нөлөөг бий болгодог хүчин зүйлсэд дэд бүтцийн хөгжил, аж үйлдвэржсэн байдлын түвшин ба тухайн хугацааны эцсийн байдлаарх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ ордог. Манай улсын хувьд дээрх үзүүлэлтүүд нэлээд сул.
- iv. Орон зай – тээврийн зардал.** Өргөн уудам нутагт, сийрэг таруу байрлан амьдардаг. Нөгөө талаас жижиг эдийн засаг, зах зээл өргөн уудам нутагт тархан байрладаг. Иймээс шууд тээврийн зардлыг нэмэгдүүлнэ. Гэхдээ зам тээвэр, холбоо харилцаа хөгжих нь үүнийг бууруулж байдаг.

2. Өрсөлдөх чадварын үзүүлэлт

- i. Макро эдийн засаг, банк санхүүгийн салбарын тогтвортой байдал.** Гадаадын хөрөнгө оруулалтын хамгийн гол татдаг зүйл нь улсын эрсдэл нь доогуур, макро эдийн засгийн тогтвортой байх үзүүлэлтүүд юм. Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт явагдаж, үнийн түвшин тогтворжиж, банкны салбар эрүүлжин, иргэдийн банкны салбарт итгэх итгэл сайжирч хадгаламж өсөн, санхүүгийн зуучлал өргөжин ББСБ олон тоогоор шинээр байгуулагдаж байна.
Гэвч эдийн засгийн өсөлт нь тогтворжоогүй, хэлбэлзэл ихтэй, гадаад зах зээлийн шоконд хэт өртөмтгий, уул уурхай, алт, мал аж ахуй, барилга гэх мэт цөөн салбарт эдийн засгийн өсөлт гарч үйлдвэрлэлийн бусад салбаруудад жигд хангагдаагүй, сүүлийн жилийн өндөр өсөлтөнд зарим талаар улс төрийн зорилго агуулагдсан байх өндөр магадлалтай; гадаад зах зээлээс бүрэн хамааралтай нефть, бензиний үнийн өсөлтөөс шалтгаалж инфляцийн түвшин нь тогтворгүй зэрэг сөрөг, сул талууд оршин байгаа юм.
- ii. Төрийн нэгдсэн бодлого сул, бараг байхгүй.** Манай улсын хувьд цаашид юугаар, үйлдвэрлэлийн ямар салбараар хөгжихөд төрийн нэгдсэн бодлого султай. Учир нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж ороод харьцангуй удаагүйгээс (зарим салбар нь уг харилцаанд бүрэн шилжиж ороогүй) уламжлал, туршлага байхгүй, шинжлэх ухаанчаар судалгаа шинжилгээ хийн бодлого боловсруулах үндэсний боловсон хүчний бэлтгэлжилт, дадлага туршлага нимгэн, мэдээлэл өгөгдлийн хангалттай хэмжээний бааз бүрэлдэн бий болоогүй, төрийн албан хаагчдын үр ашигтай ажиллах механизм бүрэлдэн тогтоогүй (намын харьяалалаар томоос нь бага албан тушаалд бүгдэд нь дээрээс томилдог, цалин хангамж муутайгаас авилгал, хээл хахуульд өртөх магадлал өндөр, үнэн сэтгэлээсээ хариуцлагаа ухамсарлан ажилладаггүй гэх мэт) байна.

Маш олон хөтөлбөр, үзэл баримтлал, үндсэн чиглэл боловсруулсан боловч тэдгээр нь хоорондоо уялдаа холбоо сул, бие биенээ нөхөн дэмжих механизм байхгүй, суурь судалгаагүйгээр боловсруулсан нь тэдгээрийг хоосон уриа лоозон, хэвлэмэл цаас болгож байна. Жишээ нь, жил бүрийн төсвийн хуулинд эдийн засгийн өсөлтийг хангах, хөгжүүлэх бодлогын чанартай зүйл ордоггүй, хөрөнгө оруулалтын зарим төслүүд эдийн засгийн үр ашиггүй хөрөнгө оруулалтууд байдаг. Мөн үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн, баталж нотолсон дунд болон урт хугацааны хөгжлийн концепц, илүү хурдацтай хөгжүүлэх үйлдвэрлэлийн салбаруудын сонголт, үзэл бодолгүй байгаа нь үүний баталгаа юм.

iii. Өрсөлдөх чадвар сул. Олон улсын зах зээл дээр хүчтэй өрсөлдөх эцсийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний салбар байхгүй байсаар байна. Экспортийн үйлдвэрлэлийн бүтэц нь үндсэндээ байгалийн түүхий эд болон зэсийн баяжмал, алт, нүүрс зэрэг цөөн нэр уул уурхайн бүтээгдэхүүн; АНУ гэх мэт өндөр хөгжилтэй улсуудын Монгол Улсад олгосон хөнгөлттэй нөхцлийг ашиглаж ашиг олох зорилготой гадны хөрөнгө оруулагчдын (дийлэнх нь БНХАУ, Гонг-Конг, Тайвань) үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл эдлэл; ноолууран хувцас, эдлэлээс бүрддэг.

Үүнээс болж манай улсад гадны банк орж ирж хөрөнгө оруулалт хийн ашиг олох үйлдвэрлэлийн салбар байхгүй байна гэж болно.

iv. Хүчин зүйлийн зардал өндөртэй. Манай улсын хувьд үйлдвэрлэлийн тогтмол зардал өндөртөйд (цахилгаан, дулаан, уур ус, тээврийн зардал өндөртэй, эрс тэс цаг агаартай) тооцогддог. Үйлдвэрлэлийн бүх техник, тоног төхөөрөмжийг гаднаас импортолдог, өөрсдөө үйлдвэрлэдэггүй болохоор үнэтэй. Ажиллах хүчин үндсэн суурь боловсрол сайтай боловч, мэргэжилтэй ажилчин, дадлага туршлага, ур чадвар, үнэнч шударгаар ажиллах сонирхлын хувьд сул дорой. Энэ байдал

нь сүүлийн үеийн барилгын салбарын хөдөлмөрийн зах зээл дээр түлхүү ажиглагдаж байгаа.

v. Бүртгэл тооцооны орчин үеийн стандарт хангагдаагүй. Банк, санхүүгийн салбарт эрсдэл өндөртэй, үүнээсээ улбаалан чанаргүй зээлийн түвшин сүүлийн жилүүдэд харьцангуй буурч байгаа боловч байсаар байгаа. Чанаргүй зээлийг байгуулах, бүртгэх процесс нь нэлээн эргэлзээтэй, олон улсын түвшинд хүрээгүй байгаа. Үүнийг 1997-1999 оны хооронд явагдсан банкны секторын хямрал харуулдаг.

Энд мөн сүүдэр эдийн засгийн асуудал хамаарна. Сүүдэр эдийн засаг нь хууль бус үйл ажиллагаанаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн бараа үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон мэдээлэгдээгүй орлогуудыг (мөнгөний болон бартерийн хэлцлүүд) агуулдаг. Үүний бодит эдийн засагт үзүүлэх нэг нөлөө нь мөнгөний үзүүлэлтүүдэд хамаарагддаг. Сүүдэр эдийн засгийн ихэнх хэлцлүүд нь бэлэн мөнгөөр хийх сонирхолтой байдгаас түүний өсөлт нь бэлэн мөнгөний эрэлтийг нэмэгдүүлж байдаг.

Манай улсын хувьд сүүдэр эдийн засгийн хэмжээг ойролцоогоор хөгжиж буй орнуудын жишгээр ДНБ-ий 35-44 хувь, шилжилтийн эдийн засагтай орнуудынхаар 21-30 хувь, 2002 оны нэрлэсэн ДНБ 1094.5 сая ам.доллар байсан гэж үзвэл харгалзан 383.1-481.6 сая ам.доллар, 229.8-328.4 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл дунджаар 229-481 сая ам.долларын хооронд байна.

Монгол улсын албан бус хэвшлийн үйл ажиллагааг судалсан хэд хэдэн ажлууд байдаг. Тухайлбал, Ж.Андерсон *Шилжилтийн үеийн Монгол улсын албан бус хэвшлийн хэмжээ, гарал үүсэл, хэв маяг* (1998), Б. Бикалес, Ч. Хүрэлбаатар, Ш.Карин *Монгол улсын албан бус хэвшил: Санал асуулгын үр дүн болон шинжилгээ* (1999), Э. Моррис *Монгол дахь албан бус хэвшил* (2001). Ж.Андерсоны судалгаагаар манай улсын албан бус хэвшлийн үйлдвэрлэл (нэмүү өртөг) ДНБ-ий 30-38 хувьтай тэнцүү гэж дүгнэсэн нь

дээрх тооцоотой ойролцоо байна.

vi. Дэд бүтцийн сул хөгжил. Авто зам, төмөр зам, агаарын тээвэр сул хөгжсөн. Авто замын сүлжээ багатай, замын нягтшил 1 км² нутаг дэвсгэрт 0.03 км, нийт замын 3.4% нь засмал зам байгаа нь маш бага үзүүлэлт юм. ОХУ-ыг БНХАУ-тай холбох дан ганц улсын мэдлийн төмөр замтай, агаарын тээвэрт улсын болон хувийн хэвшил ажиллаж байгаа боловч хүн амын орлого бага, үйлдвэрлэл үйлчилгээний хөгжил удаан байгаагаас санхүүгийн хүндрэлтэй, ашигт ажиллагаа багатай байгаа.

vii. Ил тод байдал (Transparency).

Эдгээр олон шалтгаанууд нь манай улсад гадаадын банк үйл ажиллагаа явуулахыг хориглоод байгаа нүдэнд харагдахгүй далд саад хориг, зохицуулалтууд гэж үзэж болно. Учир нь эдгээр нь бүгд чөлөөтэйгөөр зах зээлд нэвтрэх, шударгаар өрсөлдөхөд сөргөөр нөлөөлдөг шалтгаанууд юм.

Үүнээс гадна Монгол Банкны Ерөнхийлөгчийн "... Цаашид дотоодын хөрөнгө оруулагчдад ч банкны зөвшөөрөл олгохгүй. Учир нь Монголд одоо үйл ажиллагаа явуулж буй банкуудын хэмжээ жижигхэн, нэг удаа дүрмийн сангийн 20 хувиас хэтрэхгүй зээл олгодогтоос зээлийн хэмжээ бага, богино хугацаатай байна. Үүнийг өөрчилж, сайжруулахын тулд 1-рт шинээр лиценз олгохгүй, 2-рт банкуудын дүрмийн санг 2 жилд 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авна..." гэсэн мэдэгдлээс ирэх цаг хугацаанд банкны секторын өрсөлдөөн, ялангуяа гадаадын банкттай хийх өрсөлдөөн нилээн хязгаарлагдмал, хаалттай болж ирнэ гэж дүгнэж болж байна.

Эдгээр далд саад хориг, зохицуулалт, хязгаарлалтуудыг банк байгуулах хүсэлтийн татгалзлын түвшин гэсэн үзүүлэлтийн тооцоололд нэгтгэвэл татгалзлын түвшин 50-100% байна гэсэн үр дүн гарна. Энэ үед индексийн үзүүлэлт 3-4 болж буурна.

Гадаадын менежмент, шинэ үйлчилгээ, техник технологийн өрсөлдөөн

Гадаадын банк байгуулагдахгүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа боловч сүүлийн жилүүдэд манай улсын банкны секторт гадаадын банкуудын хэрэгжүүлдэг үйлчилгээ, менежмент, маркетингийн арга хэрэгслүүд, шинэ техник технологи зэрэг төлөөлөх үйл ажиллагаа эрчимжиж байна.

Олон улсын мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ *MoneyGram, SWIFT, Western Union*, бэлэн бус төлбөр тооцооны сүлжээ *MasterCard, VISA, American Express, Chinese Credit Card*, гадаадын менежментийн баг, Эх сурвалж татах олон шинэлэг арга хэрэгслүүд нэвтэрч байгаа нь үүний илэрхийлэл юм. Үүнтэй хамт үйлчилгээний шинэ технологийн дэвшил, ололт, нээлтүүд зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлж, дэмжиж байна.

Банкны удирдлагад гадаадын менежмент нэвтэрснээр шилдэг, орчин үеийн мэдлэг, чадвартай боловсон хүчний өрсөлдөөн банкуудын дунд хүчтэй болж ирж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай 4 банкны хувьд ХХБ дэлхийн томоохон банкны менежментийн багтай хамтарч, ХААН банкиг гадаадын банкир, хувь хүний туршлагаар, Менатеп банкны салбар цэвэр гадаад удирдлага, Чингис Хаан банкиг дотоодын боловсон хүчин удирдаж байна.

Менежментийн өрсөлдөөний үр дүнд банкны шинэ үйл ажиллагаа, бүтээгдэхүүн бий болж, боловсон хүчний чанар сайжирч, шинэ техник технологи нэвтэрч байна. Бусад салбаруудаас хамгийн өрсөлдөөнтэй, ашигтай салбар нь банкны салбар байгаа ба дундаж цалингийн түвшингээр хамгийн өндөр байна.

Санхүүгийн зах зээлд шинээр гарч ирэн эрчимтэй хөгжиж байгаа нэг үйлчилгээний салбар нь Банк бус санхүүгийн байгууллагууд болж байна. Мөн банк санхүүгийн салбарт гадаадын хөрөнгө байршиж байгаа нэг талбар нь Банк Бус Санхүүгийн Байгууллагууд /ББСБ/ болж байна.

ББСБ Монголд анх 1999 онд байгуулагдаж байсан бол 1999 онд 2, 2000 онд 7, 2001 онд 28, 2002 онд 66, 2003 онд 88, 2004 онд 110 болж өссөн байна.

2001 онд нийт активын хэмжээ 23.4 тэрбум, үүний 64 хувь буюу 15 орчим тэрбум төгрөгийг

гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын актив эзэлж байна.

2003 онд гадаадын хөрөнгө оруулалттай зургаан ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрийн дүрмийн сангийн хэмжээ 2.4 тэрбум төгрөг байгаа нь ББСБ-уудын нийт дүрмийн сангийн 20.0 хувийг эзэлж байсан байна.

ББСБ-ууд үйл ажиллагаа өргөжүүлэх үүднээс гадаадын байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж байна. ББСБ-ууд олон улсын санхүүгийн болон бусад байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа төсөлд олгох Эх сурвалжийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг явуулж эхэлж байна.

2004 оны эцсийн байдлаар 100%-ийн гадаадын хөрөнгө оруулалттай 5 ББСБ, хамтарсан хөрөнгө оруулалттай 11 ББСБ ажиллаж байна. Эдгээр ББСБ-уудын нийт актив 7157.5 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын активын 25%, нийт капитал нь 5242.5 сая төгрөг болсон нь нийт ББСБ-уудын капиталын 29.3% болж байна.

ББСБ-уудын нийт актив банкны секторын нийт активын 2.7 хувьтай тэнцүү гэдгээс гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын актив банкны секторын нийт активт эзлэх хувь 0.68 байна.

1999 оноос хойш ББСБ-ууд дахь гадаадын хөрөнгө өссөн бөгөөд 2004 оны байдлаар нийт банкны секторын хөрөнгийн 0.68 хувь болсон, санхүүгийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт гэдэг утгаар нь индексийн тооцоололдоо оруулбал одоогийн байдлаар нөлөөгүй байна.

4.3.В Хувийн хэвшилд олгож байгаа зээл

Тодорхойлолт

Зээлийн зах зээлийн эрх чөлөө нь тухайн орны эдийн засаг дахь хувийн хэвшлийнхэнд зээл хир зэрэг олдцотой байгаагаас ихээхэн хамаардаг. Компаниуд арилжааны банкнаас зээл авахад аливаа саад бэрхшээлгүй бол тухайн компанийн үйл ажиллагаа эрх чөлөөтэй, солилцоонд чөлөөтэй орох боломжтой, чөлөөтэй өрсөлдөх эрх чөлөө өндөр байгааг харуулдаг.

Манай улсад 1990 оноос эхлэн хувийн хэвшил бий болж, банкнаас зээл авч эхэлсэн. 1994, 1995 онуудад улсын салбарт олгосон зээлийн хэмжээ огцом буурч, нийт зээлд

хувийн секторын эзлэх хувийн жин өсөж, 2000 оноос эхлэн нийт зээлийн 50-60 хувийг эзлэх болсон.

Монгол Улсын Төв банк бүх зээлийг дараах байдлаар ангилдаг²²:

1. Улсын байгууллагын зээл
2. Хувийн хэвшлийн зээл
3. Гадаадын байгууллагын зээл (оршин суугч ба оршин суугч бус).
4. Хамтын үйлдвэрийн
5. Иргэдийн зээл

2003 оны 12 сарын 31-ний байдлаар, нийт Монголын банкуудын ердийн зээл 405 орчим тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс 9 тэрбумыг улсын байгууллагууд, хувийн хэвшил 97 тэрбум. Монгол Банкны ангиллын дагуу 2004 оны байдлаар, Монголын ДНБ-ий 80 орчим хувийг хувийн хэвшил үйлдвэрлэж, арилжааны банкуудаас олгосон нийт зээлийн ойролцоогоор 55% нь хувийн хэвшилд ноогдож байна.

Хүснэгт 4.3.3.1. Нийт зээл, хувийн хэвшилд олгосон зээлийн хэмжээ

Он	Нийт зээл	Хувийн хэвшилд олгосон зээл	Нийт зээлд эзлэх хувь
2005.06	764,605	411,315	53.8%
2004.12	648,979	360,219	55.5%
2003.12	448,759	222,096	49.5%
2002.12	235,068	138,675	59.0%
2001.12	137,537	85,934	62.5%
2000.12	67,881	40,127	59.1%
1999.12	49,466	23,997	48.5%
1998.12	86,328	40,580	47.0%
1997.12	51,516	26,825	52.1%
1996.12	35,562	17,937	50.4%
1995.12	66,925	43,012	64.3%

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

2004 оны байдлаар банкны салбарын нийт активын хэмжээ 962 тэрбум төгрөгт хүрсэн нь 2004 оны ДНБ-ий (1808 тэрбум төгрөг) 53.2%-тай тэнцүү байна. 2004 оны эцсээр зээлийн

²² - Монгол Банк, Банкны Хураангуй Тэнцэл, 2003. Хувийн хэвшилд албан ёсны хувийн хэвшил, хувь хүмүүс, гадаадын байгууллагуудыг оруулбал улсын бус секторт олгосон зээлийн хувь нь өндөр болох боловч хувийн хэвшилд олгосон зээлийн хувийн албан ёсны тоо нь 2005 онд 53.8%-тай тэнцэж, хүснэгт 4.4.3.1-тэй адилхан байсан.

Хүснэгт 4.3.3.2. Хувийн хэвшилд олгосон зээлийн талаарх үзүүлэлтүүд

	1995	2000	2001	2002	2003	2004
Банкны салбар дахь нийт зээлийн хэмжээ, тэрбум төгрөг	66.925	67.881	137.537	235.068	448.759	648.979
Хувийн секторт олгосон зээлийн хэмжээ, тэрбум төгрөг	43.012	40.127	85.934	138.675	222.096	360.219
Хувийн секторт олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувь	64.3%	59.1%	62.5%	59.0%	49.5%	55.5%
Тухайн онд хувийн секторт олгосон зээлийн хамгийн их хэмжээг нийт зээлд харьцуулсан харьцаа (индексийн тооцонд өгөгдсөн нөхцөл)	99.9%	99.9%	99.9%	99.9%	99.9%	99.9%
Тухайн онд хувийн секторт олгосон зээлийн хамгийн бага хэмжээг нийт зээлд харьцуулсан харьцаа (индексийн тооцоонд өгөгдсөн нөхцөл)	10.0%	10.0%	10.0%	10.0%	10.0%	10.0%

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

хэмжээ 648.9 тэрбум төгрөг болж өссөн бөгөөд нийт зээлийн 43.7% үйлдвэрийн салбарт, 56.3% нь үйлдвэрийн бус салбарт олгогдсон байна.

Банкуудын нийт активын 63.1%-ийг зээл эзэлж байгаа бөгөөд 2004 оныг 2000 онтой харьцуулахад нийт зээлийн хэмжээ 9.5 дахин өссөн байхад хувийн хэвшилд олгосон зээлийн хэмжээ 8 дахин өссөн байна. Гэвч энэ нь дөнгөж шинээр бий болж, хөгжлийнхөө эхний үед байгаа хувийн хэвшлийн улам бүр өсөж байгаа зээлийн хэрэгцээг бүрэн хангахгүй байна.

Фрейзер Институтын аргачлалаарх тооцоолол (1995, 2000-2004)

Фрейзер Институтын аргачлалаар уг индексийг дараах томъёог ашиглан тооцдог.

$$(V_i - V_{min}) / (V_{max} - V_{min}) * 10 \quad (1)$$

- V_i - хувийн секторт олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувь
- V_{max} - суурь онд хувийн секторт олгосон хамгийн том зээлийг нийт зээлд харьцуулсан харьцаа
- V_{min} - суурь оны хувьд хувийн секторт олгосон хамгийн бага зээлийг нийт зээлд харьцуулсан харьцаа

Монголын арилжааны банкуудын хувийн секторт олгож байгаа зээлийн нийт зээлд эзлэх хувийг суурь оноор авч хэмжихдээ 1995, 2000-2004 онуудыг суурь оноор авлаа. Фрейзер институтын V_{max} утгыг 99.9%, V_{min} утгыг 10.0% иар авч тооцдог аргачлалаар тооцохдоо бид Монгол Банкнаас гаргадаг улсын/хувийн зээл

хэмээх ангилалтай бэлэн өгөгдлийг ашиглалаа (Хүснэгт 4.3.3.2.).

Хүснэгт 2-т өгөгдсөн мэдээллийг ашиглан Фрейзер институтын V_{max} утгыг 99.9%, V_{min} утгыг 10.0% иар авч тооцдог аргачлалаар тооцоход дараах түвшний индекс гарсан.

$$1995: (64.3 - 10.0) / (99.9 - 10.0) * 10 = 6.04$$

$$2000: (59.1 - 10.0) / (99.9 - 10.0) * 10 = 5.46$$

$$2001: (62.5 - 10.0) / (99.9 - 10.0) * 10 = 5.83$$

$$2002: (59.0 - 10.0) / (99.9 - 10.0) * 10 = 5.45$$

$$2003: (49.5 - 10.0) / (99.9 - 10.0) * 10 = 4.39$$

$$2004: (55.5 - 10.0) / (99.9 - 10.0) * 10 = 5.06$$

Хүснэгт 4.3.3.3. Хувийн хэвшилд олгосон зээлийн хувьд эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс

	1995	2000	2001	2002	2003	2004
Хувийн хэвшилд олгосон зээл	6.0	5.5	5.8	5.5	4.4	5.1

Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

Энэ индекс 10 гэсэн утга руу ойртох тусам зээл авах, зээл олгоход эдийн засгийн эрх чөлөө өндөр байгааг харуулдаг. Монгол улсын зээлийн зах зээл дээрх эрх чөлөөт байдал дундаж түвшинд байгаа бөгөөд 1995 оноос 2004 хооронд 6.0 хувиас 5.0 болтлоо буурч ирсэн байна.

Нэмэлт судалгаа ба индекс:**Монголын онцлог байдал**

Банкуудын нийт актив 1995-2004 оны хооронд 102-962 тэрбум төгрөг хүртэл, нийт зээл 66.9-648.9 тэрбум төгрөг болтол өссөн. Гэтэл хувийн хэвшилд олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувь эдгээр онуудад 64.3-55.5 % болж буурсан нь нийт зээлийн ихэнх нь төрийн өмчийн томоохон компаниудад олгогдсоныг харуулж байна.

Энэ хугацаанд чанаргүй зээлийн нийт хэмжээ 13.5- 60.7 тэрбум төгрөг болж өссөн нь ихээхэн хэмжээний зээл авсан төрийн өмчийн томоохон компаниуд зээлээ эргэн төлж чадахгүй байж болзошгүйг Хүснэгт 4.3.3.4 харуулж байна.

Хамгийн их ба хамгийн бага зээлийн хэмжээ, хувийн хэвшилд олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувийн жинд тулгуурласан эдийн засгийн эрх чөлөөтэй байдлын индекс 1995-2004 хооронд Монголд 4.3- 6.0 хооронд хэлбэлзэж уг индекс өссөн бус буурсан динамик харагдаж байгаа нь Монголын хувийн хэвшлийнхний хувьд зээл авахад нэлээд саад бэрхшээл буйг харуулж байна. Үүнд:

1. Зээлийн хүү өндөр байгаа
2. Ашгийн болон нэмүү өртгийн татвар өндөр байгаа
3. 2004 оны байдлаар нийт зээлийн 18.8% нь 1-2 жилийн, 7% нь 2-5 жилийн, 1.5% нь 5 дээш жилийн хугацаатай олгогдсон. Зээлийн 73% нь нэг жилийн хугацаатай олгогдож байгаа нь зээлийн хугацаа тун богино байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь зээл авахад тодорхой байдлаар хязгаарлалт болж байна.

Хүснэгт 4.3.3.4 Чанаргүй зээл, өмчлөлөөр

	Чанаргүй зээл/ нийт зээл 6/30/2000	Чанаргүй зээл/ нийт зээл 6/30/2004
Нийт чанаргүй зээл	28,36%	8,27%
Төрийн өмчит	72,90%	1,30%
Төрийн өмчийн оролцоотой	34,40%	19,54%
Хувийн	11,60%	8,19%

Эх сурвалж: Монгол Банкны Судалгааны Ажил, Товхимол-2, хуудас 676

Дэлхийн Банкны *Хувийн Секторын Хөгжил Зээлийг* хэрэгжүүлэгч ХХБ, Голомт Банк, Зоос

банкуудын уг зээлийн хэрэгжилтийн талаар Японы Засгийн Газрын санхүүжилтээр хийсэн судалгаанд дүгнэснээр бүх зээл хувийн хэвшилд олгогдсон ба ХХБанкнаас олгосон нийт зээлийн 81.5% нь том зээлийн хэлбэрээр (100 сая төгрөгнөөс дээш хэмжээний) олгогдсон байна. 40 том зээлэгч компаниуд 500 саяас 5.600 сая төгрөгний хооронд зээл авсан байна.

Жижиг дунд бизнесийг дэмжих зээлийн дундаж хэмжээ нь компаниудын хувьд 20 сая төгрөг, хувь хүмүүст 10 сая төгрөг байна. Дээр дурдсан Дэлхийн банкны *Хувийн хэвшлийг хөгжүүлэх хөтөлбөрт* хамрагдсан банкуудын зээлээс гадна Монгол Банк болон Сангийн Яамаар дамжин төслийн зээлийг улсын эсвэл хувийн компанид олгож, зарим тохиолдолд хөтөлбөрийн зорилгоос хамаарч 100% хувийн хэвшилд, 1.75% -ийн хүүтэй олгодог байна.

Төрийн өмчийн томоохон компаниуд, тухайлбал, МИАТ, Эрдэнэт, Говь ХК зэрэг нь зайлшгүй төрийн өмчийн банкуудаас зээл авах талаар Төв Банкнаас аливаа хязгаарлалт тавьдаггүй байна. Арилжааны банкууд найдвартай зээлдэгчдэд зээл олгох өөрсдийн стратегитэй байдаг ба дундаж арилжааны банк хамгийн ихдээ 1 сая ам. долларын зээл олгох боломжтой байдаг бол хамгийн том зээлдэгчдийн (тухайлбал уул уурхай, эрчим хүч, оёдлын салбар дахь) жилийн орлого ойролцоогоор 10-200 сая ам. доллар байдаг. Тиймээс зээл олгоход өмчийн харьяалал гол биш, зээлдэгчийн ашгийн түвшин, үүнээс үүдээд зээлээ төлөх чадвар гол нь байна.

Арилжааны банкны зээл олгох үйл ажиллагаанд зээлдэгчийг шалган сонгох, зээлийн ашиглалтыг хянах, зээл төлүүлэх гэсэн гурван гол дараалал байдаг.

Банкуудын зээл олгох гол үзүүлэлтүүдэд барьцаа хөрөнгө, түүний үнэлгээ, зээлдэгчийн бэлэн мөнгөний урсгал, зээл авч байсан түүх, бизнес төлөвлөгөө зэрэг үзүүлэлтүүд ордог ч бүх зээл бодитой барьцаанд тулгуурласан байдаг. Тиймээс барьцаа, хөрөнгөгүй хүн бол эргэлтийн хөрөнгөөр зээл авах боломжгүй байх тул зээлийн зах зээл дээрх эдийн засгийн эрх чөлөө тодорхой түвшинд хязгаарлагдаж байна.

Монгол Улсын Төв Банкны тухай хуулийн 9-р зүйлд зааснаар банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцлийн дагуу

Хүснэгт 4.3.3.5. Нийт актив, нийт зээл, чанаргүй зээлийн талаарх үзүүлэлтүүд, 1992-2003

	1992	1994	1995	1998	2000	2001	2002	2003	2004
Нийт актив (тэрбум төг)	24.3	83.4	102	180	215	304.4	448	767	962
Нийт зээл (тэрбум төг)	19.1	52.8	63.4	85.6	66.8	135.1	231	442	606.8
Нийт зээл/нийт актив, %	78.6	63.3	62.1	47.6	31.1	44.4	51.6	57.7	63.1
Чанаргүй зээл (тэрбум төг)	1.1	7.3	13.5	32.6	15.9	10.9	16.6	36.7	60.7
Чанаргүй зээл/нийт зээл, %	5.76	13.8	21.3	38.1	23.8	8.1	7.2	8.3	10

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

зээл олгож болно. Банк зээлийн хүүг өөрөө тогтооно гэж заасан байдаг тул банкууд барьцаа болгож бэлэн мөнгөний дараах хөрвөх чадвар сайтай, гүйлгээтэй болох орон сууцыг голлон барьцаалж байна.

Банкны тухай хуулийн 26-р зүйлд зааснаар зээлийг гэрээнд заасан зориулалтаар ашиглана. Банк олгосон зээлийн ашиглалтыг шалган, тухайн зориулалтаар олгосон зээл эргэж төлөгдөх найдваргүй гэж үзвэл зээл олголтыг зогсоож, уг зээлийг хугацаанаас нь өмнө төлүүлэхийг шаардах эрхтэй.

Зээл төлүүлэх асуудал бол зээлийн удирдлагын хамгийн чухал хэсэг. Гэтэл иргэд, компаний зээл авахдаа байрцаанд тавьсан хөрөнгийг нь зээлээ эргэж төлөөгүй тохиолдолд арилжааны банкуудын тогтоолоор бус зөвхөн шүүхийн тогтоолоор хураан авдаг тул энэ тал дээр зээл олгогч, банк, санхүүгийн байгууллагын хувьд эдийн засгийн эрх чөлөө нь хязгаарлагдаж байдаг байна. Энэ явдал зээлийн эрсдлийг ихээхэн өсгөж байгаа юм.

Банкны тухай хуулийн 4-р бүлгийн 27-р зүйлд зааснаар, Монгол Банкнаас баталсан зааврын дагуу зээлийг хэвийн, хэвийн бус, чанаргүй зээл гэж ангилдаг (Хүснэгт 4.3.3.5).

Монгол улсад зээл олгох, зээлийг хянах, зээл төлүүлэх талаар гаргасан ихээхэн хууль, дүрэм журам байдаг. Тухайлбал:

1. Банкны тухай хууль
2. Төв Банкны тухай хууль
3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
4. Монгол Банкны нууцын тухай журам
5. Банк хоорондын овернайт зээлийн журам
6. Банкинд олгох санхүүжилтын журам

7. Банкнаас батлан даалт гаргахад мөрдөх түр журам
8. Зээлийн мэдээллийн сангийн журам
9. Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам (CAMELS)
10. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
11. Банкинд олгох санхүүжилтийн журам
12. Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох журам
13. Активыг байгуулж, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам
14. Зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл авахыг хүссэн банк нь Монгол Банктай *Хамтын ажиллагааны гэрээ* байгуулах журам зэрэг.

Зээлийн талаар гарсан эдгээр нийт дүрэм журмууд нь зээлийн институтыг бий болгож, зээл олгох, зээл авах үйл ажиллагааг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны чанарыг сайжруулж, эрсдлийг багасгах гол механизм болж байна.

Индексийн харьцуулалт

Монгол улсын хувьд хувийн хэвшилд олгосон зээлийн байдлаар 1995-2004 онуудын хооронд Фрейзерийн индексийн түвшин 4-6 гэсэн онооны ангилалд багтаж байгаа бөгөөд 2004 оны байдлаар энэ индекс 5 байна.

Дараах хүснэгтэд Фрейзер Институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн 2004 оны илтгэлээс бусад

орнуудын хувьд гарсан үзүүлэлттэй харьцуулан харуулав.

Шилжилтийн эдийн засгуудтай харьцуулахад эдгээр орнуудын хувьд хувийн хэвшилд олгосон зээлийн индекс 1995-2002 хооронд өссөн байна. Ялангуяа Эстони, Латви, Унгар зэрэг орнуудын хувийн хэвшил зээл авах талаар өндөр эрх чөлөөтэй байдаг байна. Монголын хувьд шилжилтийн эдийн засагтай орнуудын хамгийн сүүлд жагсаж байна. Эдийн засгийн эрх чөлөөт байдлаараа тэргүүлдэг Гонконг, Канад, Сингапур, Их Британи, АНУ орнуудын хувьд энэ үзүүлэлт нь 8. 8-10.0 байна.

Хүснэгт 4.3.3.6 Олон улсын харьцуулалт

Улс	1995	2000	2002
Бангладеш	7.4	8.0	7.6
Болгар	3.0	7.1	7.3
Канад	8.3	8.8	10.0
Чех	6.5	8.0	6.1
Чили	9.9	9.8	9.8
Хятад	9.8	9.4	9.2
Гонконг	9.7	9.1	8.9
Унгар	6.1	7.8	7.5
Эстони	7.9	9.6	9.5
Япон	7.6	8.0	7.9
Латви	9.2	8.9	8.4
Литва	-	5.2	7.0
Орос	5.0	5.9	7.0
Польш	4.2	6.7	7.4
Сингапур	8.8	8.3	8.0
Словак	5.3	8.1	6.0
Өмнөд Солонгос	9.7	9.5	9.6
Их Британи	9.7	9.9	9.8
АНУ	8.8	9.4	9.4
Монгол	6.0	5.5	5.0

Эх сурвалж: Economic Freedom of the World. 2004 Annual Report

4.3.Г Зээлийн хүү сөрөг түвшинд байх

Тодорхойлолт

Зээлийн хүү сөрөг түвшинд байх явдлыг дараах байдлаар тайлбарлаж болно. Инфляци буюу хэрэглээний үнийн өсөлтийн хувь банкны зээлийн нэрлэсэн хүүгийн түвшнээс өндөр байх юм бол, зээл олгож байгууллага ашиг олохгүй, харин алдагдалд орох болно. Жишээ нь, банкны


зээлийн жилийн хүү 25%-тай тэнцүү байхад, бараа бүтээгдэхүүний үнэ 30%-иар өсөхөд, зээл олгосон байгууллага бол бодитоор -5%-ийн алдагдалтай байна, яагаад гэвэл зээл болон хүү нь эргэж төлөгдөөд нийт зээлдүүлсэн мөнгө нь 25%-иар өссөн ч, үнийн өсөлтөөс болоод тэр мөнгөөр худалдаж авах боломжтой барааны хэмжээ 5%-иар багассан гэсэн үг. Энэ байдлыг зээлийн хүү сөрөг түвшинд байна гэж хэлдэг.

Өндөр инфляцитай үед банк, зээлдүүлэгчид аль болохоор өндөр хүүгээр зээл олгож, өөрийгөө болзошгүй алдагдлаас ийнхүү урьдчилсан сэргийлдэг. Инфляци тогтворгүй байх үед буюу үнийн түвшин их хэлбэлзэх нөхцөлд зээлдүүлэгчид өөрийн зээлийн хүүгээ үнийн түвшинтэй уялдуулан уян хатнаар өөрчилж ажилладаг. Хэрэв банкууд, зээлдүүлэгчид зах зээлд чөлөөтэй ажиллах, хүүгийн түвшинг чөлөөтэй өөрчлөх нөхцөл бүрдсэн байвал, банкууд өөрийн ашгаа бодож зээлийн хүүгээ инфляцийн түвшнээс дээгүүр тогтоож, алдагдалд орох, зээлийн хүү сөрөг түвшинд байх явдал гарах учиргүй. Тиймээс, энэ бодит зээлийн хүүгийн түвшин зээлийн зах зээлийн эдийн засгийн чөлөөт байдлыг харуулдаг нэг үзүүлэлт юм.

Монгол Улсад банкны зээлийн хүү шилжилтийн жилүүдэд маш их хэлбэлзэлтэй байсан бөгөөд сүүлийн жилүүдэд тогтворжиж ирсэн билээ. Инфляци мөн 1990-оны эхээр маш өндөр түвшинд байсан боловч, 1999 оноос хойш нилээд тогтворжиж, ерөнхийдөө жилийн 20%-иас доош хэмжээнд байна. 2004 онд дэлхийн газрын тосны үнэ, төгрөгийн ханшны хэлбэлзлээс болоод инфляци 10%-иас өндөр гарч байгаа боловч шилжилтийн эдийн засагтай орны хувьд өнөөгийн инфляцийн түвшин тийм ч өндөр биш гэж хэлж болно (Зураг 4.3.4.1).

Нөгөө талаас зээлийн хүү, хадгаламжийн хүү хоёрын зөрүү бол банкуудын ашигтай ажиллагааны нэг үзүүлэлт мөн. Зөрүү нь их байвал, банкуудын ашиг өндөр байна, яагаад гэвэл банкууд үндсэндээ хадгаламжаар хөрөнгийг татаж, зээлээр түүнийг олгож, хоёр хүүгийн зөрүүнээс ашгаа олдог гэж үздэг. Зөрүү их байвал, банкууд хэтэрхий өндөр ашиг олж, хөрөнгийг олсон үнээс маш өндөр үнээр шилжүүлэн олгож байна гэж хэлж болно. Энэ бол цаад утгаар банкууд зээлийн зах зээл

Зураг 4.3.4.1. Монгол Улс дахь инфляци, зээлийн хүү, бодит зээлийн хүүгийн түвшин (%-иар)



Эх сурвалж: Монгол Банк, УСГ-ын тоо баримтууд

дээр, эсвэл хадгаламжийн зах зээлд бас тийм ч идэвхтэй өрсөлдөхгүй байгаагийн нэг шинж болдог. Өрсөлдөөн нь идэвхтэй явагдахгүй байгаагийн шалтгаан нь тухайн зах зээлд зайлшгүй ямар нэгэн хязгаарлалт байна гэсэн үг. Жишээ нь, тус салбарт аж ахуйн нэгжүүд чөлөөтэй нэвтрэн орох байдлыг хязгаарласан (limited freedom of entry), эсвэл хэд хэдэн том компаниуд ноёрхож, чөлөөт өрсөлдөөнийг хязгаарласан байж болзошгүй (олигополи эсвэл монополь өрсөлдөөн ноёрхсон). Тийм учраас хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү мөн л зах зээлийн чөлөөт байдлын нэг чухал үзүүлэлт мөн.

Фрейзер Институтийн аргачлалаарх тооцоолол

Бодит зээлийн хүүг нэрлэсэн зээлийн хүүгийн түвшин, инфляцийн түвшний зөрүүгээр тооцдог. Фрейзерийн дэд индексийг энэ үзүүлэлтийг 0, 2, 4, 6, 8, 10 гэсэн оноогоор үнэлдэг бөгөөд ерөнхийдөө зээл болон депозитын бодит хүү нь эерэг, мөнгөний бодлого нь тогтвортой, зээлийн хүү нь зах зээл

дээрээ тодорхойлогддог улс орнуудын үнэлгээ нь өндөр байдаг:

- Зээлийн хүү нь анхнаасаа зах зээл дээрээ тодорхойлогддог бөгөөд бодит зээлийн хүү нь эерэг бол 10 оноог
- Зээлийн хүү нь анхнаасаа зах зээлээр тодорхойлогдож, харин бодит хүү нь заримдаа бага зэрэг сөрөг (5%-иас бага) эсвэл зээл болон депозитын хүүгийн зөрүү нь нэлээд их (8% -иас багагүй) бол 8 оноог
- Зээл болон депозитын бодит хүүнүүд нь байнга нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх сөрөг утгатай эсвэл тэдгээрийн зөрүүг Засгийн газраас зохицуулдаг бол 6 оноог
- Зээл болон депозитын хүүнүүд нь Засгийн газраас тогтоогдсон тогтмол бөгөөд бодит хүүнүүд нь байнга нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх сөрөг утгатай бол 4 оноог
- Зээл болон депозитын бодит хүүнүүд нь байнга хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэх сөрөг утгатай бол 2 оноог
- Зээл болон депозитын хүүнүүд нь Засгийн газраас тогтоогдсон тогтмол бөгөөд бодит хүүнүүд нь байнгын хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэх сөрөг утгатай эсвэл гиперинфляциас бий болсон зээлийн зах зээл нь сүйрлийн шинжтэй бол 0 оноог өгдөг.

Мэдээллийн Эх сурвалж

Монгол улсын зээл болон хадгаламжийн хүү, инфляцийн түвшинг дараах хүснэгтэд үзүүлэв. 1995-2004 он /жилийн хүү, хувиар/. Төгрөгийн богино хугацаат банкуудын зээлийн хүү болон төгрөгийн 0-1 жилийн хугацаатай хадгаламжийн хүүг авав. (Хүснэгт 4.3.4.1)

Монгол улсын хувьд зээлийн хүү нь зах зээл дээрээ тодорхойлогддог гэж үздэг. Өөрөөр хэлбэл, банкууд өөр өөрсдийн стратегиараа зээлийн хүүгээ тодорхойлдог.

Дээрх хүснэгтээс харахад зээл болон хадгаламжийн бодит хүүнүүд нь эерэг боловч зээлийн болон хадгаламжийн хүүний зөрүү нь 8 хувиас илүү байна. Ийм учраас 1995, 2000-2004 оны Монгол улс нь Фрейзерийн индексийн 8 онооны ангилалд багтана.

Хүснэгт 4.3.4.1.

Он	Зээлийн хүү /%/	Хадгаламжийн хүү /%/	Инфляци /%/	Бодит зээлийн хүү /%/	Бодит хадгаламжийн хүү /%/	Зээл хадгаламжийн хүүний зөрүү /%/
2004	30.0	20.4	11.0	19.0	9.4	10.4
2003	31.5	22.0	4.7	26.8	17.3	9.5
2002	33.4	22.0	1.6	31.8	20.4	11.4
2001	41.4	24.0	8.0	33.4	16.0	17.4
2000	34.7	24.0	8.1	26.6	15.9	10.7
1999	38.8	30.0	10.0	28.8	20.0	8.8
1998	45.8	42.6	6.0	39.8	36.6	3.2
1997	71.0	69.6	20.5	50.5	49.1	1.4
1996	125.0	60.1	44.6	80.4	15.5	64.9
1995	110.0	101.2	53.1	56.9	48.1	8.8

Эх сурвалж: Монгол Банкны сарын бюллетень 2004-12 сар

Хүснэгт 4.3.4.2.

	1995	2000	2001	2002
Монгол	8.0	8.0	8.0	8.0
Бангладеш	8.0	10.0	10.0	10.0
Болгар	8.0	4.0	9.0	10.0
Канад	10.0	10.0	10.0	10.0
Чили	10.0	10.0	10.0	10.0
Хятад	4.0	10.0	10.0	10.0
Чех	6.0	8.0	10.0	10.0
Словак	6.0	10.0	10.0	10.0
Эстони	0.0	6.0	10.0	10.0
Унгар	6.0	10.0	10.0	9.0
Латви	2.0	8.0	10.0	10.0
Литов	0.0	8.0	10.0	10.0
Польш	6.0	10.0	10.0	10.0
Орос	8.0	2.0	8.0	8.0
Сингапур	10.0	10.0	10.0	10.0
Гонконг	10.0	10.0	10.0	10.0
Япон	10.0	8.0	10.0	10.0
Өмнөд Солонгос	10.0	10.0	10.0	10.0
АНУ	10.0	10.0	10.0	10.0
Их Британи	10.0	10.0	10.0	10.0

Эх сурвалж: Economic Freedom of the World 2004 Annual report

Харьцуулалт

Дараах хүснэгтэд Фрейзер Институтээс хэвлэн гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн 2004 оны илтгэлээс зарим улс орны

энэ үзүүлэлтээр гаргасан оноог дээрх Монгол улсын оноотой зэрэгцүүлэн харуулав.

Зээлийн хүү, хадгаламжийн хүүгийн зөрүүний тухай дараах 4.5.Д бүлэгт дэлгэрэнгүй танилцуулах болно.

4.3.Д. Банкны хүүгийн хяналтын талаар

Хүүгийн хяналт нь хадгаламж, зээлийн хүүнд хяналт байгаа эсэх буюу хүү нь чөлөөт зах зээлээр өөрөө тогтоодог эсвэл төрөөс хяналттай эсэхийг авч үздэг.

Монголын хадгаламж, зээлийн зэх зээл дээр хүүгийн түвшинд хяналт байна уу?, хүүгийн түвшин нь зах зээлийн хуулиар тодорхойлогдож байна уу?

Тодорхойлолт

Аливаа улсын нийгэм эдийн засгийн хөгжилд арилжааны банкууд асар чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэдний үйл ажиллагааны нийгмийн өгөөжийг дүгнэхэд тухайн эдийн засаг өөрөө хир зэрэг эрх чөлөөтэй, түүний дотроос арилжааны банкуудын хадгаламж зээлийн хүүд зах зээлийн бус аливаа хяналт, хязгаар байгаа эсэхийг тодорхойлох нь өндөр ач холбогдолтой болно.

Монгол улсад 1990-ээд оны эхнээс явуулсан санхүүгийн либералчлах бодлогын үр дүнд олон тооны хувийн банкууд үүсэн гарч, түүнтэй

Хүснэгт 4.3.5.1. Зээл, хадгаламжийн хүүний зөрүү: 1990-2004 он, хувиар

Он	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Хадгаламжийн хүү	153	101.2	101.2	60.1	69.6	42.6	30.0	24.0	24.0	22.0	22.0	20.4
Зээлийн хүү	300	264.0	110.0	125.0	71.0	45.8	38.8	34.7	41.4	33.4	31.5	30.0
Зээл хадгаламжийн хүүний зөрүү	147	162.8	8.8	64.9	1.4	3.2	8.8	10.7	17.4	11.4	9.5	9.6

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

уралдан хадгаламж, зээлийн хүү өсч, зөрүү нь ч улам их болж байжээ (Хүснэгт 4.3.5.1-д харуулав).

Монголын төр, засгийн газрын зүгээс арилжааны банкуудын хадгаламж зээлийн хүүг тодорхой түвшинд тогтоох, барих талаар тусгай хууль, дүрэм журам гаргаж байгаагүй бөгөөд хүү зах зээлийн хүчээр зохицуулагдаж ирсэн болно.

Зээлийн хүү тогтвортой, бага багаар бууж байгаа ч олон улсын зах зээлтэй харьцуулахад өндөр хэвээр байсаар 15 дахь жилийн нүүр үзэж байгаа учир зээлийн хүүг багасгах шаардлагатай байгаа болон түүнийг бууруулах ямар нэг арга хэмжээ авах тухай улам их ярилцах боллоо.

Фрейзер Институтийн аргачлалаарх тооцоолол

Фрейзер Институтийн аргачлалаар бол тухайн оронд банкны хадгаламж болон зээлийн хүүг хязгаарлах, тогтмол түвшинд байлгах арга хэмжээ төр засгийн зүгээс тусгайлан авж байгаагүй бол хүүг зах зээл өөрөө тогтоож байна гэж үзээд тухайн оронд зээлийн эрх чөлөөг сайн буюу 10 гэсэн үнэлгээ өгдөг. Хэрэв хадгаламжийн хүү зээлийн хүүгийн хоорондын зөрүү ихээхэн бол (8 % ба түүнээс их бол) үнэлгээ 8, хэрэв засгийн газар хүү тогтооход оролцдог бол 6 гэсэн үнэлгээ өгдөг.

Зөвхөн Фрейзер Институтийн үнэлгээ хэрэглэхэд зээл хадгаламжийн хүүгийн зөрүү нь тооцооны 1995 онд 8.8, 2001 онд 10.7, 2002 онд 11.4, 2003 онд 9.5, 2004 онд 9.6 байгаа нь бүгд 8 гэсэн оноо авч байна.

Монгол орны хувьд төрийн хяналтын арга хэмжээ авагдаагүй учир хамгийн өндөр үнэлгээ шууд өгч болох ч

- хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү их,
- зээлийн хүү тогтвортой өндөр байгаа,

- нэг жилээс дээш хугацаагаар зээл бага хэмжээгээр олгогдож байгаагийн цаана эдийн засгийн эрх чөлөө, түүний дотор зээлийн эрх чөлөө ямар нэгэн байдлаар боогдмол байна гэж үзэж байна. Иймээс, бодит байдлыг тооцон нэмэлт үнэлгээг оруулах санал гаргаж байна.

Нэмж боловсруулсан индексийн үзүүлэлт

Фрейзерийн дэд индексийн тооцоог Монголын нөхцөлд тохируулан өөрчлөхдөө, зөвхөн хүү биш, зээлийн хугацааг нэмж индексийн тооцоонд оруулах саналыг дэвшүүлж байна. Зээлийн хугацаа бол эдийн засагт тухайн зээл санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, цаад утгаар эдийн засгийн өсөлтөд нөлөөлөхүйц чухал үзүүлэлт мөн.

Индексийг тооцохдоо

- зээлийн хүүгийн түвшинг үнэлгээний хувийн жингийн хагас нь,
- зээлийн хугацааг үлдсэн хагас нь болгож тооцох санал тавьж байгаа юм.

Хүүгийн түвшинг тухайн жилийн инфляцаас хасаад (өөрөөр хэлбэл бодит хүүгийн түвшинг) үнэлэхдээ

- 15 аас дээш бол 5,
- 10-аас дээш бол 6,
- 10-9 байхад 7,
- 9-7 байхад 8,
- 7-5 байхад 9
- харин 5-аас доош бол 10 байхаар тооцлоо.

Энэ үзүүлэлтийг цаашдаа LIBOR-ийг оролцуулан тооцвол улам боловсронгуй болох юм. Манайд энэ үзүүлэлт манай судалгаанд орж байгаа 1995 онд 60, 2001 онд 27, 2002 онд 33, 2003 онд 27, 2004 онд 19 буюу 15-аас дээш хувь байгаа учир бүх жилүүдэд энэ үнэлгээ 5 болж байна.

Хүснэгт 4.3.5.2. Зээлийн ерөнхий үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр

Огноо	2002.12.31	2003.06.30	2003.09.30	2003.11.30	2003.12.31	2004.11.30	2004.12.31	2005.05.31
Ердийн зээл	214.9	294.6	319.8	393.6	405.4	534.5	545.6	614.3
Чанаргүй зээл	16.6	32.3	33.2	35.6	36.7	56.6	60.7	45.5
Хугацаа хэтэрсэн зээл	4.8	13.3	11.5	14.4	15.5	21.5	21.6	25.2
Хэвийн бус зээл	2.0	5.9	6.1	4.8	5.4	9.5	11.6	11.9
Эргэлзээтэй зээл	1.1	3.3	2.7	2.7	2.0	7.6	7.1	6.1
Муу зээл	8.6	10.8	12.8	13.7	13.8	18	20.5	27.5

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Зээлийн хугацаа өөрөө эдийн засагт байгаа урт хугацааны санхүүжилтийн Эх сурвалжийн олдцоос хамаардаг бөгөөд хөрөнгийн зах зээлийн хөгжлөөс хамаардаг учир зээлийн эрх чөлөөнд онцгой нөлөөтэй гэж хэлж болно.

Тиймээс, хэрэв арилжааны банкууд:

- Нийт зээлийнхээ 10 хувиас дээш хэсгийг нэг жилээс дээш хугацаагаар олгоогүй бол 5,
- Олгосон зээлийн хагас нь нэг жилээс урт бол 8 оноо,
- 25 хувь нь 3 жилээс их бол 9 оноо,
- Харин 10 хувь нь 5 жилээс дээш бол 10 оноо болгож тооцож болох юм²³.

Энэ аргачлалаар бол 1990 оноос хойш одоог хүртэл нэг жилээс дээш хугацаатай зээлийг хувийн секторт олгосон хэмжээ 27 хувьд л (2004 он) хүрч байжээ. Ийм учир энэ үнэлгээ бүх онд 5 гэж гарч байна. Эцэст нь дээрх 2 үзүүлэлтийн дунджийг Фрейзер Институтын үнэлгээн дээр нэмээд 2-т хувааж манай орны банкны хүүд шууд болон шууд бус хяналт байгаа эсэхийг тоогоор илэрхийлж байх санал гаргаж байгаа юм.

Энэ үзүүлэлт нь сүүлчийн 2 үнэлгээний дундаж буюу 5 дээр 8-ыг нэмж хагаслан 6.5 гэсэн үнэлгээ гэж гарч байна. Бид энэ судалгаагаараа Монгол улсад арилжааны банкны хадгаламж, зээлийн хүүгийн түвшинд шууд хяналт байдаггүй, харин шууд бус хяналт тодорхой хүчин зүйлсийн улмаас оршиж байна гэж үзэж байгаа юм.

Ийм учир Монгол улсын зээлийн эрх чөлөөнд 6.5 гэсэн үнэлгээ өгөх саналтай байгаа юм. Үнэлгээнд нөлөөлж байгаа олон хүчин

зүйлүүд байгаа бөгөөд зарим гол гол хүчин зүйлүүдийг бид доор танилцуулж байна. Гэхдээ бүх шалтгаан бүрэн орсон гэж үзэхгүй байна. Доорх бүлэгт зарим шалтгааныг дэлгэрэнгүй тусгасан болно.

Нэмэлт судалгаа ба индекс: Монгол Улс дахь хадгаламж, зээлийн хүүгийн өнөөгийн байдал болон нөлөөлж байгаа зарим хүчин зүйлүүд

Өнөөдөр санхүүгийн зах зээл давамгайлан ноёрхож байгаа арилжааны банкууд үндсэн хоёр үүрэг гүйцэтгэж байна. Үүнд: Улс орны гадаад дотоод төлбөрийг гүйцэтгэх механизмыг бүрдүүлэх болон мөнгө хадгалагч болон зээлдэгчийг \хөрөнгө оруулагч\ хооронд нь холбодог санхүүгийн зуучлалын үйлчилгээг явуулах үүрэг юм (Хүснэгт 4.3.5.2).

Даатгал, тэтгэвэр болон нийгмийн бусад халамжийн сангууд, хөрөнгийн бирж зэрэг санхүүгийн институт хөгжиж бэхжээгүй Монголын нөхцөлд, бусад хөгжиж байгаа орнуудын нэгэн адилаар арилжааны банкууд нь санхүүгийн секторт давамгайлж ирлээ.

Банкууд зээлийн Эх сурвалжийг нилээд хэмжээгээр хадгаламжаас бүрдүүлдэг бөгөөд Монголын банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө болох хадгаламжийн хэмжээ нь сүүлийн жилүүдэд өсч байна.

Тухайлбал, 1991 оноос буурч 1992-1999 онуудад дунджаар 7.9 хувь байсан хадгаламж, ДНБ-ий харьцаа 2000 оноос эхлэн өсч 9.1 хувь болж 2003 он гэхэд 26.7 хувьд хүрэн, 2004 оноос өсөлтийн хурд нь саарч 28.6²⁴ хувь болсон байна. Энэхүү харьцаа өссөн нь банкны

²³ - Энэ аргачлалд 50, 25 болон 10 гэсэн хувийн жинд өөрчлөлт хийж болох юм.

²⁴ - ДНБ-ийг 2004 оны урьдчилсан гүйцэтгэлээр авав. Монголын УСГ

Хүснэгт 4.3.5.3. Инфляцийн түвшин, 1990-2004 он, хувиар

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Инфляцийн түвшин /%/	52.7	325.5	183.0	66.3	53.1	44.6	20.5	6.0	10.0	8.1	8.0	1.6	4.7	11.0


Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Хүснэгт 4.3.5.4. Бодит хадгаламжийн хүүгийн түвшин: 1990-2004 он, хувиар

Он	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Хадгаламжийн хүү, %	153.0	101.2	101.2	60.1	69.6	42.6	30.0	24.0	24.0	22.0	22.0	20.4
Инфляцийн түвшин, %	183.0	66.3	53.1	44.6	20.5	6.0	10.0	8.1	8.0	1.6	4.7	11.0
Бодит хадгаламжийн хүүгийн түвшин, %	-30.0	34.9	48.1	15.5	49.1	36.6	20.0	15.9	16.0	20.4	17.3	9.4

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Зураг 4.3.5.1. Хадгаламжийн хэмжээ болон хадгаламж, ДНБ-ий харьцаа




Эх сурвалж: Монгол Банк, УСГ, Дэлхийн банкны статистик

систем дэх хямралыг гэтлэн давж, иргэдийн банкинд итгэх итгэл сайжирсан, банкуудын үйл ажиллагаа эрүүлжин идэвхижиж, инфляцийн түвшин тогтвортой болж ирсэнтэй холбож үзэж болно. 2004 онд уг харьцааны өсөлтийн хурд харьцангуй саарсан нь тухайн онд бодит ДНБ-ий өсөлт өндөр буюу 10.6 хувь байсан мөн инфляцийн түвшин өмнөх онуудтай харьцуулахад мөн харьцангуй өндөр буюу 11.0 хувь байсантай холбоотой. Уг үзүүлэлт 28.6 хувь болсноор дэлхийн бусад хөгжиж буй орнуудын түвшинтэй²⁵ дөхөж очсон.

²⁵ - Хөгжиж буй орнуудын Хадгаламж, ДНБ-ий харьцаа 1998 оноос 2003 он хүртэл 24.6-29.9% болтлоо аажмаар өссөн байна. Дэлхийн банкны статистик

Хадгаламж абсолют хэмжээгээрээ 2000, 2001 онд тус тус 36.3, 45.2 хувиар өсч байсан бол 2002, 2003 онд тус тус 62.2, 66.5 хувиар, 2004 онд 42.1 хувиар өсчээ. 2000-2004 оны хугацаан дахь хадгаламжийн хэмжээг ангилал тус бүрээр нь авч үзэхэд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувийн жин 2000-2003 онд дунджаар 66 хувь байсан бол 2004 онд 58 хувь болж буурсан байна. Энэ нь 2004 онд төгрөгийн хадгаламж 25.2 хувиар, валютын хадгаламж 75.0 хувиар өссөнөөс болжээ. Валютын хадгаламж төгрөгийн хадгаламжтай харьцуулахад ингэж ихээр өссөн нь 2004 оны инфляцийн өсөлт болон тухайн он дахь төгрөгийн ханшны тогтворгүй байдлаас үүдсэн байж болох юм. (Зураг 4.3.5.1)

Зураг 4.3.5.2. Инфляцийн түвшин, хувиар 1990-2004 он

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Хүснэгт 4.3.5.5. Инфляцийн татварын орлого, тэрбум төгрөгөөр

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
ДНБ	18.9	47.3	195.0	324.0	550	647	833	817	925	1018.9	1115.6	1240.8	1363
Төсвийн урсгал орлого	6.1	11.3	51.8	82.2	128	153	211	205	248	346.2	430.0	467.7	545

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Гэвч эдийн засгийн хөгжлийн хувийн болон улсын төслүүдийг санхүүжүүлэх “урт мөнгө” Монгол дотроо хараахан алга байна. Монгол Улсад 90-оны эхээр асар өндөрт гарсан бодит зээлийн хүүгийн түвшин 1995 оноос хойш харьцангуй буурч байгаа ч бизнесд сөргөөр нөлөөлж, зээлээ эргүүлэн төлөхгүй байх, дампуурсан компанийн тоо өндөр хэвээр үлдсэн хэвээр байна. Өнөөгийн байдлаар арилжааны банкуудын хадгаламж, зээлийн хүүгийн түвшин тасралтгүй бага багаар буурч байгаа ч, харьцангуй өндөр хэвээр үлдсээр, улмаар бизнес, жижиг дунд пүүсүүдийг санхүүгийн хувьд хүндрүүлэх томоохон шалтгаан болж байна.

Энэхүү хадгаламж, зээлийн хүүгийн түвшин өндөр байсаар байгаад дараах хүчин зүйлүүд нөлөөлж байна гэж үзэж байна. Үүнд:

1. Санхүүгийн систем ихээхэн өндөр татвартай байна.

Монголын санхүүгийн систем ихээхэн өндөр татвар төлж байна. Нэг өвөрмөц татвар нь инфляцитай холбоотой, мөнгийг шинээр

гүйлгээнд гаргах явдал буюу эмисси. Энэ татвар далд утгаараа засгийн газрын хөрөнгийн Эх сурвалж болж төрийн санг баяжуулдаг бөгөөд түүнийг Монгол Банк цуглуулж өгдөг (Хүснэгт 4.3.5.3).


Инфляцийн үр дүнд хадгаламж эзэмшигчдийн мөнгөний худалдан авах чадвар унадаг (Хүснэгт 4.3.5.5) бөгөөд энэ уналтын хэмжээгээр энэ татвар нь төв банкны тусламжтайгаар бүрдэж засгийн газрын орлогын эх сурвалж болдог /Fгу, 1995, р 5/.

26 улсын жишээн дээр засгийн газрын инфляци-татварын орлогын өгөөж нь 1984 онд дунджаар ҮНБ-ий 2.8 %-тай тэнцүү; энэ нь засгийн газрын урсгал орлогын 17%-тай тэнцэж байжээ.

2. Банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээ их өндөр байна.

Монголын арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээ 14 хувь байгаа нь санхүүгийн либералчлах бодлого явуулж буй орны хувьд нилээд өндөрт тооцогдож байна. Эдийн засагчид банкны заавал байлгах

Зураг 4.3.5.3. Заавал байлгах нөөцийн хэмжээ, сая төгрөгөөр



Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Хүснэгт 4.3.5.6. Банкуудын нөөц, нийт хадгаламжийн харьцаа, 1991-2004 он, өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөгөөр

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Хад/ДНБ,(%)	43.3	23.7	17.4	17.9	15.2	13.4	14.4	13.6	13.7	15.5	19.9	28.2	42.0	38.91
ДНБ	18.9	47.3	194.8	324.4	550.3	646.6	832.6	817.4	925.3	1018.9	1115.6	1241.0	1363.0	1808.0
Хадгаламж	8.2	11.2	33.9	58.1	83.6	86.6	119.9	111.2	126.8	157.9	222.0	349.9	572.3	703.5
Банкнаас гадуурх мөнгө	1.7	1.8	8.8	18.8	25.6	41.7	49.8	56.4	87.3	100.9	109.2	120.8	131.5	143.5
Нөөц мөнгө	2.1	5.3	14.3	29.1	37.5	51.2	63.0	74.8	112.1	132.9	143.8	175.3	200.8	234.9
Банкуудын нөөц	0.4	3.5	5.5	10.3	11.9	9.5	13.2	18.4	24.8	32	34.6	54.5	69.3	91.4
Банкуудын нөөц/Хадгаламж, %	4.9	31.2	16.2	17.7	14.2	11.0	11.0	16.6	19.6	20.3	15.6	15.6	12.1	13.0

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

нөөцийн хэмжээг бас нэг татвар гэж үздэг бөгөөд манайх шиг хадгаламжийн хүү өндөр оронд энэ бол Төв банкинд зах зээлээс үнэгүй Эх сурвалж татах боломж болдог. Арилжааны банкууд энэ хөдөлдөггүй мөнгөний зардлыг зээлийн хүүндээ тусгаж байна.

Хэрвээ илүүдэл нөөц хамгийн бага түвшиндээ байна гэж үзвэл, мөнгөний нийлүүлэлтийн үржүүлэгч нь илүү тааварлаж болохуйц болно.

Заавал байлгах нөөц өндөр байгаа нь бас банкны үйл ажиллагааны зардлыг өсгөж байна. Заавал байлгах нөөц нь тэгтэй тэнцүү байхад банкны өөрийн хөрөнгө болон илүүдэл

нөөцийг үл тооцвол, орлого олдог актив нь хадгаламжийн өр төлбөртэй тэнцэх байсан.

Банкуудын нөөц мөнгө (Нөөц мөнгөнөөс хасах нь банкнаас гадуурх мөнгө) болон банкуудын хадгаламж (Хугацаатай болон хугацаагүй хадгаламжийг оруулаад)-ийн харьцаа нь хөгжиж буй 91 орны хувьд дунджаар 21.2 хувь, аж үйлдвэржсэн 19 орны хувьд дундажаар 7.1 хувь байна. Монголд энэ харьцаа Хүснэгт 4.3.5.6 байдалтай байна.

3. Санхүүгийн зуучлалын зардал өндөр байна.

Заавал байлгах нөөцтэй нэгэн адилаар, санхүүгийн зуучлалын зардал нь хадгаламж, зээлийн хүүгийн ялгааг ихэсгэж, энэ нь улмаар санхүүгийн системийн хөрөнгийн хэмжээг багасгадаг. Зээлийн зуучлалын зардал гэдэг нь анхны хадгаламж эзэмшигчээс санхүүжүүлтийн сувгуудаар дамжуулан зээлийг олгогчдоос авагчдад хүргэхтэй холбоотой гарах зардлыг ойлгоно. Тухайн зардал нь дараах зүйлсийг багтаана: зээлийн төслийг шалган сонгох, ашиглалтыг хянах, санхүүгийн тайлан тооцоо гаргах болон чанаргүй зээлээс гарч болох алдагдал зэрэг зүйлүүд орно.

Санхүүгийн зуучлалын зардлыг микро түвшинд хэмжихдээ, хадгаламж нэмэгдсэн хэсгээс шинээр оруулж буй хөрөнгө оруулалтад олгох зээлтэй холбогдон гарах хөрөнгийн зардлуудыг тодорхойлох замаар хэмжиж болно.

Практик дээр санхүүгийн зуучлалын нийт зардлуудад - цалин, элэгдэл хорогдол, болон компьютер болон зар сурталчилгааны зардлууд гэх мэт санхүүгийн зуучлалын орцын зардлуудыг тооцох бөгөөд эдгээр зардал нь нийт орлого олдог хөрөнгийн тодорхой хэсгийн хувьд харьцангуй тогтмол үзүүлэлт болдог.

Хөгжиж байгаа орны банкны систем нь өрсөлдөх чадвар бага, өндөр татварт нэрвэгдсэн, хөгжингүй оронтой харьцуулахад илүү өндөр алдагдалтай байдаг.

Үйл ажиллагааны зардлын, орлого олдог хөрөнгөд эзлэх хувийг арилжааны банкнуудын жилийн тайлангийн эмхтгэлээс тэдний тэнцэл, орлого, зарлагын тайлангаас авч тооцож болно. Энэхүү харьцаа нь санхүүгийн зуучлалын зардлыг нөхөхөд шаардлагатай хадгаламж, зээлийн хүүгийн хоорондын хамгийн бага дундаж зөрүүг /бас тархалт гэдэг/ тогтоож өгдөг.

Монголын хувьд энэ харьцааг цаг хугацааны цуваа (time series)-гаар зэрэгцүүлэн тооцож болно. /Хөгжиж буй орнуудын хувьд 6.56 болон 8.54-ийн хооронд байдаг ба АНУ-ынх 3.4 байсан (1977). Fгу.p X J/. Тухайн зардлыг бас CIR (Cost Income Ratio)-аар буюу зардал орлогын харьцаагаар тооцож болно.

Энэ зардлыг олон нийтэд зориулан хэвлэдэг банк бүрийн жилийн тайлангаас гаргаж болох

бөгөөд Монголын нөхцөлд нийтлэг өндөр гардаг ч татварт тооцогддог зардал бол зар сурталчилгааны зардал юм.

4. Банкуудын ашиг харьцангуй өндөр байна.

Зөвхөн хадгаламж, зээлийн үйл ажиллагаанаас л гэхэд эрсдэлгүй олгоод байхад хүүгийн зөрүү нь хангалттай их байгаа нь өндөр ашиг олох суурь нөхцөл болж байна.


5. Зээлийн эрэлт маш их хэвээрээ байна.

Зах зээлд нийлүүлж байгаа зээл түүний дотор арилжааны банкны зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд нийт активийн өсөлтөөс ч хурдан өсч байгаа ч зээл авах өргөдөл арилжааны банкуудаар улам их болж байна.

6. Банкны гадуур байгаа мөнгөний тоо их

Банкны гадуур байгаа мөнгөний тоо их байна. Энэ мөнгө банкны эргэлтэд ордоггүй учир мөнгөний үржих чадварыг нэмдэггүй улмаар бэлэн мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлдөггүй (Хүснэгт 4.3.5.7).

Зураг 4.3.5.4. Банкнаас гадуурх мөнгө(CR): 1998.01-2004.12



Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл


7. Монгол улсад аж ахуйн байгууллагын ашиг болон бусад татварууд их учир татвараас зугтах, нягтлан бодох давхар бүртгэлийн систем тогтож байгааг бараг бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээлж байна.

Хүснэгт 4.3.5.7. Банкнаас гадуурх мөнгөний үзүүлэлтүүд, мөнгөний үржүүлэгч, 1991-2004 он

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Банкнаас гадуурх мөнгө(CR)	1.7	1.8	8.8	18.8	25.6	41.7	49.8	56.4	87.3	100.9	109.2	120.8	131.5	143.5
Нөөц мөнгө(M0)	2.1	5.3	14.3	29.1	37.5	51.2	63.0	74.8	112.1	132.9	143.8	175.3	200.8	234.9
Нийт мөнгө(M2)	9.9	13.1	42.8	76.8	102.0	128.4	170.1	167.2	220.2	258.8	331.1	470.1	703.3	847.0
CR/M0, %	80.95	33.96	61.54	64.6	68.27	81.45	79.05	75.4	77.88	75.9	75.9	68.91	65.49	61.09
CR/M2, %	17.17	13.74	20.56	24.48	25.1	32.48	29.28	33.73	39.65	39.0	33.0	25.7	18.7	16.94
Мөнгөний үржүүлэгч (M2/M0)	4.714	2.472	2.993	2.639	2.72	2.508	2.70	2.235	1.964	1.95	2.3	2.7	3.50	3.61


Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Зураг 4.3.5.5. Банкнаас гадуурх мөнгөний нийт нөөц мөнгөнд эзэлж буй хувь: 1998.01-2004.12



Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

Зураг 4.3.5.6. Банкуудын нөөц мөнгөний нийт нөөц мөнгөнд эзэлж буй хувь: 1998.01-2004.12



8. Монгол улсын засгийн газар хамгийн том худалдан авагч боловч асар их мөнгийг (Төрийн сангийн өөрийн нь мэдээллээр 2005 оны 7-сарын эхээр 66 орчим тэрбум төг) Төрийн Сан байгуулан хүүгүй ба бараг эргэлтгүй шахуу хадгалж байна. Энэ бол санхүүгийн зах зээлийг ихээхэн сулруулж байгаа нэг шалтгаан мөн. Засгийн газрын хөрөнгө аж ахуйн банкаар дамжиж байсан бол, тэр хэмжээгээр банкуудын санхүүгийн боломж нь өсч, нийт эдийн засагт эерэг нөлөө бий болно. Япон Улсад энэ жил улсын шуудангийн хадгаламжийн системийг хувьчлах гэж байгаа нь адилхан шалтгаантай бөгөөд нийт хадгаламжийн хэмжээ бага байгаа буурай хөгжилтэй Монгол Улсын хувьд байгаа бүх санхүүгийн нөөцөө аж ахуйн эргэлтэнд оруулах, хувийн банкаар дамжуулах нь нийт улсын санхүүгийн зах зээлийг эрүүлжүүлэхэд маш чухал зүйл байгаа юм. Зарчмын хувьд Төрийн сангийн тогтолцоо бол зах зээлд ихээхэн харш, төрийн оролцоог бэхжүүлсэн механизм гэж үзэж болно.

9. Монгол улсад муу зээлийн хэмжээ нилээд их байна.

Монгол улсын банкуудын олгосон нийт зээлд эзлэх муу зээлийн хэмжээ тогтмол буурч ирсэн ч 2005 оны эхний хагас жилийн байдлаар 6.6 % буюу 45.5 тэрбум төгрөгийн чанаргүй зээлтэй байна гэж Үндэсний Статистикийн Газар мэдээлжээ. (Зууны Мэдээ сонин. 2005-07-16. 6-р нүүр) Монгол улсын арилжааны банкууд муу зээлийн үнэлгээгээ өөрчилсөн учир зарим зээл дээр эрсдлийн сан байгуулж байгаа ч

Хүснэгт 4.3.5.8. Чанаргүй зээлийн үзүүлэлт, 1992-2003 он, өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөгөөр

Он	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Чанаргүй зээл	1.1	4.1	7.3	13.5	33	14.5	32.6	42.1	15.9	10.9	16.6	36.7	60.7
Нийт зээл	19.1	31.6	52.8	63.4	64.8	50.4	85.6	77.5	66.8	135.1	231.4	442.1	606.8
Чанаргүй зээл/ Нийт зээл, %	5.76	13	13.8	21.3	50.9	28.8	38.1	54.3	23.8	8.068	7.174	8.3013	10.0**

Эх сурвалж: Монгол банкны тоон мэдээлэл

Хүснэгт 4.3.5.9. Монголын гадаад худалдааны тэнцэл, 1990-2004 он, сая ам. доллараар

Он	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Экспорт	444.8	346.5	355.8	365.8	367.0	451.0	423.4	568.4	462.3	454.2	535.8	523.2	523.9	627.3	853.3
Импорт	1023.6	486.5	418.4	374.5	370.4	473.0	510.8	538.3	582.4	567.1	675.9	693.1	752.8	826.9	1011.6
Гадаад худалдааны тэнцэл	-578.8	-140	-62.6	-8.7	-3.4	-22.0	-87.4	30.1	-120	-112.9	-140.1	-169.9	-228.9	-199.6	-158.3

Эх сурвалж: Монгол Банкны тоон мэдээлэл

муу зээлдээ оруулахгүй болсон учир энэ тоо 2 оронтой байснаа нэг оронтой тоонд шилжээд байгаа нь энэ (Хүснэгт 4.3.5.8).

10. Монголын гадаад худалдааны тэнцэл тогтмол, тогтвортой сөрөг гардаг.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 1996 оноос хойш байнга сөрөг гарч байгаа. Гадаад худалдааны алдагдал зөвхөн 2003 онд бараг 200 сая ам доллар хүрч байхад төгрөгийн долларын ханш нилээд сулрах (буурах) шахалтанд байна гэсэн үг. Гэтэл төгрөгийн ханшийг зохиомлоор тогтоож байгаа нэг хүчин зүйл бол банкны хүү нь маш өндөр байгаа явдал. Онолын талаас харахад, Монгол Улс гадаад худалдааны алдагдлаа хөрөнгийн балансын илүүдлээр нөхөхийн тулд банкны хүүг өндөр түвшинд хадгалж, төгрөгийн ханшийг хэт өндөр түвшинд байлгаж байна. Энэ бол импортын бараа их хэрэглэдэг Монголын хэрэглэгчдэд ашигтай боловч (импортын бараа хямд байна), экспортлогч үйлдвэрүүдэд сөрөг нөлөө үзүүлж, Монголын барааг дэлхийн зах зээлд үнэтэй болгож буй нэг шалтгаан гэж хэлж болно (Хүснэгт 4.3.5.9).

11. Монголын нийт банкуудын нийт хадгаламжийн хагас нь америк доллараар байна. Гадаад валютын хадгаламжийн хүү төгрөгийнхөөс бага байхад хэмжээ нь ийм өндөр байгаа нь нийт

хадгаламж эзэмшигчдийн үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл бас доогуур хэвээрээ байгааг харуулж байна.

12. ББСБ-тай өрсөлдөхийн тулд түүнчлэн зээлийн хүүг өндөр байлгаж байна. Мөн хувь хөрөнгө нийлүүлэн хорших сонирхол өсөж хадгаламж зээлийн хоршоо олон тоогоор байгуулагдаж байна. Эдгээр хоршоод болон БСББ хадгаламжийн төлөө өрсөлдөж, хадгаламжийн хүүг өсгөж байгаа нь нийт банкны хүү өндөр байгаагийн нэг хүчин зүйл мөн.

** - Энэ үзүүлэлтийг тооцдог аргачлал 2004 оны 10-р сард өөрчлөгдөж, түүний дагуу тооцсон чанаргүй зээлийн үзүүлэлт нь 6%-тай болсон. (Монгол Банкны 2004 оны тайлан): 2004 оны 10 дугаар сард «Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам»-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу хугацаа хэтэрсэн зээлийг чанаргүй зээлд оруулж тооцохыг больсон бөгөөд шинэ аргачлалаар тайлант онд чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл ...39.1 тэрбум төгрөг болсон нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.0 хувийг эзэлж, өнгөрсөн оны эцсийнхээс 1.3 нэгжээр өссөн байна. ... Иймд банкуудын хувьд зээл олгох үйл ажиллагааг чанаржуулах бодит шаардлага гарч байгаа юм.

Хүснэгт 4.4.5.8-д тус үзүүлэлтийг он дарааллаар нь харьцуулах үүднээс 2004 оны 10-р сард Монгол Банкны журамд өөрчлөлт орсноос өмнөх нь баримталж байсан аргачлалын дагуу харуулсан.

Хүснэгт 4.4.1 Монгол Улсын зээлийн зах зээлийн эрх чөлөө

Он	2000	2001	2002	2003	2004
Банкны өмчлөл	2.0	5.0	5.0	8.0	8.0
Өрсөлдөөн	-	6.0	6.0	7.0	7.0
Хувийн хэвшилд олгосон зээл	5.5	5.8	5.5	4.3	5.0
Зээлийн хүү сөрөг түвшинд байх	8.0	8.0	8.0	8.0	8.0
Банкны хүүгийн хяналт	6.5	6.5	6.5	6.5	6.5
Зээлийн зах зээл дэх эдийн засгийн эрх чөлөөний нэгдсэн индексийн үзүүлэлт	5.5 (Өрсөлдөөнийг хасаад)	6.26	6.16	6.76	6.9

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

4.4 МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ НЭГТГЭСЭН ИНДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Зээлийн зах зээлийн бүх дэд индексүүдийг нэгтсэн байдлаар үзүүлэхэд, судалгааны дүн дэд үзүүлэлтээр болон оноор Хүснэгт 4.4.1 байдалтай байна.

Энэ дүнгээс харахад, Монгол Улс дах зээлийн зах зээлийн эрх чөлөө аажмаар дээшилж байна гэж дүгнэж болно. Энэ үзүүлэлт сүүлийн үед ийнхүү сайжирч байгаа нь банкны өмчлөлд төрийн оролцоо багасч, төрийн өмчийн банкууд хувьчлагдсантай холбоотой, нөгөө талаас хувийн секторт олгож буй зээлийн хэмжээ нэмэгдэж, Монголын банкны системд гадаадын хөрөнгийн оролцоо өсч байгаатай холбоотой.

Монголын банкны салбарыг өнгөцхөн харахад, хувийн болон гадаадын хөрөнгө давамгайлсан, харьцангуй чөлөөтэй бөгөөд өрсөлдөөнтэй салбар болж байна гэсэн дүгнэлт хийж болох юм. Үүнийг 2001-2004 оны Фрейзерийн индексийн өсөлтөөр төсөөлж болно. Фрейзерийн индекс Монгол улсын банкны салбарт 2001 онд 6.26 байснаа 2004 онд 6.9-рүү дөхөж байгаа нь сайшаалтай хэрэг.

Гэхдээ энд хоёр асуудлыг авч үзэх шаардлагатай.

1. Энэ үзүүлэлт олон улсын хэмжээнд хэр өндөр байна вэ?
2. Энэ үзүүлэлт өөрөө Монголын зээлийн зах зээлийн байдлыг хэр сайтар харуулж чадаж байна вэ?

Эхний асуултыг бид 5.7 бүлэгт олон улсын харьцуулалтыг хийж авч үзэх болно. Хоёрдугаар асуултыг дүгнэлтийн хэсэгт авч үзнэ.

4.5 ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ

Монгол улс бусад орнуудтай хувийн банкууд дахь хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь, банкны салбарын нийт хөрөнгөнд гадаадын банкны хөрөнгийн эзлэх хувь, гадаадын банкны зөвшөөрлийн/татгалзлын түвшин, хувийн хэвшилд олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувь, бодит зээлийн хүү эерэг, эсвэл сөрөг байх, зээлийн болон хадгаламжийн хүүгийн зөрүү, банкны хадгаламж болон зээлийн хүүг төрөөс хязгаарладаг эсэх зэрэг үзүүлэлтүүдээр 1995, 2000, 2002 оны байдлаар харьцуулахад ямар түвшинд байгааг судалгааны баг 5 субкомпонентээр тус тус харуулсан.

Фрейзер Институтээс гаргасан дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний 2004 оны тайланд хөрөнгийн зах зээл болон зээлийн хүүд тавих хяналт, хязгаарлалт дэлхийн хэмжээнд багассан байна. Хөрөнгийн хяналтын индексийн дундаж утга 1980 онд 2.2 байснаас 2002 онд 5.3 болж, зээлийн хүүгийн хяналтын талаарх индекс 1980 онд 5.4 байснаас 2002 онд 9.1 болж тус тус өссөн гэж дүгнэсэн байна²⁶.

Хүснэгт 4.5.1-д шилжилтийн эдийн засгуудын зээлийн зах зээлийн эрх чөлөөний нэгдсэн индексийг 2000, 2001, 2002 онуудаар харууллаа.

1990 онд ижил гараанаас эхэлсэн шилжилтийн эдийн засгуудтай харьцуулахад ихэнх орнуудын хувьд зээлийн зах зээлийн эрх чөлөөний индекс 2002 оны байдлаар 7.0-8.5 түвшинд байна. Ялангуяа Эстони, Хорват, Латви, Польш, Чех, зэрэг орнуудад хувь хүмүүс, компаниудын хөрөнгө баялгийг

²⁶ - Economic Freedom of the World 2004 Annual Report, хуудас 16.

хамгаалсан, зээл авах, өгөх асуудлаар чөлөөтэй сонголт хийх эрхтэй, чөлөөтэй солилцоо хийх боломжийг бий болгож, социализмын үеийн төрийн хэт зохицуулалтаас чөлөөтэй болж чадсан байна. Монголын хувьд энэ үзүүлэлтээр шилжилтийн эдийн засагтай орнуудын дунд хавьд жагсаж байна.

Хүснэгт 4.5.1 Шилжилтийн эдийн засгуудын зээлийн зах зээлийн эрх чөлөөний индекс

Улс	2000	2001	2002
Болгар	5.9	6.9	7.9
Латви	7.9	8.3	8.4
Литва	6.4	6.8	7.9
Монгол	5.6	6.26	6.16
Орос	3.7	5.1	6.0
Польш	7.1	7.7	8.1
Румын	4.6	6.7	7.2
Словак	7.4	7.4	7.9
Словени	6.5	6.7	8.0
Украйн	4.6	5.5	6.9
Унгар	8.1	8.1	7.9
Хорват	7.7	9.1	8.9
Хятад	4.7	4.7	4.7
Чех	5.8	6.8	8.1
Эстони	7.8	9.0	9.0

Эх сурвалж: Economic Freedom of the World 2004 Annual Report

Эдийн засгийн эрх чөлөөтэй байдлаараа тэргүүлдэг Гонконг, Канад, Сингапур, Их Британи, АНУ орнуудын хувьд зээлийн зах зээлийн эрх чөлөөний индекс 8. 8-10.0 байна. Эдгээр орнуудтай болон хөгжиж буй (шилжилтийн бус) орнуудтай харьцуулалтыг мөн хийлээ. Хүснэгт 4.5.2-д өндөр хөгжилтэй болон хөгжиж байгаа зарим орнуудын хувьд зээлийн зах зээлийн эрх чөлөөний индексийг 2002 оноор харууллаа. Хаалтанд байгаа тоо нь тухайн эдийн засгийн хувьд энэ үзүүлэлтээр 123 орны хаана жагсаж байгааг харуулж байна (Хүснэгт 4.5.2).

Зээлийн зах зээлийн эрх чөлөөний 2002 оны индексийг харахад, Шинэ Зеланд, АНУ, Их Британи, Канад, Гонконг зэрэг орнуудын зээлийн зах зээл маш их эрх чөлөөтэй байхад Бирм, Сири, Уганда зэрэг ядуу буурай орнуудад эрх чөлөө тун хязгаармагдмал байна.

Монгол Улс банкны зээлийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн байдлаар дэлхийн 123 орноос 83 дугаарт жагсаж байна.

Хүснэгт 4.5.2. Зээлийн зах зээлийн эрх чөлөөний индекс, ранг

Улс	2002
Шинэ Зеланд	9.7 (2)
АНУ	9.2 (8)
Их Британи	9.2 (11)
Канад	9.0 (16)
Гонконг	8.9 (19)
Чили	8.3 (34)
Франц	8.2 (40)
Сингапур	7.9 (50)
Филиппин	7.6 (57)
Өмнөд Солонгос	7.4 (63)
Япон	7.3 (69)
Мексик	7.2 (73)
Шри ланк	6.7 (88)
Турк	6.1 (102)
Энэтхэг	5.9 (106)
Бангладеш	5.8 (108)
Малайз	5.8 (107)
Индонез	5.2 (115)
Бирм	2.8 (123)
Монгол	6.9 (83)

Эх сурвалж: Economic Freedom of the World 2004 Annual Report

Монгол Улсын үзүүлэлт нь ийнхүү олон улсын түвшинд Зүүн Европын шилжилтийн орнуудаас арай доогуур, хоёр хөрш ОХУ болон БНХАУ-аас дээгүүр гарсан байна. Энэ бол ирээдүйд Монголд ОХУ болон БНХАУ-аас хөрөнгө орж ирэх замыг бас нээж өгч болох сайшаалтай үзүүлэлт. Гэхдээ Зүүн Европын шилжилтийн орнууд, хөгжилтэй орнуудаас манай улсын үзүүлэлт харьцангуй доогуур байгаа нь улс орны хөгжилд улам жинтэй хувь нэмэр оруулахын тулд Монголын банкны салбарт цаашид нилээд олон зүйлийг сайжруулах хэрэгтэй байгааг харуулж байгаа юм.

4.6 ХЕРИТЭДЖ САН/УОЛЛ СТРИТ ЖОРНАЛЫН «ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БАЙДЛЫН ИНДЕКС»-ТЭЙ ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

Судалгааны баг Фрейзер Институтын аргачлалаар Монгол Улсын банкны зээлийн зах зээлийн эдийн засгийн чөлөөт байдлын индексийг тооцож гаргасан.

Улс орнуудын эдийн засгийн чөлөөт байдлыг хэмждэг өөр нэг байгууллага нь Херитэдж Сан юм. Уг сан нь *Уолл Стрит Журналтай* (The Wall Street Journal) хамтран 1995 оноос дэлхийн улс орнуудын эдийн засгийн чөлөөт байдлыг судлан тогтоож, жил бүр тайлан хэвлүүлж байна. Хамгийн сүүлийн 2005 оны тайланд дэлхийн 161 орон хамрагдсны дотор манай улс багтсан байгаа бөгөөд нэгдсэн индекс 2.70, 50-р байранд “Бараг чөлөөтэй” гэсэн ангилалд багтсан байна.

Фрейзер Институтын аргачлаар тооцсон индексийг харьцуулж болох хамгийн тохиромжтой өөр нэг судалгааны ажил буюу индекс нь Херитэдж Сангийн *Эдийн засгийн чөлөөт байдлын индекс* юм. Учир нь бусад олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын Монгол Улсад хийсэн судалгааны зорилго, арга аргачлал, хандсан талбар зэрэг нэлээн зөрүүтэй, тухайн байгууллагынхаа үйл ажиллагааны зорилгын дагуу хийгдсэн байдаг учраас харьцуулах боломжгүй юм. Жишээ нь, ОУВС-гийн манай улсад явуулж буй гол үйл ажиллагаа нь эдийн засгийг тогтворжуулах, төсвийн алдагдлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах, Дэлхийн Банкны гол үйл ажиллагаа нь ядуурлыг бууруулах, дэд бүтцийг сайжруулах зэрэг үйл ажиллагаанууд байгаа билээ.

Херитэдж Сангийн индекстэй харьцуулахын тулд эхлээд уг индекс, түүнийг тооцдог арга аргачлал болон 2005 оны Монгол Улсын банк санхүүгийн салбарын чөлөөт байдлын индексийн үр дүнг товч танилцуулах хэрэгтэй болов уу. Танилцуулгыг Херитэдж Сангийн *Эдийн засгийн эрх чөлөөний индекс-2005* илтгэлээс бэлдсэн.

Херитэдж Сан/Уолл Стрит Журнал Эдийн засгийн эрх чөлөөний индексийн танилцуулга

Херитэдж Сан/Уолл Стрит Журнал нь 1980-аад оны сүүл үеэс эхлэн *Эдийн засгийн эрх чөлөөний индекс*-ийг анх бодлого боловсруулагчид болон хөрөнгө оруулагчдад зориулан гаргаж эхэлсэн. Өнөөдөр үүний зорилго нь өргөжин дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөг системтэй, эмпирик судалгаагаар хэмжих хэмжилтийг хөгжүүлэх явдал болсон байна.

Уг индекс нь зөвхөн өгөгдлийн олонлог дээр үндэслэсэн эмпирик судалгаанаас илүү эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөгч хүчин зүйлүүдийн онолын маш нухацтай шинжилгээ байдаг.

Дээрх хоёр байгууллага олон жилийн судалгаа, шинжилгээндээ үндэслэн 1995 оноос жил бүр улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлыг илтгэж ирсэн. Эдийн засгийн хөгжлийн төлөв байдал болон үр дагаварын тухай олон онолууд байдаг ч уг индексийн судалгааны үр дүнгүүд нь дараах энгийн, ойлгомжтойгоор тодорхойлогдсон байдаг.

1. Тухайн улсын эдийн засгийн эрх чөлөө хэдий чинээ их байна урт хугацааны эдийн засгийн өсөлт нь өндөр байна.
2. Эдийн засгийн чөлөөт байдал их байх тусам хангалуун байдал нэмэгдэж байна.
3. Эдийн засгийн чөлөөт байдал өнөөгийн интеграцлагдаж, глобалчлагдаж байгаа нөхцөлд эдийн засгийн хөгжилд хүрэх, амжилтаа тогтвортой барихад хамгийн чухал зүйл мөн.
4. Глобал эдийн засагт гарч буй байнгын өөрчлөлтөнд өрсөлдөх чадвартай, эерэгээр хариу үйлдэл үзүүлэхийг хүсэж буй улс орны хувьд нээлттэй зах зээл хамгийн чухал юм.

2005 оны илтгэлд дэлхийн 161 улс орны эдийн засгийн чөлөөт байдлыг өргөн хүрээг хамарсан нийт 10 бүлэг, 50 бие даасан хувьсагчаар судлаж, хэмжин тогтоожээ. Үүнд:

- Худалдааны бодлого (Trade policy)
- Засгийн газрын санхүүгийн дарамт (Fiscal burden of government)
- Эдийн засаг дахь засгийн газрын оролцоо (Government intervention in the economy)

Хүснэгт 4.6.1 Санхүү, банкны секторын эрх чөлөөний индексийн онооны тайлбар

Оноо	Банкин дахь хязгаарлалт	Шалгуур
1	Маш бага	Санхүүгийн секторт засгийн газрын оролцоо өчүүхэн бага; гадаадын санхүүгийн байгууллагууд маш цөөхөн хязгаарлалттай; банкууд бүх төрлийн санхүүгийн үйлчилгээг сонирхох боломжтой
2	Бага	Санхүүгийн секторт засгийн газрын оролцоо бага; гадаадын банкуудад цөөхөн хязгаарлалт оноодог; тухайн улс зарим хязгаар санхүүгийн үйлчилгээнд оноодог; дотоодын банкны үйл ажиллагаа зарим саад хоригтой учирдаг
3	Дунд зэрэг	Засгийн газар банкуудад их хэмжээгээр нөлөөлдөг; засгийн газар зарим банкуудыг эзэмшдэг эсвэл хянадаг; засгийн газар зээлийг хянадаг; дотоодын банкны үйл ажиллагаа хүнд саад хоригтой учирдаг
4	Их	Санхүүгийн секторт засгийн газрын оролцоо хүнд; банкны систем нь шилжилтийн шатанд байгаа; банкууд засгийн газрын шууд хяналтанд байдаг; хээл хахууль боломжтой; дотоодын банкны үйл ажиллагаа бараг байхгүй
5	Маш их	Санхүүгийн тогтолцоо нь эмх замбараагүй байдалд байгаа; банкууд нь энгийн, хуучин арга барилаар ажилладаг; ихэнх зээл засгийн газрын хяналтанд, зөвхөн улсын үйлдвэрийн газруудад олгогддог; хээл хахууль өргөн тархсан

- Мөнгөний бодлого (Monetary policy)
- Капиталын урсгал ба гадаадын хөрөнгө оруулалт (Capital flows and foreign investment)
- Банк, санхүү (Banking and finance)
- Цалин ба үнэ (Wages and prices)
- Өмчийн эрх (Property rights)
- Зохицуулалт (Regulation)
- Албан бус зах зээлийн үйл ажиллагаа (Informal market activity)

Эдийн засгийн чөлөөт байдлын хэмжилт. Эдийн засгийн чөлөөт байдал нь *иргэд өөрсдөө эрх чөлөөгөө хамгаалах болон сахин хадгалахад зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт ба хэрэглээн дэх засгийн газрын албадлага эсвэл хязгаарлалт хэр зэрэг байгаагаар тодорхойлогдоно*. Өөрөөр хэлбэл, хүмүүс хамгийн зөв гэж бодсон зүйлээ хийж, хэрэглэж, тэр зүйлдээ хөрөнгө оруулж байхыг хэлнэ.

Засгийн газар хүмүүст ямар нэгэн хязгаарлалт оноовол тэдгээрийн төлөв байдал өөрчлөгдөж, энэ нь ихэнхдээ сайн сайхан тал уруугаа биш байдаг. Албадлага нь хүмүүс энгийн, хэвийн байхдаа хийх байсан сонголтуудыг өөрчилж, ялгаатай болгодог. Энэ үед эдийн засгийн чөлөөт байдал буурч эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөнө.

Жин: 10 хүчин зүйл нь ямар ч улсын эдийн засгийн чөлөөт байдалд ижил нөлөөтэй, ач холбогдолтой учраас бүгд адилхан жинтэй

байна. Нөгөө талаас индекс гэдэг нь хүчин зүйл тус бүрийн нөлөөг хэмжих зориулалттай бус нийт эдийн засгийн төлөв байдлыг илэрхийлэх зорилготой учраас ижил жин авах нь тохиромжтой байдаг.

Үнэлгээ: Тухайн улсын эдийн засгийн чөлөөт байдлыг тодорхойлогч үндсэн 10 хүчин зүйл бүр 1-5 гэсэн түвшингээр үнэлэгдэнэ. 1 гэсэн үнэлгээ нь эдийн засгийн орчин буюу бодлогын олонлог нь эдийн засгийн чөлөөт байдалд хамгийн сайнаар нөлөөлж байгаа, түлхэц болж байгааг, харин 5 гэсэн үнэлгээ нь өмнөхийн эсрэг байдлыг тэмдэглэнэ. Үүнээс гадна, хүчин зүйл тус бүрийн үнэлгээг “илүү сайн” (чөлөөт байдлын хүчин зүйл сайжирсан), “муу” (чөлөөт байдлын хүчин зүйл муудсан), “тогтвортой” (чөлөөт байдлын хүчин зүйл өөрчлөгдөөгүй) гэж тодорхойлж болно.

Эцэст нь 10 хүчин зүйлсийн үнэлгээний энгийн дунжийг тодорхойлсноор тухайн улсын эдийн засгийн чөлөөт байдлын индекс тодорхойлогдоно. Гарч ирсэн индексээр нь улс орнуудыг дараах 4 категорт хувааж болдог.

1. **Чөлөөтэй** – нийт дундаж оноо нь 1.99 болон үүнээс бага улс орнууд
2. **Бараг чөлөөтэй** – нийт дундаж оноо нь 2.00-2.99 улс орнууд
3. **Бараг чөлөөтэй бус** – нийт дундаж оноо нь 3.00-3.99 улс орнууд
4. **Боогдмол (repressed)** – нийт дундаж оноо нь 4.00 болон түүнээс дээш улс орнууд

“Банк, санхүү” бүлэгт хамаарагдах хувьсагчид болон үнэлэсэн зарчим: Уг бүлэг нь 10 үндсэн бүлэг хүчин зүйлсийн нэг бөгөөд үүнийг дэлгэрэнгүй танилцуулж байгаагийн шалтгаан нь уг бүлэг нь судалгааны багийн гүйцэтгэсэн Фрейзер Институтын индексийн 5-р бүлгийн “А” хэсэг “Зээлийн зах зээлийн зохицуулалт” гэсэн дэд бүлэгтэй ерөнхийдөө адилхан, индексийг тодорхойлж байгаа хувьсагчид нь мөн адилхан байгаа юм.

Банк, санхүү гэсэн энэ бүлгээр тухайн улсын банк болон санхүүгийн системийн харьцангуй нээлттэй байдлыг хэмжих зорилготой. Хэмжилтийг дараах хувьсагчдыг үнэлэх замаар гүйцэтгэдэг. Үүнд:

- Засгийн газрын санхүүгийн байгууллагын эзэмшил
- Гадаадын банкууд салбар болон төлөөлөгчийн газраа нээх боломжийг хязгаарласан хязгаарлалт
- Зээлийн хуваарилалтан дахь засгийн газрын нөлөөлөл
- Засгийн газрын зохицуулалт
- Бүх төрлийн санхүүгийн үйлчилгээ, хамгаалалт болон даатгалын бодлого санал болгох чөлөөт байдал

Эдгээр хувьсагчдад Хүснэгт 4.6.1 зарчмаар оноо тавина.

Монгол Улсын “Банк, санхүү” бүлгийн 2005 оны үр дүн. Херитэдж Сангийн 2005 оны индексийн судалгаа нь улс орнуудын 2003 оны 2-р хагасаас 2004 оны 1-р хагасад хамаарах өгөгдлүүд, мэдээллийг хамарчээ.

Монгол Улсын “Банк, санхүү” гэсэн бүлгийн ерөнхий оноо “3” буюу банк, санхүүгийн зах зээл **дунд зэргийн хязгаарлалттай** гэсэн үр дүн гарчээ. Энэ нь өмнөх оноосоо өөрчлөгдөөгүй, тогтмол гарсан байна. Манай улсын банк, санхүүгийн зах зээлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Монголын сул хөгжилтэй санхүүгийн сектор нь 12 арилжааны банкнаас бүрдэх ба зарим нь хувийн, зарим нь улсын өмчийнх байна. Засгийн газар өөрийн эзэмшлийн зарим банкуудаа хувьчилж байгаа. Худалдаа Хөгжлийн банк 2002 онд олон улсын консерциумд зарагдсан бол Хөдөө Аж Ахуйн банк 2003 онд Япон Улсын нэгэн компанид зарагджээ.

- 2004 оны 3-р сард Төв Банк арилжааны банкны дүрмийн сангийн доод хэмжээг 3.4 сая ам.доллар болгож нэмэгдүүлсэн.
- АНУ-ын Худалдааны Албанаас (U.S Department of Commerce) мэдээлснээр “Орон сууцны зээл Монголд бараг байхгүй, учир нь банкны сектор сул. Жилийн дундаж хүүгийн түвшин 35 хувиар маш цөөн хүн орон сууцны зээлийг авахыг хүсэх буюу боломжтой байдаг. Маш олон бизнес эрхлэгчид өөрсдийн тогтмол хөрөнгөө олон төрлийн бизнесийн харилцаанд баталгаа болгож хэрэглэхийг эрмэлздэг. Энэ үед эдгээр хөрөнгө нь албан ёсны бүртгэлгүй (registry) байдгаас баталгаа болох боломжгүй болдог.
- Хувийн хадгаламж зээлийн хоршоод бий болж жижиг банкны үүргийг гүйцэтгэж эхэлж байна.

Харьцуулалт

Судалгааны багийн тодорхойлсон Фрейзер Институтын “Зээлийн зах зээлийн зохицуулалт” хэсгийн индекс болон Херитэдж Сангийн гаргасан 2005 оны “Банк, санхүү” хэсгийн индексийн үр дүнгүүдийг дараах байдлаар нэгтгэн харуулья (Хүснэгт 4.6.2).

Хоёр индексийн харьцуулалтын дүгнэлт

Дээрх зүйлүүдээс дараах харьцуулсан дүгнэлтүүдийг хийх боломжтой байна.

1. Банк, санхүүгийн сектор буюу зээлийн зах зээлийг төлөөлүүлж байгаа хувьсагчид нь хоёр индексийн хувьд ерөнхийдөө адилхан байна.
2. Индексийг тооцож буй аргачлал, үнэлгээ, жин, дундачлал нь зарчмын хувьд яг адилхан. Зөвхөн чөлөөт байдлын зэргийг тэмдэглэх онооны дараалал, хэмжээсийн ялгаатай байдал байна. Тухайлбал, Фрейзер Институт 2-10-ын хоорондох тэгш тоогоор чөлөөт байдлыг нэмэгдэх байдлаар тэмдэглэж байгаа бол Херитэдж Сангийн аргачлалаар 1-5 гэсэн тоогоор урвуу, өөрөөр хэлбэл чөлөөт байдал сайжрах тусам бага тоогоор тэмдэглэж байна.
3. Манай улсын банк, санхүүгийн зах зээлийн тухайн үеийн төлөв байдлыг тодорхойлсон

Хүснэгт 4.6.2 Хоёр индексийн харьцуулалт

Фрейзер Институтын «Зээлийн зах зээлийн зохицуулалт» хэсгийн индекс			Херитэдж Сангийн «Банк, санхүү» хэсгийн индекс		
Хувьсагч, үзүүлэлт	Үр дүн	Тайлбар	Хувьсагчид	Үр дүн	Тайлбар
Банкны өмчлөл	8.0	Хувийн банкны хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувьд 75-90%	ЗГ-ын санхүүгийн байгууллагын эзэмшил	-	- Засгийн газар банкуудад их хэмжээгээр нөлөөлдөг;
Гадаадын банкуудтай хийж буй өрсөлдөөн	7.0	Гадаадын банкны хөрөнгийн нийт банкны секторын хөрөнгөнд эзлэх хувь 40%; хүсэлтийн татгалзлын түвшин 16.7%	Гадаадын банкууд салбар болон төлөөлөгчийн газраа нээх боломжийн хязгаарлалт	-	- засгийн газар зарим банкуудыг эзэмшдэг эсвэл хянадаг;
Хувийн хэвшилд олгож буй зээл	5.0	Нийт банкны зээлд хувийн хэвшилд олгосон зээлийн эзлэх хувь 55%.	Зээлийн хуваарилалтан дахь ЗГ-н нөлөөлөл	-	- засгийн газар зээлийг хянадаг;
Зээлийн хүү сөрөг түвшинд байх	8.0	Зээлийн хүү зах зээлээр тодорхойлогддог; зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү 8%-иас их	Засгийн газрын зохицуулалт	-	- дотоодын банкны үйл ажиллагаа хүнд саад хоригтой учирдаг
Банкны хүүгийн хяналт	6.5	Бодит хүү 8%-иас их; хугацааг тооцсон	Бүх төрлийн санхүүгийн үйлчилгээ, хамгаалалт болон даатгалын бодлого санал болгох чөлөөт байдал	-	
Нэгтгэсэн индекс	6.9	10-аас харьцангуй бага, дунд зэрэг	Нэгтгэсэн индекс	3	Дунд зэргийн хязгаарлалттай

тодорхойлолтууд нь судалгааны багийн хийсэн дүгнэлтүүдтэй ерөнхийдөө тохирч байна.

- Херитэдж Сангийн индексийн хувьд хувьсагч бүрийн оноог илтгэлгүй, тэдгээрийн энгийн дундаж буюу нэгтгэсэн ганц индексийг л өгсөн байгаа. Хэрвээ хувьсагч тус бүрийн оноо тодорхой байсан бол үзүүлэлт тус бүрээр харьцуулалт хийх боломжтой байсан.
- Аль аль индекс нь банк, санхүүгийн салбар буюу зээлийн зах зээлийн *эдийн засгийн чөлөөт байдал дунд зэрэг* байна гэдгийг харуулж байна. Эндээс судалгааны багийн тооцоолол үндсэндээ өөр тусдаа байгууллагаас тооцсон үр дүнтэй адилхан, энэ утгаараа бодит байдлыг илтгэж чадсан гэж дүгнэж болно.

4.7 БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Судалгааны багаас Фрейзерийн индексд ордог 5 компонентийн буюу

- Банкны өмчлөл
- Өрсөлдөөн
- Хувийн хэвшилд олгосон зээл
- Зээлийн хүү сөрөг түвшинд байх
- Банкны хүүгийн хяналт-ын хувьд

тус тусд нь, мөн нэгдсэн индексийн талаар дараах дүгнэлтэд хүрсэн байгаа:

Банкны өмчлөл: Сүүлийн жилүүдэд идэвхтэй явагдсан банкны хувьчлалын үр дүнд Монгол дахь хувийн, түүний дотор гадаадын банкуудын нийт банкны системд эзлэх хувь нь эрчимтэй өсч, улсынболон төрийн оролцоотой банкуудын нийт жин нь их багассан байна.

Хэрэв энэ үйл явцыг нийт банкны систем дэх бүх арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн гадаадын болон хувийн банкуудын хувиар илэрхийлбэл, энэ өсөлт улам тод харагдаж байгаа юм. 2004 оны 6-р сарын байдлаар

банкуудын өөрийн хөрөнгийн 141 тэрбум төгрөгийн 48.92% зөвхөн гадаадын банкууд эзэлж, нийт дүрмийн сангийн 110 орчим тэрбум төгрөгийн 45% эзэлсэн байна²⁷.

Үүнээс ОХУ-ын Чингис Хаан банк дангаараа нийт банкуудын өөрийн хөрөнгийн 27% эзэлж байгаа, дүрмийн сангаар нь мөн л Чингис Хаан банк нийт банкуудын дүрмийн сангийн 33.2% -ийг бүрдүүлж байгаа нь Монголын банкны систем одоохондоо олон улсын хэмжээнд цар хүрээ их бага байгааг харуулж байгаа юм. Мөн Монголын бусад банкууд хараахан түүнтэй дүйцэх хэмжээнд очиж чадаагүй байна. Монголын хувьчлагдсан томоохон банк болох ХХБ-ны өсөлт салбарын дундаж өсөлтөөс ихээхэн хоцорч, зах зээлд эзэлж байсан байр сууриа алджээ.

Хэдийгээр банкны өмчлөл нь Фрейзерийн индекс банкны үйл ажиллагааны чухал нэг үзүүлэлт байгаа боловч, дээрх тооноос үзэхэд Монгол Улсад банкны хувьчлал нь харилцан адилгүй үр дүнд хүргэж байгаа нь харагдаж байна. Үүний нэг шалтгаан гэвэл банкны хувьчлал гэдэг нь механикаар өмчлөгчийг солиод зогсох биш, банкны үйл ажиллагааны чиглэл, бүтэц, боловсон хүчин, стратегийг хэвээр нь үлдээх юм бол жинхэнэ шинэчлэл хийгдэхгүй бөгөөд харин ч үзүүлэлтүүд дордож болзошгүй байна. Төрийн өмчид үлдсэн бусад Монголын төрийн болон төрийн оролцоотой банкуудын ихэнхи нь 2000-2004 онд ХХБ-аас нилээд өндөр өсөлттэй байсан. Тэгэхлээр, үүнээс банкны өмчлөл бол чухал үзүүлэлт мөн боловч банкны үйл ажиллагааг тодорхойлох цорын ганц үзүүлэлт биш гэдэг нь харагдаж байна.

Өрсөлдөөн: Гадаадын банк гэсэн ойлголтыг гадаадын хөрөнгө оруулалттай гэж үзэн Фрейзер Институтийн аргачлаар тооцоход индекс 2001-2002 онуудад 6, 2003-2004 онуудад 7 гэсэн утгууд авч байна. Харин гадаадын банкиг гадаадын банкны төлөөлөл, салбар гэж үзсэн үед дээрх онуудад индексийн утга тогтмол 6 байна. Сонгож авсан улсуудтай 2001, 2002 онуудыг харьцуулахад ерөнхийдөө дундаж

түвшинд байна. Гэхдээ ижил нөхцлөөс эхэлж, шилжилт хийж буй улсуудаас сүүл барьж байна.

Монгол Улсын санхүү, банкны салбарын өнөөгийн нөхцөл байдлын нэмэлт судалгаа болон нөхцөл тавьсан үед дээрх үр дүн 3-4 хүртэл буурч байна. Үүнийг бусад улсуудтай харьцуулахад хөрш БНХАУ-аас л ганцхан илүү гарч, манай улсын нөхцөл байдал илт муудна. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хөрөнгийг нэмж тооцоход индексийн үр дүнд нөлөө үзүүлэхгүй байна.


Хувийн хэвшилд олгосон зээл: Манай улсад арилжааны банкуудаас хувийн хэвшилд олгож байгаа зээлийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж ирсэн бөгөөд энэ нь нэг талаас улс орны эдийн засагт хувийн секторын хэмжээ идэвхтэй нэмэгдсэн, нөгөө талаас эдийн засаг өөрөө хурдан өсч ирсэнтэй холбоотой. 1990 оноос хойш Монгол улсын засгийн газар улсын үйлдвэр аж ахуйн газруудыг эрчтэйгээр хувьчилж ирсэн бөгөөд одоо үлдээд байгаа үндэсний агаарын тээврийн компани, дийлэнхи хувийг эзэшиж байгаа ноолуурын үйлдвэр, Оростой хамтарсан зэсийн баяжуулах үйлдвэр зэрэг цөөн тооны газруудыг хувьчлах бодлого баримталж байна. Олгосон зээлийн хэмжээ өсч байгаа зээлийн эрэлт улам бүр их болж байгаа нь нэг талаас эдийн засгийн өндөр өсөлтөөс болж, нөгөө талаас Монгол улсад хадгаламж зээлийн хүү өндөр, зээлийн хугацаа богино байгаатай холбоотойг энэ судалгаа харуулж байна.

Зээлийн хүү сөрөг түвшинд байх ба банкны хүүгийн хяналт: Энэ хэсэгт хадгаламж, зээлийн хүүнд хяналт байгаа эсэх, чөлөөт буюу зах зээлээр өөрөө тогтоодог эсвэл төрөөс хяналттай тухай судалгаа дүгнэлт хийсэн болно.

Монголын төр, засгийн газрын зүгээс арилжааны банкуудын хадгаламж зээлийн хүүг тодорхой түвшинд тогтоох, барих талаар тусгай хууль, дүрэм журам гаргаж байгаагүй, хүү зах зээлийн хүчээр зохицуулагдаж ирсэн нь харагдаж байгаа ч хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү их, зээлийн хүү тогтвортой өндөр байгаа, нэг жилээс дээш хугацаагай зээл их хэмжээгээр олдохгүй байгаагийн цаана эдийн засгийн эрх чөлөө, түүний дотор зээлийн эрх чөлөө боогдмол байна гэж үзэж болно.

²⁷ - А.Хулан, «Банкны салбар дахь гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа», Монгол Банк, Судалгааны ажлын эмхтгэл, Дугаар 8, 2004 он.

Зураг 4.7.1 Монголын зээлийн зах зээлийн эрх чөлөөний байдал, дэд индексээр



Фрейзер Институтийн үнэлгээг хэрэглэн зээл хадгаламжийн хүүгийн зөрүү нь жилд 8 хувиас их учир 8 гэсэн оноо өгч байгаа ч Монголын бодит байдлыг тооцон зээлийн хүүний түвшин, зээлийн хугацааг нэмэлт үнэлгээ болгон тооцлоо. Энэ тооцоогоор энэ үзүүлэлт нь Монгол улсын зээлийн эрх чөлөөнд 6.5 гэж гарч байна. Үнэлгээнд олон хүчин зүйлүүд нөлөөлж байгааг дурдаад заримыг нь танилцуулсан болно. Үүнд:

- Санхүүгийн системийн өндөр татвар, банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээ их өндөр байгаа,
- Банкуудын ашиг харьцангуй өндөр байгаа,
- Зээлийн эрэлт маш их хэвээрээ байгаа,
- Банкны гадуур байгаа мөнгөний тоо их,
- Аж ахуйн байгууллагын ашиг болон бусад татварууд,
- Засгийн газар хамгийн том худалдан авагч боловч асар их мөнгийг төвлөрүүлсэн,
- Муу зээлийн хэмжээ асар их байгаа,
- Гадаад худалдааны тэнцэл тогтмол, тогтвортой сөрөг гардаг,
- Нийт банкуудын нийт хадгаламжийн хагас нь ам.дол-аар

байгаа зэрэг хүчин зүйлүүд орсон байна.

Банкны салбар Монгол Улсын эдийн засгийн хөгжил, өсөлтэд асар их үүрэгтэй байгаа. Монгол Улсад хөрөнгийн зах зээл сул хөгжсөн улмаас хувийн хөрөнгө оруулалт, нийт эдийн засгийн байдал банкны зээл, банкны салбарын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай болсон байна.

Гэтэл өнөөгийн нөхцөлд Монгол Улсад олгогдож байгаа нийт зээлийн дөнгөж 20-иос илүү хувь нь 1 жилээс дээш хугацаатай зээл байгаа явдал, зээлийн хүү дунджаар 30%, дээд тал нь жилийн 48% хүрч байгаа нь хувийн хөрөнгө оруулалтыг ихээхэн хязгаарлаж, эдийн засгийн өсөлтөд маш сөрөг нөлөө үзүүлж байна.

Зээлийн хүү их өндөр байгаагаас гадна нийт Монголын эдийн засагт хөрөнгийн дутагдал илт болж, өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад эдийн засгийн хөрөнгөжилт (financial deepening) буюу M2 мөнгөний нийлүүлэлт/ДНБ-ий харьцаа дөнгөж 50%-тай байна. Тус судалгааны дүнгээс үзэхэд нийт 5 дэд индексээс 2004 оны байдлаар хамгийн доогуур дүнтэй гарсан нь хувийн секторт олгож буй зээлийн байдал ба хүүгийн тогтолцоо байсан нь дээрх саналыг бататгаж байна гэж үзэж болно.

Зураг 4.7.1—ээс 2000–2004 онуудад банкны өмчлөлийн хүрээнд бий болсон нааштай

өөрчлөлтүүд буюу хувийн банкуудын эрчимтэй өсөлт болон төрийн банкуудын хувьчлал нь хувийн хэвшилд олгох зээл, хүүгийн хяналтын байдалд эерэг нөлөө үзүүлээгүй байна. Мөн энэ хугацаанд банкны өмчлөлийн дэд индексийг эс тооцвол, бусад үзүүлэлтүүд нь бараг өөрчлөгдөөгүй эсвэл хувийн секторт олгосон зээлийн дэд индексийн хувьд буурсан байдалтай байна. Энэ бол бүтцийн болон чанарын өөрчлөлт бага байна, голдуу тооны өөрчлөлтүүд давамгайлж байна гэсэн үг.

Үүний шалтгаан нь гэвэл банкны хувьчлал, гадаадын банкны тооны өсөлт нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах, урт хугацааны зээлийн Эх сурвалжийг нэмэгдүүлэх, Монголын банкны салбарын менежмент, арга барилыг шинэчлэх, мэргэжлийн шинэ ноу-хауг өргөнөөр оруулж ирэх, боловсон хүчний мэргэжлийн түвшинг ахиулахад бодитой нөлөө үзүүлж чадахгүй өөрчлөлтүүд болоод байна гэсэн үг. Жишээлбэл, Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаа ОХУ-ын банкууд бүрэн хэмжээний банкны үйлчилгээг төдийлэн үзүүлэхгүй байна, гадаадын хөрөнгө оруулагчдад хувьчлагдсан ХХБ-ны үйл ажиллагааны үзүүлэлтүүд эрс дордож, тус банк дахь гадаадын хөрөнгө оруулалтын эерэг нөлөө огт харагдахгүй байна. Гадаадын банкны тоо өссөн мэт харагдаж байгаа боловч тус өсөлтийн үр дүн хүлээлтэнд хүрэхгүй байна. Мөн гадаадын том банкууд Монголын зах зээлд орж ирээгүй хэвээр л байна.

Банкуудын тоо нэмэгдэн, салбарууд, бүтээгдэхүүний тоо, төрөл нь олширч, активын хэмжээ ихсэх зэрэг тооны өөрчлөлтүүдээр Монголын банкны систем хөгжиж байна. Гэвч энэ өөрчлөлтүүд нь улс орны хөгжилд илүү их хувь нэмэр оруулах үйлчлүүлэгч, дотоодын бизнес эрхлэгчид, хувь хүмүүст илүү хямд үнэтэй, илүү урт хугацаагаар санхүүгийн Эх сурвалжийг нийлүүлж өгөх, хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зэрэг чанарын хөгжил болж хараахан чадаагүй байна.

Энэ байдал ил тод болж байгаа нь Фрейзер институтын аргачлаар хийсэн уг судалгааны нэг чухал дүн болсон гэж үзэж байна.

4.8 ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС-ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙНЗОХИЦУУЛАЛТ

Монголын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал

Хөдөлмөртэй холбоотой аливаа үйл ажиллагаа нь *Хөдөлмөрийн тухай хууль*, *Үйлдвэрчний Эвлэлүүдийн Эрхийн тухай хууль*, *Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль*, *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль*, *Нийгмийн даатгалын тухай хуулиуд*, *Ажиллах хүчин гадаадад гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль* болон тэдгээртэй холбогдон гарсан бусад хууль тогтоомжуудын актуудаар зохицуулагддаг.

Монголын хөдөлмөрийн зах зээл дээрх агентууд нь ажиллах хүчин, тэдгээрийн эрх ашгийг хамгаалахаар нэгдэн байгуулагдсан үйлдвэрчний эвлэлүүд болон ажил олгогч пүүс компани, байгууллагуудаас бүрддэг.

Монголын ажиллах хүчний бүтэц

Монгол улсын нийт хүн ам 2004 онд 2533.1 мянга болсон бөгөөд үүний 1531.1 мянга нь хөдөлмөрийн насны хүн ам, 986.1 мянга нь эдийн засгийн идэвхтэй хүн юм. Эдийн засгийн идэвхтэй хүн ам нь одоогоор ажил эрхэлж байгаа болон ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүмүүсээс бүрддэг. Ажиллах хүчний оролцооны түвшин 64.4 хувь, ажилгүйдлийн түвшин 3.6 хувь байна.

Өмнөх ондуудад ажиллах хүчин, ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин Хүснэгт 4.8.1 байдалтай байсан.

Дээрх хүснэгтээс харвал ажиллах хүчний оролцооны түвшин 1994 оноос хойш 2001 он хүртэл тасралтгүй буурсаар байсан байна. Энэ хугацаанд ажиллах хүчний оролцооны түвшин нийтдээ 11.7 пунктээр буурсан байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын өсөлтөөс хөдөлмөрийн насны хүн амын өсөлт илүү өндөр байсан учраас ажиллах хүчний оролцооны түвшин буурчээ. Энэ хөдөлмөрийн насны хүн амын их, дээд сургуульд суралцах, гадаадад гарч буй ажиллах хүч болон ажил олдохгүйгээс эсвэл бусад шалтгаанаар ажиллах хүчнээс гарч байгаатай холбоотой байж болох юм. Тухайлбал их дээд, сургууль болон тусгай мэргэжлийн сургуулиудад суралцагчдын тоо

Хүснэгт 4.8.1 Ажиллах хүчний бүтэц

	/мян.хүн/									
	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
Хөдөлмөрийн насны хүн ам	1165.7	1186.7	1212.8	1229.6	1256.8	1279.3	1347.4	1402.8	1439.2	1488.9
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	861.4	839.8	847.2	852	859.3	869.8	847.6	872.6	901.7	959.8
үүнээс:										
Ажиллагчид*	786.5	794.7	791.8	788.3	809.5	830	809	832.3	870.8	926.5
Бүртгэлтэй ажилгүйчүүд	74.9	45.1	55.4	63.7	49.8	39.8	38.6	40.3	30.9	33.3
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	73.9	70.8	69.9	69.3	68.4	68	62.9	62.2	62.7	64.5
Ажил эрхлэлтийн түвшин, %	67.5	67	65.3	64.1	64.4	64.9	60	59.4	60.5	62.2
Ажилгүйдлийн түвшин, %	8.7	5.4	6.5	7.5	5.8	4.6	4.6	4.6	3.4	3.5

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 1999, 2003, YCF

Хүснэгт 4.8.2 Салбарын ажил эрхлэлт

	/мян.хүн/								
Салбар	1995	1998	1999	2000	2001	2002	2003	2004	
Бүгд	767.6	792.6	813.6	809	832.3	870.8	926.5	950.5	
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	354.2	394.2	402.6	393.5	402.4	391.4	387.5	381.8	
Уул уурхай, олборлох үйлдвэр	18.2	18.6	19	18.6	19.9	23.8	31.9	33.5	
Боловсруулах үйлвэр	67.3	57.1	58.5	54.6	55.6	55.6	54.9	57.3	
Бөөний жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	64.8	74.5	83.1	83.9	90.3	104.5	129.7	133.7	
Төрийн байгууллагын үйл ажиллагаа	31.1	30.9	31.5	34.7	41	43.9	44.8	46.2	
Боловсрол	48.5	42.5	43.2	54.4	55.2	59.3	55.3	57.8	
Бусад	183.5	174.8	175.7	169.3	167.9	192.3	222.4	240.2	

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2000, 2004, YCF

1995 онд 48 мянга байснаа тасралтгүй өссөр 2001 онд 107.3 мянга болсон байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2002, 2003 онуудад бага зэрэг өссөн байна. 2000 оноос хойш (2005 оныг үл оролцуулан) ажиллах хүчний оролцооны түвшин дунджаар 63.3 хувь байна. 1994 оноос 2000 он хүртэл үзүүлэлт дунджаар 70.1 хувь байжээ.

Ажиллагсдыг салбараар нь харуулбал Хүснэгт 4.8.2.байдалтай байна.

Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын тоо нэлээд хэлбэлзэлтэй тогтворгүй бөгөөд нийт ажиллагсдад эзлэх хувь нь 1998 оноос хойш тасралтгүй буурчээ. 1998, 1999 онд нийт ажиллагсдын тал хувь нь хөдөө ахуйн салбарт ажиллаж байсан бол сүүлийн гурван жилд дунджаар 42.3 хувь болж буурсан байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын хувь бас тасралтгүй буурсан

байхад бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллагсдын эзлэх хувь өссөн байна. Уул уурхайн салбарт ажиллагсдын тоо болон нийт ажиллагсдад эзлэх хувь хоёулаа өссөн.

Ажилгүйдлийн түвшин 1996, 1997 онуудад өссөн бөгөөд 1998 оноос 2002 он хүртэл буурсан. Хүснэгт 4.8.3-д ажилгүйчүүдийг боловсролын түвшингээр харууллаа.

Хүснэгт 4.8.3. Ажиллах хүч боловсролын түвшнээр

	/хувь/			
	2001	2002	2003	2004
Дээд боловсролтой	6.1	8.9	9.3	9.7
Тусгай дунд боловсролтой	12.8	10.9	9.9	8.6
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгссөн	28.1	12.2	10.9	10.5
Мэргэжилгүй	53.1	68.1	70.0	71.1

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2004, YCF

Ажилгүйчүүдийн дунд дээд боловсролтой болон мэргэжилгүй хүмүүсийн эзлэх хувь 2001 оноос хойш бага багаар өссөөр байхад тусгай дунд боловсролтой болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн хүмүүсийн эзлэх хувь мөн тасралтгүй буурсаар байна.

2002-2003 оны ажиллах хүчний судалгаагаар ажилгүйдлийн түвшин дунджаар 14.2 хувь байсан бөгөөд улирлаар ажилгүйдлийн түвшинг тооцоход I улиралд 18.0 хувь, II улиралд 15.0 хувь, III улиралд 13.2 хувь, IV улиралд 10.7 хувь байжээ. Өөрөөр хэлбэл I улиралд ажилгүйдэл хамгийн өндөр байдаг бөгөөд цаашид буурдаг байна. Энэ нь Монголын цаг уурын байдалтай холбоотойгоор улирлын шинж чанартай ажилгүйдэл юм.

Цалин, хөдөлмөрийн бүтээмжийн харьцаа

Цалин болон чөлөөт цагийн алийг илүү эрхэмлэж байгаагаас хамааран хүмүүс ажил эрхлэх эсэхээ шийддэг. Иймээс цалин нь эдийн засаг дахь ажил эрхлэлтийг шийдэх үндсэн хөшүүрэг юм. Хэрвээ цалин бага байвал хүмүүсийн ажилгүй байх алдагдсан боломжийг өртөг бага байдаг учраас хүмүүс ажиллахаас илүүгээр суралцах болон чөлөөт цагийг эрхэмлэдэг. Нөгөө талаас албан секторт цалингийн түвшин бага байх нь ажилчдын албан бус сектор буюу далд эдийн засагт орох нэг үндсэн шалтгаан болдог. Иймээс хөдөлмөрийн зах зээлийн тухай ярьж буй тохиолдолд цалинг зайлшгүй авч үзэх шаардлагатай. Улсын хэмжээнд сарын дундаж цалинг Хүснэгт 4.8.4-д харууллаа.

Хүснэгт 4.8.4 Дундаж цалин

	оны үнээр, /мян.төг/				
	2000	2001	2002	2003	2004
Дундаж нэрлэсэн цалин	62.3	65.2	71.3	81.5	93.1

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2003, 2004, УСГ

2001 онд дундаж нэрлэсэн цалин 4.4 хувь өссөн байхад инфляци 8 хувь байсан байна өөрөөр хэлбэл, бодит цалин 3.7 хувь буурсан байна гэсэн үг. Харин 2002, 2003, 2004 онуудад дундаж бодит цалин 7.0, 7.8 болон 1.5 хувь тус тус өссөн байна. Иймээс сүүлийн жилүүдэд бодит цалин өсөх хандлагатай байсан боловч 2004

онд инфляци өндөр байсантай холбоотойгоор бодит цалингийн өсөлтийн хурд огцом буурчээ. 2005 оны урьдчилсан байдлаар энэ байдал хадгалагдаж чадахааргүй байна.

Цалинг байгууллагын төрлөөр нь авч үзвэл улсын үйлдвэрийн газрын дундаж цалин хамгийн өндөр, түүний дараа хувьцаат компаний цалин орж байна. Харин хоршоо болон хувиараа эрхлэх аж ахуй хамгийн бага цалинтайг хүснэгт 4.8.5-аас харж болно. Улсын дундаж цалинтай харьцуулахад төсвийн байгууллагын цалин дунджаар 10,000 төгрөгөөр бага байдаг байна.


Хүснэгт 4.8.5. Дундаж цалин байгууллагын төрлөөр:

	оны үнээр, мян.төг				
	2000	2001	2002	2003	2004
Улсын үйлдвэрийн газар	69.9	74.7	81.5	93.6	114.4
Хувьцаат компани	67.8	67.1	77.5	97.2	104.6
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	59.6	63.6	70.9	72.3	80.7
Хоршоо	37.3	50.3	41.9	43	53.2
Хувиараа эрхлэх аж ахуй	39.3	36.1	38.3	57	61.0
Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл	45.9	55.9	80.6	82.5	72.7
Зарим гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл	43.5	38.6	41.7	57.1	60.5
Төсөвт байгууллага	51.3	56	60.5	71.4	85.9
Ашгийн бус байгууллага	42.5	53.9	54.3	63.8	86.9

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2003, 2004, УСГ

Дундаж хөдөлмөрийн бүтээмж болон салбарын хөдөлмөрийн бүтээмжийг Хүснэгт 4.8.7-д харууллаа. Зочид буудал, зоогийн газар болон нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээнээс бусад салбарт хөдөлмөрийн бүтээмж өссөн байна. Хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөртэй салбар нь уул уурхай, олборлох үйлдвэр байна. Түүний дараа тээвэр, агуулахын аж ахуй, холбоо болон санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа гэсэн салбарууд орж байна.

Зураг 4.8.1. Хөдөлмөрийн бүтээмж ба цалнигийн хамаарал



Хүснэгт 4.8.6 Ажиллагсдын дундаж цалин ажил мэргэжлийн төрлөөр

	/мян.төг/			
	2001	2002	2003	2004
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер	93.3	102.1	114.7	135
Мэргэжилтэн	70.3	75.8	88.4	100.8
Инженер, техникийн ажилтан	73.1	81.9	90.3	106.4
Бичиг хэргийн туслах ажилтан	52.0	61.0	67.3	77.0
Үйлчилгээний ажилтан	56.2	59.2	68.6	77.4
ХАА, загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	43.8	54.0	63.0	58.0
Үйлдвэр, худалдааны ажилчин	70.6	76.0	86.8	100.1
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	66.6	79.4	89.6	104.5
Энгийн ажил мэргэжил	48.7	56.8	65.2	69.6

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2003, 2004, ҮСГ


Хөдөлмөрийн бүтээмж багатай салбаруудад зочид буудал, зоогийн газар болон эрүүл мэнд нийгмийн халамжийн салбар орж байна. Боловсруулах үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн бүтээмж нь улсын хэмжээний хөдөлмөрийн бүтээмжтэй харьцуулахад хэлбэлзэлтэй байна. 2001, 2003 онуудад улсын дундаж бүтээмжээс өндөр байсан боловч 2002, 2004 онуудад бага болсон байна.

Хүснэгт 4.8.7 Хөдөлмөрийн бүтээмж

	/мян.төг/			
	2001	2002	2003	2004
Бүгд	1359.5	1457.1	1626.0	1926.5
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	2288.7	2697.1	4015.4	4588.6
Уул уурхай, олборлох үйлдвэр	5238.0	5761.8	6671.0	9565.2
Боловсруулах үйлвэр	1636	1402.4	1637.4	1719.2
Цахилгаан, дулааны үйлд вэрлэл, усан хангамж	1851.4	2490.0	2315.9	2323.7
Барилга	1001.5	1264.2	1477.4	1265.3
Бөөний жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	3305.6	3531.9	3305.6	3382.6
Зочид буудал, зоогийн газар	957.0	824.2	741.9	703.6
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	4189.1	4946.3	5178.9	5607.7
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	4974.3	4731.8	5037.8	5033.9
Үл хөдлөх хөрөнгө түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	1632.6	1663.0	2127.8	2309.2
Төрийн байгууллагын үйл ажиллагаа	1272.9	1318.2	1390.3	1498.1
Боловсрол	913.5	1001.3	1153.1	1330.7
Эрүүл мэнд нийгмийн халамж,	620.7	668.4	714.8	745.2
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	176.4	283.0	273.8	271.1

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2004, ҮСГ

Зураг 4.8.2. Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт улсаар



Эх сурвалж: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, 2005

Зураг 4.8.1-ээс харахад хөдөлмөрийн бүтээмж нь дундаж цалингаас нэлээд өндөр байна. Гэхдээ аль аль нь өсөх хандлагатай байна.

Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн

Монгол Банкны Жилийн Тайланд дурьдсанаар 2003 онд Монгол Улсад ажиллах эрх авсан гадаадын иргэд 7532 байгаа бөгөөд үүний 65.4 хувь нь БНХАУ-ын, 17.6 хувь нь ОХУ-ын, 2.2 хувь нь БНСУ-ын иргэд, үлдсэн нь бусад орны иргэд байна.

Уг тайланд дурьдсанаар манай улсын дэд бүтэц, тухайлбал авто зам, эрчим хүч болон бусад салбарт хэрэгжиж байгаа хэд хэдэн төсөл, улсын хэмжээний томоохон барилга байгууламжууд, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нь улирлын чанартай, богино хугацаанд эрчимтэй явагддагаас шалтгаалан хавар, зуны улирлуудад гадаадаас орж ирэх ажиллах хүч эрс нэмэгддэг байна. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй ажиллаж буй гадаадын иргэдийг эдийн засгийн салбараар авч үзвэл уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт 42.2 хувь, боловсруулах үйлдвэрийн салбарт 12.9 хувь, боловсролын салбарт 10.5 хувь, барилгын салбарт 6.9 хувь, үлдэх хувийг бусад салбарууд эзэлж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны тайланд дурьдсанаар 2005 оны эхний 10 сарын

байдлаар Монгол Улсад нийт 71 орны 9629 гадаадын иргэн хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэдийн 4766 буюу 49.5 хувь нь БНХАУ-ын иргэд, 1803 буюу 18.7 хувь нь ОХУ-ын иргэд, 602 буюу 6.3 хувь нь Украин Улсын иргэд, 377 буюу 3.9 хувь нь БНСУ-ын иргэд, 320 буюу 3.3 хувь нь АНУ-ын иргэд, 1761 буюу 18.3 хувийг бусад орны иргэд тус тус эзэлж байна.


Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн салбараар авч үзвэл:

- Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарт 5230 буюу 53.6 хувь
- Барилгын салбарт 873 буюу 8.9 хувь
- Боловсруулах үйлдвэрийн салбарт 646 буюу 6.6 хувь
- Боловсролын салбарт 621 буюу 6.4 хувь
- Тээвэр холбооны салбарт 527 буюу 5.4 хувь
- 1859 буюу 19.1 хувь нь бусад салбарт тус тус ажиллаж байна.

Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийг боловсролын ангиллаар авч үзвэл:


- 5059 буюу 52.5 хувь нь техник мэргэжлийн
- 2613 буюу 27.1 хувь нь дээд
- 1814 буюу 18.8 хувь нь тусгай дунд боловсролтой

Зураг 4.8.3. Гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



Эх сурвалж: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, 2005

Зураг 4.8.4. Хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэд, боловсролын түвшингээр



Эх сурвалж: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, 2005

- 138 буюу 1.4 хувь нь бүрэн дунд боловсролтой
- 5 буюу 0.2 хувь нь бүрэн бус дунд боловсролтой иргэд тус тус эзэлж байна.

Албан бус сектор дахь хөдөлмөрийн зах зээл


Дэлхийн Банкны хийсэн албан бус секторын талаарх түүвэр судалгаагаар 1997 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотод өрхийн тэргүүн нь албан ёсны ажил эрхэлдэг боловч албан бус сектороос орлого олдог өрх 44%, өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй

бөгөөд албан бус сектороос орлого олдог өрх 73% байсан байна.

1996 оны сүүл болон 1997 оны эхний байдлаар хөдөлмөрийн насны хүн амын 23-32% нь дан ганц албан бус секторт ажиллаж байсан байна.

Уг судалгаагаар Улаанбаатар хотод өрхийн орлогын 32% нь албан бус сектороос олж байна гэсэн үр дүн гарсан. Мөн түүнчлэн өрхийн орлогод албан бус сектороос олсон орлогын эзлэх хувь 1993 оны 1 сараас 1996 оны 12 сарын хооронд хоёр дахин өссөн гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүнийг Зураг 5.8.5-аас харж болно.

Зураг 4.8.5.



Эх сурвалж: «The Size, Origins and Character of Mongolia's Informal Sector during The Transition», James H.Anderson, 1998

4.9. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг хэмжих Фрейзер институтын аргачлал нь дараах таван үзүүлэлтүүдийг 0-ээс 10 хүртэлх түвшингээр тооцдог:

- Хөдөлмөрийн хөлсний доод түвшингийн нөлөө
- Ажилд авах болон ажлаас халах процесс
- Цалин нь төвлөрсөн хамтын хэлэлцээрээр тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь
- Ажилгүйдлийн тэтгэмж
- Цэргийн алба

Одоо эдгээр үзүүлэлтүүдийг тус тусад нь авч үзье.

4.9.А Хөдөлмөрийн хөлсний доод түвшингийн нөлөө

Цалингийн доод түвшин өндөр байх нь ажилчид болон ажил олгогчдын хооронд гэрээ хэлэлцээр хийх боломжийг хязгаарладаг. Тухайлбал, чадвар муутай ажилчид болон ажиллах хүчинд шинээр орж ирж буй хүмүүсийн ажил олгогчтойгоо тохиролцож гэрээ хийх боломжийг хязгаарлаж байдаг. Хэрвээ цалингийн доод түвшин гэж байдаггүй бол ажил олгогчид болон эдгээр ажилчид хоорондоо тохиролцох боломж илүү өндөр байдаг. Иймээс цалингийн доод түвшин

нь ажилчид болон тэдгээрт ажил олгох байсан ажил олгогчдын эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж байдаг.

Хэрвээ хуулиар тогтоогдсон цалингийн доод түвшин нь цалинд маш бага нөлөөлдөг бөгөөд төдийлөн хэрэгждэггүй бол эрх чөлөөний индекс өндөр буюу сайн байна. Харин цалингийн доод түвшингийн тухай хууль нь хүчтэй хэрэгждэг бөгөөд цалингийн доод түвшин нь орлогын түвшинд нэлээд нөлөө бүхий байдаг бол хөдөлмөрийн зах зээлийн эрх чөлөөний индекс бага байдаг.

Фрейзер Институт нь цалингийн доод түвшингийн нөлөөг “Global Competitiveness Report”-ийн цалингийн доод түвшингийн хүч, нөлөө (enforcement) гэсэн үзүүлэлтийг ашиглан тооцдог. Гэвч уг үзүүлэлт нь 2004 оны тайланд ороогүйгээс гадна Монголд авсан судалгааны асуулгад уг үзүүлэлт тусгагдаагүй учраас энэ үзүүлэлт шууд олдох боломжгүй юм.

Цалингийн доод түвшин болон нэг хүнд ноогдох ДНБ-ий харьцаагаар цалингийн доод түвшингийн нөлөөг хэмждэг аргыг 2004 оны Хойд Америкийн эдийн засгийн эрх чөлөөг тооцоход ашигласан²⁸. Иймээс энэ индексийн судалгаанд тус аргыг ашигласан болно.

Хэрвээ хөдөлмөрийн хөлсний хамгийн доод түвшингээр ажиллаж байгаа хүний жилийн орлогыг нэг хүнд ноогдох ДНБ-тэй харьцуулсан харьцаа өндөр байвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж байна гэж үздэг. Хэрвээ энэ харьцаа маш бага байвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь эдийн засгийн эрх чөлөөнд нөлөөлөхгүй. Энэ харьцааг ашиглан бид дараах байдлаар индекслэж болох юм.

Хүснэгт 4.9.1

Жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба нэг хүнд ноогдох ДНБ-ий харьцаа	Индекс
80 дээш	0
50-80 хувь	1
30-50 хувь	3
20-30 хувь	5
10-20 хувь	7
0-10 хувь	10

²⁸ - Economic Freedom of North America: 2004 Annual Report, page 8

Энэ индексийг ашиглан Монголын хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөөг тооцъё.

1998 оны 1 дүгээр сарын 8-нд баталсан Хөдөлмөрийн Хөлсний Доод Хэмжээний Тухай хуулиар цалингийн доод хэмжээ зохицуулагддаг.

5 дугаар зүйл. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх зарчим, хүчин зүйлс

5.1. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг амьжиргааны доод түвшингээс багагүйгээр тогтоох зарчмыг баримтална.

7 дугаар зүйл. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх

7.1. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ажил олгогчдын болон нийт ажилтны эрх ашгийг төлөөлөх улсын хэмжээний байгууллагын саналыг харгалзан Засгийн газар тогтооно.

7.2. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасныг үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жилд нэгээс доошгүй удаа шинэчлэн тогтооно.

Энэ хууль дээр үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн Газар жилд нэгээс доошгүй удаа шинэчлэн тогтоодог. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хүснэгт 2.1.2-т харууллаа. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жилээс жилд өсгөж тогтоосон байна.

Хүснэгт 4.9.2

	оны үнээр, мян.төг					
	2000	2001	2002	2003	2004	2005
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (сард)	12	18	24.75	30	40	42.5

Эх сурвалж: Засгийн газрын тогтоолууд 2000, 2001, 2002, 2004, 2005

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэг хүнд ноогдох ДНБ-тэй харьцуулсан харьцаа (Хүснэгт 4.9.3) байдалтай байна.

Иймээс дээрх индексийг ашиглан хөдөлмөрийн хөлсний доод түвшингийн нөлөөний индексийг тооцвол 2001, 2002 онд уг индекс Монголын хувьд 3.0 байснаа, 2003, 2004 онд 1.0 болсон байна.

Монголын хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон нэг хүнд ноогдох ДНБ-ий харьцаа ийм өндөр гарч байгаа нь хөдөлмөрийн

хөлсний хэмжээ өндөр тогтоогдсондоо биш, харин нэг хүнд ноогдох орлого буюу нэг хүнд ноогдох ДНБ бага байдагтай холбоотой гэж үзэж байна. Иймээс энэ үзүүлэлтийг хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудад хэрэглэхдээ болгоомжтой хандах нь зүйтэй.

Хүснэгт 4.9.3

	оны үнээр, мян.төг			
	2001	2002	2003	2004
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (жилд)	216.0	297.0	360.0	480.0
Нэг хүнд ноогдох ДНБ	460.1	504.6	586.8	717.3
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нэг хүнд ноогдох ДНБ-ий харьцаа (%)	46.9	58.9	61.3	66.9

Эх сурвалж: Засгийн газрын тогтоолууд 2000, 2001, 2002, 2004, 2005

Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2004, УСГ

4.9.Б Ажилд авах болон ажлаас халах процесс

Пүүс компаниудын ажилд авах болон ажлаас халах процесс нь хувийн гэрээгээр тодорхойлогдож байвал эрх чөлөөний индекс өндөр байх болно.

Уг индексийг *Global Competitiveness Report*-ийн 8.17 үзүүлэлтээр тооцдог. Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан нийт 117 орноос 22-р байр эзэлж, 4.6 оноо авсан байна. Фрейзер институтын индексэд шилжүүлэхийн тулд дараах томъёог ашиглана:

$$i_{5B-1} = (V_i - V_{\min}) / (V_{\max} - V_{\min}) * 10$$

i_{5B-1} - Цалингийн доод түвшний нөлөөний Фрейзерийн индекс

V_{\max} - Тухайн үзүүлэлтийн хамгийн өндөр утга

V_{\min} - Тухайн үзүүлэлтийн хамгийн бага утга

V_i - Тухайн орны үнэлгээ

Тухайн үзүүлэлтийн хамгийн өндөр утга нь 7, хамгийн бага утга нь 1 байдаг. Үүнийг ашиглан 2004 оны байдлаар Монголын хувьд тооцвол цалингийн доод түвшний нөлөөний Фрейзерийн индекс 6.0 байна.

Хүснэгт 4.9.4.1

Тэтгэмжийн хэмжээ (ажилласан жилээс хамааран хамгийн өндөр түвшингээр бодоход)	Ажилгүйдлийн тэтгэмж өгөх хугацаа (7 хоног)			
	12 сар, түүнээс дээш	6-аас 12 сар хүртэл	3-аас 6 сар хүртэл	3 сар хүртэл
Цалингийн 80 болон түүнээс дээш хувь	0	3	5	7
60-80 хувь	3	6	7	9
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү	5	7	9	10

4.9.В Нэгдсэн хэлэлцээрээр цалин нь тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь

Цалинг компаниуд өөрсдөө тогтоодог бол уг индекс өндөр утга авна. *Global Competitiveness Report*-ийн 8.18 үзүүлэлтээр уг индексийг тооцдог. Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан нийт 117 орноос 14-р байр эзэлж, 5.9 оноо авсан байна. Үүнийг ашиглан 2004 оны байдлаар Монголын хувьд тооцвол нэгдсэн хэлэлцээрээр цалин нь тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувийн Фрейзерийн индекс **8.2** байна.

Аливаа байгууллага, компанид ажиллаж байгаа ажилчид эвлэлдэн нэгдэж тухайн байгууллага, компаний Үйлдвэрчний Эвлэлийг байгуулдаг. Уг үйлдвэрчний эвлэл, ажилчин болон ажил олгогч байгууллага, компаний удирдлага гэсэн гурван талаас оролцож цалинг байгууллага, компани бүр дээр тогтоож, уг цалингийн түвшингээрээ гэрээ байгуулдаг. Хэрвээ байгууллага, пүүс компаниуд үйлдвэрчний эвлэл байхгүй бол ажилчдаас байгуулсан ажилчдын төлөөлөл түүнийг орлож гэрээ байгуулдаг.

Монголын байгууллага, компаниудын Үйлдвэрчний Эвлэлүүд нэгдэж Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоо гэсэн төрийн бус сайн дурын байгууллагыг байгуулсан.

4.9.Г. Ажилгүйдлийн тэтгэмж

Ажилгүйдлийн тэтгэмжийн систем нь ажиллах инсентивийг агуулж байдаг.

Энэ индексийг *World Competitiveness Yearbook*-ээс ажилгүйдлийн тэтгэмж гэсэн

үзүүлэлтийг ашиглан тооцдог. Одоогоор энэ эмхтгэлд Монгол Улс хамрагдаагүй байгаа учраас энэ индексийг тооцоход доорхи аргачлалыг саналыг ашигласан. Энэ аргачлал бол Банкны зээлийн эрх чөлөөний хэсэгт гардаг өрсөлдөөний аргачлалтай ижил бөгөөд үүнийг хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээнд ашиглаж байгаа юм (Хүснэгт 4.9.4.1).

Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай Хуулийн 3, 4-р зүйлд зааснаар ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ болон тэтгэмж өгөх хугацаа тодорхойлогддог.

3 дугаар зүйл. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ

1. Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дор дурдсан хувь хэмжээгээр тооцож олгоно:

Шимтгэл төлж ажилласан хугацаа /жилээр/	Тэтгэмж бодох хувь хэмжээ /хувиар/
5 хүртэл жил	15
5-10 хүртэл жил	50
10-15 хүртэл жил	60
15, түүнээс дээш	70

2. Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний **75** хувиас багагүй байна.

4 дүгээр зүйл. Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг Хөдөлмөрийн хуульд зааснаар ажлаас халагдсаны тэтгэмж авч байгаа бол түүнийг авч дууссаны дараагийн өдрөөс, хэрэв ажлаас халагдсаны тэтгэмж олгогдоогүй

бол энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсний дараагийн өдрөөс тус тус эхлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.

Хуулийн дээрх заалтаас харахад Монголын хувьд ажилгүйдлийн тэтгэмжийн индекс 7.0 байна.

Монголын онцлог

Тайлант хугацаанд ажилгүйдлийн тэтгэмжинд нийт 5334 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 858 хүнээр нэмэгдсэн буюу 119.2 хувьтай байна. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдагсдын нийт ажилгүйчүүдэд эзлэх хувь аймгийн дунджаар 3.9 хувь, нийслэлд 12.5 хувь, улсын дунджаар 6.7 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, ажилгүйчүүдийн дунд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдагсдын хувь маш бага байна.

4.9.Д Цэргийн алба

Фрейзерийн институтын энэ индексийг тооцоходоо цэрэг татлагыг хэрэглэдэг эсэх болон түүний үргэлжлэх хугацаан дээр үндэслэн үнэлгээний интервалыг байгуулдаг. Цэрэг татлагын хугацаа нь удаан байдаг орнууд бага үнэлгээ авна. Цэрэг татлага байдаггүй орнууд 10 гэсэн үнэлгээ авна. Цэрэг татлагын хугацаа нь зургаан сар буюу түүнээс бага орнууд 5 гэсэн үнэлгээ авдаг. Зургаан сараас 12 сарын хугацаагаар цэрэгт татдаг бол 3 гэсэн үнэлгээ, 12-18 сарын хооронд бол 1 гэсэн үнэлгээ, 18-аас дээш сар бол 0 гэсэн үнэлгээ авна.

1992 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу цэргийн албаны үйл ажиллагаа зохицуулагддаг.

14 дүгээр зүйл. Байлдагч, түрүүчийн алба / Энэ зүйлийн нэрийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

1. Байлдагч, түрүүчийн алба нь хугацаат цэргийн алба, гэрээт цэргийн албанаас бүрдэнэ. Хугацаат цэргийн алба хаах хугацаат 12 сар, гэрээт цэргийн алба хаах анхны хугацаа 24 сар байх бөгөөд гэрээний хугацааг цаашид

байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүртэл үргэлжлүүлэн сунгаж болно.

Иймээс Монголын хувьд цэргийн албаны эрх чөлөөний индекс нь 3.0 байна. Үүнээс өмнө 1987 он хүртэл 3 жил, 1992 он хүртэл 2 жилийн хугацаатайгаар цэргийн албыг хаадаг байсан. Өөрөөр хэлбэл 1987 он хүртэл уг индекс 0, түүнээс хойш 1992 он хүртэл 1 гэсэн үнэлгээтэй байсан байна. Цэргийн албаны эрх чөлөөний индекс сайжирсаар байна.

Монголын онцлог

Монгол Улсын газар нутаг 1564.1 мянган км², хүн ам 2533.1 мянга, хүн амын нягтшил 1.6 хүн/км². Нутгийн баруунаас зүүн цэг хүртэл 2392 км, хойноос өмнө цэг хүртэл 1259 км болно. Хойт талаараа Оросын Холбооны Улстай 3485 км, өмнө талаараа Хятад Улстай 4676.9 км хиллэсэн.

4.10. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ИНДЕКС БА ТҮҮНИЙ ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ

Хүснэгт 4.10.1 Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын индекс

	Оноо
5B.1 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөө	1.0
5B.2 Ажилд авах болон ажлаас халах процесс	6.0
5B.3 Цалин нь төвлөрсөн хамтын хэлэлцээрээр тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь	8.2
5B.4 Ажилгүйдлийн тэтгэмж	7.0
5B.5 Цэргийн алба	3.0
5B Дэд үзүүлэлтийн ерөнхий индекс	5.0

Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын ерөнхий индексийг тооцдог үзүүлэлтүүдээс хамгийн өндөр оноотой нь цалингийн уян хатан байдлын индекс байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад цалин нь үйлдвэрчний эвлэл буюу нэгдсэн хэлэлцээрээс хамаарч тогтоогддоггүй гэж үзэж болно.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөөний индекс хамгийн бага гарсан бөгөөд

түүний дараа цэргийн албаны индекс орж байна. Энэ нь Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал, газар нутаг том, хүн ам цөөнтэй холбоотой байж болох юм.

Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын индексийг бусад шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулж үзье. *Economic Freedom of the World 2005 Annual Report* дээрх 2003 оны бусад орны индексийг авч үзлээ. Харин бидний тооцоо 2004 оны индекс учраас шууд харьцуулах боломжгүй боловч 2001-ээс 2003 оны улс орнуудын индексийг харвал эдгээр индексүүд харьцангуй тогтвортой байна. Иймээс бид 2003 оны байдал 2004 онд мөн хадгалагдна гэж үзээд харьцуулалт хийе.

Хүснэгт 4.10.2

Улс	5B
Украйн	6.1
Словак	5.9
Унгар	5.5
Хорват	5.3
Эстони	5.2
Болгар	5.0
Монгол	5.0
Чех	4.9
Латви	4.9
Орос	4.6
Румын	4.6
Хятад	4.4
Польш	4.3
Словени	3.6

Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөлмөрийн зах зээлийн индекс ерөнхийдөө бага байна. Украин, Словак хамгийн өндөр 6.1, 5.9 байхад хамгийн бага индекстэй орнуудад Хятад, Польш, Словени улс орж байна. Монгол дундаж улсад орж байна.

Өндөр хөгжилтэй орнуудын хувьд энэ индекс тийм ч өндөр биш байна. Өөрөөр хэлбэл хөгжилтэй орнуудын хувьд ч хөдөлмөрийн зах зээл нэлээд зохицуулалттай байдаг байна. Жишээ нь Герман улс гэхэд л нийт 102 орноос 101-р байранд орж хамгийн бага индекстэй орон болсон байна.

Хүснэгт 4.10.3

Улс	2003					
	5Bi	5Bii	5Biii	5Biv	5Bv	5B
Шинэ Зеланд	3.6	3.5	8.0	3.6	10.0	5.7
АНУ	3.8	7.2	8.0	6.2	10.0	7.0
Их Британи	4.6	5.8	8.2	4.3	10.0	6.6
Канад	4.3	5.3	7.2	5.6	10.0	6.5
Гонконг	4.3	8.2	9.5	6.3	10.0	7.7
Чили	3.4	4.5	8.5	6.9	0.0	4.7
Франц	4.5	2.0	5.3	3.0	10.0	5.0
Сингапур	4.6	7.7	8.0	8.1	0.0	5.7
Филиппин	4.4	2.8	5.2	5.1	10.0	5.5
Өмнөд Солонгос	4.1	3.8	7.3	5.3	0.0	4.1
Япон	4.0	3.7	8.5	5.4	10.0	6.3
Мексик	2.7	4.2	6.3	4.6	5.0	4.6
Шри Ланк	4.1	2.0	5.8		10.0	5.5
Турк	3.4	5.5	6.8	5.6	1.0	4.5
Энэтхэг	4.3	2.2	6.8	5.3	10.0	5.7
Бангладеш	4.6	5.0	7.5		10.0	6.8
Малайз	4.5	5.8	7.0	6.8	10.0	6.8
Индонез	4.6	5.0	5.2	3.6	5.0	4.7
Герман	4.6	2.0	2.3	2.2	3.0	2.8
Монгол	1.0	6.0	8.2	7.0	3.0	5.0

4.11 ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС-БИЗНЕСИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Танилцуулга

Хувь хүмүүс болон тэдний өмч хөрөнгийг гадны гэмт халдлагаас хамгаалдаг, хувь хүмүүс өөрсдийн санаачилгаараа гэрээ хэлцэлд оролцдог хууль эрх зүйн бүтцийг бий болгосон Засгийн газар л эдийн засгийн эрх чөлөөг хангаж байдаг. Зах зээлийн үйл ажиллагаа, сайн дурын арилжаа, хувийн сонголтыг орлуулах төрийн аливаа зохицуулалт, засгийн газрын хэрэглээ, татвар нь эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж байдаг. Эдгээр хязгаарлалт нь ажил хөдөлмөр эрхлэх болон бизнесийн үйл ажиллагаанд саад болсноороо эдийн засгийн эрх чөлөөг боогдуулдаг байна.

Бизнесийн үйл ажиллагааны зохицуулалт буюу 5C дэд бүлэг нь зах зээлийн үйл ажиллагаанд хүнд суртал, зохицуулалт нь ямар хэмжээтэй байгааг хэмждэг. Фрейзерийн институтээс гаргасан аргачлалаар бизнесийн

үйл ажиллагаа хэр зэрэг эрх чөлөөтэй байгааг дараах таван үзүүлэлтээр хэмждэг байна.

- I. Үнийн хяналт
- II. Төрийн зохицуулалт ба шинэ бизнес
- III. Хэлэлцээр хийхэд зарцуулж буй хугацаа
- IV. Шинээр бизнес эрхлэх
- V. Нэмэлт төлбөр

Үзүүлэлт тус бүр нь 0-10 оноогоор хэмжигдэх бөгөөд өндөр байх тусам эрх чөлөөтэй байгааг илэрхийлдэг. Энэ индексийн утга өндөр байхын хэрээр эдийн засаг дахь үнэ нь зах зээл дээрээ тодорхойлогддог, шинээр бизнес эрхлэх үйл ажиллагааг саатуулах болон бараа үйлчилгээ үйлдвэрлэх зардлыг нь өсгөх төрийн зохицуулалт байхгүй байгааг илэрхийлдэг.

Фрейзер институтээс бизнесийн зохицуулалтын салбар дахь эрх чөлөөг хэмждэг дээрх 5 дэд индексийн талаарх мэдээг Дэлхийн эдийн засгийн форумын *The Global Competitiveness Report* цувралаас авдаг. Уг цувралын 2005-2006 оны түүвэрт манай улс хамрагдсан тул эдгээр индексийг тооцох боломжтой болсон юм. Дэлхийн эдийн засгийн форумын аргачлалаар улс бүрт 1-ээс 7 гэсэн оноо өгдөг бөгөөд онооны утга өсөх нь тухайн үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илэрхийлдэг.

Монголын эдийн засаг, бизнесийн орчин

Монгол улс 1990 оны эхэнд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хувийн хэвшил байгуулагдах нөхцөл бүрдсэн. Энэ үед хуучин тогтолцооны үед үйл ажиллагаа явуулж байсан том үйлдвэрүүдийг задалж, хувьчилсан. Шинэ тогтолцоонд шилжиж, зах зээл либералчлагдсанаар аж ахуйн нэгжүүд олноор бий болж, манай улсын бизнесийн орчин бүрдэж эхэлсэн гэж болох юм.

Үндэсний Статистикийн Газраас гаргадаг статистикийн мэдээнээс харахад 2004 оны эцсийн байдлаар 34.2 мянган хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэний 25.4 мянга буюу 74.1 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт: 4.11.1 Хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллагын тоо

Он	Аж ахуйн нэгж, байгууллагын тоо /оны эцэст/	Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо /оны эцэст/
2001	27271	24954
2002	29142	25523
2003	31478	26552
2004	34218	25356

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2004, ҮСГ

Нийт аж ахуйн нэгжүүдийн 95 хувь орчим нь хувийнх бөгөөд хувийн секторын ДНБ-д эзлэх хувь нь 75 орчим хувьтай байдаг.

Хүснэгт 4.11.2 Дотоодын нийт бүтээгдэхүүн ба хувийн секторын эзлэх хувь

Он	Дотоодын нийт бүтээгдэхүүн /оны үнээр, сая төгрөг/	ДНБ-д хувийн секторын эзлэх хувь /хувиар/
2001	1115 641.4	75.0
2002	1240 786.8	74.5
2003	1461 169.2	73.0
2004	1807 985.9	76.0

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2004, ҮСГ

Түүнчлэн 2003 оны байдлаар банкны салбарын олгосон нийт зээлийн 84.8 хувь нь хувийн секторт ашиглагдаж байсан байна.

4.12 «БИЗНЕСИЙН ЗОХИЦУУЛАЛТ» БҮЛГИЙН ИНДЕКСИЙН ТООЦОО

Үнийн хяналт

Энэхүү үзүүлэлт нь аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүний үнийг чөлөөтэй тогтоох байдлыг харуулдаг. Фрейзерийн институтээс гаргасан аргачлалаар бол ямар ч үнийн хяналт байхгүй улс орнууд 10 оноо авдаг. Эдийн засгийн өргөжилтийн үр өгөөж нь өрсөлдөөний үр ашгийг бууруулдаг (эрчим хүч гэх мэт) салбаруудад хязгаарлагдмал хэмжээгээр үнийн хяналт байдаг улс орнууд 8 оноо авдаг. Хөдөө аж ахуй гэх мэт цөөн хэдэн салбарт үнийг хянаж байдаг улс орнуудын

үнэлгээ 6 оноо. Эрчим хүч, хөдөө аж ахуй болон бусад олон өргөн хэрэглээний барааны үнийг хүчтэй хянаж байдаг бол 4 оноо. Хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарын олон тооны бүтээгдэхүүний үнийг хянаж байдаг бол 2 оноо. Эдийн засгийн янз бүрийн салбаруудад үнийн хяналт өргөн хэмжээгээр байдаг бол тэг үнэлгээ авдаг байна.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжихдээ урьд нь хатуу тогтоож байсан үнийг чөлөөлсөн. Харин үнэ чөлөөлөх үйл ажиллагаа нэгмөсөн биш дэс дараалалтай хийгдэж, эхлээд өргөн хэрэглээний барааны үнийг чөлөөлж байжээ. Харин хүн амын амьжиргааны түвшин, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлдөг учраас суурь үнэ нь төрийн анхааралд байсан билээ. Иймээс энэ үзүүлэлтийн хувьд хамгийн өндөр 10 оноог авах боломжгүй гэж үзлээ. Үнийн хяналт байхгүй, аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнийхээ үнийг чөлөөтэй тогтоох боломжтой боловч цахилгаан эрчим хүч, нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлаж байдаг учраас Монгол улсын хувьд энэ үзүүлэлт нь **8 оноо** байна.

Төрийн зохицуулалт ба шинэ бизнес

Шинээр бизнес эрхлэхэд тохиолддог гол саад болох төрийн захиргааны (administrative) процедурыг энэ индексээр хэмждэг. Энэхүү дэд индексийг “*The Global Competitiveness Report 2005-2006*”-ийн Хүснэгт 7.10 дахь үзүүлэлт буюу шинээр бизнес эрхлэхэд шаардлагатай процедурын тоо гэсэн үзүүлэлтээр хэмжинэ. Энэ үзүүлэлтийн хувьд 2005 оны байдлаар манай улс ямар оноо авсныг тодруулбал дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан нийт 117 орноос 27-р (21-36) байр эзэлсэн байна. Шинээр бизнесээ бүртгүүлэхэд шаардлагатай процедурын тоог 8 гэжээ. Австрали улсад энэ процедурын тоо хамгийн бага 2 байдаг бол уг түүвэрт хамрагдаж энэ үзүүлэлтийн талаарх мэдээлэл өгөгдсөн улсуудаас Чад улсад хамгийн их 19 байна.

Энэ үзүүлэлтийн хувьд $V_{\min}=2$, $V_{\max}=19$ гэж Фрейзер институтын эдийн засгийн эрх чөлөөг хэмжих аргачлалаар тооцохдоо

$$i=(V_i-V_{\min})/(V_{\max}-V_{\min})*10$$

томъёог ашиглана. Монгол улсын хувьд энэ дэд индекс нь 2005 онд **6.5 оноо**

$$V_i=8 \text{ ба } \frac{19-8}{19-2} \cdot 10=6.5$$

авч байна.

Хэлэлцээр хийхэд зарцуулж буй хугацаа

Энэ дэд индекс нь аж ахуйн нэгжүүдийн удирдлага засгийн газар, яам албан газартай хэлэлцээр хийхийн тулд хэр их хугацаа зарцуулж байгаагаар хэмждэг.

Энэ индексийг *The Global Competitiveness Report 2005-2006*-ийн Хүснэгт 6.09 үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ гэж үзье. Энэ үзүүлэлт нь тухайн аж ахуйн нэгжийн ахлах менежер нь төрийн албан тушаалтнуудтай хэлэлцээр хийхдээ хэр хугацаа зарцуулж байгааг хэмждэг. Эдгээр менежерүүд нь ажлын цагийнхаа хэдэн хувийг хэлэлцээр хийхэд зарцуулж байгааг хэмжээд 0% бол 1 оноо, 1-10% бол 2, 11-20% бол 3, 81-100% бол 8 гэх мэтчилэн оноо өгсөн байна.

Монгол улсын 2005 оны байдлаар Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан нийт 117 орноос 77-р байр эзэлж, 3.0 гэсэн оноо авсан байна. Ерөнхийдөө энэ утга бага (1-рүү дөхөх тусам) байхын хэрээр төрийн албан тушаалтнуудтай хэлэлцээр хийхдээ бага цаг зарцуулж байгааг илэрхийлэх бөгөөд тэр чинээгээр бизнесийн үйл ажиллагаанд төрийн зохицуулалт бага байгааг илтгэнэ. Эдийн засаг болоод бизнесийн үйл ажиллагаа ч эрх чөлөөтэй байна гэсэн үг юм.

Уг тайланд тусгагдсан 117 орноос энэ үзүүлэлтээр хамгийн бага оноо болох 2.0 гэсэн утгыг Румын, хамгийн өндөр оноог Баруун Тимор улс авчээ. Энэ улс 4.2 гэсэн оноотойгоор 117-д жагсчээ. Харин манай урд хөрш болох Хятад улс 3.9 оноотой 116-д орсон байна. Энэ үзүүлэлтээр бага оноо авсан улсууд эдийн засгийн эрх чөлөөтэй байгааг илэрхийлэх учраас Фрейзер институтын аргачлалаар индексээ илэрхийлэхийн тулд

$$i=(V_i-V_{\min})/(V_{\max}-V_{\min})*10$$

томъёогоор шилжүүлб.

Тиймд $V_{\min}=20$, $V_{\max}=4.2$ учраас Монгол улсын хувьд энэ дэд индекс нь 2005 онд **5.5 оноо**

$$V_i=2.0 \text{ ба } \frac{3.0-4.2}{2.0-4.2} \cdot 10 = 5.5$$

авахаар байна.

Монголын эдийн засаг бизнесийн орчны 2004 оны судалгаанаас үзэхэд хамгийн их хүнд сурталтай, зардал чирэгдэл учруулдаг байгууллагууд нь татвар, гааль, төр захиргааны байгууллага бөгөөд эдгээр байгууллагатай харьцахад бизнес эрхлэгчдэд хүндрэлтэй хэвээр байна гэж гарчээ. Олон удаагийн судалгаагаар эдгээр байгууллагуудыг аж ахуйн нэгжүүд өөрсдийн байнга харьцдаг төр засгийн байгууллагуудаас хамгийн хүнд сурталтай, зардал чирэгдэл учруулдаг гэж үздэг бөгөөд эдгээр нь жилээс жилд бараг өөрчлөгддөггүй байна. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс авсан санал асуулгаас харахад лиценз, зөвшөөрөл авах, зөвшөөрөл олгодог байгууллагын ажлын зохион байгуулалт нь тэдгээр аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн болон цаг хугацааны хувьд нэлээдгүй саад бэрхшээл учруулдаг гэжээ.

Судалгаанаас үзэхэд Монгол улсын бизнесийн хөгжилд саад болж буй гол хүчин зүйлүүдэд татварын тогтолцоо, авилгал, шударга бус өрсөлдөөн гэх мэтийг аж ахуйн нэгжүүд хамгийн их нэрлэжээ. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ихээхэн хамааралтай хууль тогтоомжууд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хэр зэрэг хүндрэл бэрхшээл учруулдаг талаар тодруулан асууж, зэрэглэн үзэхэд хамгийн хүндрэлтэй хууль нь татварын хууль тогтоомж гэж судалгаанд оролцогсдын 80,5 хувь нь, лиценз, тусгай зөвшөөрлийн талаарх хууль тогтоомжийг 71,8 хувь нь, гаалийн хууль дүрмийг 63,3 хувь нь нэрлэсэн байна.²⁹ Татварын хураамж өндөр, хяналт шалгалт их, татварын байцаагчдын харьцаа муу зэрэг татвартай холбоотой асуудлууд бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдаг болох нь судалгаагаар тогтоогджээ.

Шинээр бизнес эрхлэх

Энэ нь шинээр бизнес эрхлэхэд ерөнхийдөө хэр зэрэг хялбар байгааг харуулдаг индекс юм. Энэхүү дэд индексийг *The Global Competitiveness Report 2005-2006*-ийн Хүснэгт 6.07 дахь үзүүлэлт болох бизнес дэх төрийн дарамт ачаалал хэр зэрэг байгаа болон 7.11 дахь үзүүлэлт болох шинээр бизнес эрхлэхэд шаардлагатай хугацаагаар хэмжигдэх бөгөөд энэ хоёр үзүүлэлт тэнцүү жинтэй гэж үзье. Эдгээр үзүүлэлтийн хувьд 2005 оны байдлаар Монгол улс ямар оноо авсныг тодруулья.

Манай улс 6.07 үзүүлэлтийн хувьд Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан нийт 117 орноос 86-р байр эзэлж, 2.6 гэсэн оноотой байна. Өөрөөр хэлбэл бизнесийн үйл ажиллагаанд төрийн административ шаардлагууд нь дарамт ачаа болдоггүйг илэрхийлнэ. Уг тайланд тусгагдсан 117 орноос энэ үзүүлэлтээр хамгийн өндөр оноо болох 5.4 гэсэн утгыг Сингапур, хамгийн бага оноо болох 2.0 гэсэн утгыг Босния & Херцеговина авчээ. Иймээс $V_{\min}=20$, $V_{\max}=5.4$ гэж үзээд Фрейзер институтын аргачлалаар шилжүүлбэл Монгол улсын хувьд 1.8 гэсэн индекс гарч байна.

$$V_i=2.6 \text{ ба } \frac{2.6 - 2.0}{5.4 - 2.0} \cdot 10 = 1.8$$

Харин 7.11 үзүүлэлт нь шинээр бизнес эрхлэхэд шаардлагатай өдрийн тоог харуулах ба Монгол улсын хувьд энэ нь 20 байдаг гэжээ. Манай улс Дэлхийн эдийн засгийн форумын түүвэрт хамрагдсан улсаадаас 19-р байр эзэлсэн бол 1-р байранд Австри улс оржээ. Энэ улсын хувьд шинээр бизнес эрхлэхэд шаардлагатай өдрийн тоо 2 байдаг байна. Түүвэрт хамрагдсан бөгөөд мэдээлэл нь өгөгдсөн улсуудын хувьд энэ тоо хамгийн их байдаг нь Мозамбик бөгөөд шаардлагатай өдрийн тоо 153 байна. Тиймээс Фрейзер институтын аргачлалаар шилжүүлбэл Монгол улсын хувьд 8.7 $V_i=20$ ба

$$\frac{153 - 20}{153 - 2} \cdot 10 = 8.7$$

гэсэн индекс гарч байна.

Энэ хоёр индексийн дунджаар дэд бүлгийн индекс гарна. Монгол улсын хувьд шинээр бизнес эрхлэх бүлгийн индекс нь **5.3** $((1.8+8.7)/2=5.3)$ байна.

²⁹ - МҮХАҮТ «Монголын эдийн засаг бизнесийн орчин», 2004

Хүснэгт 4.11.3 Монгол улс дахь нэмэлт төлбөр

Хүснэгт	Нэмэлт төлбөр	Ранк /117-с/	МУ-ын GCR-ын оноо	V _{min}	V _{max}	Фрейзер институтын индексэд хөрвүүлбэл
6.19	Экспорт ба импортод	107	3.1	6.7 (Исланд)	2.2 (Камбожи)	2.0
6.20	Нийтийн хэрэглээн дэх	84	4.3	6.8 (Исланд)	2.1 (Бангладеш)	4.6
6.21	Татвар хураалт дахь	90	3.8	6.8 (Шинэ Зеланд)	2.2 (Бангладеш)	3.5
6.22	Гэрээ хэлцэл дэх	93	3.2	6.4 (Шинэ Зеланд)	2.1 (Бангладеш)	2.5
6.23	Шүүхийн шийдвэр дэх	109	2.8	6.8 (Исланд)	2.4 (Чад)	0.9

Эх сурвалж: The Global Competitiveness Report 2005-2006

Нэмэлт төлбөр

Энэ үзүүлэлт нь экспорт импортын лиценз, бизнесийн зөвшөөрөл, валютын солилцооны зөвшөөрөл авах, цагдаагийн хамгаалалт авах болон зээл авахад нэмэлт төлбөр шаардлагатай эсэхийг хэмждэг.

Энэхүү дэд индексийг *The Global Competitiveness Report 2005-2006*-ийн Хүснэгт 6.19-6.23 үзүүлэлтүүдээр илэрхийлэгдэнэ гэж үзээд эдгээр үзүүлэлтийн хувьд 2005 оны байдлаар манай улс ямар оноо авсныг Хүснэгт 4.11.3 -т харуулья.

Фрейзерийн аргачлалын оноог өгөхдөө

$$i = (V_i - V_{\min}) / (V_{\max} - V_{\min}) * 10$$

томъёогоор шилжүүлсэн. Эдгээр үзүүлэлтийн дунджаар нэмэлт төлбөр гэсэн дэд индексийг тооцвол **2.7 оноо** $((2.0 + 4.6 + 3.5 + 2.5 + 0.9) / 5 = 2.7)$ авч байна.

Ер нь ихэнх хяналт, шалгалгалтуудыг явуулж буй байцаагчдын зорилго нь төрийн хууль, дүрэм журмын мөрдөлтийг хянахаасаа илүүтэйгээр нэмэлт төлбөр, хураамж нэхэх, торгууль оноогдуулахад чиглэгддэг нь төрийн эрх мэдэл бүхий байгууллагын албан хаагчдын дунд түгээмэл байгааг хэвлэл мэдээллээр тэмдэглэсээр байгаа билээ.

Монгол улсын хувьд энэ үзүүлэлтийг мөн л МҮХАҮТ-иас 2004 онд явуулсан Монголын эдийн засаг бизнесийн орчны судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудын 62,8 хувь нь засгийн газрын албан тушаалтнуудтай харьцах хамгийн дөт зам бол төрийн байгууллагад ажилладаг найз, нөхөд, хамаатан садныхаа туслалцааг авах, 21,6

хувь нь хариуцсан албан тушаалтанд хахууль өгөх, үйлчлэх, тусламж үзүүлэх явдал гэсэн бол дөнгөж 15,7 хувь нь л албан журам номоор явах нь хялбар гэж хариулсан байна.

Монгол Улсын бизнесийн зохицуулалтын нэгдсэн индекс

Дээрх тооцоонуудаа нэгтгэн хүснэгтэд харуулья.

	5.С хэсгийн дэд үзүүлэлтүүд	2005 он
5.С.1	Үнийн хяналт	8.0
5.С.2	Төрийн зохицуулалт ба шинэ бизнес	5.5
5.С.3	Хэлэлцээр хийхэд зарцуулж буй хугацаа	6.5
5.С.4	Шинээр бизнес эрхлэх	5.3
5.С.5	Нэмэлт төлбөр	2.7
5.С	Хэсгийн нэгдсэн индекс	5.6

Эндээс харахад 5-р бүлгийн С хэсэг буюу бизнесийн зохицуулалт бүлгийн эрх чөлөөний индекс нь 5.6 оноотой байна.

Бүлэг дотроо хамгийн өндөр оноотой нь үнийн хяналт байна. Энэ нь манай улсад үнэ ханш төрөөс харьцангуй чөлөөтэй, зах зээлийн жамаараа зохицуулагдаж байдаг гэсэн үг. Харин хамгийн бага индекс нь нэмэлт төлбөртэй холбоотой байна. Үүнийг дараах байдлаар тайлбарлаж болох байх. Монголд шинээр бизнесийг нээх нь амархан, гэвч түүнийг явуулах нь нэлээд бэрхшээлтэй, төрөл бүрийн дарамт, хязгаарлалттай тулгардаг. Үүнээс зайлсхийхийн тулд голдуу албан бус аргуудыг (хахууль, танил тал гм) ашигладаг

байна. Монгол Улсын хөгжилд хувийн хэвшил ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа тул цаашид төр засгаас аль болохоор төр, бизнесийн харьцаа албан журмын дагуу явагдах нь амархан болгох явдал нь хувийн хэвшлийн болон нийт улсын хөгжлийг түргэтгэх боломжийг бүрдүүлж байна гэж үзэж байна.

4.13. ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ

Бизнесийн зохицуулалтын индексийг бусад шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулж үзье. *Economic Freedom of the World 2005 Annual Report* дээрх 2003 оны бусад орны индексийг авч үзлээ. Харин бидний тооцоо 2004 оны индекс учраас шууд харьцуулах боломжгүй юм. Гэхдээ судалгааны Эх сурвалж болох *Global Competitiveness Report* нь санал асуулгын дүн учраас эдгээр санал бодол нь цаг хугацаанд төдийлөн хурдан өөрчлөгдөхгүй байж болох юм. Тиймээс 2004 онд 2003 оныхоос өөрчлөгдөөгүй гэж үзээд бусад орны 2003 оны индекстэй харьцуулж үзье.

Хүснэгт 4.13.1 Шилжилтийн эдийн засагтай орнуудын бизнесийн зохицуулалтын индекс

Улс	2003					
	5Ci	5Cii	5Ciii	5Civ	5Cv	5C
Украин	4.0	1.7	3.5	3.0	4.6	3.4
Словак	5.0	2.8	6.8	6.0	6.0	5.3
Унгар	6.0	2.8	8.3	6.7	6.9	6.1
Хорват	4.0	2.0	7.3	4.5	5.4	4.6
Эстони	7.0	5.5	6.0	7.5	7.9	6.8
Болгар	6.0	2.8	4.8	2.5	7.5	4.7
Монгол	8.0	6.5	5.5	5.3	2.7	5.6
Чех	7.0	2.8	6.3	3.8	6.0	5.2
Латви	6.0	3.3	5.8	5.3	6.0	5.3
Орос	3.0	2.5	4.8	3.7	4.7	3.7
Румын	1.0	3.7	7.5	4.0	4.8	4.2
Хятад	2.0	4.7	4.5	5.8	6.0	4.6
Польш	1.0	2.0	5.5	3.8	5.2	3.5
Словени	4.0	3.0	5.5	5.5	7.8	5.2

Хамгийн өндөр оноотой Эстони (6.8), Унгар (6.1) улсын дараа Монгол улс (5.6) орж байгаа нь шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад бизнесийн зохицуулалт нь

харьцангуй чөлөөтэй байна гэсэн үг юм. Ерөнхийдөө шилжилтийн эдийн засагтай орнуудын бизнесийн зохицуулалтын индекс бага байгаа нь харагдаж байна.

Эдийн засгийн эрх чөлөөтэй байдлаараа тэргүүлдэг улс орнуудад энэ индекс ямар байдаг болон тэдгээртэй орнуудтай өөрийн орны индексийг харьцуулан авч үзье.

Хүснэгт 4.13.2 Өндөр хөгжилтэй орнуудын бизнесийн зохицуулалтын индекс

Улс	2003					
	5Ci	5Cii	5Ciii	5Civ	5Cv	5C
Шинэ Зеланд	10.0	3.3	6.5	8.0	9.5	7.5
АНУ	7.0	3.7	6.5	7.5	8.3	6.6
Их Британи	5.0	4.2	6.5	7.7	9.0	6.5
Канад	8.0	4.0	5.3	6.8	8.5	6.5
Гонконг	8.0	6.8	6.8	8.8	9.0	7.9
Чили	8.0	4.5	6.8	4.8	8.2	6.5
Франц	7.0	2.0	7.8	4.5	8.2	5.9
Сингапур	7.0	7.2	6.8	7.8	9.1	7.6
Филиппин	3.0	2.0	5.5	5.0	3.5	3.8
Өмнөд Солонгос	1.0	2.8	6.5	5.2	6.2	4.3
Япон	5.0	3.0	6.5	5.5	8.8	5.8
Мексик	4.0	2.3	4.5	3.2	6.0	4.0
Шри Ланк	4.0	3.5	5.5	6.2	5.3	4.9
Турк	5.0	2.5	5.3	5.2	5.3	4.7
Энэтхэг	5.0	3.7	5.8	5.0	5.3	4.9
Бангладеш	6.0	2.2	4.0	3.8	2.3	3.7
Малайз	4.0	5.3	5.0	6.7	7.0	5.6
Индонез	2.0	4.7	4.8	5.8	5.5	4.6
Герман	7.0	4.7	6.3	5.2	8.8	6.4
Монгол	8.0	6.5	5.5	5.3	2.7	5.6

Хүснэгтээс харахад бизнесийн зохицуулалтын индекс өндөр хөгжилтэй орнуудын хувьд ч төдийлөн өндөр байдаггүй байна. Гонконг (7.9), Сингапур (7.6), Шинэ Зеланд (7.5) зэрэг улсууд энэ индексийн хувьд тэргүүлж байна.

Бизнесийн зохицуулалтын судалгааны хавсралт үзүүлэлтүүд

	хөдөлмөрийн бүтээмж				дундаж цалин			
	2001	2002	2003	2004	2001	2002	2003	2004
Бүгд	1359.5	1457.1	1626	1926.5	782.4	855.6	978.0	1117.2
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	2288.7	2697.1	4015.4	4588.6	-	554.4	576.0	631.2
Уул уурхай, олборлох үйлдвэр	5238.0	5761.8.0	6671.0	9565.2	603.6	928.8	1064.4	1076.4
Боловсруулах үйлвэр	1636.0	1402.4	1637.4	1719.2	799.2	824.4	992.4	1113.6
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	1851.4	2490.0	2315.9	2323.7	930.0	972.0	1165.2	1341.6
Барилга	1001.5	1264.2	1477.4	1265.3	884.4	1087.2	1030.8	1195.2
Бөөний жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	3305.6	3531.9	3305.6	3382.6	658.8	691.2	775.2	885.6
Зочид буудал, зоогийн газар	957.0	824.2	741.9	703.6	849.6	964.8	1056	1204.8
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	4189.1	4946.3	5178.9	5607.7	1009.2	1090.8	1273.2	1308
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	4974.3	4731.8	5037.8	5033.9	710.4	998.4	1245.6	1504.8
Үл хөдлөх хөрөнгө түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	1632.6	1663.0	2127.8	2309.2	704.4	663.6	783.6	792.0
Төрийн байгууллагын үйл ажиллагаа	1272.9	1318.2	1390.3	1498.1	711.6	798.0	938.4	1132.8
Боловсрол	913.5	1001.3	1153.1	1330.7	729.6	774.0	930.0	1058.4
Эрүүл мэнд нийгмийн халамж,	620.7	668.4	714.8	745.2	580.8	618.0	729.6	958.8
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад	176.4	283.0	273.8	271.1	574.8	608.4	644.4	748.8

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2004, ҮСГ

Улс	2001						2002						2003					
	5Bi	5Bii	5Biii	5Biv	5Bv	5B	5Bi	5Bii	5Biii	5Biv	5Bv	5B	5Bi	5Bii	5Biii	5Biv	5Bv	5B
Болгар	2.6	4.6	7.6	6.8	3.0	4.9	2.6	5.3	7.8	6.8	3.0	5.1	2.6	5.0	7.8	6.8	3.0	5.0
Латви	3.3	5.1	7.3		3.0	4.7	3.3	5.7	7.7		3.0	4.9	3.3	5.2	8.0		3.0	4.9
Орос	2.6	6.2	8.1	5.5	0.0	4.5	2.6	6.2	8.0	4.9	0.0	4.3	2.6	7.3	8.0	5.3	0.0	4.6
Польш	3.4	3.7	6.4	4.8	3.0	4.3	3.4	4.0	7.0	3.2	3.0	4.1	3.4	4.5	7.5	3.0	3.0	4.3
Румын	4.7	5.1	7.4		3.0	5.0	4.7	4.5	8.0	4.8	3.0	5.0	4.7	3.5	7.8	4.1	3.0	4.6
Словак	4.2	4.3	7.1	4.8	3.0	4.7	4.2	4.2	7.7	3.2	3.0	4.4	4.2	5.7	7.8	6.9	5.0	5.9
Словени	4.0	2.7	5.3		3.0	3.8	4.0	2.7	5.2	3.1	3.0	3.6	4.0	2.7	5.3	2.9	3.0	3.6
Украин	1.9	5.6	6.6	5.3	10.0	5.9	1.9	6.0	6.5	5.3	10.0	5.9	1.9	6.7	6.7	5.3	10.0	6.1
Унгар	4.6	6.0	7.4	5.8	5.0	5.8	4.6	4.7	7.0	5.8	5.0	5.4	4.6	4.7	7.5	5.9	5.0	5.5
Хорват		3.4	6.5		5.0	4.9		3.8	6.2		5.0	5.0		4.2	6.7		5.0	5.3
Хятад	4.4	5.1	7.1	6.2	0.0	4.6	4.4	5.3	7.3	5.3	0.0	4.5	4.4	5.2	7.0	5.4	0.0	4.4
Чех	5.1	6.3	7.4	5.0	3.0	5.4	5.1	5.0	7.5	3.1	3.0	4.7	5.1	6.2	7.2	3.0	3.0	4.9
Эстони	2.9	5.8	8.6		3.0	5.1	2.9	5.3	8.7	5.5	3.0	5.1	2.9	6.2	8.2	5.8	3.0	5.2

Улс	2001						2002						2003					
	5Bi	5Bii	5Biii	5Biv	5Bv	5B	5Bi	5Bii	5Biii	5Biv	5Bv	5B	5Bi	5Bii	5Biii	5Biv	5Bv	5B
Шинэ Зеланд	3.6	4.0	8.0	4.8	10.0	6.1	3.6	4.0	8.0	3.8	10.0	5.9	3.6	3.5	8.0	3.6	10.0	5.7
АНУ	3.8	7.0	8.7	7.0	10.0	7.3	3.8	7.3	8.3	6.9	10.0	7.3	3.8	7.2	8.0	6.2	10.0	7.0
Их Британи	4.6	6.1	8.2	6.5	10.0	7.1	4.6	5.5	7.8	5.4	10.0	6.7	4.6	5.8	8.2	4.3	10.0	6.6
Канад	4.3	5.6	7.9	4.8	10.0	6.5	4.3	5.5	7.7	5.1	10.0	6.5	4.3	5.3	7.2	5.6	10.0	6.5
Гонконг	4.3	7.8	9.5	7.7	10.0	7.8	4.3	7.8	9.2	7.2	10.0	7.7	4.3	8.2	9.5	6.3	10.0	7.7
Чили	3.4	3.2	8.0	6.5	0.0	4.2	3.4	2.8	8.2	6.5	0.0	4.2	3.4	4.5	8.5	6.9	0.0	4.7
Франц	4.5	2.0	5.5	3.2	10.0	5.0	4.5	2.0	6.0	3.0	10.0	5.1	4.5	2.0	5.3	3.0	10.0	5.0
Сингапур	4.6	7.6	8.1	7.5	0.0	5.6	4.6	7.7	8.0	8.5	0.0	5.7	4.6	7.7	8.0	8.1	0.0	5.7
Филиппин	4.4	2.8	5.7	5.7	10.0	5.7	4.4	3.2	5.2	5.5	10.0	5.6	4.4	2.8	5.2	5.1	10.0	5.5
Өмнөд Солонгос	4.1	4.4	6.8	6.0	0.0	4.3	4.1	4.0	6.3	4.9	0.0	3.9	4.1	3.8	7.3	5.3	0.0	4.1
Япон	4.0	3.0	8.1	6.8	10.0	6.4	4.0	2.5	8.0	5.4	10.0	6.0	4.0	3.7	8.5	5.4	10.0	6.3
Мексик	2.7	3.1	6.0	6.5	5.0	4.7	2.7	3.0	6.5	4.6	5.0	4.4	2.7	4.2	6.3	4.6	5.0	4.6
Шри ланк	4.1	4.6	6.1		10.0	6.2	4.1	3.2	6.3		10.0	5.9	4.1	2.0	5.8		10.0	5.5
Турк	3.4	4.8	6.5	6.2	1.0	4.4	3.4	4.8	7.0	5.9	1.0	4.4	3.4	5.5	6.8	5.6	1.0	4.5
Энэтхэг	4.3	1.8	7.7	6.5	10.0	6.1	4.3	2.0	7.7	6.5	10.0	6.1	4.3	2.2	6.8	5.3	10.0	5.7
Бангладеш	4.6	5.0	6.8		10.0	6.6	4.6	5.3	7.3		10.0	6.8	4.6	5.0	7.5		10.0	6.8
Малайз	4.5	4.0	7.4	7.0	10.0	6.6	4.5	3.8	7.7	7.2	10.0	6.6	4.5	5.8	7.0	6.8	10.0	6.8
Индонез	4.6	3.1	5.2	5.8	5.0	4.8	4.6	4.5	4.5	2.5	5.0	4.2	4.6	5.0	5.2	3.6	5.0	4.7

4.14. ЗЭЭЛ, ХӨДӨЛМӨР, БИЗНЕСИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Судалгааны баг Монгол Улсын банкны зээл, хөдөлмөрийн зах зээл, бизнесийн эрх чөлөөний эдийн засгийн эрх чөлөөг Фрейзер Институтын аргачлалаар тооцож үзэхэд, эдгээр салбарууд дараах дүнтэй байгаа нь тогтоогдсон:

Банкны зээлийн салбар	2004
Банкны өмчлөл	8.0
Өрсөлдөөн	7.0
Хувийн хэвшилд олгосон зээл	5.0
Зээлийн хүү сөрөг түвшинд байх	8.0
Банкны хүүгийн хяналт	6.5
Банкны зээлийн зах зээл дэх эдийн засгийн эрх чөлөөний нэгдсэн индексийн үзүүлэлт	6.9
Хөдөлмөрийн зах зээл	
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөө	1.0
Ажилд авах болон ажлаас халах процесс	6.0
Цалин нь төвлөрсөн хамтын хэлэлцээрээр тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь	8.2
Ажилгүйдлийн тэтгэмж	7.0
Цэргийн алба	3.0
Хөдөлмөрийн ерөнхий индекс	5.0

Бизнесийн зохицуулалт	
Үнийн хяналт	8.0
Төрийн зохицуулалт ба шинэ бизнес	6.5
Хэлэлцээр хийхэд зарцуулж буй хугацаа	5.5
Шинээр бизнес эрхлэх	5.3
Нэмэлт төлбөр	2.7
Бизнесийн зохицуулалтын нэгдсэн индекс	5.6
Банкны зээл, хөдөлмөрийн зах зээл, бизнесийн зохицуулалтын салбарын эдийн засгийн эрх чөлөөний Монгол Улсын ерөнхий үзүүлэлт	5.8

Үүнээс үзэхэд, дээрх гурван зах зээлийн эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт Монголын эдийн засагт 2004 оны байдлаар 5.8-тай тэнцүү байсан. Үүнээс хийж болох дүгнэлт гэвэл, Монголын бизнес болон хөдөлмөрийн зах зээлд төрийн зохицуулалт харьцангуй хүчтэй байдаг ба бизнесийн хувьд шинээр бизнесийг эхлэх нь хэцүү байдаг, мөн төрөл бүрийн нэмэлт төлбөрүүд буюу авилгалтай тулгарах тохиолдох явдал нилээд газар авсан байна гэж хэлж болно. Банкны зээлийн салбарт хамгийн бага үзүүлэлт бол хувийн хэвшилд олгож буй зээлийн хэмжээ байгаа учир нийтдээ энэ судалгаанаас дүгнэж болох зүйл гэвэл Монголд хувийн хэвшил, түүний өсөлтийг банкны зээл, зохицуулалт, хөдөлмөрийн зохицуулалтаар ерөнхийдөө бага дэмжиж байна гэж харагдаж байна. 2003 оны

судалгаанд хамрагдсан 129 орны дотор Монгол Улсын зохицуулалтын нэгдсэн индекс болох 5.8 бол 74-р байранд орж, Гондурас, Пакистан, Литва, Папуа болон Перу улсуудтай зэрэгцэж байна. Харин энэ үзүүлэлтээр хамгийн өндөр индекстэй орнууд бол Гонконг, Исланд, Нэгдсэн Арабын Вант Улс, Шинэ Зеланд болон АНУ зэрэг орнууд тодорсон байна. Цаашид Монгол Улсыг хөгжүүлэх нэг арга зам бол эдийн засгийн эрх чөлөөг сайжруулж, төрийн зохицуулалт, түүний хүрээг зөв тодорхойлж, төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгах замаар эдийн засгийн өсөлтийг хурдасгах бүрэн бололцоотой байгаа нь энэ судалгааны дүнгээс харагдлаа.

ДҮГНЭЛТ

Манай улс өнгөрсөн арван таван жилийн хугацаанд хөгжлийн ямар амжилтанд хүрсэн, түүнийг яаж хэмжих, эдийн засгийн бодлого аль зэрэг зөв явж байгаа, юуг засаж сайжруулах, юуг өөрчлөх тухай улс орон даяар хэлэлцэн ярилцаж байгаа энэ цагт энэ гарын авлагыг Нээлттэй Нийгэм Форумгаас санаачлан гаргалаа.

1990 оноос ээлж дараалан солигдож ирсэн арав гаруй засгийн газар тус бүр үйл ажиллагаандаа тасралтгүй хэрэгжүүлж ирсэн бөгөөд нэгэн чиглэлтэй, зөвхөн эрч, хурдаар л ялгагдаж байсан гол асуудал бол бол макро эдийн засгийн тогтворжуулалт, хатуу мөнгөний бодлого, хувьчлалыг хурдасгах ажил байсан. Олон Улсын Валютин Сангийн удирдлага, хяналтын дор хэрэгжүүлж ирсэн энэ бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт тогтвортой болж, инфляци буурч, банкуудын актив эрс өсч байгаа ч манай иргэдийн амьдралын түвшин буурч, ядуурлын түвшин нэмэгдсээр байна. Баян ядуугийн ялгаа улам ихсэж, ажилгүйдлийн хэмжээ өндөр хэвээрээ байна. Нийгэмд “нинжа”-гийн шинэ давхарга үүсэж хот хөдөөгүй газар авлаа.

Ядуурлын гол шалтгааныг манай улсын эдийн засгийн макро түвшний бодлого нь микро түвшинд буюу баялгийг бүтээгч аж ахуйн байгууллага, компаниудын хэмжээнд явагдах ёстой бодлоготой уялдаж чадаагүйд оршиж байна гэж үзэж байна. Микро түвшний эдийн засгийн бодлого нь тухайн орны зах зээл дээр компаниуд хоорондоо чөлөөтэй өрсөлдөж үнэхээр чадаж байгаа эсэхээр тодорхойлогдоно.

Энэ өрсөлдөөний орчныг чөлөөтэй эсэхийг хэмжих олон аргуудын дотроос Фрейзер институтийн аргыг хэрэглэн та бүхэнд толилуулсан энэ гарын авлага нь хамгийн үнэн бодит үзүүлэлт болсон гэж бид маргахгүй. Гэвч дөрвөн бүлгээр хуваагдсан гуч гаруй үзүүлэлтийн ихэнх нь сүүлийн жилүүдэд нааштай өөрчлөгдөж байгаа нь манай улсын эдийн засаг бага багаар эрх чөлөөтэй болж буйг харуулж байгаа ч, шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Эдийн засгийн эрх чөлөө хязгаардмал байгаа нь хувийн секторт байгаа компаниуд өөрсдийн стратегийн давуу тал, удирдлага менежментийн өрсөлдөх чадвараар биш хээл хахууль, тусгай зөөлөн нөхцлийг улс төрчдөөр “арын хаалгаар” гаргуулах, төр засгийн албан тушаалыг хувийн сонирхолд ашиглах замаар илэрхийлэгдэж байна.

Энэ гарын авлага нь эдийн засгийн бодлого боловсруулагчид, гүйцэтгэх засаглалын ажилтнууд, судлаачдад манай улсын өмнө шийдэх ёстой ямар асуудал байгаа, түүнийг шийдэх, үйл ажиллагааныхаа үр дүнг хэмжих болон түүнийг хэлэлцэн ярилцахад тодорхой хувь нэмэр болох байх гэж судлаачдын баг үзэж байна.

Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс

Он	1995	2000	2001	2002	2003	2004
1. Төрийн байгууллагын хэмжээ	5.45	6.1	6.4	6.4	6.4	6.8
А. Улсын байгууллагын хэрэглээ	6.8	6.0	5.9	6.2	6.1	5.7
В. Татаас, урсгал шилжүүлэг	10.0	7.5	7.6	7.3	7.4	7.5
С. Улсын үйлдвэр ба хөрөнгө оруулалт	2.0	6.0	7.0	7.0	7.0	7.0
Д. Татварын дээд хэмжээ	3.0	5.0	5.0	5.0	5.0	7.0
- Аж ахуйн нэгжийн албан татварын дээд хэмжээ	7.0	7.0	7.0	7.0	7.0	9.0
- Хүн амын орлогын албан татварын дээд хэмжээ	1.0	2.0	2.0	2.0	2.0	4.0
2. Эрүүл мөнгө хүртэх боломж		7.3	7.7	8.4	8.7	8.8
А. Сүүлийн 5 оны мөнгөний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлтөөс хасах нь сүүлийн 10 оны ДНБ-ий жилийн дундаж бодит өсөлт		5.0	6.3	6.5	6.5	8.0
В. Сүүлийн 5 жилийн инфляцийн стандарт өөрчлөлт		5.8	5.9	7.5	9.3	9.2
С. Өнөөгийн инфляцийн түвшин		8.4	8.4	9.7	9.1	7.8
Д. Дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрх		10.0	10.0	10.0	10.0	10.0
3. Олон улсын худалдааны эрх чөлөө	6.9	7.0	6.6	7.0	7.0	6.97
А. Олон Улсын худалдааны татварын индекс	7.8	7.3	6.1	6.6	6.9	7.1
- Гадаад худалдааны эргэлтэнд гадаад худалдаанаас олох татварын орлогын эзлэх хувийн индекс	7.7	7.3	6.5	7.0	6.8	7.1
- Дундаж тарифын хэмжээний индекс	7.5	7.9	7.7	8.1	8.1	8.1
- Тарифын хэмжээний стандарт хазайлтын индекс	8.2	6.7	4.0	4.7	5.8	6.0
В. Худалдааны саад хоригийн зохицуулалтын индекс						5.45
- Импортын далд хориг саадын индекс						5.9
- Импортын зардлын индекс						5.0
С. Худалдааны секторын бодит ба хүлээгдэж буй утгын харьцааны индекс		7.8	7.4	7.5	7.3	7.3
Д. Валютын хар захын ба албан ханшны зөрөөний индекс	9.9	10.0	10.0	10.0	10.0	9.9
Е. Олон Улсын хөрөнгийн зах зээлийн хяналтын индекс	3.0	3.0	3.0	3.8	3.8	5.08
- Гадаадын хөрөнгийн зах зээлд дотоодын иргэдийн, дотоодын зах зээлд гадаад иргэдийн оролцох боломжийн индекс						6.35
- Хөрөнгийн зах зээлийн эзэмшил дэх иргэдийн чөлөөт байдлын хязгаарлалтууд	3.0	3.0	3.0	3.8	3.8	3.8
5. Банкны зээл, хөдөлмөрийн зах зээл, бизнесийн зохицуулалтын салбарын үзүүлэлт						5.8
А. Зээлийн зах зээлийн зохицуулалт		5.5	6.26	6.16	6.76	6.9
- Банкны өмчлөл		2.0	5.0	5.0	8.0	8.0
- Өрсөлдөөн			6.0	6.0	7.0	7.0
- Хувийн хэвшилд олгосон зээл		5.5	5.8	5.5	4.3	5.0
- Зээлийн хүү сөрөг түвшинд байх		8.0	8.0	8.0	8.0	8.0
- Банкны хүүгийн хяналт		6.5	6.5	6.5	6.5	6.5
В. Хөдөлмөрийн зах зээл						5.0
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөө						1.0
- Ажилд авах болон ажлаас халах процесс						6.0
- Цалин нь төвлөрсөн хамтын хэлэлцээрээр тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь						8.2
- Ажилгүйдлийн тэтгэмж						7.0
- Цэргийн алба						3.0
С. Бизнесийн зохицуулалт						5.6
- Үнийн хяналт						8.0
- Төрийн зохицуулалт ба шинэ бизнес						5.5
- Хэлэлцээр хийхэд зарцуулж буй хугацаа						6.5
- Шинээр бизнес эрхлэх						5.3
- Нэмэлт төлбөр						2.7
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	6.2	6.5	6.74	6.99	7.22	7.1

НОМ ЗҮЙ

1. The Fraser Institute. (2004). *Economic Freedom of the World: 2004 Annual Report*
2. The Fraser Institute. (2001). *Economic Freedom of the World: 2001 Annual Report*
3. The Fraser Institute. (2004). *Economic Freedom of the World: 2004 Annual Report*
4. Mark Skousen « The making of modern economics»
5. Монгол Улсын статистикийн эмтгэл, 2003, 2004
6. World Bank, World Development Indicators, 2001, 2005
7. Үндэсний Статистикийн газрын дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо
8. Олон улсын Валютын Сан. Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлага
9. Monetary fund, International Financial Statistics
10. Хөгжлийн эдийн засгийн асуудлууд сэтгүүл, 2004, №4
11. Ш.Цогтоо, «Гаалийн эрх зүй» Улаанбаатар хот 2003 он
12. Ж.Сувдням, М.Сувд. «Гадаад худалдаа», Улаанбаатар хот, 2002 он
13. С.Норжинсүрэн. «Олон Улсын Худалдааны зохицуулалт», Улаанбаатар хот, 2004 он
14. Г.Сэсээр, «Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал», Улаанбаатар хот, 2000 он
15. МУ-ын Үндэсний Статистикийн газар «Монголын Улсын Статистикийн эмхтгэл» 2003, 2002, 2001, 2000, 1999, 1998, 1997, 1995, 1992, 1991
16. МУ-ын Үндэсний Статистикийн газар «Статистикийн Бюллетень» 2005, 2004, 2003, 2002, 2001 онуудын сар бүрийн бүх дугаарууд
17. МУ-ын Үндэсний Статистикийн газар «Монголын Улс Зах Зээлд Статистикийн эмхтгэл» Улаанбаатар 2004
18. Монгол Банк «Жилийн тайлан» 2003, 2002, 2001, 2000, 1999, 1998, 1997, 1996
19. Монгол Банк «Сарын мэдээ» 2004, 2003, 2002, 2001, 2000, 1999
20. Монгол Улсын Их Хурал «Гаалийн тухай хууль» Улаанбаатар хот 1996 он
21. Монгол Улсын Их Хурал «Гаалийн тарифын тухай хууль» Улаанбаатар хот 1996 он
22. Монгол Улсын Их Хурал «Онцгой албан татварын тухай» Улаанбаатар хот 1993 он
23. Монгол Улсын Их Хурал «Үнэт цаасны тухай хууль» Улаанбаатар хот 1994 он
24. Монгол Улсын Их Хурал «Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль» 1993 он
25. Монгол Улсын Их Хурал «Төрийн мэдээлэл» 2005, 2004, 2003, 2002, 2001, 2000, 1999, 1998, 1997, 1996, 1995
26. Монгол Улсын Их Хурал «Зарим бараанд ноогдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай» 1996 он, бусад нэмэлт өөрчлөлтүүд
27. Монгол Улсын Их Хурал «Импортын барааны гаалийн албан татварын тухай хууль» 1997 он, бусад нэмэлт өөрчлөлтүүд
28. Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар «Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл» 2004, 2003, 2002, 2001, 2000, 1999, 1998, 1997, 1996, 1995
29. Damodar Gujarati «Basic Econometrics» Fourth Edition, 2004
30. R.Davidson, J.G.MacKinnon «Econometric Theory And Methods» 1999
31. William.H.Greene «Econometric Analysis» Fifth Edition 2003
32. G.S. Maddala «Introduction to Econometrics» Second Edition 1992
33. Jeffrey Wooldridge «Introductory Econometrics A Modern Approach» First Edition
34. Nelson C.Mark «International Macroeconomics And Finance Theory And Empirical Methods» 2000
35. P.H.Lindert «International Economics» 1991
36. P.R.Krugman, M.Obstfeld «International Economics Theory and Policy» Sixth Edition 2003
37. M.Obstfeld, K.Rogoff «Foundations of International Macroeconomics»
38. The Center for International Comparisons «Penn World Table 5.6a»
39. The Center for International Comparisons «Penn World Table 6.1» 2002
40. The World Bank «World Development Indicators» 2005, 2004, 2003, 2002, 2001, 2000
41. C.Skipton, R.Lawson «Estimating the Size of the Trade Sector: An Explanation of the Methodology Used to Construct Actual and Expected Trade Sector Size for Component 4-C of the Economic Freedom of the World Index»
42. N.T.Tamirisa «Exchange and Capital Controls as Barriers to Trade» IMF 1998, 1999
43. J.Gwartney, R.Lawson «Economic Freedom of the World Reports» 2004, 2003, 2002, 2001, 2000, 1999, 1998, 1997, 1996
44. World Economic Forum «Global Competitiveness Reports» 2004, 2003, 2002, 2001
45. International Monetary Fund «Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions» 2003, 2002
46. Монгол Банк. *Монгол Банкны Жилийн Тайлан: 1995-2004*
47. Монгол Банк. *Монгол Банкны Судалгааны Ажлын Эмхэтгэл 1-9 цуврал*
48. Монгол Банк. *Монгол Банкны танилцуулга: 2004 оны 12-р сар*
49. Монгол Банк. *Монгол Банкны танилцуулга: 2005 оны 2-р сар*
50. Монгол Банк. *Монгол Банкны сарын бюллетень – 2004 оны 12-р сар*
51. Монгол Банк. *Монгол Банкны нууцын тухай журам*
52. Монгол Банк. *Банк хоорондын овернайт зээлийн журам*
53. Монгол Банк. *Банкинд олгох санхүүжилтын журам*
54. Монгол Банк. *Банкнаас батлан даалт гаргахад мөрдөх түр журам*
55. Монгол Банк. *Зээлийн мэдээллийн сангийн журам*
56. Монгол Банк. *Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам (CAMELS)*

57. Монгол Банк. *Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих тавих журам*
58. Монгол Банк. *Банкинд олгох санхүүжилтийн журам*
59. Монгол Банк. *Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох журам*
60. Монгол Банк. *Активыг байгуулж, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам*
61. Монгол Банк. *Зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл авахыг хүссэн банк нь Монгол Банктай «Хамтын ажиллагааны гэрээ» байгуулах журам*
62. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар. *Монгол Улсын Статистикийн Эмхтгэл: 1995-2003*
63. Адам Смит. (1776). *Улс Орнуудын Баялаг*
64. Presentation by D.Jargalsaikhan. (June 16, 2005). *International Conference on Innovation and Socio-Economic Development, Ulaanbaatar, Mongolia*
65. Монгол Улсын Хууль «Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай»
66. Монгол Улсын Хууль «Үнэт цаасны зах зээлийн тухай»
67. Монгол Улсын Хууль «Гадаадын хөрөнгө оруулалтын тухай»
68. Монгол Улсын Хууль «Валютын зохицуулалтын тухай»
69. Монгол Улсын Хууль «Төв Банк /Монгол Банк/-ны тухай»
70. Монгол Улсын Хууль «Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай»

Өдөр тутмын сонинууд:
Өдрийн Сонин, Зууны Мэдээ

Ашигласан вэб сайтууд

71. <http://www.mongolbank.mn/>
72. <http://www.khanbank.mn/>
73. <http://www.transbank.mn/>
74. <http://www.capitalbank.mn/>
75. <http://www.savingsbank.mn/>
76. <http://www.postbank.mn/>
77. <http://www.interbank.mn/>
78. <http://www.xacbank.mn/>
79. <http://www.tdbm.mn/>
80. <http://www.zoosbank.mn/>
81. <http://www.anod.mn/>
82. <http://www.monjustice.url.mn>
83. <http://www.mongolbank.mn>
84. <http://www.nso.mn>
85. <http://www.worldbank.org>
86. <http://www.imf.org>
87. <http://www.undp.org>
88. <http://www.freeworld.com>
89. <http://www.wto.org>

Ашигласан программ хангамжууд

90. MSS Group, Starsoft Co.Ld «Find Law 2.0» 2002 он
91. Quantitative Micro Software «Eviews 4.1», «Eviews 5.0» 1994-2005
92. Stata Corporation «Intercooled Stata 8.0» 2003

